



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-157
<hr/>	
1. <i>Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайлан</i>	17-85
2. <i>Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	85-101
3. <i>Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	101-128
4. <i>Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	128-157

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 06-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, С.Ганбаатар, С.Одонтуяа;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Ганболд, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар;

Тасалсан: А.Адъяасүрэн, Ж.Сүхбаатар, Н.Учрал, Б.Чойжилсүрэн;

Хоцорсон: С.Амарсайхан – 3 цаг 01 минут, Э.Бат-Амгалан – 3 цаг 01 минут, Н.Ганибал – 38 минут, Х.Ганхуяг – 2 цаг 43 минут, Т.Доржханд – 29 минут, Х.Нямбаатар – 30 минут, Д.Өнөрболор – 22 минут, Ц.Сэргэлэн – 18 минут, Ч.Хүрэлбаатар – 54 минут, Ж.Эрдэнэбат – 41 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адъяаа, Э.Батшугар нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Э.Батшугар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлгийг долоо хоног хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 13

Бүгд: 50

74.0 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг долоо хоног хойшлуулахаар тогтов.

Нэг.Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, С.Цэдэндамба, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн, Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбарам, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Захиргаа, удирдлагын газрын дарга В.Жавзан, Судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Л.Лхамжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Б.Буянзаяа нар байлцав.

Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, тайланг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ц.Идэрбат, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр, Ш.Адьяа, М.Оюунчимэг, Б.Баярсайхан, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат, Ж.Батжаргал, Б.Жаргалмаа, Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг, Н.Ганибал, Ж.Батсуурь, Х.Баделхан, Ц.Туваан нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, С.Цэдэндамба, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 01 минут үргэлжилж, 13 цаг 05 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 07 минутад эхлэв.

Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайланг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, С.Цэдэндамба, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн, Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбарам, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Захиргаа, удирдлагын газрын дарга В.Жавзан, Судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Л.Лхамжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Б.Буянзаяа нар байлцав.

Тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг, Н.Ганибал, Ж.Батсуурь, Х.Баделхан, Ц.Туваан нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, С.Цэдэндамба, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төрийн байгуулалтын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлд тайлантай холбогдуулан чиглэл өгөв. /14:53/

Улсын Их Хурлын гишүүд Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайланг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, мөн газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн С.Лхагвадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Б.Саранчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “улаан буудайн” гэсний дараа “, хүнсний ногооны” гэж, “шимтгэлийг” гэсний дараа “тухайн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 25
Бүгд: 53
52.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрөөс олгох урамшууллаас” гэсний дараа “эрүүл мэндийн болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 23
Бүгд: 53
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “, шаардлага” гэснийг хасаж, мөн зүйлийн 3.1 дэх хэсгийн “улаан буудайн” гэсний дараа “, хүнсний ногооны” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 23
Бүгд: 53
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмэх:

“3.2.Төрөөс олгох урамшуулал авах эрх үүссэн иргэн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг уг урамшууллаас төлж болно.”

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан саналыг үндэслэн 4, 5 дугаар саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4, 5 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул 6 дугаар саналаар санал хураалт явуулаагүй болно.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “төв байгууллагаас” гэснийг “төв байгууллага энэ хуулийн 4.1-д заасан журмын дагуу суутган эрүүл мэндийн болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ц.Туваан, Н.Энхболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 27
Бүгд: 51
47.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 23
Бүгд: 52
55.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “төв байгууллагаас” гэснийг “төв байгууллага энэ хуулийн 4.1-д заасан журмын дагуу суутган эрүүл мэндийн болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 19
Бүгд: 51
62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Энэ хуулийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 23
Бүгд: 51
54.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн, 2 дугаар зүйлийн, 4 дүгээр зүйл, мөн зүйлийн 4.1, 4.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн” гэснийг, “эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 23
Бүгд: 49

53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд шинээр зүйл, хэсэг нэмсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлэх, мөн төслийн нэр томъёо, найруулгыг жигдлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 20
Бүгд: 50

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутган төлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Энхболд, мөн газрын Төмөр замын тээврийн хэрэгжилтийн дарга Х.Итгэлт, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Л.Булганхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Д.Ганбат, Т.Энхтүвшин, Б.Энхбаяр, Ш.Адьшаа, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Энхболд, мөн газрын Төмөр замын тээврийн хэрэгжилтийн дарга Х.Итгэлт нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг түр хойшлуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг урьдчилан зарлахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн, уран бүтээлч Ц.Зориглон, “Азтай савар” төрийн бус байгууллагын зохицуулагч, Эм-Си-Эс Интернэйшнл ХХК-ийн ахлах мэргэжилтэн Э.Бүжинлхам, “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, “Диди Лекс” ХХК-ийн хуульч М.Золзаяа, “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа, “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Хаан Банкны төслийн менежер Д.Оюун-Эрдэнэ, “Азтай савар” төрийн бус байгууллагын хуульч Б.Алтаншагай, “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фермийн хуульч М.Ариунзул, Өмгөөллийн “Легал Гайд” ХХК-ийн хуульч Э.Анударь, Өмгөөллийн “Легал Гайд” ХХК-ийн хуульч У.Азжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Б.Саранчимэг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 17 цаг 39 минутаас 18 цаг 45 минутад хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Ц.Идэрбат, Б.Жаргалмаа, Ц.Сандаг-Очир, Г.Амартүвшин, М.Оюунчимэг, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн, уран бүтээлч Ц.Зориглон, “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, “Диди Лекс” ХХК-ийн хуульч М.Золзаяа, “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Хаан Банкны төслийн менежер Д.Оюун-Эрдэнэ, “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фермийн хуульч М.Ариунзул, Өмгөөллийн “Легал Гайд” ХХК-ийн хуульч Э.Анударь, Өмгөөллийн “Легал Гайд” ХХК-ийн хуульч У.Азжаргал нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Рашаант сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн урилгаар Улсын клиникийн Хоёрдугаар төв эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Амарсайхан нарын урилгаар Багануур дүүргийн 5 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 11-ийн Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрэм, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 8 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Б.Энхбаяр нарын урилгаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2003 оны төгсөгчдийн төлөөлөл, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн 11-ийн А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 39 минут үргэлжилж, 73 гишүүнээс 61 гишүүн хүрэлцэн ирж, 83.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 04 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайлан.

Хоёрдугаарт, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг.

Тэгээд дөрөвдүгээрт Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Тавдугаарт, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Зургаадугаарт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу өнөөдөр үг хэлэхээр 3 гишүүн бичгээ ирүүлсэн байна.

Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбаньдийн Адьшаа, Энхбаярын Батшугар нараас албан бичиг ирүүлсэн байна.

Б.Пүрэвдорж гишүүн алга байна. Үүнийг ингээд хасъя.

Эрхэм гишүүн Ширнэнбаньдийн Адьшаа үг хэлнэ. Ш.Адьяаа гишүүн.

Ш.Адьяаа: Гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дээр нэг асуудал ярихгүй бол болохгүй байна.

Өнөөдөр Сонгуулийн тухай хуулийг батална гээд л бүгдээрээ чичрээд л байгаа.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль гээд ийм асуудлуудыг оруулж ирсэн байна.

Гэхдээ өнөөдөр Улсын Их Хурлын гишүүдийнхээ асуулгад хариу өгмөөр байна. Халзан бүргэдэйн асуудлаар би 11

сард асуулга тавиад Засгийн газар одоог хүртэл хариу өгөхгүй байна. Энэ дээр Улсын Их Хурлын удирдлага анхаарал авч өгмөөр байна.

Дээр нь өнөөдөр Улсын Их Хурал, Засгийн газар авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг сайжруулна гэж удаа дараа ярьж байгаа. Гэтэл өнөөдөр ам ажил хоёр чинь алд дэрэм зөрж байна шүү. Эрх баригчид аа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн бариад гурван долоо хонож байна. Гэтэл өнөөдөр ямар ашиг сонирхлын зөрчилтэй болоод өнөөдөр хуулийн төсөл оруулж ирэхгүй байна.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд Байнгын хороогоор хэлэлцсэн асуудлыг тэр долоо хоногт нь багтааж Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлдэг ийм дэгтэй. Гэтэл энэ хуулийг өнөөдөр Улсын Их Хурал дээр орж ирээд гурван долоо хонож байна. Яагаад энэ хуулийг оруулж ирэхгүй байна.

Энд мэдээж том дарга нарын эрх ашиг хөндөгдсөн ийм асуудлууд байгаа. Хуулийн хэлэлцүүлэг дээр манай шударга дарга Б.Энхбаяр нэлээн таа муутай хандаж байсан. Б.Энхбаяр дарга дээр гацаад байна уу? Авлигатай тэмцье гэдэг лоозон бариад ард түмнийг уриалаад байгаа Г.Занданшатар дарга дээр гацаад байна уу гэдгийг ард түмэн асуух шаардлагатай байна шүү.

Өнөөдөр энэ хуулийг бид батлах ёстой. Засгийн газар үнэхээр бодлогоо хэрэгжүүлэх гэж байгаа, Улсын Их Хурал нь авлигатайгаа тэмцэх гэж байгаа юм бол

энэ хуулийн төслийг яаралтай өнөөдрийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж ирье.

Өнөөдөр бид ингээд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхгүйгээр албан тушаал, авлигын асуудалтай тэмцэх асуудал чинь зүгээр хий хоосон үг болоод байна. Энэ дээр Улсын Их Хурлын удирдлагууд анхаарал хандуулмаар байна.

Ингээд л одоо нэг малын гэжээвэр амьтдын тухай хууль гээд л ийм юм оруулж ирдэг. Гэтэл өнөөдөр улс, ард түмний эрх ашиг, өнөөдөр нийгмийг цочроосон том эрх мэдэлтэй хүмүүсийн эрх ашгийг хязгаарласан хуулийн асуудлыг яагаад өнөөдөр Улсын Их Хурал оруулж ирэхгүй ингэж олон хоног гацаагаад байна.

Улсын Их Хурал дээр би хариулт авмаар байна. Энэ хууль батлагдсанаар мэдээж том дарга нарын эрх ашиг энд хөндөгдөж байгаа. Үүнийг ойлгож байгаа. Гэтэл бид нийт ард түмний эрх ашиг, нийт улсын олонхын эрх ашгийн төлөө энэ хууль чинь, энэ нийгэм чинь цаашдаа явах ёстой биз дээ.

Гэтэл өнөөдөр энэ хууль ингээд гацаад, Улсын Их Хурлын гишүүдээс нийгэмд, иргэдэд хамгийн их хүч хохирол учирсан тухай асуудлыг бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газарт асуулга тавихаар хариуг нь өгдөггүй. Усанд хаясан чулуу шиг байдаг байдал чинь хэний эрх ашгийг хамгаалаад, хэнд үйлчлээд, ийм асуудал өнөөдөр орж ирэхгүй удаж гацдаг, тэрнийг батлуулахыг оролддоггүй, хүний эрх, шударга ёс, Үндсэн хууль зөрчдөг асуудлаар ярьж асуудлыг хойшлуулдаг асуудлаа нэн даруй зогсоож, нийтийн эрх ашиг, Монгол Улсын эрх ашгийн төлөө хуулиа дээдлэх зарчмын хүрээнд Авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг

бүрдүүлэх хуулийнхаа төслийг энэ долоо хоногийн чуулганы хуралдаанд хэлэлцүүлэхийг би Улсын Их Хурлын гишүүний хувьд Улсын Их Хурлын даргаас би шаардаж байна.

Г.Занданшатар: Ш.Адъяа гишүүний шаардлагад хариу өгье. Тодруулж хэлье.

Ер нь Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулийн төслийг Байнгын хороогоор хэлэлцсэн.

Хууль санаачлагч нь бол Засгийн газар. Хууль санаачлагч Засгийн газраас энэ долоо хоногийн хуваарьт байсан боловч ирэх долоо хоногт болгож 04 сарын 13-нд ажил үүргийн ачаалал хуваариас болж Ерөнхий сайд бас өөрөө оролцох хүсэл сонирхолтой тул 04 дүгээр сарын 13-нд хэлэлцүүлж өгөхөөр саналаа ирүүлснийг үндэслээд ирэх долоо хоногт хэлэлцэхээр хойшлуулсан байгаа.

Ш.Адъяа гишүүн ээ. Энэ бол ингээд хууль санаачлагчийн эрх мэдэлтэй холбогддог юм.

Ер нь Сонгуулийн тухай хуулийн хувьд энэ долоо хоногт бусад гэдэг асуудлаар хэлэлцэхээр төлөвлөгдсөн байсан.

Гэхдээ ерөөсөө энэ Улсын Их Хурал бол бас асуудлыг нухацтай авч үзэж байх ёстой. Өглөө нь өргөн бариад өдөр нь Байнгын хороогоор хэлэлцүүлж болохгүй.

Улсын Их Хурлын гишүүдэд уншиж танилцах боломжийг олгох ёстой гэсэн үүднээс Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх асуудлаас хойшлуулж ирэх долоо хоног хоёр дахь өдөр хэлэлцүүлэхээр хойшлуулсан.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүд тус тус хоёр хуулийн төслийг өргөн барьсан байгаа.

Ер нь Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа асуудлыг бас зарим нь буруу ойлгоод байдаг. Ерөөсөө зарим нь ингээд олон нийтээр хэлэлцүүлэхгүй ороод ирдэг юм байна. Хэлэлцүүлээд ороод ирдэг юм байна гэж.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурлын тухай хуульд зааснаар Засгийн газраас нэн яаралтай горимоор оруулж ирсэн хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг явуулах шаардлагагүй. Хууль тогтоомжийн хуулийн шаардлагыг биелүүлсэн эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд хянаж хариуцаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан байдаг.

Улсын Их Хурлын Тамгын газар үүнийг хянах эрх байдаггүй.

Тийм учраас нэн яаралтай горимоор оруулаад ирсэн асуудлыг дараалал харгалзахгүйгээр хэлэлцэнэ гээд Улсын Их Хурлын тухай хуульд заачихсан. Энэ горимоор л хэлэлцэж ирсэн.

Тэр олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хууль нэн яаралтай горимоор орж ирэхэд нэн яаралтай горимоор л хэлэлцсэн.

Үүнийг харин хоригоос хойш ийм журмаар хэлэлцүүлэх энэ хуулийн заалтыг хэрэглэхгүй шүү. Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгч, Засгийн газар, хууль санаачлагч эрх бүхий этгээдүүд нэн яаралтай горимоор хэлэлцүүлээ. Яаралтай хэлэлцүүлж өгөөч гэсэн шаардлага тавихгүй шүү гэдгийг анхааруулсан.

Хуулийн заалт хэдийгээр ийм байгаа боловч хуулийн заалтыг өөрчлөх шаардлагыг тавьсан. Үүнийг зөв ойлгох хэрэгтэй. Түүнээс биш хоёр өөр чиглэлээр хандаад байгаа юм биш.

Тийм ч учраас Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг Улсын Их Хурлын гишүүд уншиж судалж, хариуцлагатай хандах ёстой. Нэн яаралтай давхиад байж болохгүй гэсэн ийм шаардлага тавьж байгаа юм.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө их хариуцлагатай байх хэрэгтэй. Юмнуудаа уншиж байх хэрэгтэй. Ш.Адъяаа гишүүн. Байнгын хороогоор тэр хэлэлцсэн асуудлууд дээр энэ чинь Засгийн газар, хууль санаачлагч нь өөрсдөө хуулиа тэдийд хэлэлцүүлбэ гээд тавьж байхад Улсын Их Хуралд шаардлага тавиад нэмэргүй. Энэ юмнуудаа ойлгож байж асуудлууддаа хандаж бай.

Энхбаярын Батшугар гишүүн үг хэлнэ.

Э.Батшугар: Баярлалаа. Эрхэм гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Баялгийн сангийн хуулийг яаралтай оруулж ирж баталмаар байна.

Өнгөрсөн жил бид 12 тэрбум долларын экспорт хийсэн. 32 сая тонн нүүрс экспортолсон. Гэтэл ард иргэд хүртээмж нь хаана байгаа юм бэ гэж их асууж байна. Энэ хүртээмж нь хамгийн жигд хуваарилах хамгийн зөв механизм бол Баялгийн сан байгаа юм.

Яагаад гэвэл байгалийн баялаг жишээ хэн нэг нь бүтээж хийгээгүй. Тийм болохоор Монгол Улсын иргэн бүр жигд хүртэх ёстой. Зөв зөв кэйсүүд байна.

Жишээлбэл, Норвегийн баялгийн сан 1.3 триллион долларын үнэлгээтэй. 9300 компанид хөрөнгө оруулалт хийсэн. Нэг хүнд оногдохоор 250 мянган доллар ногдож байгаа юм.

Тэгэхээр энэ жишгээр бид Баялгийн сангийн хуулийг яаралтай баталмаар байна. Тэгж байж байгалийн баялгаа жигд хүртээнэ. Ард түмэндээ.

Энэ жил аягүй бол бүр 40 сая тонн нүүрс экспортлох тийм төлөв хандлага харагдаж байна.

Хоёрт нь, сая Хөгжлийн банкны сонсголоор нэг юм би ойлгосон. Тэр нь юу вэ гэхээр үндсэндээ эдийн засгийн баатрууд жижиг, дунд эрхлэгч нар. Бор зүрхээрээ явж байгаа аж ахуйн нэгжүүд юм байна.

Тийм болохоор жижиг, дунд бизнес эрхлэгч нараа бодитоор дэмжих тийм бодлого хэрэгтэй байна. Дийлэнх бид нарын мэддэг том том компаниуд, бизнесменүүд бүгдээрээ л Хөгжлийн банкнаас бараг зээл авчихсан байна. Тэгээд хамгийн харамсалтай нь зарим нөхдүүд эргэж төлөхгүй байгаад байна. Зориулалтын бусаар ашигласан байна.

Тэгэхээр юу харагдаж байна. Яг бодитой бор зүрхээрээ явж байгаа хөдөлмөр эрхлэгч нараа дэмжих ёстой. Эд нар чинь эдийн засгийн үндсэн ачааг нь үүрч явж байна. Ажлын байр бий болгож байна.

Энэ нүүрсний хулгайтай тэмцээд, тэгээд нүүрсийг биржээр арилжиж эхэлснээс хойш хэд хэдэн эерэг өөрчлөлт гарлаа. Манай эдийн засагт. 70 доллар арилждаг байсан нүүрс өнөөдрийн байдлаар 170, 180 доллароор арилжиж эхэлж байна. 9 доллар, 7 доллар байсан

эрчим хүчний нөөц 70 доллар болсон байна. Үүнийг дагаад биржээр өнөөдрийн байдлаар 800 мянган тонн нүүрс өнөөдөр арилжаалсан.

Тэгэхээр энэ бол шууд манай бодит эдийн засагт мэдрэгдэж эхэлж байна л даа. Сүүлийн хоёр долоо хоногийн дотор Монголбанканд 61 сая доллар зарья гэсэн банкны санал ирсэн. Энэ бол миний мэдэхээр сүүлийн 12, 13 жил банкууд доллар худалдаж авъя л гэж ирдэг болохоос зарья гэсэн тийм санал ирүүлж байгаагүй.

3528 байсан албан ханш өнөөдөр 3513 болж буурсан. 2008, 2009 оноос хойш ханш бууж байсан түүх байхгүй.

Тэгэхээр бидэнд ийм алтан боломж, эдийн засагтаа бодитой өөрчлөлт хийх боломж гарчхаад байна. Гарсан байна. Алтны үнэ 2000 гарчихлаа.

Тэгэхээр бодит алтан боломжийг манай эдийн засагч нар болон Их Хурал, Засгийн газар зөв ашиглаад бодит ард иргэддээ нуруун дээр нь ачааг нь авах тийм үйл ажиллагаа хэрэгтэй байна.

Нөгөө инфляц чинь өндөр хэвээрээ байгаа. Тэгэхээр ойлгож байна. Энэ бол дан Монгол Улсад байгаа зүйл биш. Гаднын санхүүгийн нөхцөл байдалд хүнд байна.

Америкийн 2 банк дампуурсан. Швейцарын топ 10-т орох банк дампуурсан. Дэлхийн нийт Төв банкууд, Америкийн Төв банк 400 тэрбум доллар банкныхаа санхүүгийн салбар луу нийлүүллээ. Хятадын Төв банк 200 тэрбум юань нийлүүллээ.

Гэхдээ бид уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа цагт

ямар нэгэн байдлаар үүнийг зөв ашиглах нь зүйтэй л дээ. Бодит эдийн засагтаа оруулж ирж ард иргэддээ мэдрүүлэх ёстой. Бодитойгоор.

Хэлэлцэх асуудлын талаар нэг санал. Хууль санаачлагчийн хувьд санал гаргамаар байна.

Энэ Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт орох тухай хуулийг нэг долоо хоногоор хойшлуулж өгнө үү гэж хүсэлт гаргая. Яагаад гэвэл бас Засгийн газартайгаа бид ярилцаж нэмж ажиллах хэрэг гарсан юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд анхаараарай. Э.Батшугар гишүүний гаргасан горимын саналаар хоёр асуудлыг хойшлуулах санал хураалт явуулна.

Ер нь батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар Э.Батшугар гишүүн маш чухал асуудал хөндлөө. Энэ талаар манай Б.Баттөмөр гишүүн бас их санаачилгатай ажиллаж байгаа. Тэгээд Б.Баттөмөр гишүүн, Э.Батшугар гишүүн нар хамтраад батлагдсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуулийн хэрэгжилт, Банкны тухай хуулийн хэрэгжилтүүдийн талаар бас хяналт шалгалтын ажил хийж, хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Сая Б.Баттөмөр гишүүн Хөрөнгийн бирж дээр өнгөрсөн долоо хоногт ажилласан. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуулийг Улсын Их Хурал манлайлсан баталснаар 9.5 доллароор аман дээрээ зарагдаж байсан нүүрс 73 доллар болж одоо бараг 8 дахин, 6 дахин өслөө. Энэ их үнийн зөрүүгийн асуудал Монголдоо үлдэх, валютын нөөц өсөх боломж бүрдлээ.

Хоёрдугаарт нь, 60 доллароор зарагдаж байсан нүүрсний үнэ 180 доллар болж өслөө. Энэ бол манай баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хэрэгжилтийн бодит үр дүн юм гэж Б.Баттөмөр гишүүн ажлаа тайлагнасан.

Одоо үүнийхээ хэрэгжилтийг улам бүр хангуулах талаар ил тод, нээлттэй ийм биржийн арилжаанд оруулснаас нүүрсний хулгай, нүүрсний далд эдийн засаг ил болж байна гэсэн үг.

Энэ хуулийн хэрэгжилтийг улам бүр хангуулах талаар манай Төсөв, Эдийн засгийн байнгын хороод онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Маш чухал асуудал Э.Батшугар гишүүн хөндлөө.

Тэгээд алтны үнэ рекорд дээд түвшиндээ хүрч 2000 доллар давлаа. Нүүрсний гаралт нэмэгдэж байна. Урсгал тэнцэл ашигтай гарч, барааны данс анх удаа ашигтай гарч урсгал тэнцэл, валютын нөөцөд эергээр нөлөөлж байна.

Дээр нь ноолуурын үнэ нэмэгдэж. Манай Үйлдвэржилтийн байнгын хороо Т.Энхтүвшин гишүүн санаачилж тэр самнасан ноолуурыг хөрөнгө оруулалт, үйлдвэрлэгчдийг дэмжих бодлогын хэрэгжилтийг хянаж, шалгаж ажиллаж байгаа. Үүний үр дүнд дотооддоо самнадаг болсноос ноолуурын ханш 170 мянгаар сүүлд зарагдлаа шүү дээ.

Ноолуурын ханш өсөж байна. Улсын Их Хурлаас баталсан тогтоолынхоо хэрэгжилтийг хангуулах хэрэгтэй. Х.Болорчулуун сайд хаана байна.

Ингээд дотооддоо самнасан ноолуурын үйлдвэрийг дэмжихэд ер нь малчид хоршоолоод ноолуураа самнуулаад гадагшаа гаргахад малчдын орлого бодитой нэмэгдэж байгаа энэ Ховдын

хоршооны жишээн дээр бодитой жишээнүүд байна. Доллароор нь Италид экспортолсон. Ноолуураа. Ховдын дундын хоршоо. Малчдынх.

Ингээд малчид маань угаалгаад, самнуулаад нэмүү өртөг шингээгээд гаргавал Монгол Улсын валютын нөөцөд ч хэрэгтэй, малчдын орлогод ч хэрэгтэй ийм чухал зүйлийг санаачилж манай Үйлдвэрчдийн байнгын хороо, манай Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тэргүүтэй ажлын хэсэг их сайн ажиллаж байгаа. Үүнийхээ хэрэгжилтийг хангах хэрэгтэй.

Тэгээд асуудлуудын хойноос их анхаарч Э.Батшугар гишүүн чухал асуудлын хөндлөө.

Э.Батшугар гишүүн бас тэр банкны IPO, Банкны хууль батлагдаад нэг эзэнтэй банк бүх төрлийн бизнес рүү ороод байна. Банкны монопол, зээлийн хүүгийн дарангуйлал тогтлоо. Зээлийн дарамт их байна гэж бизнес эрхлэгчид хувийн хэвшлээс шүүмжлэлтэй хандаж ирсэн.

Энэ асуудлыг банкны IPO-гийн хэрэгжилтийг тууштай хангуулах ёстой. Эн онд. Банкны IPO гарснаараа нэг хувьцаа эзэмшигчийн хувь 20 хувиас хэтрэх ёсгүй. Ингэхэд олон эзэмшигчтэй болж, улмаар олон нийтийн компани болж байгаа шүү дээ. Хэдэн мянган хувьцаа эзэмшигчтэй болж, олон нийтийн хяналтад орсноороо банкны хөрөнгө үр ашигтай, зээлжүүлэлт үр ашигтай байх, зээлийн хүү буурах, хөрөнгийн зах зээл хөгжих маш олон эерэг үр дагаврыг бий болгож байгаа.

Тэгээд энэ хуулиудынхаа хэрэгжилтийг бид хангаж ажиллаж байх хэрэгтэй. Энэ талаар Э.Батшугар гишүүн маш чухал санаачилга хэллээ. Үүнийг Байнгын хороод дээрээ ярьж, анхаарч ажиллах нь зүйтэй.

Бас нэг чухал асуудал хөндлөө. Э.Батшугар гишүүн. Тэр инфляц маш өндөр байна. 12.2 хувь байна. С.Чинзориг сайд аа. Энэ дээрээ анхаар та хэд.

Махны үнэ инфляцын тал хувь болж байна. Хотын ард түмэн нөөцийн мах зарагдсан чинь нөөцийн мах гуанзуудаар зарагдаж байна. Хямдхан мах нь. Ард иргэдийн гар дээр очихгүй байна. Үүнээс болоод махны үнэ өсөж, иргэдийн амьжиргаанд хүндээр нөлөөлж байна. Энэ үнийн өсөлт чинь.

Үүнийгээ анхаарч ажиллах асуудлыг бид анхаарч байхгүй бол өөр хэн ярих юм бэ. Эрүүл мэндийн сайд үүнийг анхаарч ажиллах хэрэгтэй байна. Засгийн газрын гишүүд анхаарч ажлаа хийх хэрэгтэй. Одоо ингэж найран дундаа байгаад байж таарахгүй.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Одоо Э.Батшугар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд. Засгийн газрын тусгай сан чинь хамт явах билүү. Тусдаа хэлэлцэнэ. Тийм ээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг долоо хоногоор хойшлуулъя гэсэн горимын санал гаргасан.

Хууль санаачлагч Г.Тэмүүлэн нарын гишүүд дэмжиж байгаа юу? Тийм ээ.

Дэмжиж байгаа юм байна.

Засгийн газар сайд дэмжиж байгаа юу?

Дэмжиж байгаа юм байна.

Бүлэг дээрээ хэлэлцье гэж байгаа юм байна.

Ингээд Э.Батшугар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг суудалдаа суугаарай. Санал хураалт үймүүлэхгүй байхыг сануулъя. Цалингийн 20 хувиар хасна шүү. Засгийн газарт уламжлаад хасуулж болно. Давхраар нь хасна. Тэгвэл. Давхар дээлтэй юм чинь давхар хасалт хийгдэж болно шүү дээ.

74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Э.Батшугар гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх хэсэх асуудлыг долоо хоногоор хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайлан

Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулъя. Тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Балдангийн Батзориг танилцуулна. Б.Баатарзориг даргыг урьж байна.

Төрийн албаны зөвлөлийн дарга Балдангийн Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулна. Төрийн албаны зөвлөлийн гишүүд, ажлын хэсгийг урьж байна. Суудалд. Б.Баатарзориг даргыг индэрт урьж байна.

Б.Баатарзориг: Монгол Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж, төрийн албаны шинэтгэлийн үйл явцад ач холбогдол өгч байгаад талархлаа илэрхийлье.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан шинэчлэлийг эрчимжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, боловсронгуй болгох, цахим технологийн дэвшлийг нэвтрүүлэх, ёс зүй, сахилга хариуцлага, сургалт хөгжил, хандлага, соёлын өөрчлөлт, мерит зарчмыг хэрэгжүүлэхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Миний товч тайлан Та бүхэнд өмнө нь хүргүүлсэн 2021 оны 272 хуудастай, 2022 оны 226 хуудастай нийт 498 хуудас бүхий 2 номыг нэгтгэн богино хугацаанд багтаамж ихтэй мэдээллийг товч хүргэхийг хичээж байгаа юм.

Ийм учраас манай тайланд анхаарлаа хандуулахыг хүсье.

1.Ур чадварын шилжилт хийх эрх зүйн орчин бүрдлээ.

Шинэчлэлтийн жилүүдийн сорилт, сургамжид үндэслэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор төрийн байгууллага хооронд адил, ижил албан тушаал, ангиллын хооронд ур чадварын хөндлөн шилжилт хийх эрх зүйн үндэс бүрдсэн.

Хуулийн энэ өөрчлөлтийн дагуу 8 журмыг шинээр боловсруулж баталснаас гадна өмнөх онуудад батлагдан мөрдөгдөж байсан 47 дүрэм, журамд шинэчлэлт хийж байна.

Төрийн албаны өөр өөр ажил, ангиллын албан тушаалуудыг адилтгах, ажилласан хугацааг дүйцүүлэн тооцох болсноор ажилтны туршлага, ур чадварыг шилжүүлэх, хүний нөөцийн нөхөн хангалтыг тэлэх боломж нээгдлээ.

Тодруулбал, боловсрол, эрүүл мэнд, соёлын болон төрийн үйлчилгээний салбарт үр дүнтэй ажиллаж байгаа удирдах ажилтан, төрийн захиргааны ажил, албан тушаалд шилжин томилогдох боломж бүрдсэн юм.

2.Сонгон шалгаруулалт цахимжлаа.

Сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар ур чадвартай хүнийг бүрдүүлэхэд ёс суртахуун, туршлага чадварыг үнэлж, зөв хүнийг шилж олох, шилж сонгох, сонгон шалгаруулах аргачлалыг олон улсын түвшинд хүрэх зорилт тавин ажиллаж тодорхой үр дүнд хүрлээ.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал бүр зохион байгуулж эхэлснээр төрийн албанд анх орох иргэний нөөц 14 мянгад хүрээд байна.

Энэхүү нөөцийг зарим хувийн хэвшлийн салбарынхан, төрийн өмчит үйлдвэрийн газрынхан ч ерөнхий шалгалтыг хүлээн зөвшөөрч нөөцөд орсон өндөр оноотой иргэдэд ажил санал болгох ч хандлагууд байна.

Төрийн захиргааны удирдах албан тушаалын 729, гүйцэтгэх албан тушаалын 5042, төрийн үйлчилгээний байгууллагын шууд захирагчийн 358 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулсан.

3731 иргэнийг нэр дэвшүүлж томилуулаад байна. Энэ тоо өмнөх оноос 1.8 дахин өссөн байгаа.

Авлигалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн олон улсын шинжээчдийн тайланд Төрийн албаны сонгон шалгаруулах үйл ажиллагаа бүрэн цахимжсан нь сайн туршлага болсныг онцлон тэмдэглэсэн. Энэ бол эерэг мэдээлэл юм.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил буурах хандлагатай байна.

Тайлант хугацаа нь 415 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж хариуцлага хүлээснээс төрийн

захиргааны албан тушаалтан 221, төрийн үйлчилгээний албан тушаалтан 194 байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо өмнөх оноос өссөн хэдий ч төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тоо өмнөх оноос буурсан нь сахилга, хариуцлага, ёс зүйг сайжруулах талаар Улсын Их Хурлаас, Засгийн газраас явуулж байгаа бодлого, төрийн байгууллагуудын хэрэгжүүлж байгаа соён гэгээрүүлэх болон нөлөөллийн олон талт үйл ажиллагаа нь харилцаа, хандлага, соёлд тодорхой хэмжээний эерэг нөлөөлөл үзүүлж эхэлсний үр дүн гэж үзэж байна.

Улсын хэмжээнд 2002 оны жилийн эцсийн байдлаар 2961 ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байна.

Ёс зүйн зөрчлийн бүртгэл мэдээллийн цахим системийг нэвтрүүлэн ашиглаж байгаа юм.

Олон нийтээр хэлэлцэгдэж буй Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль батлагдсанаар энэ чиглэлээр тодорхой өөрчлөлт гарна гэсэн иргэдийн шударга ёсны хүлээлт байна.

Зарим нэг төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй үйлдлийг нийт төрийн албан хаагчдад хамаатуулан, төрийн алба, шударга төрийн албан хаагчдын нэр хүндэд халдах хандлага илэрч байгаад дүгнэлт хийж бодитойгоор хандахыг хүсье.

Төрийн албанд сайн ч тал байна, бэрхшээл, сорилт, шийдэх асуудлууд цөөнгүй байгаа юм.

4.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалт үр дүнд хүрч байна.

Хуульд заасан томилгооны хяналт шалгалтыг төрийн 58 байгууллагын 1012 албан хаагчийг хамруулан, 193 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсныг тогтоон зөрчлийг арилгууллаа.

Тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн албаны зөвлөл тухайн шийдвэрийг хүчингүй болгосон 31 тогтоол шийдвэрийг гаргалаа.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийтдээ 453 байгууллагын 7178 албан хаагчийн томилгоонд хяналт шалгалт хийж, 1489 зөрчилтэй томилгоог илрүүлж, урьдчилан сэргийлэх, хуульд нийцүүлэх арга хэмжээг авлаа.

Томилгооны хяналт, шалгалтаас гадна чадахуйн зарчмын хэрэгжилтэд хийх хүний нөөцийн аудитыг яам, агентлаг, орон нутгийн 57 байгууллагын 1585 албан хаагчийг хамруулан зохион байгууллаа.

Аудитын үр дүнгээр 11 дүгнэлт, 39 зөвлөмж, 8 тогтоол гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны хүний нөөцийн аудит хийх үндэсний хүний нөөц бэлтгэгдэж аудитын шинэ төрөл хэвшин тогтох үндэс суурь тавигдлаа.

Төрийн зарим байгууллагаас хүний нөөцийн аудит хийлгэх, зөвлөн туслах үйлчилгээ авах захиалга Төрийн албаны зөвлөлд давтамжтай ирэх болсон нь зөв эхлэл, зөв хандлагын бодит илэрхийлэл гэж үзэж байна.

5.Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хуулийн заалт бодитой хэрэгжиж эхэллээ.

Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх нэг механизм нь шийдвэр гаргагчдын төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих шинэ хуулийн зохицуулалт байлаа.

Төрд учруулсан хууль бус шийдвэр гаргасан, хохирол учруулсан, хууль бус шийдвэр гаргасан 27 албан тушаалтанд холбогдох 303 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, шаардлагыг биелүүлээгүй 7 албан тушаалтанд холбогдох 107 сая төгрөгийн нэхэмжлэлийг шүүхэд гаргалаа.

Иргэний хэргийн шүүхээр 13 хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж, төрд учруулсан 145 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаа явагдаж байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд хууль бусаар томилох, чөлөөлөх зөрчил мэдэгдэхүйц буурч байна. Хууль бус шийдвэрийн эрсдэлийг урьдчилан сэргийлж хүний нөөцийн зөвлөгөө, тусламж авах эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь хууль засаглах соёл төлөвших эерэг эхлэл болж байна.

6.КОВИД-ын дараах төрийн алба.

Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахал нь төрийн албаны шинэ хуулийн хэрэгжих хугацаанд тохиосон томоохон сорилт байлаа.

Энэ хугацаанд төрийн байгууллага, албан хаагчдад хандаж онцгой дэглэмийн нөхцөлд ажил, үйлчилгээг хэрхэн зохион байгуулах чиглэлээр зөвлөмж, шийдвэрүүдийг тухай бүр гарган мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллаж байсан.

Урьдчилан төсөөлөх боломжгүй КОВИД-ын хүнд үед үүргээ сайн биелүүлсэн нийт төрийн албан хаагчдад амжилт хүсэж байна.

КОВИД-ын хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн хугацаанд төрийн албанд томилогдсон нийт 2808 иргэний томилгоонд хяналт, шалгалт хийж, зөрчлийг арилгуулах талаар анхаарал хандуулан ажилласан.

Хуулийн болон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй 794 иргэнийг төрийн албанаас чөлөөлүүлж, шаардлага хангасан 823 иргэнийг сонгон шалгаруулалтаар төрийн албанд томилуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

7.Нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан иргэдийн судалгаа мэдээллийн сантай боллоо.

Авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан иргэдийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн цахим системд бүртгэн хяналт тавих ажлыг эхлүүллээ.

Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан 579 иргэдийг санд бүртгэснээс 227 нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдон ажиллаж байсан тул төрийн албанаас чөлөөлүүлсэн.

Төрийн албанд шударга ёсны зарчим тогтоох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах чиглэлээр нэг алхам хийгдлээ.

Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Таван Ш” үйл

ажиллагаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд түлхэц болж байна.

8.Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулах ажил үр дүнгээ өгч байна.

Төрийн ажил үйлчилгээг иргэдэд шууд хүргэх, хүлээлтийг багасгах, илүү тод болгох, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нэг арга бол цахимжилт юм.

Энэ зорилтын хүрээнд Төрийн албаны зөвлөл хүний нөөцийн удирдлагын цахим системийг ирж бүрэн хөгжүүллээ.

Суурь системүүдтэй интеграц хийх, мэдээллийн чанарыг сайжруулах, их өгөгдлийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэж байна.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн 12 модуль бүхий иж бүрэн цахим системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Цахим системийг нийгмийн даатгал, e-mongolia, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний бүртгэлийн, боловсролын, төрийн байгууллагын цалингийн нэгдсэн мэдээллийн системтэй холбосон.

Ингэж холбосноор төрийн аль нэг байгууллагад байгаа мэдээллийг хувийн хэвшлээс шаардах, мэргэжлийн холбоодоос шаардах байдлыг арилгаж, төрийн үйлчилгээг хүндрэлгүй, түргэн шуурхай үйлчлэх эхлэл тавигдаж байна.

9.Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлж байна.

Төрийн албан хаагчдыг сургах ажил 50 хувиар өссөн. Товчилж ярьж байна.

Тэргүүн түшмэлийн сургалтад 53, эрхэлсэн түшмэлийн сургалтад 282, ахлах түшмэлийн багц сургалтад 806, богино, дунд хугацааны сургалтад 8179 албан хаагч хамрагджээ.

Ирэх онд Удирдлагын академи болон боловсрол эзэмшүүлэх сургалтын бусад байгууллагуудтай хамтран мэргэшүүлэх багц сургалтад чанарын өөрчлөлт гаргах юм.

Төрийн албаны зөвлөл долоо хоног бүр “7:4:10” вебинар[webinar-онлайн] сургалтыг тогтмол зохион байгуулж байгаа. Энэ сургалтад 32 сэдвийн хүрээнд 92 мянган хэрэглэгчтэйгээр бүх шатын байгууллагуудад оролцсон 150 мянга гаруй албан хаагчийг хамруулсан сургалтыг долоо хоног бүхэн явж байгаа.

Өнөөдөр Пүрэв гараг. Өнөөдрийн 10.00 цагийн сургалтаар “Стресс менежмент” чиглэлээр бүх шатын байгууллагуудад сургалт явагдаж байгаа болно.

Шинэчлэлийн бодлого, шийдвэрийг таниулах зорилготой 114 удаагийн сургалт, семинарыг зохион байгуулж, 12 мянган төрийн албан хаагч хамрагдсанаар төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, соёл, сэтгэлгээнд эерэг өөрчлөлтүүд гарах эхлэл тавигдаж байна.

10.Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл үргэлжилж байна.

Төрийн албаны суурь болон хавсарга, захиалгат 47 судалгааг төлөвлөн судалгааны үр дүнд үндэслэн

бодлого, шийдвэр гаргахад тусган ажиллаж байгаа.

Тайлант онд “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хэрэгжилт, төлөв байдал” сэдэвт суурь судалгааг, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал”-ын судалгааг, “Төрийн албанд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүн”-гийн судалгааг, “Төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл, гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоог боловсронгуй болгох нь” зэрэг захиалга судалгаануудыг хийж гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнд Төрийн албаны зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийн дагуу төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээ, нэмэгдэл, урамшуулал, нэмэгдэл хөлсний талаар Улсын Их Хурал, Засгийн газарт санал хүргүүлэн хамтран ажилласан нь төрийн албан хаагчдад өгөөжөө өгч байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчдын улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж Улсын Их Хурлыг мэдээллээр хангах чиг үүрэгтэй.

Энэ үүргийнхээ дагуу тайлангийн хоёрдугаар хэсэгт Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо, бүртгэлийн талаар товч танилцуулья.

Монгол Улсын төрийн алба 2023 оны төсвийн жилд 4232 төрийн байгууллагатай, 225 мянга 205 төрийн албан хаагчтайгаар төрийн бодлого, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлээд байна.

Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүнийг танилцуулья.

Дэлгэц дээр гарч байгаа. 1.7 хувийг төрийн улс төрийн албан хаагч эзэлж байна. 9 хувийг төрийн захиргааны албан хаагчид эзэлж байна. 20 хувийг төрийн тусгай албан хаагчид эзэлж байна. 67.7 хувийг төрийн үйлчилгээний ангиллын албан хаагчид эзэлж байгаа юм.

Нийт төрийн албан хаагчдын 64.6 хувь нь эмэгтэй, 65.4 хувь нь эрэгтэй төрийн албан хаагчид байна.

Хүн амын тооны өсөлт, насны бүтцийн онцлогоос хамаарч боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэгчдийн тоо өсөж байгаа. Энэ хандлага цаашид ч хэвээр хадгалагдах төлөвтэй байна.

Иймээс төрийн үйлчилгээний салбарын албан хаагчдын эрх зүйн байдал, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах тусгайлсан хуулиар зохицуулах боломж, хувилбарууд байгаа юм.

Улсын Их Хурал, Засгийн газар төсвийн хяналтын зарчмыг хэрэгжүүлснээр төрийн улс төрийн албан хаагчдын тоо өмнөх үеэс 10 орчим хувиар буурсан. Энэ бол зөв шийдэл байсан гэдэг нь шийдвэр гарсны дараах үйл явцаас харагдаж байна.

Энэ жишгээр төрийн захиргаа болон төрийн тусгай албан хаагчдын тоог тодорхой хугацаанд зохистой түвшинд тогтвортой хадгалах нь улс төрийн шийдвэр, бодлогын асуудал боллоо.

Цаашдаа хүний нөөцийн бодлого, стратегийг өөрчилж албан хаагчдын тоог нэмэгдүүлэх биш чанарт анхаарах, ур чадвар, гүйцэтгэл өндөртэй, цогц чадамж бүхий иргэнээс сонгон бүрдүүлэх, сургаж

бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах замаар төрийн албаны давхардал, хийдлийг арилгаж чадавхжуулах бодлогын шилжилт хийх нь цаг үеийн эрэлт хэрэгцээ болжээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэдлэг, ур чадварт суурилсан хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх дараах саналыг товчлон танилцуулья. Гурван санал байгаа.

1. Улсын Их Хурлын түвшинд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулж 2030 он хүртэлх төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг батлан мөрдүүлэх. Энэ баримт бичигт нь төрийн албаны бүтэц, тогтолцоо, зохистой хэмжээ, төрөл, ангилал, албан хаагчдын хууль эрх зүй, нийгмийн баталгаа, сургалт хөгжлийн асуудлыг иж бүрнээр нь уялдаа холбоотой судалгаа, нотолгоотойгоор боловсруулсан, өөрчлөгдөж байгаа нөхцөлд уян хатан зохицож, үр нөлөөтэй, мэргэшсэн, цомхон төрийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэлийн хүлээлт байна.

2. Төрийн албаны хуулийн хэрэгжилтэд иж бүрэн шинжилгээ хийж, суурь хуулийн үндсэн зарчим, үзэл баримтлалтай салбарын хуулиудын зохицуулалтыг нийцүүлэх, төрийн албаны шинэчлэлтийн таатай орчныг бүрдүүлэх. Энэ хийгдэж байгаа. Хамтраад.

3. Төрийн байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, дахин

хуваарилалт хийх замаар парламентын хяналтын хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцын бодлого, стратегийн түвшинд хянах шинэ механизмыг бүрдүүлэх.

Засгийн газрын түвшинд гурван голлох санал байгаа.

1.Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаанд цогц судалгаа, шинжилгээ хийх, орон нутаг дахь төвлөрсөн болон зэрэгцээ удирдлагын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох. Босоо, хэвтээ ч гэж хэлдэг. Төвлөрлийг сааруулах.

2.Бүх шатын төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах цогц бодлого боловсруулж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хуулийн хэрэгжилтийг хангах.

Төрийн албан дахь жендэрийн тэгш байдлыг дэмжсэн соёл, сэтгэлгээ, зан төлөвийг бүх шатад төлөвшүүлэх.

3.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох, гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, цалин хөлс, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх, ажлын үнэлэмж, эдийн засгийн баталгаа, хариуцлагын тогтолцоог хамтран шийдвэрлэх 360 хэмийн үнэлгээний систем нэвтрүүлэх одоогийн дүрэм журмыг хялбаршуулах, ижил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох зарчим хэрэгжүүлэх зэрэг болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны хөгжлийн өнөөгийн байдал, чадахуйн зарчмын хэрэгжилт, төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, төрийн албаны сургалт, хөгжил, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Төрийн албаны зөвлөлөөс 2021, 2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг товч танилцууллаа.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Тайлан хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлд заасан журмын дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Г.Занданшатар, А.Адьяасүрэн, Ш.Адьяа Н.Энхболд нар тайлантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн гишүүдээс асуулт асууж, хариулт авч, саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл

ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4-г заасны дагуу нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайланд шинжилгээ хийж ирүүлснийг Та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулна. Түүний өмнө зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Рашаант сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн дарга Балдангийн Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Цэнддаваагийн Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Сандангийн Цэдэндамбаа, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Должингийн Баатарсайхан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Бадамцоогийн Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Ганбаатарын Билгүүн, Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Төмөрхуягийн Сосорбарам, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Чандагийн Бат-Эрдэнэ, Төрийн албаны зөвлөлийн Захиргаа, удирдлагын газрын дарга Вандансүрэнгийн Жавзан, Төрийн албаны зөвлөлийн Судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Лхагважавын Лхамжав нарын ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Жамбын Батсуурь гишүүн орчихсон байна. Хавдисламын Баделхан гишүүн ороод гараад, эргээд орчихлоо. Тийм. Мөнхөөгийн Оюунчимэг, Ц.Цэрэнпунцаг гишүүн хоёр л орж гараад л байх юм. Одоо тэгээд тогтчихмоор байх юм. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа.

Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг асуулт асууж, үг хэлнэ.

Ё.Баатарбилэг: Гишүүдийнхээ өглөөний амрыг айлтгая.

Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайлантай танилцсан. Бидэнд өмнө нь бас мэдээлэл ирүүлсэн байгаа. Байнгын хороогоор хэлэлцсэн.

Харьцангуй Төрийн албаны зөвлөл хууль эрх зүйн орчны шинэчлэл хийгдээд үйл ажиллагаа бол нэлээн аятайхан жигдрээд явж байгаа гэж би харж байгаа.

Сүүлийн хоёр, гурван жилийн дотор хууль, эрх зүйн орчны шинэчлэлтэйгээ холбоотой КОВИД-ын үед дотоод дүрэм, журам, Засгийн газар, холбогдох байгууллагуудтай холбоотой дүрэм, журам юмнуудаа нэлээн сайн шинэчлээд цэгцэлчихсэн юм байна гэж ойлгосон.

Ялангуяа төрийн албаны шалгалт авах гэж байгаа гээд жилд нэг, хоёрхон удаа авдаг, маш их очер дугаартай. Тэгээд л бөөн хардлага, сэрдлэгтэй ийм байдаг байсан. Төрийн алба албаны шалгалт одоо улирал тутам зохион байгуулагдаж. Ерөнхий шалгалт.

Тэр тусгай шалгалт юмнууд нь ном журмаараа ингээд явдаг. Онлайн, цахим, нээлттэй, ил тод шалгалтын систем бүрдүүлчихсэн.

Төрийн албаны шалгалт нэлээд аятайхан болсон байна гэж харагдаж байгаа юм. Нөгөө талаараа төрийн үйлчилгээнээс төрийн захиргаа руу дүйцүүлдэг болъё гэдэг саналыг л сүүлийн хоёр, гурван жил би бас нэлээд ярьж Төрийн албаны тухай хуульд оруулсан юм.

Зүгээр энэ дээр хоёр, гурван зүйл тодруулаадахъя.

Дүйцүүлэх шалгуураа төрийн үйлчилгээнээс төрийн захиргаа руу орж байгаа дүйцүүлэх шалгуурыг нь нэлээн

тийм хатуу босготой тавьчихсан байна гэдэг юм л яригдаад байна лээ л дээ. Жишээлэхэд маш олон жил. Одоо 15, 20 жил эмнэлэг, сургууль гээд боловсрол, эрүүл мэндийн байгууллагын дарга, удирдлагаар ажиллаж ажилласан, олон жил ажилласан хүмүүсийг одоо төрийн албаны захиргааны алба руу зүгээр ахлах мэргэжилтний түвшинд дүйцүүлж байх жишээтэй.

Ингэхээр нөгөө бид нарын яриад байгаа олон жил салбартаа ажилласан хүмүүсийг төрийн захиргаа руу татаж оруулж ирж, газрын дарга, холбогдох бас нэг тодорхой удирдлагын түвшинд ажиллах боломжтой хүмүүсийг ингэж шилжүүлбэ гэтэл нөгөө хүмүүс нь зүгээр нэг тийм ахлах түшмэлийн түвшинд очихоор тэр лүү төрийн захиргаа руу орж ажиллах сонирхолгүй л болчихоод байгаа юм л даа.

Тэгэхээр үүнийг ямархуу журмаар яаж дүйцүүлсэн юм? Үүнийг эргэж харах боломж байгаа юм уу гэдэг нэг ийм юм байна.

Хоёрдугаарт, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн биелэлт хэр байгаа вэ? Сая нэлээн харьцангуй сайжирч байгаа л гэж байна. Төрийн албаны зөвлөлийн шийдвэр гарчхаад хэрэгждэггүй, хэрэгжүүлдэггүй нэг ийм юм яваад. Тэгээд ямар сайндаа өмнөх чуулганы хуралдаанууд дээр би ярьж байсан шүү дээ. Төрийн албаны зөвлөл нэг тийм шүдгүй арслан шиг ажиллаад байна гэж. Одоо шүдтэй арслан болчихсон байх ёстой. Бүх эрх нь оччихсон байгаа.

Тэгэхээр шүдтэй арслан болж ажиллаж чадаж байна уу, үгүй юу гэдгийгээ Та бүхэн шийдвэрийн биелэлт. Хэрвээ биелэгдэхгүй байгаа хувь байгаа бол ямар асуудлууд дээр шийдвэр

хангалттай биелэгдэхгүй байна гэдэг тоо, мэдээлэл, судалгаа, юмнууд Та бүхэнд байна уу, үгүй юу?

Гуравдугаарт, багш, эмч нар гадагшаа их явж байна. Мэдээж цалин хөлс хүрэлцээгүй, зээл хуультай гээд л ингээд гадаад улс орнууд руу ингээд ажиллах гээд их явж байна. Төрийн албан хаагчид, ялангуяа төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгааны асуудал дээр Та бүхэн Төрийн албаны зөвлөлөөс Засгийн газарт, Их Хуралд холбогдох тодорхой саналууд юу байна?

Саяынх дээр тийм тодорхой дурдагдсангүй гэж харагдаад байна л даа. Нийгмийн баталгааных нь асуудлыг нь ингэмээр байна. Төрийн албан хаагчдынхаа нийгмийн баталгаа, цалин хөлс, урамшуулал, тэр тэтгэмж, тэтгэврийн асуудал дээр ийм бодлого баримаар байна гэдэг юмыг Төрийн албаны зөвлөлөөс бас хүчтэй дуу хоолой болмоор байна л даа. Үйлдвэрчний эвлэлүүд л дуугараад байгаа юм.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл дээр энэ талаар судалгаа юмнууд байна уу, үгүй юү? Энэ тал дээр хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ?
83. С.Цэдэндамба гишүүн хариулъя.

С.Цэдэндамба: Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба. Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийн асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт. Төрийн үйлчилгээ төрийн захиргааны албан тушаалд шилжүүлэхтэй холбоотой байна.

Төрийн албаны хуульд 2022 оны 07 дугаар сарын 05-нд орсон өөрчлөлтөөр төрийн тусгай, төрийн үйлчилгээний

албан хаагчдыг төрийн захиргааны албан тушаалд адилтгаж үзэх тухай шийдвэр гарсан.

Мөн төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргаанд ажилласан хугацаатай дүйцүүлэх гэсэн адилтгах дүйцүүлэх гэсэн хоёр өөр зохицуулалт орж ирсэн.

Саяын асуултаар төрийн үйлчилгээний байгууллагын зөвхөн удирдах албан тушаалтнуудыг төрийн захиргааны албан тушаалд шилжин ажиллах боломжийг нээсэн хууль зүйн зохицуулалт байгаа.

Хуулийн агуулга ажилласан жилүүдийг хооронд нь дүйцүүлэх биш, албан тушаалын ангилал, зэрэглэлийг адилтгах байдлаар зохицуулсан.

Тийм учраас төрийн үйлчилгээнд байгаа ямар ямар албан тушаалуудыг аль салбарын ямар албан тушаалыг төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаалтай адилтгах вэ гэдэг ийм жагсаалтыг Засгийн газрын санал болгосноор Төрийн албаны зөвлөл батлан мөрдөж хэрэгжүүлж байгаа.

Ахлах түшмэлийн албан тушаалтай адилтгах төрийн үйлчилгээнд ажиллаж байгаа албан тушаалтан бол төрийн албанд орохдоо ахлахаас ахлах, адил ангилалдаа шилжиж болно. Мөн эрхэлсэн түшмэлийн албан тушаалд өрсөлдөх тийм эрх нь нээгдсэн гэдэг ийм боломжуудыг өргөтгөж өгснөөрөө энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт нь төрийн захиргааны албанд байгаа сул орон тоог нөхөх, тэнд байгаа хүний нөөцийн хомсдолыг, төрийн үйлчилгээний ур чадвар, туршлагатай албан хаагчдаар нөхөн хангалт хийх ийм зохицуулалт болсон гэж үзэж байна.

Гурав дахь асуултад эмч, багш, одоо ер нь нийгмийн салбарын ажилтнууд гадаадад гарах, ажиллах ийм хандлага байна гэж. Энэ дээр Төрийн албаны зөвлөл ер нь судалгаа гаргаж харж байгаа. Энэ яах аргагүй нийгмийн баталгаатай холбоотой байна гэдэг дүгнэлтийг удаа дараагийн Төрийн албаны зөвлөлийн тайлангуудад тодорхой дурдсан.

Тийм ч учраас 2023 оны эхэнд Засгийн газарт төрийн үйлчилгээ, ер нь төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн тусгай ангиллын албан тушаалуудын цалинг нэмэгдүүлэх саналыг оруулсан.

Засгийн газар хэлэлцээд 2023 оны төсөвт баталсан төсөвтөө багтаагаад тодорхой хэмжээнд нь цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал болон бусад нэмэгдлүүдийг нэмэх 6 шийдвэр гаргасан нь төрийн албаны саналын дагуу хийгдсэн.

Тэгэхдээ нэмэгдлийн хэмжээ нь Зөвлөлийн санал болгосон хэмжээнд хараахан хүрээгүй. Учир нь гэвэл нэгэнт баталсан 2023 оны төсвийнхөө хэмжээнд тооцож үзлээ.

Тийм учраас төрийн албанаас оруулж ирж байгаа энэ саналыг 2024 оны төсөвтөө тусгаж авч үзнэ гэсэн ийм байр сууриа Засгийн газар илэрхийлсэн байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 102 жилийн ойг тохиолдуулан Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их

Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс төрийн тусгай албаных нь ажил үйлсэд өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр дүйцүүлэхтэй холбоотой нэг ийм асуудал байгаа юм байна.

Тэр тогтоол, шийдвэрийн биелэлттэй холбоотой тоо баримт юмнууд Та бүхэн хэлэх нь зөв байх. Тийм ээ. Тогтоол, шийдвэрийн биелэлт дээр.

Тодорхой Төрийн албаны зөвлөлийн шийдвэрүүд гарчхаад байхад биелэгдэхгүй байна, шийдвэр биелүүлээч гээд бараг Шүүхийн шийдвэр биелүүлэх газар гэдэг шиг Төрийн албаны зөвлөлийн шийдвэр биелүүлэх газар байгуулмаар байна гэдэг асуудал хүртэл хөдөө орон нутагт явж байхад ийм юм яригдаад байдаг юм.

Тэгэхээр энэ дээр ямархуу тоо баримт юмнууд байгаа юм.

Ер нь саяын тэр нийгмийн баталгааны асуудал, тэр тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлууд дээр Төрийн албаны зөвлөл маань жаахан хүчтэй дуу хоолой гаргаж явахгүй бол зүгээр санал хүргүүлэх маягаар орхиод баймааргүй байгаа юм. Яг төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг хамгаалах хамгийн том байгууллага бол Та бүхэн байдаг учраас Та бүхнийг л хараад энэ төрийн албан хаагчид сууж байгаа гэдгийг бас.../минут дуусав/

Г.Занданшатар: 81.
Бадамцоогийн Идэрчулуун гишүүн хариулъя.

Б.Идэрчулуун: Ё.Баатарбилиг гишүүний асуусан асуултын хоёр дахь асуултад нь хариулъя.

Тайлант жилд жишээлбэл 2021 онд 1112, 2022 онд 175 шийдвэрийг бид хүчингүй болгосон.

Тэгээд одоо энэ шийдвэрийн биелэлтийг харахаар зөрчил арилгаад илаарьшсан 1128 шийдвэр биелэгдчихээд байна. Тухайлбал, КОВИД-ын хууль 2022 оны 12 сарын 31-нээр хүчингүй болсон. Энд хууль бусаар томилогдсон хүмүүсийг чөлөөл гээд Төрийн албаны зөвлөлөөс мэдэгдэл хүргүүлсэн. 2022 оны 11 сарын 02-ны 43 дугаар хуралдаанаар мэдэгдэл хүргүүлсэн.

Энэ мэдэгдлийн биелэлт гэхэд.../минут дуусав/

Г.Занданшатар: Б.Идэрчулуун дарга гүйцээгээд хариулчихъя. 81.

Б.Идэрчулуун: Одоо ирүүлсэн 1196 хууль бус томилгоог биелүүлчихсэн гээд. Одоо ирүүлээгүй зөрчил арилгаагүй нийт тоогоор нь авч үзэх юм бол 491 хууль бус томилгоо биелэгдээгүй явж байна.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Эндээс асууж тодруулах хоёр, гурван зүйл байна.

Нэгдүгээрт, “Алсын хараа-2050” дээр “төрийн албыг цомхон, чадварлаг болгоно” гэсэн ийм том зорилт байгаа. Үүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана гэсэн ийм зүйлийг ярьж байна.

Тэгээд би “цомхон болгоно” гэдгийг ер нь яг юу гэж ойлгох юм бэ? Цомхон болгоно гэж олон жил ярьж байгаа. Олон арван жил ярьж байгаа байх.

Гэхдээ Та бүхнийг чуулганы танхимд орж ирж танилцуулж байх үед би Монгол Улсын төрийн албаны тоо, албан хаагчийн тоо, тэр дотроо төрийн захиргааных нь хэд юм бэ гээд үзэхээр 240 мянга, 250-иад мянган төрийн албан хаагчтай. Эндээс төрийн захиргааны алба хаагчид нь 21 мянга байгаа. Бусад нь тэгээд л төрийн үйлчилгээ, төрийн тусгай гээд ингээд явж байгаа.

Тэгэхээр ер нь яг аль хэсгийгээ цомхон болгоно гэж ингэж том зорилт тавиад байгаа юм бэ? Жишээ нь, боловсролын салбарынхныг цомхон болгоно гэж байгаа бол мэдэхгүй. Би лав биелэхгүй байх гэж бодож байна. Жил болгон сургууль, цэцэрлэг нэмэгдэж байна. Эрүүл мэндийн салбар сувилагчийнх нь тоо хүрэхгүй байна. Цагдаагийн тоо бас тийм хангалттай биш байна гэж байгаа юм.

Тэгэхээр явж явж энэ чинь төрийн захиргаа руугаа очих гэж байна уу? Яг аль салбарыг нь цомхон болгох гээд байгаа юм? Эсвэл 240 мянгаасаа цомхон болгох гээд байгаа юм уу? Төрийн захиргаанаасаа цомхон болгох гээд байгаа юм уу? Үүнийгээ тодорхой болгож хэлмээр байна.

Чуулганы завсарлагаанаар тойргоороо ажиллахад 21 хүн ажиллах ёстой Тамгын газарт 15 хүн ажиллаж

байна. 16 хүн ажиллаж байна. 5, 6 хүн, 7 хүн дутуу.

Би сая Нийгмийн даатгалын хуулийн хэлэлцүүлгээр зүүн 3 аймгаар явлаа. Сүхбаатар аймаг дээр очоод Сүхбаатар сумын Засаг даргаас асуухад л 21 хүнээс 6 дутуу л гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр дутуу байгаа ийм зүйлийг бид харсаар байгаа. Гэхдээ эргүүлээд цомхон болгоно гэдэг зүйл хэлээд байгаа нь яг аль сегмент рүүгээ явах юм бэ гэдгийг тодорхой болгож хэлмээр байна.

Хоёрдугаарт, томилгооны асуудал. Өнөөдөр орон нутгийн аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга хоёр томилдог хүн гэж байхгүй боллоо. 23 агентлаг байгаагаас ердөө 4, 5-ыг нь л томилж байна. Бусад нь бүгд босоо болчихсон. Зөвшилцсөн нэртэй босоо томилгоотой болчихсон.

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга 21 хүнээсээ үйлчилгээний ажилтан, жижүүр, манаач, жолоочоо нийлүүлээд 21-ээсээ 5-ыг нь, 6-г нь л томилж байна.

Одоо Газрын хууль дээр гэхэд газрын түшмэлийг бүгдийг нь энэ ерөнхий газар нь, энэ агентлаг нь томилно гэсэн юм орж ирж байгаа.

Өнөөдөр татвар тийм байдалтай байгаа. Улсын бүртгэл тийм байдалтай байгаа. Ингээд сумын мэргэжилтнийг хүртэл тийм түвшинд аваачих юм уу? Тэгээд энэ чинь зөв юм уу? Тэнд удирдах, удирдагдах ёс алдагдаж байна. Яг үнэндээ бол.

Гуравдугаарт, цалингийн сүлжээ. Төрийн албан хаагчдын цалингийн асуудлыг ер нь яг аль яам нь, аль агентлаг

нь хариуцдаг юм бэ? Яагаад тэнгэр газар шиг зөрүүтэй, хойно өврөөс нь гарсан юм шиг ийм цалингийн сүлжээтэй Монгол Улс болчихов оо.

Өнөөдөр төрийн үйлчилгээний алба хаагчид орон нутагт очоод ажиллахад цалингийн доод хэмжээний, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин яг гар дээрээ авч байна гэсэн гомдлыг яриад сууж байгаа шүү дээ.

Тэгэхээр сая Ё.Баатарбилэг гишүүний хэлж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн халамж, хамгааллын асуудал дээр би бас түрүүн та нараас асууж л байсан. Хэн үүний талаар дуугардаг байх юм бэ? Багш, сургууль, эмнэлэг эд нар бол үйлдвэрчний эвлэл нь дуугараад байдаг. Төрийн захиргааныхны тал дээр ердөө дуугарч байгаа амьтан алга. Төрийн үйлчилгээний алба хаагчдын талаар дуугарч байгаа хүн ер нь байхгүй байна шүү дээ.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл ингээд шалгаад суугаад байх эрхтэй байхаас гадна энэ хүмүүсийн нийгмийн хамгааллын асуудал дээр бас анхаарч болдоггүй юм уу?

Дөрөвдүгээрт нь, төрийн ангиллын асуудлууд. Төрийн захиргаа, ТЗ-ийн ангилал гээд.

Өнөөдөр орон нутагт олон орон тоо дутуу байгаа чинь бүгдээрээ ТЗ болчихсоны уршиг юм билээ шүү дээ. Байгаль хамгаалагч ТЗ. Тавигдах шаардлага нь 12 дугаар анги төгссөн байж болно. Төгссөн ч гэсэн төрийн албаны шалгалт өгнө. Үүнийг би юу ердөө ойлгохгүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Ё.Баатарзориг дарга хариулъя. 84. С.Цэдэндамба. Самдангийн Цэдэндамба. 83.

С.Цэдэндамба: Ц.Идэрбат гишүүний асуултад С.Цэдэндамба би хариулъя.

Ях аргагүй “Алсын хараа-2050” болон ер нь төрийн баримт бичгүүдэд төрийн алба цомхон, чадварлаг байна гэсэн ийм томъёолол бий.

Сая гишүүний асууж байгаа асуулт бол маш чухал асуулт байна. Цомхон байх гэдэг нь юу вэ гэдэг нь Төрийн албаны зөвлөлийн байр суурь бол энд төрийн үйлчилгээний салбар бол хүн амын өсөлт, төрийн үйлчилгээ авч байгаа хэсгийн тоо жилээс жилд нэмэгддэг учраас энэ бол түүнийгээ дагаад энэ орон тоо цомхотгогдох боломжгүй.

Тийм учраас саяын илтгэлд ч гэсэн энэ салбарын асуудлыг тусгайлан зохицуулах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй юм гэсэн санал дэвшүүлсэн.

Төрийн захиргааны байгууллага, төрийн тусгай байгууллагуудын хувьд энэ томъёоллыг бас харж явах ёстой. Тэгэхдээ тоон талаасаа гэхээсээ илүү бүтэц, зохион байгуулалтын хувьд илүү оновчтой, чиг үүрэг нь давхардалгүй ийм агуулгаар төрийн алба цомхон байна гэдгийг үйл ажиллагааны чиглэл, бүтцийн оновчтой хэлбэрээр нь ингэж ойлгож явж байгаа.

Өнөөдөр үнэхээр төрийн захиргаанд 20 мянга байна гэдэг бол Монгол Улсын ийм өргөн газар нутаг, засаг захиргааны олон нэгжийн хувьд үнэхээр хязгаарлагдмал тоо.

Тийм учраас төрийн захиргааны албан тушаал цаашаа нэмэгдэх боломж бий гэж харж байна.

Хоёрдугаар асуулт. Томилгооны хувьд яах аргагүй Ц.Идэрбат гишүүний тавьсан асуулт байгаа. Ялангуяа орон нутагт хоёрдмол засаглалын шинж байгаад байгаа. Төв удирдлагатай байгууллагын томилгоо, нутгийн захиргааны байгууллагын томилгоо. Энэ хоёрын харьцааг Төрийн албаны зөвлөл саяын тайланд Улсын Их Хуралд орсон саналдаа тавьж байгаа.

Ер нь орон нутгийн захиргааг бэхжүүлэхийн тулд орон нутагт байгаа агентлагийн төлөөлөл, нутгийн захиргааны Тамгын газрын ажилтнуудыг ер нь орон нутгаасаа томилдог. Төв байгууллагууд нь мэргэжил, арга зүйн үйл ажиллагааныхаа чиглэлээр хариуцаж явдаг ийм тогтолцоонд шилжихгүй бол энэ хоёрдмол байдал орон нутагт засаглалын хоёрдмол байдал, чиг үүргийг нь ч бас хоёрдмол байдал үүсгэж байна гэдгийг Засгийн газарт тавьж байгаа. Засгийн газар энэ чиглэлээр бас санал хүлээж авч ирэх төсвийн жилээс бас харж үзье гэсэн санал байгаа.

Гуравт, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний ангиллын харьцааны тухай ярьж байна.

Ях аргагүй байгаль хамгаалагч, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн салбар, эрүүл мэндийн салбар, ер нь олон салбарт салбарын хуулиуд дээрээ тухайн албан тушаалыг төрийн захиргааны байна гэсэн зохицуулалт хийчихсэн учраас Төрийн албаны зөвлөл хуулиа хэрэгжүүлэх үүднээс ингэж явж байгаа.

Төрийн албаны зөвлөлийн байр суурь бол байгаль хамгаалагч, мал эмнэлгийн мэргэжилтнүүдийг ТҮ-гийн

ангилалд оруулж өгөөч ээ гэдэг. Салбарт нь ч асуудал тавьж байгаа. Өнгөрсөн удаагийн тайлан мэдээнд ч бас асуудал тавьж байгаа. Энэ ангиллыг бас эргэж харах шаардлагатай байна гэдэг.

Энэ бол хууль эрх зүйн хүрээнд шийдэгдвэл Төрийн албаны зөвлөл үүнийг хүлээж аваад хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Ийм ч саналтай байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Идэрбат: Би төрийн албан хаагчдын тэр цалингийн асуудал дээр бас нэг хариулт авмаар байгаа юм.

Яг асуудал дээр Төрийн албаны зөвлөл ер нь ямархуу байр суурьтай байдаг юм бэ? Ийм маш их хэлбэлзэлтэй, маш их ялгасан салгасан ийм цалингийн сүлжээ яваад байна.

Хоёрдугаарт, саяын босоо томилгоотой, хэвтээ томилгоотой гэдэг асуудал маань сая орон нутгийн нэмэгдэл гээд ярихаар дахиад л нэг төвөгтэй байдал үүсгэж байгаа юм.

Тэгэхээр ер нь төрийн албаны асуудлыг бид бүр цогцоор нь авч үзээд хэнд ч ойлгомжтой болгомоор байгаа юм. Одоо төрийн албан хаагчдаас хүнд нөхцөлийн асуудлууд ярьж байна. Сая тойргоор Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгаар нийгмийн даатгалын хууль яриад л явахад цэцэрлэгийн багш нар бид хүнд нөхцөл рүү ормоор байна гэдэг ийм зүйлүүдийг ярьж эхэлж байгаа юм. Яагаад гэвэл би эмээ гэж дуудуулмааргүй байна гээд бүр тойрог дээр надад нэг багш ярьж байсан. Тийм.

Тэгэхээр ер нь ингээд бид төрийн албан хаагчдынхаа тэр ажиллах орчин нөхцөл нь ямар байгаа юм, аль нь хүнд нөхцөлд орж байгаа юм. Энэ болгоныг бас нэг ялгаж салгаж.../минут дуусав/

Г.Занданшатар: 83. Самдангийн Цэдэндамба гишүүн хариулъя.

С.Цэдэндамба: Уучлаарай. Би түүрүүн асуултад бас хариулаагүй үлдээсэн байна.

Цалин хөлсний асуудал яах аргагүй анхаарлын төвд байгаа.

Хуулиар цалин хөлсийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцаж байгаа. Сангийн яам тэндээс гарч ирсэн тооцоон дээр тулгуурлаж төсвийг баталж байгаа.

Төрийн албаны зөвлөл мөн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллын асуудлаар цогц саналыг 2022 оны төсөв өргөн барих үед Засгийн газарт тавьсан.

Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэх саналаа холбогдох яам, Засгийн газарт тавьж ажилласан. Яах аргагүй 2022 оны 12 сар хүртэлх мөрдөж байсан сүлжээгээр орон нутгийн төрийн албан.../минут дуусав/

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Төрийн албаны зөвлөлийн тайлан хэлэлцэж байна л даа. Сонсож байна.

Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хийсэн, түүний зөрчил дутагдал гээд иймэрхүү мэдээллүүд. Нэг байдаг л тайлан байна.

Төрийн албаны зөвлөл ер нь Монголын төрийн алба гэдэг чинь өөрөө асар их том. Үүний цаана нөгөө талд нь асар их том асуудал илэрч байдаг ийм л зүйл. Тэр нь авлига. Авлига гэдэг чинь өөрөө эрх мэдэл бүхий хүмүүс авлигатай холбогддог. Тэр эрх мэдэл бүхий хүмүүс хэн бэ. Төрийн албанд ажиллагсад, шат шатад ажиллагсад.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл болоод ер нь Монголын төрийн албаны тогтолцооны ажлын хэмжүүр авлигын үзүүлэлт байх ёстой болж таарч байна. Гэтэл авлигын үзүүлэлтээр бид яг ямар түвшинд, хаана яваа вэ? Зөвхөн өнгөрсөн жил **“Трансперенси Интернэйшнл”** байгууллагын судалгаа саяхан танилцуулагдаж байсан. 16 байраар хойш ухарсан ч билүү. Энэ чинь шат шатны төрийн албаны авлигатай холбоотой зүйл гэж энд харагдаж байгаа байх.

Тэгвэл энэ тоо сая та нарын өгсөн тайлан тооноос ингээд харьцуулахад 2021 оны та нарын өгсөн тайлангаар төрийн албанд 208 мянган хүн ажиллаж байж. 2022 оны дүнгээр 225 мянган гэж байна. Зөвхөн өнгөрсөн нэг жилийн дотор 20-иод мянган хүн, төрийн хаагч нэмэгдэж. Нэг жилийн дотор. Та нарын л өгсөн тайлан. 208-аас 225 буюу 18 мянга орчим төрийн албан хаагч нэг жилийн дотор нэмэгдэж. 2017 оноос харьцуулах юм бол 30 орчим мянган төрийн албан хаагч нэмэгдэж.

Тэгэхээр энэ их төрийн албан хаагч нэмэгдээд байгаагийн чинь цаана нөгөө талд нь тэр авлига гэдэг зүйл чинь ингэж илэрч гарч ирээд байгаа юм биш биз дээ.

Бүр том тоо харах юм бол дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа төсөв буюу төрийн зарцуулж байгаа зардал зөвхөн сүүлийн арван жилд

27-оос 37 гэдэг хувь руу очиж байгаа. Саяын тэр 225 мянган төрийн албан хаагчийн зарцуулж байгаа мөнгө чинь жилээс жилд сүүлийн арван жилд хэд дахин нэмэгдчихсэн.

Тэгэхээр зөвхөн нэг тайлан төдий яриа биш. Энэ төрийн албаны үйл ажиллагаа, сая та нарын гаргаж байгаа санал, олон зүйл дотор чинь энэ бодлогын асуудал, бодлогын шийдэл, тэр тусмаа тэр авлига гэдэг том үйл ажиллагааны хэмжүүртэй холбоотой олон зүйлүүдийг бид ярих шаардлагатай болчихож байна л даа.

Тэгэхээр ёс төдий нэг асуулт л асуух юм даа. Зөвхөн нэг жилийн дотор наад төрийн алба чинь 10 хувиар данхайчихсан байна шүү дээ. Зөвхөн нэг жилийн дотор. Би буруу хараагүй бол та нарын тэр тоонуудыг яг ийм дүн алга. Энэ тоонуудыг нэмж хасаж үзлээ. Нэг жилийн дотор 18 мянган төрийн албан хаагч нэмэгдсэн байна.

18 мянган төрийн албан хаагч нэмэгдэхээр төсөв, төлөвлөгөө нь нэмэгдэж байдаг. Дахиад дээрээс нь үүнийг дагасан баахан хүний асуудал, шалгалт. Үүнийг дагасан баахан хяналт. Үүнийг дагасан баахан хуулийн зөрчил чинь гарч л таарна шүү дээ. Баахан хуулийн зөрчил гарч л таарна.

Тэгээд өөрөө өөртөө ажил бий болгосон нь ийм л систем энэ улс оронд бий болчихоод тэгээд хуримтлагдсан асуудлуудаа шийдэж байгаа нэртэй дахиад л. Яг үндсэндээ авлигын эсрэг тэмцэл ч гэсэн зүгээр л нэг тийм төрийн алба нь жилд 20 мянгаар нэмэгдэж байдаг. Эдийн засагт эзэлж байгаа төрийн өмчийн эзэлж байгаа хэмжээ нь хэдэн арав дахин нэмэгдэж байдаг. Тэгээд нөгөө талд нь авлигатай тэмцээд байна гэдэг чинь зүгээр л агуулгын биш нэг ийм

хэлбэрдсэн тэмцэл яваад байна гэдэг ийм л утга санаа цаана нь харагдаад байгаа юм л даа.

Г.Занданшатар: 82. Должингийн Баатарсайхан.

Д.Баатарсайхан: О.Цогтгэрэл гишүүний асуултад Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан би хариулъя.

Авлигын асуудал үнэхээр хурц байгаа нь үнэн. 2012 оноос хамгийн багадаа 35 оноогоор дүгнэдэг олон улсын үзүүлэлтийн үнэлгээн дотор манай улс хамгийн сүүлчийн буюу 35 оноогоор үнэлэгдээд л явж байгаа энэ байдал нь байгаа.

Тэгээд авлигын асуудал гэхээр ганц мөнгө төгрөгийн асуудал биш. Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан асуудал ороод явж байгаа.

Тэгэхээр төсвийн шууд захирагч буюу томилгоо хийж байгаа албан хаагчидтай төрийн албан хаагчийг, ажилтныг албан тушаалд томилохдоо холбогдох хуулийн зохицуулалтаар нь сонгон шалгаруулалтаар нь байдаг юм уу, албан тушаалын тодорхойлолт, чиг үүргийн шаардлага хангасан байдлаар нь томилгоо хийгээч ээ гэдэг зүйл явж байгаа.

Саяын тайлан дотор тавигдсан хүний нөөцийн томилгоотой үзсэн шалгаруулалтын дотроос албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангахгүй байгаа хүмүүс нэлээн байсан. Үүний нэг хэсэг нь КОВИД-ын хуулийн үйлчлэлийн үед, энэ цаг хугацааны үед хийгдсэн томилгоонууд дийлэнх нь байсан юм. Энэ дээр Төрийн албаны зөвлөл нэлээн анхаарал тавиад ажиллаж байгаа.

Шаардлага хүргүүлсэн байгаа. Мэдэгдлийг гаргасан байгаа. 411 гээд төрийн албан хаагчдын дунд нэлээн анхаарал татсан ийм тогтоол гаргаж хүртэл хэрэгжилтийг нь хангуулж ажилласан зүйлүүд байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: 83. Самдангийн Цэдэндамба.

С.Цэдэндамба: О.Цогтгэрэл гишүүний төрийн албан хаагчдын тоо нэмэгдсэн талаарх мэдээлэлд товч хариу өгье.

Яах аргагүй төрийн нийт албан хаагчдын тоо өнгөрсөн оныхоос 17 мянга 700-аар нэмэгдсэн нь үнэн. Үүний 16 мянга 659 нь ерөөсөө төрийн үйлчилгээний салбарын албан хаагчид нэмэгдсэн байгаа. Энэ бол яах аргагүй энэ онд байгуулагдсан, шинээр байгуулагдсан цэцэрлэг, сургууль, соёл, эрүүл мэндийн чиглэлийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой байна гэдэг тоон мэдээ гаргасан.

Харин улс төрийн албан тушаал 400-аар хорогдсон байгаа нь зөв эхэллээ гэдгийг харж байгаа.

Төрийн захиргаанд 998 хүн орон тоо шинээр нэмэгдсэн. Энэ бол яам байгуулагдсан. 2 агентлаг шинээр байгуулагдсан. Үүнийг дагаад орон нутагт бас тэр агентлагийн салбарууд бий болсонтой холбоотой. Ийм үндэслэл байсан гэдгийг нэмж хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтцэрэл: Ямар ч байсан төр нэг гараараа авлигатай тэмцэж байна гэж сэлэм сугалаад байдаг. Нөгөө гараараа

төрийн албан хаагч нь хэдэн арван мянгаараа. Төсөвт эзэлж байгаа зардал нь хэдэн их наядаар нэмэгдээд байдаг. Энэ хоёр яалт ч үгүй тэр ам ажлын зөрүү энэ дээр харагдаад байна. Бодлого хэрэгжилтийн зөрүү энэ дээр харагдаад байна гэдэг л байр суурьтай байгаа.

Дахиж тодруулах шаардлагатай нэг зүйл нь, Монгол Улс чинь цахим үндэстэн болж байна, цахим төрийн алба болж байна. Бүх л зүйл цахимжаад л. Цахимжина гэдэг чинь технологи ашиглана. Баахан хөрөнгө оруулалт орж байгаа. Энд хөдөлмөр, хүч хэмнэнэ, бүтээмж нэмэгдэнэ гэдэг зүйл үүний цаана байх ёстой.

Цахимжаад байдаг e-mongolia болоод байдаг, цахим үндэстэн болоод байдаг. Тэр цахимжилт гэдэг зүйлийн үр дүн ер нь Монгол Улсад байгаа юм уу? Энэ төрийн албанд байгаа юм уу?

Жилд хэдэн арван мянгаараа нэмээд байдаг юм бол цахимжиж яг яах юм. Тэнд мөнгө тавьж яг яах юм. Тэр ажлын үр дүн нь яг хаана яваа юм бол. Төрийн албанд яг талаар.../минут дуусав/

Г.Занданшатар: 88. Ганбаатарын Билгүүн, ажлын албаны дарга.

Г.Билгүүн: Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Түрүүн таны асуусан нэмэлт асуулт дээр тодорхой тоо хэлчихье. Тайлант онд буюу 2022 онд улсын хэмжээнд 70 байгууллага шинээр байгуулагдсан байна.

Үүний задаргааг танд танилцуулах юм бол 17 цэцэрлэг, 11 сургууль, 4 эмнэлэг, 1 шинжлэх ухааны хүрээлэн, 4

соёлын төв, 2 яам, 2 агентлаг, төрийн захиргааны 31 байгууллага гээд нийтдээ 70 байгууллага шинээр байгуулагдсан нь төрийн албан хаагчдын тооны өсөлтөд нөлөөлсөн.

Эдгээрийн дийлэнх нь буюу 90 гаруй хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалтан байгаа.

Энэ яагаад төрийн байгууллагууд нэмэгдээд байна вэ гэхээр өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн орчинтой холбоотой. Агентлаг байгуулахыг Засгийн газар шийддэг. Баг, хороо.../минут дуусав/

Г.Занданшатар: 88. Гүйцээгээд хариулчихъя. Г.Билгүүн.

Г.Билгүүн: Цахимжуулах асуудал явагдаж байгаа. Энэ бол шинэ тутам асуудал.

Харьцангуй сайн явж байгаа хэдий ч яг бодитоор цахимжсанаар өнөөдрийн байдлаар тэдэн орон тоо хэмнэх боломж гарсан гэдэг тооцоо судалгаа улсын хэмжээнд нэгтгэгдэж гараагүй байна.

Г.Занданшатар: Цахимжаалд л чухам өчнөөн орон тоо хэмнэнэ гээд байсан чинь яг тэр тооцоо судалгаа байдаггүй юм байна шүү дээ. Цахимжилтын жил гээд. Төрийн албаны цахимжилтын жил гээд байгаа биз дээ? Та хэд чинь.

Батгөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Бид Төрийн албаны зөвлөлийн тайлан гэхээсээ илүү Монгол төрийн албаны 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж байгаа юм. Энэ бол КОВИД-ын үеийн төрийн албаны тайлан гэсэн үг.

Тэгэхээр КОВИД-ын үед төрийн албыг бид нэлээн цалинтай чөлөөтэйгөөр ажиллуулсан. Дийлэнх нь цахимаар ажилласан. Гол ачааны хүндийг цагдаа, онцгой байдал, эмч, сувилагч нар үүрч давж гарсан.

Тэгээд цахимаар хуралдаад, чөлөөтэй ажиллаад, хагас байдлаар ажиллаад байхад яагаад төрийн алба ийм том болчхов гэдэг асуултыг гишүүд асуугаад байна л даа.

Саяхан арав хүрэхгүй жилийн өмнө 140 мянган хүний хүрээнд төрийн алба эргэлддэг байсан шүү дээ. Одоо ингээд хоёр зуун хэд болчхож байгаа юм. 240 болчхож байгаа юм уу. Бараг 100 мянгаар нэмэгдчихэж байгаа юм уу.

Тэгэхээр хурдаар маш том нэг ийм сигнал өгөөд байна. Ерөөсөө Монгол төр гэдэг ганц ажил олгогч болж хувирах нь байна гэдэг сигнал өгч байна. Тэгээд бүх хүн нь төрд ажилладаг улс гэвэл мэдэхгүй. Ийм цэргийн дэглэмтэй улс ийм байж магадгүй. Социалист дэглэмтэй ийм улс л бүх ажил олгогч нь ганцхан төр байдаг ийм улс байх л даа.

Тэгэхээр хувийн хэвшил, чөлөөт эдийн засаг, бие дааж ажиллах энэ бүх юмуудыг хумьж байна гэсэн үг л дээ. Нөгөө талаараа.

Тэгэхээр энэ дээр Төрийн албаны зөвлөл нэгдүгээрт ямар дүгнэлт өгч байгаа вэ? КОВИД-ын үед түр томилгооны асуудал ер нь ямар болов? Үүнийг цэгцлэх дээр ямар бодлого барьж байна вэ гэсэн эхний асуулт байгаа юм.

Хоёрдугаарт, бид төрд ажиллаж байгаа төрийн мэргэшсэн жинхэнэ албан хаагчид руугаа их чичилж бас яримааргүй байгаа юм. Энэ хүмүүсийн бас буруу биш. Хавтгайруулаад л.

Тухайлбал, сая Хөгжлийн банкны сонсгол дээр энэ хяналт шалгалтын энэ олон зүйлүүдийг 9 төрийн жинхэнэ мэргэшсэн албан хаагчийн шударга бөгөөд ур чадвартай, мэргэшсэн ийм албан хаагчдын хүчээр илрүүлж парламентын сонсгол хийгдсэн.

Монгол төрд чадалтай, хүсэлтэй залуучууд бас байна. Энэ хүмүүсийн урмыг хугалж болохгүй шүү. Нэг л асуудал байна. Шударга биш байна. Яг ажил хийдэг, ачаа үүрүүлдэг хэдхэн хүндээ ачаа үүрүүлээд. Зарим нь ажлаа хийхгүй байсан ч гэсэн цалингаа аваад яваад байдагт төрийн албан хаагчид өөрсдөө сэтгэл дундуур байна. Сэтгэл дундуур байна.

Тэгэхээр энэ дээр ер нь залруулах чиглэлд ямар бодлогын өөрчлөлт хийгдэх шаардлагатай гэж Төрийн албаны зөвлөл үзэж дүгнэж байгаа вэ гэсэн хоёр дахь асуулт байна.

Г.Занданшатар: 85. Ц.Амартөгс. Цэнддаваагийн Амартөгс.

Ц.Амартөгс: Ц.Амартөгс. Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Бодлогын хувьд төрийн албаны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлээд бодлогын хувьд ямар шилжилт хийх вэ гэдэг энэ зүйл дээр Төрийн албаны зөвлөл хэд хэдэн чиглэлийг анхаарч авч үзэж байна. Тухайлбал, өнөөдөр төрийн албан хаагчдын тоо дунджаар ажиллах хүчний 17 орчим хувь байна.

Тэгэхээр энэ дээр нэгдүгээрт бид төрийн албандаа өнөөгийн түвшинд ангилагдаж байгаа албан хаагчдын ангиллыг яаж оновчтой тодорхойлох вэ гэдэг асуудал байна. Төрийн захиргааны болон жинхэнэ албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчид.

Концепцын хувьд төрийн үйлчилгээ хүртээмжтэй байх гэдэг агуулгаар төрийн үйлчилгээний байгууллага салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд ялангуяа хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх бодлогыг барьж тоо хэмжээг цөөрүүлэх, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх бодлогыг баримталж байна.

Төрийн албан хаагчдын хувьд КОВИД-ын хугацаанд нийт 1196 зөрчилтэй томилгоо, шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилт хангаагүй байсан гэдгийг илрүүлсэн.

Одоогоор 491 шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавиад ажиллаж байна.

Цаашдаа төрийн албаны хуулийг мөрдөх зайлшгүй шаардлагыг тавьж ажиллана гэдгийг хэлье.

Шударга байдлын тухайд яалт ч үгүй төрийн албан хаагчдын дунд асуусан асуулга дээр цалин хөлсний асуудал, нийгмийн баталгаа хангахтай холбоотой асуудал дээр шударга, тэгш бус байдал бий болоод байна. Үүнийг арилгаж өгөөч ээ. Ингэх юм бол бид цаашдаа тууштай ажиллах бололцоо нөхцөл байна гэдэг энэ зүйлийг бид тодорхойлж харсан байгаа.

Тэгэхээр КОВИД-ын хугацаанаас хойш гарсан 20 орчим хувийн хэрэгжсэн нь ялангуяа шинэ залуучуудад ажлаасаа гарах хандлага ажиглагдсан учир цалин хөлсний нэгдмэл тогтолцоог бий болгох, суурь цалингийн хэмжээг хангалттай болгож нийгмийн баталгааг хангах нэг талаас. Нөгөө талаас бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр түрүүн хэлсэн яг чиг үүргийн шинжилгээг бид байгууллага

болгон дээр хийх ёстой. Ингэж чиг үүргийн шинжилгээ хийснээр цахимжилтаас үүссэн хэмнэгдэх боломжтой ажил, үүргүүд. Нөгөө талаар хууль тогтоомжийн давхардал, хийдлийн улмаас бий болсон орон тоо байгаа эсэх. Мөн цаашдаа сайжруулж болох, нягтруулж болох ажил, үүргүүдийг байгууллага, салбар бүрээр гаргаад тоог бууруулах. Эхний ээлжид тоог нэмэхгүй байх. Дараа нь тоог бууруулах. Улмаар төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх гэсэн ийм зарчмын бодлогын шинэтгэлүүдийг хийнэ гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ш.Адьяаа гишүүн байж байгаарай. Энэ хариулт дуусаагүй байгаа юм байна. Гүйцээж хариулах хүн бий юу? 83. Самдангийн Цэдэндамба гишүүн хариулна.

С.Цэдэндамба: Б.Энхбаяр гишүүн чухал асуудлыг хөндлөө.

Төрийн албан хаагчдын тоо болон төрийн байгууллагын тоо нэмэгдэж томорч байгаа нь юутай холбоотой вэ гэж. Үүнийг хоёр хэсэгт харж болно. Нэг нь үйлчилгээний чиглэлээр яах аргагүй үйлчилгээг иргэдэд хүргэх үүднээс сургууль, цэцэрлэг, эмнэлэг нэмэгдэж байгаа.

Хоёр дахь нь, Улсын Их Хурлаар тодорхой салбарын харилцааг зохицуулсан хуулиуд батлагдах бүрт түүнийг дагасан захиргааны нэгж байгуулах. Орон тоо батлах ийм зүйлүүд явагдаад байдаг.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл нэгэнт хуулиар баталсан орон тоонд

ажиллах зөвшөөрлийг нь өгөх үүрэгтэй учраас ингэж явж байгаа. Сүүлийн хоёр жил яам, агентлаг, тэгээд түүний салбар орон нутаг дахь нэгжүүд яах аргагүй ингээд нэмэгдэж байгаа.

Тэгэхээр үүнийг ер нь цаашдаа эрх зүйн бодлогын хүрээнд бас анхаарч зохицуулах шаардлагатай асуудал гэдгийг Төрийн албаны зөвлөл хүлээн зөвшөөрч байгаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Энхбаяр: Тэгэхээр сүүлийн үед “нюу женерэйшн” гэж ярьж байгаа. Шинэ цаг үеийнхний сэтгэлгээний онцлогийг харгалзсан бодлогуудыг улс орон даяар, ялангуяа хувийн хэвшлийн компаниуд барьж ажиллаж байна.

Шинэ үеийнхнийг загнаж зандрах байдлаар биш, илүү урамшуулж, хамтарч байж үр дүн гарч байгаа хандлага байна. Энэ хандлага ч гэсэн манай төрийн албанд ажиглагдаж байгаа. Хүний эрхийн мэдрэмж огт өөр байгаа.

Үг дуулах, хатуу үг сонсох байдал өөр байгаа. Бусдын чөлөөтэй байгаа хүний ажлыг орлож нэмэгдэл урамшуулалгүйгээр хийж гүйцэтгэх гэдгийг тэр үеийнхэн ойлгохгүй байгаа. Өөрийнхөө ажлыг л хийх ёстой.

Энэ дээр ер нь Төрийн албаны зөвлөл ямар бодлого барьж байгаа юм?

Г.Занданшатар: 85. Цэнддаваагийн Амартөгс гишүүн хариулъя.

Ц.Амартөгс: Тодруулж хариулъя.

Шинэ цаг үеийн буюу залуучуудын ажиллах хэв маяг, багаар ажиллах болон бусад ажил үүргийг гүйцэтгэх хэлбэр өөрчлөгдөж байгаа.

Тэгэхээр үүнтэйгээ уялдуулаад өнгөрсөн жил хийгдсэн Хөдөлмөрийн тухай хуулийн концепцыг төрийн албанд нэвтрүүлэх боломж бололцоог бид цаашдаа харах ёстой гэсэн байр суурьтай байна.

Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр зайнаас болон бүрэн бус цагаар ажиллах, цагийн ажил, хөдөлмөр эрхлэх, job sharing болон ажил үүргээ хувааж хийх ч гэдэг юм уу, яг тухайн ажил үүргүүдийг тодорхой цаг хугацаанд хийх боломж, нөхцөлөөр хангаад тэр ажил үүргүүдийг хэрхэн яаж тэгш, зохистой хуваарилах вэ гэдэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийнх нь хувьд өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зүйлүүд ажиглагдаад байгаа.

Мөн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхдээ өөр өөр онцлог шинж байдалтай.../минут дуусав/

Г.Занданшатар: 85. Гүйцээгээд хариулчихъя. Товч тодорхой хариулъя.

Ц.Амартөгс: Өөр шинж байдалтай бүлгүүдийн харьцааг хэт их хэлбийлгэлгүй хүний нөөцөө бүрдүүлэх гэдэг их чухал асуудал болоод байгаа. Зарим салбар дээр хэт хүйсийн давамгайлал бий болсноос үүсэх харилцааны болоод бусад тулгамдаж байгаа асуудлуудыг нь тодорхойлсон байгаа.

Тийм учраас хүний нөөцийн бүрдүүлэлт дээр бодлогын өөрчлөлт хийх. Мөн хэв шинж, хөдөлмөр эрхлэлтийн байдал, үнэлгээ, ажлын

хуваарилалтыг шинэчлэх гэсэн бодлогуудыг хэрэгжүүлнэ.

Г.Занданшатар: 84.
Б.Баатарзориг дарга хариулъя.

Б.Баатарзориг: Эрхэм гишүүн Б.Энхбаяр яг концепцын зүйл асууж байна.

Эхлээд төрийн албан хаагчдын тоотой холбоотой, бүрэлдэхүүнтэй холбоотой зүйл дээр бусад орнуудтай харьцуулахад манай **civil service - төрийн алба**, **public service - нийтийн алба**. Ийм жишгүүд. Судалж байгаа зүйлүүд бий.

Япон, Солонгос, зарим орнууд суурь үйлчилгээгээ арай өөр нэршлээр авч үзээд, тэгээд нийгмийн баталгааг нь өнөөдрөөс илүү хувилбараар тавьсан тохиолдлууд байдаг.

Яг энэ утгаараа авч үзвэл “**төрийн жинхэнэ алба**”, “**төрийн тусгай алба**”. Энэ дотроо төрийн захиргааны албаа оруулахад л 69 мянган хүн л яг “төрийн албан хаагч” гэдгээр нэрлэгдээд явах ийм нэг хувилбар байгаа. Үүнийг би явцуу утгаар хэлж байна. Цаашаагаа ийм.../минут дуусав/

Г.Занданшатар:
Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ш.Адьяа: Өнөөдөр Улсын Их Хурал Төрийн албаны зөвлөлийн тайланг хэлэлцэж байна.

Төрийн албаны зөвлөл тайлангийн хугацаанд хийсэн хамгийн сайн зүйл бол энэ хууль бус томилгоо, цаашлаад төрийн албаны үйл ажиллагаанд оршиж байгаа бодлогын шинж чанартай асуудлууд, түүнчлэн хууль, эрх зүйн хүрээнд шинэчлэх тийм бичиг баримтуудын

тухай бас бодитой санал оруулж ирсэнд би талархалтай байгаа.

Төрийн албаны зөвлөлийн өнөөдрийн илрүүлсэн төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага, бодлогын хүрээний асуудлыг хэрэгжүүлэхэд төрийн эрх барих дээд байгууллага, Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллага энд хариуцлагатай ажиллах ёстой.

Өнөөдөр алдаа дутагдал, сахилга, хариуцлага илрүүлээд байдаг. Тэр нь илэрч засагддаггүй, амь бөхтэй оршоод байгаа нь өнөөдрийн манай төрийн байгууллага, ялангуяа яам, Тамгын газар, түүнчлэн орон нутгийн засаг захиргааны байгууллагад өнөөдөр амь бөхтэй оршиж байна.

Одоо өнөөдөр Ховд аймгийн тухайд би хоёр жишээ ярьж. Өнөөдөр ёс зүйгүй байдал гаргаж архи дан согтуурч өөрийнхөө иргэнийг зодсон Манхан сумын Засаг дарга гээд нөхөр би үүнийг согтуудаа хоёр удаа алгадчихсан юм гээд. Нөгөө хүнээ нэвширтэл зодчихоод их баяр бахдалтайгаар зурагтаар ярьж байсныг харсан.

Гэтэл өнөөдөр тэр хүнд ямар ч хариуцлага тооцохгүй байж байна. Түүнчлэн өнөөдөр төрийн албаны асуудал хариуцсан хүмүүс орон нутагт тендер, бусад төрийн байгууллагын үйл ажиллагааг ашиглаж хариуцлагагүй, бусадтай хуйвалдаж авлигал авдаг. Түүнчлэн барилга, объектыг хууль бусаар хүлээж авдаг ийм юм амь бөхтэй байгаа. Ховд аймгийн тухайд.

Гэтэл үүнийг хариуцаж байсан хэлтсийн дарга нөхөр хариуцлага хүлээх ёстой байтал өнөөдөр Тамгын дарга болоод дэвшээд ажиллаж байна. Энэ чинь одоо энэ Засгийн газарт ямар бодлого

байна аа? Ийм хүмүүстэйгээ бид хариуцлага ярья гэдэг, сахилга ярья гэдэг. Ерөнхий сайдад би танилцуулга бичиж өгсөн. Гэтэл одоог хүртэл надад хариу ирээгүй байгаа. Энэ баримттай асуудал байгаа.

Өнөөдөр ийм байдлаар бид төрийн алба, ёс зүй, сахилга хариуцлага яриад яах юм бэ. Хоосон шинж чанартай юм болж байна шүү дээ. Өнөөдөр төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын асуудал, гэм буруутай хүнд тооцох асуудал өнөөдөр Засгийн газрын “Таван Ш” хөтөлбөр чинь зүгээр замхарч байна шүү дээ. Үүнийг би хариуцлагатай ярьж байгаа.

Ийм асуудлыг цаашдаа гаргуулахгүйн тулд ийм хариуцлага, сахилга алдсан хүмүүстэй, төрийн албан хаагчидтай хариуцлага тооцохгүй байгаа хүмүүстэй Төрийн албаны зөвлөл цаашид ямар хариуцлага тооцох вэ?

Энэ дээр хэчнээн хүнд хариуцлага тооцох асуудлыг Засгийн газар, яам, орон нутгийн засаг захиргаанд өгсөн бэ? Энэ талаар мэдээлэл байна уу?

Цаашид ийм асуудал гарсан байхад асуудлыг тавьж ажиллах вэ? Ийм хариуцлагагүй, сахилгагүй, төр засгийнхаа явуулж байгаа бодлоготой, иргэддээ ингэдэг, зоддог, хутгалдаг, хариуцлага алддаг, гэмт хэрэг, авлига, албан тушаалын асуудлыг өөгшүүлдэг ийм төрийн байгууллагадаа, албан хаагч нартаа Төрийн албаны зөвлөл цаашид яаж ажиллах вэ гэдэг талаар хариулж сонсмоор байна.

Г.Занданшатар: 81.
Б.Идэрчулуун гишүүн хариулъя. Бадамцоогийн Идэрчулуун гишүүн хариулна.

Б.Идэрчулуун: Эрхэм гишүүн Ш.Адъяагийн асуултад хариулъя.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар албан ёсны байсан. Гэтэл оны зааг дээр, өмнөх нь Тамгын газрын даргаа чөлөөлөөд оронд нь хууль бусаар хүн томилчихсон байгаа.

Тэгээд хуульд зааснаар Төрийн албаны зөвлөлд сонгон шалгаруулалтын сул орон тооны захиалга ирүүл гэж манайхаас албан ёсоор энэ мэдээллийг аваад бичиг явуулсан. Одоо болтол ирүүлээгүй байгаа.

Энэ дээр ажиллаж байгаа хүн нь төрийн албанд огт ажиллаж байгаагүй. Өөрийг нь хаана сонгон шалгаруулж томилох тухай ч ойлголтгүй хүн байна лээ. Үүнийг телевизээр өөрөө мэдээлэл дамжуулаад явж байсныг бид анхаараад үүний ардаас хөөцөлдөж байгаа.

Г.Занданшатар: 84.
Б.Баатарзориг дарга хариулъя. Гүйцээж хариулъя гэж байна.

Б.Баатарзориг: Сахилга хариуцлагатай холбоотой Ш.Адъяаа гишүүний асуулт байна.

04 сарын 01-нээс төрийн албаны сонгон шалгаруулалтын шинэ багц журам үйлчилж байгаа.

Өмнө нь 5 тусдаа журамтай байсан. 04 сарын 01-нээс нэг журамтай. Өмнөх журмаар тухайн байгууллагууд хууль зөрчилтэй томилгоогоо захиалга ирүүлэхгүй байхад хүлээгээд байдаг байсан. 04 сарын 01-нээс энэ байдал дээр манайх шууд өөрсдөө захиалга ирүүлэхийг хүлээхгүйгээр шийдвэрлэдэг ийм зохицуулалттай болсон.

Ийм учраас аль нэгэн аймаг дээр биш нийт зүйлүүд дээр ийм байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ.

М.Оюунчимэг: Баярлалаа. Өнөөдөр төрийн албаны 2021, 2022 оны тайланг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж байгаа нь маш чухал.

Өмнө нь Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцээд тэгээд явчихдаг байсан бол одоо ингээд нэгдсэн чуулганаар хэлэлцэж байна. Энэ нь өөрөө төрийн албыг хүчтэй, хариуцлагатай болгох дээр бас зөв, бодит мэдээллийг олон нийтэд өгөх талаасаа чухал ач холбогдолтой гэж харж байгаа.

Ер нь сүүлийн жилүүд манай олонх гишүүд ч ярьж байна. Наймаа, тохироо, гуйлга, нөлөөлөл дунд төрийн алба үнэхээр хүчгүйдэж сульдсан. Үнэн хэрэгтээ төрийн жинхэнэ албан хаагчид энэ нөлөөнд бүх нийтээр нь харлуулах ажил ч явчихсан байгаа шүү дээ.

Аливаа улс орны төрийн алба бол өөрөө маш хүчтэй байх ёстой. Иргэддээ маш шударга, шуурхай, хурдан үйлчилдэг байх ёстой. Тэр хэмжээгээр улс орны хөгжил өөрөө урагшаа явж байдаг.

Тэгэхээр манайхан нэг л бол одоо ингээд төрийн алба гэхээр баахан цүнх баригчид, эсвэл дарга дагаж гүйж даргын хаалгаар нэг цаас барьсан хүмүүс нэлээд их болсон. Гэтэл энэ хүмүүс нь яг мэргэшсэн төрийн албан хаагчдынхаа нэр хүндийг унагаагаад бүхэлдээ төр гэж нэг замбараагаа алдчихсан. Үүнийг цомхотгох хэрэгтэй. Төрийн албыг

багасгах хэрэгтэй гэсэн яриа яваад байдаг.

Гэтэл өндөр хөгжсөн Финландыг хар, Япон Улсыг хар. Төрийн алба нь өөрөө үнэхээр хүчтэй, ур чадвартай, ёс зүйтэй байдаг. Тэр хэмжээгээр ажил нь явдаг. Иргэдэд үйлчлэх үйлчилгээ нь ч шуурхай байж чаддаг.

Тийм учраас бид өнөөдөр зүгээр нэг тайлан сонсоод зогсохгүй яг дээр үндэслээд тодорхой арга хэмжээнүүдээ авах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Би өчигдөр хэлж байсан л даа. Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалтаар тухайн албан тушаал дээр хүн сонгон шалгаруулж авахдаа ямар шалгуурыг гол үндэс болгодог вэ гэдэг өөрөө их чухал. Одоо жишээ нь бусад улс орнуудад хүний нөөцийг сонгон шалгаруулахдаа энэ хүний иргэддээ хандах хандлага ямар байна, харилцаа ямар байна, ёс зүй ямар байна гэдэг шалгуур нэгдүгээрт байдаг. Гэтэл манай сонгон шалгаруулалт дээр зүгээр л тэр хүнийг унагаах юм уу, эсвэл зүгээр танин мэдэхүйн шинжтэй маш хүнд хүнд асуултууд орж ирдэг. Энэ нь өөрөө тухайн мэргэжил, салбартаа нэг их холбоотой биш байдаг. Ийм шүүмжлэлүүд бас яваад байдаг л даа.

Тэгэхээр би та бүхнээсээ асуух гэж байгаа нь одоо яг сонгон шалгаруулалт авахдаа ямар шалгуур, асуултууд та бүхний гол үндэслэл болдог вэ? Нэгдүгээрт. Энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэх байна.

Хоёр дахь зүйл нь, би бас Байнгын хорооны хурал дээр ярьж байсан. Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны тайланг дүгнээд үзэхэд ажлын байран дээрээ архидан согтуурах, эсвэл иргэдтэйгээ харьцах тэр ёс зүйн

харилцаа, хандлага тал дээрээ дутагдал нь 0.1-хэн хувиар буурсан буюу 2021 онтой харьцуулахад харин өссөн үзүүлэлттэй гарчихсан байгаа юм.

Тэгэхээр ёс зүйн алдаа, тэр хандлага, харилцаа гэдэг дээр яг ямар зөрчлүүдийг Та бүхэн маань ингэж харж байгаа вэ?

Тэгэхээр ажлын байранд архидан согтуурахыг бүр таслан зогсоох асуудлаар хууль хүртэл өнөөдөр гарчихсан байгаа. Ёс зүйн харилцаа, хандлага дээр Та бүхэн одоо жишээ нь “7:4:10” гээд сургалт, семинарууд маш их хийж байгаа гээд байгаа.

Гэхдээ маань үр дүн өгч байна уу, үгүй юү? Яагаад 2021, 2022 онтой харьцуулахад энэ үзүүлэлт өссөн дүнтэй жишээлбэл гарчихсан байгаа юм гээд.

Энэ нь өөрөө бид бас ажиллах хандлага юм уу, эсвэл ёс зүйн хороо бүх байгууллагууд дээр байна гэсэн энэ ёс зүйн хороо маань ажиллахад хангалтгүй байна уу? Үүний гол шалтгаан юу байна вэ гэдгийг би нэгд асуучихъя гэж бодож байна.

Гурав дахь зүйл нь, төрийн албанд жендэрийн баланс маш их алдагдлаа. Одоо эрүүл мэндийн салбар, боловсролын салбар гэхэд үйлчилгээний салбар тэр чигээрээ ихэнх нь бараг 70 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ дотор маш олон хүүхэдтэй өрх толгойлсон ч гэдэг юм уу, эмэгтэйчүүд давамгайлдаг.

Харин эрэгтэйчүүдийн маань хувь хэмжээ маш бага байна. Энэ нь өөрөө сөрөг үр дүн өгч байна гэдгийг өнөөдөр боловсролын салбарын эрдэмтэд, эрүүл мэндийн салбарынхан маань ярьж байна л даа. Энэ хэмжээгээр үйлчилгээний салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд

маань гэр орноо орхиод л ажилладаг. Цалин хөлс багатай байдаг. Тэгээд төрийн албаны гээд нэр хүнд нь уначихсан байгаад байдаг. Бид ингэмээргүй байна л даа.

Тийм учраас төрийн албанд жендэрийн баланс барих, гүйцэтгэл дээр хийсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: 85.
Цэнддаваагийн Амартөгс гишүүн хариулна.

Ц.Амартөгс: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгээд манай зарим нэмэлт мэдээллүүдээ өгөх гишүүд байгаа.

Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны хувьд бид өнөөдөр ерөнхий болон тусгай шалгалтыг авч байгаа. Энэ дээр хууль тогтоомжийн мэдлэг болон шаардлагатай бусад ур чадваруудын, тухайлбал зөөлөн ур чадварын элементүүд орж ирсэн байгаа.

Түрүүн асуултад хариулсан. Манай сонгон шалгаруулалтын журам 04 сарын 01-нээс шинэчлэгдэж өөрчлөгдсөн. Өөрчлөгдөхдөө зөвхөн тестээр авдаг үр дүнгээр сонгон шалгаруулалтын үр дүнг эцэслэдэг байсан бол харилцаа, хандлага, ёс зүй, зөөлөн ур чадварыг хэмжих ийм сонгон шалгаруулалтын арга зүйг нэвтрүүлээд 60 хүртэл хувьд нь ярилцлагын хандлагын илэрхийлэл, яг тухайн ажлын байрандаа оновчтой ажиллаж чадах уу, үгүй юу гэдгийг хэмжих ийм хэмжүүрийг бий болгосон байгаа.

Ёс зүйн хариуцлагыг бүрдүүлэх тухайд одоо явж байгаа Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын хуулийг боловсруулах явцад нэлээн дэлгэрэнгүй заалтууд орж байгаа. Яг ямар

шаардлагыг бид ёс зүйн хариуцлага гэж үзэх вэ, хэм хэмжээг хэрхэн яаж тогтоох вэ. Тэрийг зөрчсөн тохиолдол бүр хариуцлага үүрдэг байхаар зохицуулалтыг бүрдүүлж ажиллаж байна.

Жендэрийн балансын тухайд, ажлын ачаалал хуваарилалтын тухайд үнэхээр салбарын ялгаа, ялгамж бий болсон байна. Энэ дээр тухайлбал хуулиар хэдийгээр жендэрийн балансыг тогтоож өгсөн ч гэсэн ялангуяа бодлого боловсруулах шатанд байгаа, шийдвэр гаргах түвшинд байгаа хувь хэмжээ хүрэхгүй байна.

Үүнтэй холбоотойгоор шийдвэр гаргалтад жендэрийн мэдрэмжтэй байх асуудлыг бас нийт улсын хэмжээнд гэдэг юм уу, байгууллага үйл ажиллагааны тухайд мөрдөж ажиллах чиглэлийг гаргаад нийтлэг хэрэгжүүлж байгаа сургалтын модульдаа бид жендэрийн мэдрэмжтэй төсөв, төлөвлөлт, үйл ажиллагааны аргачлал, арга зүйг батлаад мөрдүүлээд явж байгаа гэдгийг мэдээлье.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн ахмадын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт ахмадууд Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууна. 1 минут.

М.Оюунчимэг: Нэмээд хариулчхаарай. Нэг асуултад хариулт өгсөнгүй.

Ер нь бид төрийн алба, төрд итгэх итгэлийг хэзээ ч алдаж болохгүй. Ялангуяа төрийн алба гэхээр л хүчгүй байгаа юм шиг юм уу, мэргэшсэн төрийн албан хаагч өдөр шөнөгүй ажиллаж байгаа үйлчилгээний албан хаагчиддаа бид энд дандаа хамгаалж, бас гүйцэтгэл үр дүнгээр нь цалинжуулах энэ асуудал маш их чухал байгаа шүү.

Харин төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тоог цөөлөх, төр ер нь бизнес, тендерээс аль болох хол байх чиглэлд Төрийн албаны зөвлөл хяналттай байж, үнэлэлт, дүгнэлт гаргахдаа илүү анхаарч байх нь чухал шүү гэсэн байр сууриа илэрхийлье.

Тэгээд саяын хэлээд байгаа хэд хэдэн Төрийн нарийн бичгийн дарга нарыг өнөөдөр хүртэл сонгохгүй яваад байна гээд. Гэтэл хугацаа нь болчихсон юм уу? Тэр тухайн байгууллагын ажил нь явахгүй, хариуцлага хүлээсэн нэг тийм төрийн алба бас хүчгүй байх нэг нөлөөлөл болоод байна.

Яагаад энэ томилгоонууд. Ялангуяа төрийн улс төрийн албан тушаал дээр тийм нэг наймаалцах юм уу, нөлөөлөх юм уу, тохирох зүйлүүд ер нь байж болохгүй. Ийм юмыг халъя гэдгийг ч.../минут дуусав/

Г.Занданшатар: 88. Г.Билгүүн.

Г.Билгүүн: Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн. М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Зөрчлийн тоо 0.1 хувиар буурсан байна гэж байна. Үүнийг бид харьцангуй эерэг үзүүлэлт гэж харж байгаа. Юутай холбож бид үүнийг эерэг үзүүлэлт гэж харж байна вэ гэхээр ёс зүйн зөвлөлийн

тоо нэмэгдсэнээр ёс зүйн зөрчлийн илрүүлэлт нэмэгдсэн. Өмнө нь судалгаанд ордоггүй байсан ёс зүйн зөрчлийг бид илрүүлээд бүртгэдэг болчихсон.

Дээрээс нь, төрийн албан хаагчдын тоо арван хэдэн мянгаар нэмэгдсэн мөртлөө улсын хэмжээнд гаргаж байгаа зөрчлийн тоо буурчихсан.

Тийм учраас үүнийг бидний илрүүлэлт нэмэгдсэн. Төрийн албан хаагчдын тоо нэмэгдсэн ч гэсэн зөрчил буурсан нь харьцангуй эерэг үзүүлэлт. Үүнийгээ бид бас энэ сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа үр дүнгээ өгч байна. Үүнийгээ цашид улам эрчимтэй явуулах замаар ёс зүйн зөрчлийн тоог буулгах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Дээрээс нь, нэг гол асуудал бол яг юуг ёс зүйн зөрчил гэх юм. Яг юуг.../минут дуусав/

Г.Занданшатар: 88. Гүйцээгээд хариулчихъя. Ганбаатарын Билгүүн.

Г.Билгүүн: Тав, зургаан яамны Төрийн нарийн бичгийн дарга түр орлон гүйцэтгэгч хийж байгаа.

Төрийн албаны зөвлөл дээр 2 яамны сул орон тооны захиалга ирсэн. Эрчим хүчний яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сонгон шалгаруулалтын захиалга ирсэн. Бүртгэл явагдсан.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын шалгалт уржигдар зохион байгуулагдсан. Дүн нь гарсан. Дараагийн долоо хоногийн Төрийн албаны зөвлөлийн хурлаар оруулаад нэр дэвшсэн тогтоол гаргаад Засгийн газарт хүргүүлнэ.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн сонгон шалгаруулалтад шаардлага хангасан нэр дэвшигч материалаа ирүүлээгүй.

Бусад Төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтын захиалга Төрийн албаны зөвлөлд одоогоор ирээгүй байгаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн. Содномын Чинзориг сайд, Эрүүл мэндийн сайд, Улсын Их Хурлын гишүүн нэрээ өгчхөөд алга. Нэрээ бичүүлчхээд алга болчихсон байна. Дуудъя.

Содномын Чинзориг гишүүн алга байгаа учраас алгаслаа.

Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Төрийн албаны зөвлөлийн ажлын тайланг сонслоо.

Тодорхой хэмжээнд сүүлийн жилүүдэд Төрийн албаны зөвлөл маань төрийн албыг чадваржуулах, соён гэгээрүүлэх ажилд идэвхийлэн зүтгэж байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгээд та нарын маань энэ ажил төдийлөн амархан биш. Гэхдээ Засгийн газар авлигатай тэмцэж байгаа. Улсын Их Хурал авлигат авлигын эсрэг байгаа. Төрийн албаа цэвэршүүлэх гэж байгаа энэ ажилд илүү үр бүтээлтэй ажиллах нь зайлшгүй энэ цагийн шаардлага юм гэдгийг хэлье.

Тэгээд Төрийн албаны зөвлөлд хоёр асуулт байна.

Нэгдүгээрт нь, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь зүйл, заалт байгаа. Ажилтнуудыг уян хатан цагаар

ажиллуулж, байгууллагууд хүүхэд хамгааллын бодлоготой байна гэсэн. Энэ дээр Төрийн албаны зөвлөл төрийн албыг соён гэгээрүүлэх, төрийн албан хаагчдын ар гэрт хүүхдийн үл хайхрах хүчирхийлэл, гэр бүл салалт байхгүй байхад яаж анхаарч ажиллаж байгаа вэ?

Төрийн албан хаагчдын хэдэн хувь нь өнөөдөр амралтын цагаар ажиллаж байна? Хэдэн хувь нь өнөөдөр цалингүй сунаж шөнө болтол ажиллаж байгаа вэ?

Яагаад өнөөдөр Монголын төрийн албан хаагчид олон улсын байгууллагад ажилладаг хүмүүс шиг ажлын цагтаа ажиллаад, амрах цагтаа амарч болдоггүй юм бэ?

Өнөөдөр төрийн албанд ажиллах хүмүүсийн хүсэл зоригийг нь мохоож байгаа нэг зүйл бол энэ. Хэрвээ төрийн албан хаагчдыг ажиллах цагт нь чанартай ажиллуулаад, амралтын цагт нь амраагаад, ямар нэгэн ажлынх нь чиг үүрэгт ороогүй ажлаар дарахгүй байх, хагас, бүтэн сайн өдөр дууддаггүй байх, цаг наргүй дарамталж шахалж ажиллуулдаггүй байх юм бол төрийн албан хаагчдын, энэ 200-аад мянган хүний ард үр хүүхдүүд, гэр бүл нь хамгаалагдаж амар тайван байх гээд байна.

Хэрвээ ингэж чадах юм бол төрийн албан хаагчдын цалинг тодорхой хэмжээгээр нэмснээс илүү тийм үр дүн гарч урам зориг орно гэж бодож байгаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-ыг шаардан биелүүлэх, зөвлөгөө өгөх, чиглүүлэх газар нь Төрийн албаны зөвлөл. Энэ ажил дээр Та бүхэн юу хийж байна вэ?

Хоёрдугаарт, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын даргын сонгон

шалгаруулалт өнөөдөр удаж байна. Өнөөдөр томчууд бидний, Засгийн газрын, Их Хурлын, төрийн хийж байгаа үйл ажиллагааны үр дүн үргэлж хүүхэд дээр очдог байгаа.

Бид ирээдүйнхээ төлөө, тэднийхээ аз жаргалын төлөө ажилладаг гэж ойлгож байгаа. Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар мэргэжлийн, хүүхдэд сэтгэлтэй, энэ шаардлагыг бүрэн хангасан, хүүхдэд чин сэтгэлээсээ хайртай хүнийг тэр сонгон шалгаруулалтад оруулж өгөөч ээ. Төрийн албаны зөвлөлийнхөн. Зүгээр л хоосон үг биш, шаардлага биш. Цаана нь энэ хүн үнэхээр хүүхдэд хайртай юу гэдгийг та нар маань тэр ярилцлага юмаараа сайн нягталж сонгон шалгаруулж өгөөч.

Дээрээс нь, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар хэдэн хүн яг хүүхдийн мэргэжлээр төгссөн хүмүүс байгаа юм бэ? Мэргэшсэн хүмүүс байгаа юм? Энэ агентлагт. Үүнийг та нар нэг дүн шинжилгээ хийж гаргаж өгөөч ээ.

Тэгээд энэ төр, улсын чинь хамгийн үнэт баялаг нь хүүхэд шүү дээ. Тэгээд асуултыг асуугаад тэгээд тодруулъя. Дарга аа. Баярлалаа.

Г.Занданшатар: 82. Должингийн Баатарсайхан гишүүн хариулъя.

Д.Баатарсайхан: Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан байна.

Агентлагийн дарга нар буюу тэргүүн түшмэлийн сонгон шалгаруулалт түрүүн хэллээ. Хэд хэдэн агентлагийн захиалга Төрийн албаны зөвлөл дээр ирж байгаа. Үүний нэг нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын сонгон шалгаруулалт.

Энэхүү сонгон шалгаруулалтыг хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтын шаардлагын дагуу бид ил тод, шударгаар, цахим дээрээ бодит байдлаар гаргаад явдаг энэ зарчмаасаа ухрахгүй явуулна гэсэн үг.

Өмнө нь үүрэг гүйцэтгэж байсан хүн чөлөөлөгдчихсөн байгаа. Тэгэхээр дараагийн сонгон шалгаруулалт дээр бид шударга ажиллана. Өөрөөр хэлбэл сая дүрэм, журамд өөрчлөлт орсон гэдгээ бид танилцуулсан. 60 хувь нь харилцаа, хандлага, зан үйлд нь тулгуурлаж сонгон шалгаруулах юм.

Тэгэхээр энэ дээр итгэлтэй байж болно гэдгийг илэрхийлж байна.

Дараагийнх нь нэг асуудал нь сонгон шалгаруулалтад бид мэргэжлийн холбоо, эрдэмтэн судлаачдыг татан оролцуулаад сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бололцоотой байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: 88. Г.Билгүүн.

Г.Билгүүн: Б.Баярсайхан гишүүний асуултад хариулья.

Б.Баярсайхан гишүүний нэгдүгээр асуудлаар хэлсэн саналтай Төрийн албаны зөвлөл 100 хувь санал нэг байгаа.

Ер нь ажлын бус цагаар амралтын өдрүүдээр ажиллуулахыг сүүлийн үед ажлын байрны дарамт гэж үзэх болсон.

Дээрээс нь, сүүлийн үеийн менежментийн шинэ шинжлэх ухаанд цагийн менежмент гэхээсээ илүүтэй сэтгэл зүйн менежментийг онцолдог болсон. Сүүлд Харвардын хийсэн судалгаагаар ч гэсэн ажилтан, албан хаагчдын гэр бүлтэйгээ өдөр тутам өнгөрүүлэх цагийг нэгхэн цагаар

нэмэгдүүлэхэд тухайн хүний хөдөлмөрийн бүтээмж 30 хувиар нэмэгддэг гэсэн ийм судалгаа гарчихсан.

Тэгэхээр юуг хэлж байна вэ гэхээр ажил дээрээ олон цагийг өнгөрөөхдөө гол нь биш бүтээмжээ сайжруулах. Бүтээмжээ сайжруулахын тулд гэр бүлдээ цаг гаргах. Бусад өөрийнхөө сонирхдог зүйлдээ цаг гаргах. Энэ асуудлыг Төрийн албаны зөвлөл 100 хувь дэмжиж байгаа.

Дээрээс нь, уян хатан цагийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Энэ нь хэдийгээр Хөдөлмөрийн хуулиар долоо хоногт 40 цаг гэж байгаа боловч ядаж ажилдаа ирэх, тарах цаг дээр зохицуулалт хийснээр бид энэ агаарын бохирдолтой тэмцэхэд ч гэсэн, замын хөдөлгөөний ачааллыг бууруулахад ч гэсэн хувь нэмэр оруулна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас Төрийн албаны зөвлөл цаашдаа энэ талаар зөвлөмж, зөвлөгөө гаргаж анхаарч ажиллах болно гэдгийг илэрхийлнэ.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Баярсайхан: Монгол Улсын Ерөнхий сайд хуулийн хэрэгжилтэд их онцгой ач холбогдол өгч байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайдын ахалдаг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Та бүхний томилох гэж байгаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын дарга нь байдаг.

Тэгэхээр сонгон шалгаруулалтыг даруйхан явуулж, тэр хуульд заасан шаардлага гэхээсээ илүү яг үнэхээр

хүүхдүүдийн чиглэлээр мэргэшсэн нэгдүгээрт хүн байна уу?

Хоёрдугаарт, хүүхдэд чин сэтгэлээсээ хайртай хүн байна уу гэдэг дээр анхаарч өгөөч.

Тэгээд Г.Билгүүн дарга аа, Та бүхэн хэрэгжүүлэхээс гадна Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас байгууллагуудад бас зөвлөмж гарах ёстой юм.

Тэгэхээр та нар маань хамтран ажиллаад хууль хэрэгжээд жил гаран болж байна, жил хагас болж байна. Энэ хуулийн хэрэгжилтийг ялангуяа төрийн албан дээр хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдол өгөөч ээ. Тэгээд энэ дээр гишүүн би бас дэмжиж ажиллах болно. Энэ бол маш чухал ажил шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Цаг бага байна. Аасуух асуулт маш олон байна. Тэгээд асуухыг хичээе.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд манай төрийн алба маш хүнд явж ирсэн. Яг үнэнийг хэлэхэд өнөөдөр бодит нөхцөл байдал, улс төрийн намын, танил талын, ах дүүсийн, бүлэг, фракцын, ураг төрлийн ийм л сүлжээн дээр тулгуурлаж явж ирсэн. Нөхцөл байдал.

Одоо энэ зарчмаас Та бүхэн мэдэхүйн, чадахуйн зарчимд суурилуулах гээд ингээд төрийн албаны шинэчлэлийг хийх гээд зүтгэж байгаа юм. Энэ зарчимд шилжихэд цаг хугацаа шаардлагатай. Та бүхэн маш олон хүндрэл бэрхшээлүүдтэй тулж байгааг ойлгож байгаа.

Та бүхэн рүү Улсын Их Хурлын гишүүн, сайд нар, Төрийн нарийн, ах дүү, найз нөхөд, бүлэг, фракцынхан ярьж, утасддаг юмнууд зөндөө бий.

Тийм учраас би нэг дэх асуултаа юу гэж асуух гэж байна вэ гэхээр Төрийн албаны зөвлөл бие даасан хараат бус байдлаараа ажиллаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг нэгд асууя.

Хоёрт, төрийн алба өнөөдөр үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг бужигнаж байна. Төрийн албан хаагч нар маань. Энд ч одоо нэг төрийн албаны сонгон шалгаруулалт, ерөнхий шалгалт, тусгай шалгалтдаа ороогүй. Чөлөөл гээд албан тоот юмнууд дээр доороос ирээд. Энд ч мэргэжлийн хяналтын албыг татан буулгана, өөрчилнө гээд. Энд ч төрийн албаны “Шүүр” ажиллагаа явагдаж байна гээд бүх хяналт, шалгалтууд хийгдээд бүх шатдаа.

Эерэг талаас нь харвал энэ сайн. Өнгөрсөн хугацааны болж бүтэхгүй, улс төрийн томилгоогоор томилогдсон нөхдүүд дээр янз бүрийн арга саамаар хаацайлсан нөхдүүдийг ил болгох ажиллагаа. Нөгөө талаар цаашдаа тогтвортой байсан төрийн албыг хэвийн байдалд нь оруулахад бас нэлээд асуудал үүсэж байна. Нэлээд төрийн албан хаагч нар чинь айдастай хүйдэстэй, авдаг цалин мөнгө нь бага, ажиллаж байгаа ажлын байр нь баталгаагүй ийм л байдалтай болж ирсэн байна.

Тийм учраас төрийн албан хаагч нар маань нээрээ үнэхээр хүнд байдалд ажиллаж байна. Өнөөдөр хамгийн бага цалин авдаг салбарынхан төрийн албан хаагч нар болж хувирсан байна.

Тэгэхээр цаашдаа төрийн албаны цалин мөнгийг ялгаатай байдлаар олгосон байгаа. Үүнийг цаашдаа ялгааг

арилгах, огт цалин мөнгө нь нэмэгдээгүй байгаа босоо тогтолцоотой орон нутгийн төрийн захиргааны албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг хэзээ яаж нэмэгдүүлэх юм. Ялгааг нь яаж арилгах гэж байгаа юм? Энэ дээр Төрийн албаны зөвлөл яаж саналаа боловсруулж байна?

Хоол, унааны мөнгө орон нутагт, сумд 1500. Төрийн албан хаагчид. Дүүрэгт 3500, ерөнхий газар, яамд, агентлаг 18-аас 20 мянган төгрөгийн хоол, унааны мөнгө авч байгаа. Энэ яагаад ийм ялгаатай байгаа юм бэ? Энэ дээр сэтгэл ханамж маш хангалтгүй байна. Төрийн албан хаагч нар.

Хийдэг ажил, албан тушаалынхаа цалин, авдаг байдлаараа, албан тушаалын байдлаараа ходоод нь ялгагдах юм уу л гэж байна. Адилхан хүмүүс шүү дээ.

Гэтэл яагаад хоол, унааны мөнгө ийм ялгаатай олгож байгаа юм бэ? Жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтны оронд яагаад дотроос нь хүн шилжүүлэн томилж болохгүй байгаа юм бэ? Заавал гаднаас шалгалт өгсөн хүн оруулж ирэх ийм бололцоогоор. Ингээд ирэхээр дээр чинь тэр хүн чинь эргээд л ороод ирнэ. Цаг хугацааны асуудал. 3 хүртэл насанд нь л байх асуудал.

Тэгээд дотроос нь ингээд ажиллуулчих бололцоо боломж байна гэдэг дээр.

Арайхийн ерөнхий шалгалт өгсөн хүн олохоор албан тушаалын индекс нь таарахгүй байна гээд авахгүй байгаа. Та бүхэн сум, дүүргүүд дээр. Тэр дундаа алслагдсан дүүргүүд дээр ажиллаарай. Яг үнэнийг хэлэхэд өнөөдөр хуучин тогтолцоогоор төрийн албанд дарамталж байгаад, одоо захиргаадаж байгаад ажиллуулдаг байсан бол өнөөдөр төрийн

албан хаагчдыг гуйж гувшиж, аргалж байж, ингэж байж ажиллуулдаг болсон. Яагаад гэхээр авдаг цалин нь муу, бага учраас өнөөдөр залуучууд төрийн албанд ажиллах хүсэл сонирхол нэгд байхгүй байна.

Хоёрт, тэр шалгуур, шаардлага өндөр босгыг чинь давж чадахгүй байна.

Гуравт, тэгж дарамт.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт бэлдэж байгаарай. Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

82. Должингийн Баатарсайхан. Төрийн албаны зөвлөлийн гишүүн хариулна.

Д.Баатарсайхан: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан байна.

Төрийн албаны зөвлөл бие даасан, хараат бус байдлаараа ажиллаж байгаа. Ажиллахыг бас их эрмэлзэж байгаа. Гэхдээ Төрийн албаны хууль дээр байдаг Төрийн албаны зөвлөлийн зарим чиг үүргүүд заримдаа хуулиас алга болчихдог юм. Үүнийг бас анхаарч өгөөрэй. Тухайлах юм бол төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад санал өгдөг. Энэ алга болчихсон байж байх жишээтэй.

Төрийн албан хаагч нарыг их бужигнуулж байна гэдэгтэй санал нэг байгаа. Та бүхэн санаж байгаа байх. 2015 онд Төрийн албаны зөвлөл Улсын Их Хуралд тайлагнасан тайландаа төрийн албаны тогтворгүй байдал нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц хэмжээнд хүрлээ гэж анхааруулж байсан. Түүний дараа гайгүй ч явж байснаа ахиад л бужигнуулдаг асуудалдаа орсон.

Бужигнуулдаг асуудалтай бас чадлаараа тэмцэж байгаа. Нөгөө талд нь Төрийн албаны зөвлөл ажил хийлгэхгүй байна гэдэг асуудал бас гарч ирээд байдаг юм. Энэ бас бидэнд их хүнд асуудал.

Цалингийн асуудал дээр түрүүн манай С.Цэдэндамба гишүүн ч хэлсэн. Бид аль болохоор боломжоороо ижил хөдөлмөр эрхэлж байгаа, ижил чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдад ядахдаа суурь үндсэн цалинг нь ижил байлгая гэдэг зарчим барьж байгаа.

Шулуухан хэлэхэд Хөдөлмөрийн яам дээр жоохон тааруу ажиллаж байгаа. Сангийн яам гайгүй санаачилга өгөөд байдаг юм.

Цалингийн ялгаатай байдлаас болж төрийн албан хаагч нарын итгэл үнэмшил жоохон унаад байгаа. Жоохноор ч барахгүй ер нь нэлээн ихээхэн унаж байгаа гэсэн үг.

Дотроосоо хүн томилох асуудлыг зохицуулсан. Одоо ингээд нэг байгууллагад сул орон тоо гарах юм бол дотроосоо болон төрийн өөр байгууллагаас шалгалт гэж хүндрүүлэхгүйгээр томилооч ээ, шилжүүлж аваач ээ, сэлгүүлж аваач ээ гэдэг журмын зохицуулалт гарсан. Энэ маань бас нэлээн эерэг байгаа.

Мэргэжлийн индексийн талаар бид нэлээн судалгаатай ажиллаж байгаа. Боловсролын яамтай эргэж ярих байх. Тэгэхгүй бол эдийн засгийн багц гэдэг дотор орчихсон мэргэжилтэй хүн авъя гээд байдаг. Яг индексээр нь хөөхөөр зөрүүтэй болж гараад байдаг зүйл бий. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд сул орон тоог богино хугацаанд нөхөх ажлын хүрээнд индекстэй холбоотой, мэргэжлийг албан тушаалын тодорхойлолтод тодорхойлж өгөхтэй холбоотой асуудлууд байгаа. Бид судалж үзэж байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Бидний тайлангийн хуралтай холбогдуулаад яг зэрэгцээд Хэрэг эрхлэх газрын дарга, сайд мэдээлэл хийж байна л даа.

“Шүүр” ажиллагааны хүрээнд 04 сарын 06-ны дотор хууль бусаар томилогдсон улсуудыг халах ёстой. Эхний байдлаар яамдад зорьсон судалгаагаар 6-аас 8 хүнийг халахаар, чөлөөлөхөөр ийм тооцоо судалгаа гарч байна гэж байна л даа.

Энэ 6-аас 8 мянган хүний асуудал хөндөгдөж байна. Үүнийг цаашдаа Төрийн албаны зөвлөл юу гэж үзэх юм бэ гэж.

Би асуултуудаа үргэлжлүүлнэ. Бүтэц, орон тоо, жишиг норм, нормативыг шинэчлэх шаардлагатай байна. Яагаад гэхээр байгууллагууд дээр дотоод хяналтын ажилтан гэж байх ёстой гэж үздэг. Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан байх ёстой гэж үздэг. Сэтгэл зүйч байх ёстой. Архив, бичиг хэргийн ажилтан байх ёстой гэж үздэг. Биеийн тамирын багш байх ёстой гэж үздэг. Сургууль, цэцэрлэгүүд.

Гэтэл цэцэрлэгүүд дээр энэ орон тоо нь байдаггүй. Байгууллагууд дээр бичиг хэргийн архив. Улсын үзлэг болдог. Архив, бичиг хэргийн орон тоо танайх байдаггүй юм байна гээд л.../минут дуусав/

Г.Занданшатар: Д.Баатарсайхан. 82. Должингийн Баатарсайхан гишүүн хариулья.

Д.Баатарсайхан: Нэмэлт асуултад хариулья. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан.

Нэлээн олон албан хаагчид. Өөрөөр хэлбэл үүний цаана юу байна вэ гэхээр хуулийн шаардлага, албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг зөрчиж томилогдсон хүмүүс байгаа юм. Төрийн албанд.

Төрийн албаны зөвлөл өөрөө КОВИД-ын хуулийн үед нэлээн ажилласан. Нэг талд нь чөлөөлүүлж байхад нөгөө талд нь томилогдоод л байсан. Тэрний цаана төрийн ажил, алба тасалдахгүй байх ёстой гэдэг нэр доор л ингээд томилоод байсан.

Одоо Засгийн газар “Таван Ш”-ийн хүрээнд “Шүүр” ажиллагаа гэдгээр эхний ээлжид судалгаа гараад байгаа юм. 6-аас 8 мянган хүн гэдэг нь орон нутагт ч байгаа, төвдөө ч байгаа.

Шууд энд чөлөөлөх үндэслэл нь бага. Яагаад вэ гэхээр зэрэг хууль тогтоомжийн хүрээнд, тэр тусмаа Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд эхлээд үнэхээр шаардлага хангахгүй байгааг нь тогтооно. Тэгээд хуулийн хүрээнд мэдэгдэл өгөөд ингээд явах асуудлууд байгаа.

Тэр ажлын хэсэгт нь Төрийн албаны зөвлөлөөс.../минут дуусав/

Г.Занданшатар: 82. Д.Баатарсайхан. Норм, нормативыг шинэчлэх.

Д.Баатарсайхан: Норм, нормативтай холбоотой яг төрийн захиргааны албан тушаал дээр бодох асуудал юм.

Байгууллага байгуулаад бүтцийг нь орон тоотой нь батлаад өгчихдөг. Тэгээд явж байдаг. Сая гишүүн хэлж байна. Сэтгэл зүйч гэж байна. Сэтгэл зүйч төрийн захиргааны байгууллагуудад тэр болгон байхгүй. Ерөнхий боловсролын сургуулиудад бий болсон. Шинээр.

Биеийн тамирын багш төрийн захиргааны байгууллагууд дээр байхгүй. Төрийн үйлчилгээний байгууллага, тэр тусмаа сургууль, цэцэрлэгт байгаа. Орон тооны хомсдолтой байгаа нь үнэн. Одоо чиглэлээр нөгөө цалин хөлс, нийгмийн баталгаанаас шалтгаалаад очиж ажиллах хүмүүс нь ховор байгаа гэсэн үг. Баярлалаа.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн. Алга байна. Алгасъя.

Эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат асуултаа асууя.

Д.Ганбат: Эхлээд бид юу яая л даа. Нэрнээсээ эхлээд бодох ёстой юм байна уу гэж ойлгож байна.

Төрийн алба гэнэ үү. Төрийн албаны зөвлөл. Ингээд сайхан тайлан гаргажээ. Та нар. Тэгээд төрийн алба гэдэг чинь яадаг юм? Ер нь. Төр гэдгээ та нар яг юу гэж ойлгоод байгаа юм? Нэгдүгээрт.

Тэгээд хүмүүлэнг, иргэний ардчилсан нийгэм байгуулна гээд нөгөө Үндсэн хуульд заачихсан байгаа л даа. Тэгээд 225 мянган төрийн албан хаагчтай юм байна. Одоо ойролцоогоор. Та нар. Тэгээд дээр нь нэмээд төрийн өмчтэй компаниудаа нэмбэл энэ тоо хэмжээ хязгаараа алдаж байна.

Баялаг бүтээдэг, татвар төлдөг хүмүүс маань энэ ачааг даахаа больж байна. Энэ төрийн албан хаагчдын цалин пүнлүү чинь одоо тэгээд тэр амьдрал ахуйд нь хүрдэг юм уу? Төрийн албан хаагч нэртэй гээд баахан бүтээл муутай.

Энэ уг нь олон нийтийн алба ч юм уу, өөр нэртэй л байх ёстой л доо. Гэтэл баахан хүмүүсийг энд цуглуулчихаад үр дүнгүй иймэрхүү байдлаар өдөр хоногийг өнгөрөөгөөд энэ улс орон ч дуусаж байгаа юм байна л даа.

Тэгээд гишүүдийн асууж байгаа асуулт, та бүхний хариулж байгаа хариулт, энэ байж байгаа зохион байгуулалт энэ тэр бол ирээдүй байхгүй болчихож. Энэ маягаараа удаан үргэлжилбэл.

Тэгээд төрийн албанд л орж л байвал тэр хүн тэгээд насаараа баталгаатай юу? Яг л дундад зуун, кастын систем шиг, тэр социализмын үе шиг сонсогдоод байх юм. Энэ юмаа өөрчил өөрчил. Бараг энэ Төрийн албаны зөвлөл, энэ тэр юмнуудаа татан буулгасан нь дээр байх.

800 мянган хөдөлмөрийн чадавхтай иргэд байгаа байх. Тэрний хэдэн хувь нь төр орчихсон төрийн алба гэдэг нэр зүүчихсэн явж байна вэ? Энэ хүмүүсийн чинь тэгээд тэр ажиллаж байгаа орчин нөхцөл, цалин нь ямар

байна вэ? Тэр амьдрал ахуйд нь хүрдэг юм уу?

Ер нь та нарын ярьдаг тэр төрийн албан хаагч гэдгээр хэд байвал зохимжтой юм бэ? Тийм тоо гаргасан уу? Манайх шиг улс оронд ийм байдаг хүн амтай ийм улсад хэд байвал зохистой юм? Наадах чинь олон нийтийн л алба шүү дээ.

Төр гэдэг чинь арай өөр юмыг хэлдэг байх. Тэгээд энд л орж байвал хүмүүсийн энэ амьдрал баталгаажна. Тэгээд явчихна гэдэг. Үгүй шүү дээ. Одоо авч байгаа цалин хөлс, амьдарч байгаа байдал энэ тэр бараг л албан ёсны ажилгүй, ядуучууд болчихсон.

Тэгээд харсан. Би гадагшаа дотогшоо явж байгаад тэр Манилаад нэг зочид буудалд буусан чинь тэр Улаанбаатар хотын төрийн албан хаагчид гэнэ үү, нийслэлийн. Дүүрчихсэн байна лээ шүү дээ.

Тэгээд л архидаад л. Өглөө шөнөгүй. Ийм л байна лээ. Одоо Авлигатай тэмцэх газар наад төрийн албан хаагч нарын чинь хэдэн хувь нь шалгагдаад байгаа юм? Тэгээд ямар ахиц дэвшил гарсан юм?

Энэ маягаараа энэ улс орон дуусна шүү. Ерөөсөө л дундад зууны үеийн юм ярьсан сууж байна. Бид бүхэн. Энэ маягаар ингэж явж болохгүй ээ гэсэн бодолтой байна.

Тэгээд цаашдаа тэр зохистой харьцаа нь ямар байх юм? Тэгээд тэр дотроо бас ялгаатай юм шиг байгаа юм аа, бас. Нөгөө үйлчлэгч, тэр жижүүр энэ тэрээ төрийн албан хаагч гээд байсан нь хасчихсан юм уу, яасан юм?

Тэгээд одоо энэ төрийн албан хаагчдын зарим хэсэг нь яадаг юм. Форумтай байх ёстой юм уу? Тэр татварын алба. Өөр юу билээ. Мэргэжлийн хяналт. Тэгээд энэ яамдын чинь тоо чинь хэтэрчихсэн. Энэ яамдыг чинь үүдэнд заавал тэр цэрэг, цагдаа нь суух ёстой юм уу? Энэ чинь иргэд л үйлчлэх ёстой шүү дээ. Бараг үйлчлэх иргэдийн тоо нь багасчихсан.

Иймэрхүү маягаар нэг санал авах, улс орныг ядууруулах.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хариултад бэлдэж байгаарай.

Энэ хооронд Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд, Буланы Бейсен нарын урилгаар Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны иргэд, мөн Баян-Өлгий аймгийн оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, ажил, хөдөлмөрт нь ч гэсэн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Т.Аубакир гишүүн хаана байна. Энд байна уу?

Асуултад хариулна. Хэн хариулах вэ? Самдангийн Цэдэндамба. Төрийн албаны зөвлөлийн гишүүн хариулна.

С.Цэдэндамба: Д.Ганбат гишүүний тавьсан асуулт, саналтай холбогдуулж үг хэлье.

Мэдээж бүрэн эрхт улс байгаа цагт төр буюу төрийн байгууллага байх нь тодорхой. Тэгэхдээ төрийн байгууллага, энэ төрийн албанд байгаа

хүндрэлтэй, бэрхшээлтэй асуудал Монгол Улсын асуудал. Төрийн албан хаагчдад тулгарч байгаа цалин мөнгө, амьдрал ахуйн бэрхшээл бүх л Монгол иргэдэд тулгарч байгаа асуудал.

Тийм учраас асуудал зөвхөн төрийн албаны төв байгууллагын шийдэх, мэдэх хэмжээний биш.

Ер нь хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, Засгийн газар, бүх л субъектүүд хамтарч шийдэх ийм олон асуудлууд байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Шийдэл гаргаад явах ёстой.

Зохистой хэмжээ байна уу гэж асууж байна. Бас байдаг. Нийт хүн амд эзлэх төрийн албан хаагчдын тоо Монголын хувьд 6 хувьтай байна. Олон улсын түвшинд 5.8 ч билүү тийм тоо байдаг.

Хөдөлмөр эрхлэгчдийн дунд эзлэх төрийн албан хаагчдын тоо бас байдаг. Ингээд нийтдээ 1 сая 200 мянган хөдөлмөр эрхлэх хүмүүсийн 200 мянга нь гэдэг нь зургааны нэг нь төрийн албанд ажиллаж байна.

Төрийн албанд ажиллаж байгаа улсууд иргэдийн тэр хувийн хэвшил болоод бүх салбарт ажиллаж байгаа хүмүүсийн арын алба болох боловсрол, эрүүл мэнд, энэ бүх үйлчилгээнд явж байгаа.

Харин төрийн захиргааны албан хаагчдын тоо харьцангуй бага байна гэж хэлсэн.

Олон улсын жишгээр хөдөлмөр эрхлэх хүн амын дунд эзлэх төрийн албан хаагчдын тоо 15 хувь байдаг. Монгол Улсад 17 орчим хувьтай байна. Ялимгүй их байна. Гэтэл энэ тоо бас тийм олон

улсын хэмжээнд сондгой тоо юу гэвэл үгүй юм байна.

ОЕСD-гийн орнууд дахь Канад Улсад энэ 19 хувьтай байдаг юм байна. Англи буюу Их Британи Улсад энэ 16 хувьтай байна. Дунджаас бас л дээгүүр. Монгол Улсын жишигт байгаа ийм зүйл байна.

Тийм учраас төрийн алба бүхэлдээ болохгүй, бүтэхгүй байна гэдэг энэ бас хэт үгүйсгэл байдлаар харж болохгүй юм. Анхаарах асуудлуудыг засаад явах зайлшгүй шаардлага бий.

Тэр төрийн албан хаагчдын цалин хөлсний хэмжээний талаар бид Засгийн газарт саналаа боловсруулж өгөөд байна.

2022 онд хамгийн бага цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй адил байсан бол одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550 байгаа бол төрийн захиргааны хамгийн бага албан тушаал 750 болсон. 2023 оны 01 сарын 01-нээс. 2024 оноос үүнийг дахиад нэмэгдүүлэх тооцоо судалгаа гаргаад Засгийн газарт хүргүүлсэн байгаа. Засгийн газар энэ саналаа төсвийн төсөөлөлдөө оруулж тооцож төсвийн төсөөллийн хамт Улсын Их Хуралд намрын чуулганаар оруулахдаа анхаарч үзнэ гэсэн ийм байр суурьтай байгаа.

Г.Занданшатар: Өөр хариулах хүн байна уу?

800 мянга биш, сая 222 мянга 541 ажиллах хөдөлмөрийн чадвартай хүн бий. Ажиллах хүчний тоо бий. Тэгээд тэрнээс 225 мянга 205 хүн төрийн алба хашиж байна.

Тэрний 152 мянга нь төрийн үйлчилгээний алба буюу эмч багш нар, тэгээд үйлчлэгч, төрийн үйлчилгээний

албанд харьяалагдаж байгаа хүмүүс байгаа.

Содномын Чинзориг гишүүн. Хариулах гээд байна. Хариултад садаа болоод байна. Та хэн хариулах вэ? Гүйцээж хариулахгүй байсан юм уу.

Дашдондогийн Ганбат гишүүн тодруулья.

Д.Ганбат: Эд нар ч нэг олигтой ч хариулаад байгаа юм алга л байна шүү дээ. Юу вэ. Сая орчим хөдөлмөрийн насны иргэдийг 200 мянга гэхээр чинь бараг 22 хувь нь байгаа байхгүй юу. Тэгээд тэр тахир дутуу иргэд ээ хасвал бүр багасна шүү дээ.

Тэгээд төрийн өмчтэй компанид ажилладаг хүмүүсээ хасаж баривал.

Ийм байж болохгүй. Төр нь юу гэнэ вэ. Бараг би өөрөө гэхчэв үү. Төр бол бөх гээд байсан. Бараг нэг тиймэрхүү юм ярьдаг болоод байна уу, үгүй юу. Төр гэдэг чинь энэ 76 байхгүй юу даа.

Та бүхэн нийтийн үйлчилгээний ажилтнуудад байхгүй юу. Үйлчилгээ үзүүлдэг л хүмүүс байхгүй юу. Тэр Засгийн газраас явуулж байгаа үйлчилгээг. Энэ Засгийн газрыг чинь ард түмэн байгуулаад өөрсдийнхөө төлөө сайн ажилла гэж байгаа ийм л зүйл шүү дээ. Бид нараар дамжуулаад.

Ийм ойлголттой хүмүүс энд сууж байхад энэ улс орон яаж өөдлөх юм бэ. Ийм л хэмжээний юу байна шүү дээ. Түвшинд.

Та нар наад юмаа унш, судал.../минут дуусав/

Г.Занданшатар: 82. Должингийн Баатарсайхан.

Д.Баатарсайхан: Бид шинэ Үндсэн хуулийн хүрээнд, тодруулах юм бол 46 дугаар зүйлд нь заасан төрийн жинхэнэ алба гэж байгаа. Энд сууж байгаа Их Хурлын гишүүд, энд сууж байгаа Төрийн албаны зөвлөлийн гишүүд, бусад албан хаагчид бүгд төрийн албан хаагч. Үндсэн хуулиар. Нийтийн албан хаагч биш ээ. Яах вэ, нийтэд үйлчилгээ үзүүлдэг гээд.

Яах вэ, төр гэдгийг би арай тодорхойлж чадахгүй байх л даа. Германы эрдэмтэн Макс Веберийн онолоор “**төр гэдэг бол зүйд нийцэхгүй байгаа зарим зүйлүүдийг онцгой давуу эрхийг хэрэгжүүлээд удирдаж байдаг удирдлагын бүтцийг төр**” гэж байгаа гэж ойлгож байгаа. Үүгээрээ хариулья.

Хоёр дахь нь, тэр ажиллах хүчтэй холбоотой зарим зүйлийг Та тодрууллаа. Тэр дээр нь хариулья.

Өнөөдөр Монгол Улсад 3 сая 400 гаруй мянган хүн ам байна. Үүнээс хөдөлмөрийн насны хүн ам нь 2 сая 200 мянга байна. Ажиллах хүч нь 1 сая 200 мянга байна. Ажиллах хүчин дотроосоо яг ажиллагчид нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Д.Баатарсайхан гүйцээгээд хариулчихъя.

Д.Баатарсайхан: Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн мэдээгээр гээд би түрүүн хэллээ. Канад Улсад жишээ нь 19 хувьтай байдаг бол Монгол Улсад 17 хувьтай байгаа.

Яг цалин хөлс нь тэд гэдгийг Засгийн газар тогтоож байгаа. Тэр төрийн албаны 4 ангилал тогтоогоод, 4 ангилал дотроо цалин хөлсийг нь тус тусдаа ийм цалинтай байна гээд. Тус бүрдээ 5

шатлалтай байсныг 1 шатлалтай болгосон.

Төрийн захиргааны 15 зэрэглэлтэй байсныг 10 болгосон. 01 сарын 01-нээс энэ үйл ажиллагаанууд хэрэгжээд явж байгаа.

Г.Занданшатар: Тэгээд дүрэмт хувцас, энэ тэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газраас Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон шүү дээ. Хувцасны зардал гаргахыг.

Д.Баатарсайхан: Дүрэмт хувцас тус тусынхаа хуулиар яваад байгаа. Дүрэмт хувцас нь хууль дээрээ орчихсон учраас дүрэмт хувцастай байгаад байгаа.

Г.Занданшатар: Тийм. Татварын хууль, Нийгмийн даатгалын хууль дээрээ дүрэмт хувцастай байна гээд л баталчихсан юмнууд байгаа байх.

Цэрэг, цагдаа хувцастай байж болно биз. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Төрийн албаны зөвлөлөөс 2021, 2022 онд хийсэн ажлын тайлан мэдээлэл, бүх зүйлийг сонслоо.

Мэдээж төрийн албыг боловсронгуй болгох, сайжруулах, хангалт, хариуцлага, сахилга, бүтээмж, үр дүн гээд олон зүйлүүд дээр бид шинэ зорилтууд, үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлж байгаа.

Тодорхой үр дүнгүүд түрүүчээсээ гарч байгаа байх. Гүйцэд гарах нь цаг хугацаа бас шаардах болов уу гэж ингэж ойлгож байна.

Гэхдээ сая Улсын Их Хурлын намрын чуулганы завсарлагаанаар Их

Хурлын гишүүд тойрогтоо ажилласан. Иргэдээс гарсан саналуудыг бүгдийг судалж үзсэн. Багцлаад үзэхээр 10 санал гарч байгаа юм. Тэр дотроос 2 санал манай төрийн алба, төрийн албан хаагчидтай холбоотой асуудал гарч ирээд байгаа юм.

Түүнд юу байна гэхээр нэгдүгээрт цалин хөлсний ялгамжтай байдал, цалин хөлсний түвшин бага байгаатай холбоотой асуудлыг ихээхэн гаргаж ирж ярьсан. Дан дамаа соёлын байгууллага ч гэдэг юм уу, ус цаг уур, орчны шинжилгээний байгууллага ч гэдэг юм уу, эдгээр байгууллагын албан хаагчдын цалин хөлстэй холбоотой асуудал маш ихээр яригдсан.

Дээр нь, цалин хөлстэй адилтгах тэр урамшууллын асуудлууд ялгамжтай олгогдож байгаа тухай асуудлууд маш их яригдсан. Үүнийг Их Хурлын олонхын бүлгээс Засгийн газарт судалж энэ асуудлаа оруулж ир гэдэг чиглэл юмыг нь өгсөн. Нэг.

Хоёр дахь зүйл. Төрийн боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, сахилга хариуцлагыг сайжруулахтай холбоотой багц асуудал гарч ирсэн. Энэ талаар бас тодорхой чиглэл юмнуудыг холбогдох газруудад өгсөн гэж.

Тэгэхээр би юу гэж эндээс асуух гээд байна гэхээр Төрийн албаны зөвлөл холбогдох төрийн байгууллагуудтайгаа хамтарч улсын хэмжээнд төрийн боловсон хүчнийхээ бодлогын нэгдмэл байдал, тэгээд тэр цалин хөлс, үнэлэмжийнх нь асуудал, энэ юмнууд дээр тов тодорхой хийсэн судалгаа, тэгээд түүн дээр тулгуурлаж авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж, чиглэл гэдэг юм уу, хүсэлт өгөгдсөн юм

юу байна вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна.

Хоёр дахь зүйл. Төрийн байгууллагуудын бүтцийн асуудал, тэгээд цомхон, чадварлаг байх тухай асуудал гээд ярихаар яалт ч байхгүй зохист харьцааны тухай л асуудал гарч ирээд байгаа юм л даа.

Тэгэхээр бидний одоогийн байж байгаа төрийн албаны бүтэц юм чинь ер нь хэр оновчтой байгаа юм бэ? Нэг.

Хоёрдугаарт, ерөөсөө бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдгээ бид юу гэж ойлгож энэ төрийн албаны бүтцээсээ тэр чиглэлийнхээ юмыг чөлөөлөх юм бэ гэдэг асуудал. Энэ дээр хийгдсэн тодорхой тооцоо, судалгаа, бодлого, чиглэлүүд юу байна вэ гэдэг асуудал.

Гурав дахь зүйл. Чадавхын зарчмын тухай бид их ярьж байгаа улсууд. Тэгвэл төрийн боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах энэ үйл явц ямар системтэй яаж явах юм?

Зүгээр эрүүл мэндийн салбар дээр би тэр төгсөлт, төгсөлтийн дараах тэр сургалтууд гээд үе шаттай яваад бас гайгүй үр дүнгүүд байгаад байх шиг харагддаг юм. Бусад салбарууд дээр үүнийг ер нь яаж бид авч ашиглавал зохилтой байж болох юм бэ? Энэ талаар бид хэд юу ярих юм гэж.

Дараа нь гүйцэтгэлийн үр дүнгийн удирдлага, санхүүжилтийн асуудал бид яриад байгаа улсууд байгаа юм.

Тэгээд үүнийгээ журамласан харилцаанууд нь төгс. Төгс юу байх вэ дээ. Гүйцэд боловсронгуй болж чадаагүй байгаа юм биш байгаа даа гэж ингэж

харагдаад байгаа. Энэ талаар.../минут дуусав/

Г.Занданшатар: 85.
Цэрэндаваагийн Амартөгс.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн судалгаан дээр төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх нөхцөл, өнөөгийн тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлоход чиглэсэн тусгай судалгаанууд хийгдсэн байгаа.

Төрийн албаны ангилал, зэрэглэлийн байдал, мөн цалин хөлсний бүтэц, нийгмийн хамгааллын асуудлуудаар Удирдлагын академитай хамтарсан захиалгат судалгаануудыг хийгдсэн.

Энэ дээр яалт ч үгүй өнөөдөр тулгамдаад байгаа асуудлууд, цалин хөлсний ялгамжтай байдал. Энэ судалгаанууд дээр үндэслээд Төрийн албаны зөвлөл болон холбогдох Засгийн газрын байгууллагуудтай хамтраад ямар үе шаттай арга хэмжээ авахаар эхлүүлсэн бэ гэхээр нэгдүгээрт цалин хөлсний суурь тогтолцоог бий болгоё. Суурь цалин хөлс нь ямар нэгэн ялгамжгүй ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид нэгдмэлд байх юм. Энэ нь ангилал, зэрэглэл буюу ажил үүргийн хариуцлагын хэм хэмжээ, хүрээтэйгээ уялдсан байна гэдэг энэ зарчим байгаа.

Ингээд эхлүүлсэн ажлын түрүүн товч эхлэл нь таван шатлалтай цалингийн системээс нэг суурьтай цалингийн системд шилжүүлсэн энэ эхний зүйл байгаа. Гэхдээ энэ нь бүрэн бүх албан хаагчдыг хамарч чадаагүйд асуудал оршиж байгаа.

Тэгэхээр дараагийн үе шаттай арга хэмжээ тэр ялгаатай, ялгамжтай байдлыг нэг суурьтай болгох ёстой. Хөдөлмөрийн үндсэн суурь зарчмуудын асуудал байгаа учраас бид энэ үүргээ хэрэгжүүлнэ гэдэг асуудал.

Төрийн албан хаагчдыг бэлтгэж байгаа асуудал дээр 2022 онд гэхэд бид 9320 төрийн албан хаагчийг сургасан. Энэ сургалт маань анх орж ирж байгаа төрийн албан хаагчдад чиглүүлэх, ажлын байран дээр нь сургах ийм сургалт байгаа.

Мөн нэг жил болон гурван жилийн давтамжтай шатлан дэвшүүлэхэд шаардлагатай ийм сургалтын тогтол тогтолцоонууд өнөөдөр явж байгаа. Гэхдээ төрийн албан хаагчийг ажил, хөдөлмөр эрхлэхэд нь чиглэсэн яг оновчтой сургалтын систем болж байна уу, үгүй юү гэдэг дээр бид эргэж дахиж дүгнэлт хийгээд тогтолцоогоо үр дүнтэй сургах, чадавхжуулах. Ингэснээр бүтээмжийг тодорхой хувиар нэмэгдүүлнэ гэж ингэж тооцож байгаа учраас сургалтын үр өгөөж, хамрах хүрээ, агуулгыг шинэчлэх ёстой гэдэг ийм суурь байгаа. Ялангуяа төрийн албан хаагч, төрийн алба эрхэлж байгаа хүмүүст төр үйлчилж байгаа гэдэг концепцыг нэгдүгээрт баримтлах.

Хоёрдугаарт, жендэрийн болон хүний эрхийн бусад асуудлуудад мэдрэмжтэй байх, ажлын байрны дарамтаас сэргийлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэсэн энэ суурь ойлголтуудыг маш сайн өгөх ёстой юм. Ингэж байж бид дараа дараагийн үүсээд байгаа зөрчил болон эрх зүйн бусад үр дагавруудыг эерэг болгоно гэдэг ийм төсөөлөлтэй ажлууд үе шаттай хийгдээд явж байгаа.

Гүйцэтгэлийн менежментийн тогтолцоо төрийн албаны байдлаар өнөөдөр бүрэн сайн болоогүй байна гэдэг ийм зүйл байгаа юм.

Тэгээд яагаад вэ гэхээр нэгдүгээрт үнэлгээний механизм нь тодорхой бус байна. Хэнийг яаж үнэлэх вэ, ямар ажил хэнд хуваарилаад түүнийгээ үр дүнг нь тооцож чадах вэ гэдэг энэ шалгуур үзүүлэлтүүдээ оновчтой тодорхойлж чадаагүй байгаагаас болж байна.

Хоёрдугаарт, субъектив байдлаас. Зөвхөн дарга төрийн албан хаагчийг үнэлдэг ийм тогтолцоо бүтээмжид сөргөөр нөлөөлж байна гэдэг ийм зүйл ажиглагдсан учраас гүйцэтгэлийн менежмент дээр бодитой үнэлэх 360 хэмийн үнэлгээ гэж бид яриад байгаа. Тэр олон талын үнэлгээний арга арга зүйг бид ашиглана.

Хэрэглэгч юу гэж үнэлж байгаа юм, хамтран ажиллагч энэ хүний ур чадварыг юу гэж үнэлж байгаа юм, байгууллагын үр дүнд энэ хүн ямар хувь нэмэр оруулав гэдгийг бодитой үнэлэх ёстой. Ингэж байж бид жинхэнэ сайн ажиллаж байгаа хүмүүсээ урамшуулах дэмжих тогтолцоог бүрдүүлж чадна гэж ингэж тооцоод өөрчлөлтийн менежментийг хийж эхлүүлж байна.

Г.Занданшатар: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ. Ерөөсөө төрийн албанд ангиллын асуудлыг бид нэлээн бодмоор байна.

Яг мэргэжлээрээ ажиллах улсуудыг “ТЗ” болгоод л үймүүлээд байдаг юмыг больчихмоор байгаа байхгүй юу. Одоо тэр хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлгийн тасгууд гээд

байгаль орчны чиглэлийн баахан асуудлууд гээд.

Ямар ч тийм үр дүн хүлээгдэхээргүй тийм зүйл байхгүй. Өөрийнхөө үйлчилгээний ангиллаараа л яв. Тэгээд тэр баталгаа юмаа хангадаг энэ зарчим руугаа орох ёстой болов уу гэж ингэж бодоод байна.

Гүйцэтгэлийн үнэхээр тийм үр дүнд суурилсан үйл явц явах гээд байгаа бол удирдлага, санхүүжилтийнх нь тогтолцоог их боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна. Яаж дүгнэх юм? Яаж тэр урамшуулал юмнуудыг нь олгох юм? Тэр нь яаж цалингийн сандаа нөөц хэлбэрээр сууж явах юм гэдэг юм чинь тодорхой байхгүй. Тэгээд жоохон хэдэн төгрөг үлдвэл тэрийг яаж зарцуулах вэ гэдэг юм яригдаад.../минут дуусав/

Г.Занданшатар: 85.
Цэрэндаваагийн Амартөгс.

Ц.Амартөгс: Үнэхээр яг агуулга, мөн чанарын тухайд шинэчлэх ийм шаардлага гарсан гэдэгтэй тантай санал нэг байна.

Төрийн албаны ангилал өнөөдрийн нөхцөлд нийцэж байна уу, амьдрал дээр нийцэж байна уу гэдэгтэй холбоотой. Ялангуяа мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг энэ мэргэшсэн байх ёстой энэ үйл ажиллагааг төрийн үйлчилгээ гэдэг агуулгаар нь төрийн захиргаа болон үйлчилгээний ангиллыг дахин хуваарилах, мөн ажил, үүргээс нь хамааруулаад уян хатан хөдөлмөр эрхлэлтийн систем рүү шилжүүлэх гэдэг энэ асуудлыг бид судалж тодорхой шийдлүүдийг үе шаттайгаар эрх зүйн болоод бусад үе шатад нь шийднэ гэсэн ийм байдалтай байна.

Төрийн байгууллагуудын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог бид өмнө нь хэрэгжүүлж нэвтрүүлж үзэж байсан. Гэхдээ үүнийхээ давуу тал гэдэг юм уу, өмнөх туршлага, алдаа оноо дээрээ үр дүн юугаа тооцоод цаашдаа бид яг ямар сегментийг үр дүнд суурилсан гүйцэтгэлээр нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

2021-2022 оны ажлын тайлангаа Их Хуралдаа танилцуулж байгаа Төрийн албаны зөвлөлийнхөндөө баярлалаа гэж хэлье.

Мэдээж хэрэг энэ бол зөвхөн Их Хурлын гишүүдэд танилцуулахаас илүү олон нийтэд Төрийн албаны зөвлөлд ямар асуудал байгаа юм бэ гэдгээ бас таниулж мэдүүлэх ийм чухал ажиллагаа болж байна гэж би бодож байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос би нэг зүйл тодруулья. Энэ дээр Төрийн байгуулалтын байнгын хороо мэдээлэл тайланг нь сонсоод ер нь ямар дүгнэлт гаргасан юм.

Өнөөдөр яг Төрийн албаны зөвлөлд шаардлагатай хууль эрх зүйн орчин хангалттай байна гэж үзэж байна уу, үгүй юу гэдэг дээр Байнгын хорооны даргаас асууя.

Энэ нэг тоон мэдээлэл байна. Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдсон эрх нь хаагдсан 579, Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдсон 227 төрийн албан хаагч байжээ гэсэн ийм тоо байна л даа.

Тэгэхээр төрийн албаны шалгуур чинь хангалттай байж чадаж байна гэж Та бүхэн үзэж байгаа юу гэдэг дээр хариулт хэлье. Яагаад ийм асуудалд ороод байгаа юм.

Хоёрдугаарт, Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчдаа хамгаалах тухай ер нь юу хийж байгаа юм бэ?

Хоёр дахь асуултыг орхиё. Түрүүн асуучихсан учраас. Төрийн албан хаагчийн тогтмол сургалт ер нь хэр явагддаг юм. Чадавхжуулах тал дээр нь.

Гуравдугаарт, Төрийн албаны зөвлөлийн даргын хувьд таны ажилласан бүрэн эрхийн хугацаанд юун дээр голлож анхаарч ажилласан юм бэ? Мэдээж хэрэг хууль эрх зүйн орчин шаардлагатай байвал биднээс юу өгсөж байна? Тийм ээ. Одоо энэ төрийн албан дээр.

Ер нь төрийн албаны 149 мянга 450 хүн гүйцэтгэх үйл ажиллагаан дээр ажиллаж байна. Гүйцэтгэх ажилтан гэсэн байна л даа. Төрийн алба данхайгаад л байгаа. Төр том байна л гээд л шүүмжлээд байдаг.

Гэтэл өнөөдөр сургуулиуд дээр чинь багш алга. Хөдөө аймаг орон нутаг, сумд чинь соёлын төв нь бүр ажилтан байхгүй. Сумын сургууль дээр нийгмийн ажилтан байхгүй, биеийн тамирын багш ч байхгүй, дуу хөгжмийн багш ч үгүй ажиллаж байна.

Тэгвэл үүнийг яаж зохицуулах юм? Сая гарсан нэг мэдээлэл байна. КОВИД-ын хуулийн хэрэгжилт дууссанаараа 2000 гаруй хүн ажлаас нь чөлөөлөгдсөн байна. Бид ажилгүйчүүдийнхээ эгнээг л нэмээд байна шүү дээ.

Мөн 2023 оны төсөв батлахдаа бид тэтгэвэр авч байгаа хүн төрд ажиллахгүй ээ гэсэн ийм шийдвэр гаргачихсан байгаа. Тэгвэл өнөөдөр 5000 гаруй иргэн төрд ажиллаж байна гэсэн мэдээлэл байна. Тэтгэврээ аваад төрийн цалин аваад байж байна. Энэ дээр ямар зохицуулалт хийх юм. Энэ зүйлийг асууя.

Мөн ер нь бид хэмнэлтийн хуулиараа тодорхой зүйлийг хэмнэж чадаж байгаа боловчиг ажилгүйчүүдийн эгнээг улам бүр нэмсэн ийм эрсдэл бидэнд тулгараад байгаа. Амьдрал ямар байгаа билээ. Эдийн засаг ямар байгаа билээ. Бидний авч байгаа цалин ямар байгаа билээ.

Гэтэл ингээд ажилгүйчүүдийнхээ эгнээг улам бүр нэмээд байвал бидний зорьсон зорилт зорилгодоо хүрэх тэр боломж нь ер нь байгаа юм уу?

Яг Төрийн албаны зөвлөл энэ дээр ямар бодлого барьж ажиллаж байна вэ гэдэг дээр асуултад хариулт авчхаад дараа нь асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга эхлээд хариулна.

Н.Энхболд: Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны ажлын тайланг бид авч хэлэлцсэн.

Төрийн албаны зөвлөлийн тайланг дангаар нь хэлэлцсэн гэхээсээ илүү төрийн албаны нөхцөл байдалтай холбоотой олон асуудлуудыг хэлэлцсэн. Энэ дотор нэгдүгээрт төрийн албаны тоо данхайж байгаа тухай асуудал гэсэн сэдвүүд гарч байсан.

Ялангуяа төрийн албаны нийгмийн хамгааллын асуудал төрийн

албан хаагчдын нэлээн их тод яригдсан. Бүтээмж, үр дүнгийнх нь тухай.

Тэгээд төрийн албанд нам, нутаг, хамаатан садан, бүлэглэлийн нөлөө их байсаар байна гэдэг талаар ярьсан. Анхаарал татсан нэг асуудал бол ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудал.

Нийт зөрчлөө бараг 70, 75 хувь билүү. Ёс зүйн зөрчилтэй байгаа нь өөрөө төрийн албан хаагчдын зүгээс анхаарах ёстой асуудал болж чихэнд тусаж байсан.

Би хэдэн зүйл хэлчихье. Үүтэй холбогдуулаад. Хэлэлцсэн асуудлуудын тухайд ийм байна.

Ер нь өнөөдөр манай төрийн албыг их том байна л гээд яриад байгаа юм. Яг ингээд хүн амд нь харьцуулсан тоогоор аваад үзвэл жишээ нь нэг хүнд 0006 хувь байгаа. Нийт үйлчилгээний албан хаагчид. Захиргааны албан хаагчид энэ дотроо.

Тэгээд нэг хүн амын нэг хүнд ноогдож байгаа төрийн албан хаагчийн тоо, хувь бол 006 хувь. Энэ дотроо захиргааных нь 0006 хувь байгаа. Үүнийг учиргүй том тоо гэж ерөөсөө үзэх боломжгүй.

Түрүүн Д.Баатарсайхан хэлсэн үү. Дэлхийн жишигт ч гэсэн бид ойролцоо дундаж л явж байгаа. Гагцхүү үр дүнгийн асуудал. Яаж үр дүнтэй ажиллуулах вэ, яаж мотивацыг нь сайн байлгах вэ гэдэг тухай л асуудал. Илүү хөндөгдөж ярих ёстой.

Төрийн албаны зөвлөлийнх нь ажлын хувьд бас хэцүү, зовлонтой. Хэдийгээр өөрсдөө хуультай ч гэсэн яг түрүүчийн тэр янз бүрийн гадна, дотнын нөлөөллөөс болоод эд нарын ажлыг буруу зөв ойлгодог, шахдаг, шаарддаг.

Тэгээд тэр нь болохгүй болохоор янз бүрээр дүгнэдэг ийм зүйлүүд бий.

Зүгээр Байнгын хороон дээр ярьсан гишүүдийн, үг хэлсэн гишүүдийн дийлэнх нь хуулийнхаа хүрээнд сүүлийн үед бас аль болохоор төрийн албаны тухай Төрийн албаны зөвлөлийн хуулиар олгогдсон үүргийн хэрэгжилтийн тухай ярихдаа боломжийн хэмжээнд ажиллаж байгаа гэж дүгнэж байсан гэдгийг бас зориуд хэлье.

Тэгээд албагүй төр гэж байхгүй л дээ. Тэгээд тооны тухай би сая ярилаа. Манайх бол бага. Ялангуяа, захиргааны. Юутай холбогдож энэ төр данхайгаад байна гэдэг юм гардаг вэ гэхээр за яах вэ яамдын тоо олон болчихлоо.

Төрийн өмч, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд их олон байгаа нь өөрөө хамгийн гол нь үр дүн муутай ажиллаж байгаа хүмүүст энэ төрийн алба данхайгаад байна, төр лүү их олон хүн яваад байна гэдэг энэ ойлголт бий болгоход нөлөөлсөн гэж бодож байгаа. Энэ дээр бид их анхаарч ажиллах ёстой юм билээ.

Өнөөдөр нийт төрийн албан хаагчдын тэр 225 мянган хүний 88 хувь нь үйлчилгээний ажилтнууд, тусгай үүрэг гүйцэтгэдэг ажилтнууд байж байгаа юм. 88 хувь нь. Үлдсэн 12 хувь нь л улс төр, захиргаа, энэ чиглэлийн улсууд байгаа.

Тэгэхээр үүнийг тооных нь хойноос олон гэж хөөцөлдөхөөсөө илүү бид үр дүнг нь яаж сайжруулах вэ гэдэг дээр л анхаарах талаар Байнгын хороон дээр илүү ярьсан гэж би бодож байна.

Тэгээд цаашдаа би бас тэр дээр байр сууриа илэрхийлж хэлж байсан. Энэ төрийн албаны тухай ажил бол ганцхан Төрийн албаны зөвлөлийн ажил биш ээ.

Цогц ажил. Засгийн газартай яаж ажлаа уялдуулах вэ гэдэгтэй маш нарийн холбоотой.

Засгийн газрын зүгээс бас энэ төрийн албаны хүний нөөцийн удирдлага, зохицуулалт, энэ талаар нь ажил олгогчийн хувьд бас санаа тавьж сүүлийн үед бас зарим ажлууд хийхээр төлөвлөж байгаа юм билээ. Тухайлбал, цаашдаа бид нарын асуугаад байгаа Төрийн албаны зөвлөлөөс болоод байгаа юм шиг асуугаад байгаа зүйлийн нэлээд хэсэг нь ажил олгогчийн хувьд Засгийн газартай нягт холбоотой.

Тэгэхээр одоогийн Засгийн газрын зүгээс ярьж байгаа нэг санаа бол энэ хүн.../минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга гүйцээж хариулъя.

Н.Энхболд: Ажил олгогчийн хувьд хүний нөөцийн удирдлага, зохицуулалтаа гүйцэтгэх засаглал нь хариуцдаг. Үүнийгээ хариуцсан бүтэцтэй байх хэрэгтэй юм байна.

Төрийн албаны зөвлөлийн хувьд жишээ нь төрийн албаны сонгон шалгаруулалт хийдэг, шалгалт авдаг нэг том хэсэг ажил нь.

Тэгээд энэ хүн ерөнхийдөө төрийн албанд тэнцэж байна уу, үгүй юу гэдгийг нь тогтоож өгдөг. Яг хаана тавих вэ, яах вэ гэдгээ засаг шийддэг маягаар.

Дээр нь Төрийн албаны зөвлөлөөс жишээ нь томилгоо, албан тушаалыг нь бууруулчихсан, чөлөөлчихсэн, халсан, буруу үнэлсэн, цалин хөлс нь бага байгаа, нийгмийн баталгаа нь дутуу байгаа хөдөлмөрийн нөхцөлийн талаарх асуудлуудыг нь Төрийн албаны зөвлөл энэ талаар гарсан маргаанууд талаар

гарсан асуудлуудад илүү их анхаарал хангагдуулж явах ийм ажил, үүргийн хуваарь гэх юм уу, чиг үүргийн хуваарь байвал илүү тохиромжтой юм байна гэсэн байдлаар Засгийн газар ажилдаа хандаж байгаа юм билээ.

Үүнийг ч гэсэн бид дараа дараагийн хууль тогтоомжууд гаргахдаа анхаарч үзэх ёстой зүйлүүдийн нэг гэж ингэж бодож байгаа.

Тэгээд энэ үйлчилгээ, тусгайгийнхан бол 88, бараг 90 хувь нь үйлчилж байгаа юм. Энэ дотроо ер нь үйлчилгээний чиг үүргийг захиргааныхаас ялгаад.

Тэгээд ямар үндэслэлээр ялгах ёстой вэ гэхээр үйлчилгээний байгууллага, үйлчилгээний ажилтан бол цэвэр өөрийнхөө төлөө юм уу, байгууллагын өмнө л хариуцлага хүлээдэг.

Гэтэл захиргааны ажилтнууд болохоор нийтийн төлөө тэдний өмнөөс шийдвэр гаргадаг, тэдний өмнөөс ажилладаг эрс ялгаатай чиг үүрэгтэй.

Үүгээр нь зааглаад бид хэдэн жилийн өмнөөс бас энэ үйлчилгээний чиглэлийг нь аль болохоор нөгөө захиргааныхаас салгаж төрийн алба данхайж байгаа гэдгээс ойлголтыг зөв болгох гэж.

Уг нь үйлчилгээний төрийн албан хаагчдын тоо бол сургууль нэмэгдвэл. Тийм ээ. Аюулгүй байдлын шаардлага нэмэгдвэл, эрүүл мэндийн шаардлагад нэмэгдвэл тэртээ тэргүй нэмэгдээд л явахаас өөр арга байхгүй. Данхайлгахгүй гээд тэрнийхээ тоог нэмэхгүй байх арга байхгүй. Ганцхан үр дүнгийнх нь асуудал ярих ёстой.

Тэгэхээр энэ чиг үүргийнх нь онцлогийг харгалзаад үйлчилгээнийхээ ажилтнуудын ангилал, тэр чиглэлээр явуулах төрийн бодлого, захиргаа, бусад чиглэлээр төрийн алба хааж байгаа хүмүүсийнхээ чиг үүрэг, үүрэг хариуцлагын асуудлыг тусад нь түүнтэй нь уялдуулж цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудлуудыг нь зохицуулж явах нь бас магадгүй төрийн албыг илүү их үр дүнтэй байгаа.

Жаахан хөрөнгөө илүү үр дүнтэй чиг рүү нь зөв оновчтой хүмүүсийн ялгагдаж байна гэж ойлгогдохгүйгээр зохион байгуулахад хэрэгтэй юм байна лээ. Энэ талаар ч бас манай гишүүд дурдаж байсан гэдгийг хэлье.

Яагаад ингэж үйлчилгээ, захиргаа бусдыг ингээд ялгая гэж байгаа юм гэхээр би дахиад хэлэхэд хүлээж байгаа үүрэг, хариуцлага нь өөр байгаа юм. Хөдөө яваад, хэлэхэд жишээ нь, цэцэрлэгийн цэвэрлэгч, яамны цэвэрлэгч хоёр үндсэндээ нэг л адилхан үүрэгтэй. Чиг үүрэг нь адилхан. Хүлээх хариуцлагынх нь хүрээ нь адилхан.

Гэтэл багш, яамны ажилтан хоёрын бас хүлээдэг хариуцлага, хэчнээн хүний өмнө хариуцлага хүлээх вэ гэдэг талаасаа зүгээр зөвхөн энгийнээр яриад үзэхэд энэ нь өөр.

Тэгээд энэ ялгаануудыг бид харахгүй бол одоо өнөөдөр нэг л төрийн ажилтан гэсэн нэртэй л бол адилхан цалин авч байх ёстой гэж боддог.

Түүнээсээ болоод бухимддаг, тэрнээсээ болоод ажилдаа дургүй болдог ч байдаг юм уу, эсвэл төр засгийн буруу гэж боддог ч юм уу иймэрхүү байдал гараад байдаг юм.

Тэгэхээр энэ бол Засгийн газар, Улсын Их Хурал, Төрийн албаны зөвлөлийн зүгээс хамтарч олон талаас нь ярьж байж зөв ойлгуулаад зөв шийдэх асуудлууд байна гэж бодож байгаа.

Байнгын хороон дээр ийм чиглэлээр ийм сэдвүүдээр яриа болсон гэдгийг танилцуулъя.

Г.Занданшатар: 81.
Б.Идэрчулуун дарга хариулъя.

Б.Идэрчулуун: Б.Жаргалмаа гишүүний асуултад Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун хариулж байна.

Төрийн албаны зөвлөл Төрийн албаны тухай хуульд заасан хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг хэрэгжүүлж ажилладаг. Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-д заасан буюу Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэгт шийтгэгдээгүй иргэнийг бид төрийн албанд анх томилохдоо энэ шалгуурыг харж томилдог.

Төрийн алба хааж байхдаа аливаа төрлийн гэмт хэрэгт холбогдож тэр нь нотлогдоод шүүхээр шийтгэгдэн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол тэр ажиллаж байгаа хүнийг халах ийм хууль зүйн зохицуулалттай.

Түрүүний таны асуусан асуултад энэ асуудал дотор нь багтаж орж байгаа юм.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл хяналт хэрэгжүүлсэн учраас тийм хүмүүсийг илрүүлээд, дээр нь эрх хязгаарлах нэмэгдэл ялаар шийдэгдсэн хүмүүс ажиллаж байсныг бид илрүүлээд ингээд ажлаас нь халуулсан гэсэн үг.

Төрийн албан дунд зохисгүй юмнууд зөндөө байна. Зүгээр хамгийн сүүлийн тоогоор 4042 хүн гэмт хэрэгт холбогдсон байгаа юм. Төрийн алба хааж байгаа хүмүүсээс. Энэ нь гэмт хэргийн бүх тооны 15.6 хувийг эзэлж байх жишээтэй.

Тэгэхээр төрийн албанд зохисгүй зөрчлүүд байна. Төрийн албаны зөвлөл хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээд хяналт хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Б.Баатарзориг дарга. 84. Гүйцээж хариулъя.

Б.Баатарзориг: Б.Жаргалмаа гишүүнд баярлалаа. Асуултад хариулах боломж олгоод асуулт асуусанд.

Бид нарын ажлаа авсан гарааны нөхцөлд амаргүй байсан. Улсын Их Хурлын яг чуулган дээр тайлан танилцуулсан юм байна лээ. Миний өмнө. Үндэсний аюулгүй байдлын түвшинд л төрийн албаны хүний нөөцийн асуудал ирчхээд байна даа гэдэг ийм гарааны нөхцөлтэй үед ажил эхэлж байсан. Үүнтэй холбоотойгоор бид төрийн албанд тийм “салангид бодлого” явуулж байсныг “нэгдмэл бодлого” явуулах чиглэл барьсан.

Хоёрдугаарт нь, аливаа нэгэн үйл ажиллагаа, бодлого, төвлөрсөн байсан зүйлүүдийг төвлөрлийг сааруулах чиглэл дээр бид үйл ажиллагаан дээр дэвшил гаргаж байгаа. Зөвхөн тоонд үндэслэсэн зүйл, чиглэсэн зүйл байсан бол чанарт чиглэсэн ахиц дэвшилд хүргэх чиглэл барьж байна.

Төрөө дээдлэх чиглэлтэйгээр байсан бол дээр нь нэмэгдүүлээд иргэдээ дээдэлсэн чиглэлийг барьж ийм чанарын өөрчлөлт гаргах гээд үзэж байгаа. Үүнтэй холбоотойгоор ямар дэвшлүүд гарсан бэ

гэхэд сонгон шалгаруулалт гэхэд анх гарааны нөхцөлийн үед авсан шалгалтууд нь маргаан үүсэхэд гурван өөр хариу ирдэг ийм ямар ч цахимжаагүй. Бүх бүртгэлүүд цаасан хэлбэртэй. Дугаарладаг ийм байсан бол өнөөдөр сонгон шалгаруулалт бүрэн цахимжсан.

Хоёрдугаар үе буюу хүний мөн чанарыг илэрхийлж харилцаа, хандлагыг тогтоох ийм шинэ сонгон шалгаруулалтын системүүд нэвтэрч байгаа.

Хоёр дахь зүйл. Сургалттай холбоотой зүйл. Сургалт бол уламжлалт чиглэлтэй ийм сургалт байсан бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн шугамаар хаана сургалтын шинэ технологи байна, хаана мэдээлэл агуулгын ямар сайн зүйлүүд байна вэ судлаад үүнийг Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл өөрсдөө зохион байгуулж байгаа.

Зөвхөн долоо хоногийн сургалтуудыг нэгтгээд үзэхэд сүүлийн ганцхан жилийн дотор 150 мянган төрийн албан хаагчид тогтмол нэг өдөр нэг цагт шинэ мэдээлэл өгдөг ийм брэнд “7:4:10” гэдэг сургалтын модультай болсон.

Зөвхөн бүх шатад төдийгүй олон улсад гадаад үйл ажиллагаа явуулж байгаа дипломат байгууллагуудынхан хүртэл энэ сургалтад оролцож саналаа илэрхийлдэг, мэдээллээ авдаг, мэргэжил дээшлүүлэлтийн цахим системд шилжсэн.

Тус байгууллага ямар ч гаднын харилцаа хязгаарлагдмал байсан. Өнөөдрийн тухайд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн шугамаар, Канадын шугамаар төсөл хэрэгжиж байгаа. Амжилттай хэрэгжиж байгаа.

Ер нь эхлэлүүд тавигдсан. Үр дүнгийн эхлэл ч байгаа гэдгийг онцолж хэлье. Асуулт асуусан танд талархалтай байна.

Түүрүүн би энэ жилийн тухайд хийгдсэн 10 гол онцлох ажлуудыг бас дурдсан байгаа. Мөн 498 хуудаст тус тусдаа хоёр төрлийн ном дээр үйл ажиллагааныхаа тайлан, үр дүнгийн эхлэлүүдийг танилцуулсан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн урилгаар Улсын клиникийн Хоёрдугаар төв эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт эмч, эмнэлгийн ажилтнууд Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэж, ард иргэдийнхээ эрүүл энхийг хамгаалах ариун үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууна.

Б.Жаргалмаа: Тэгэхээр эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа энэ цаг мөчид төрийн албаны нэр төрийг өндөрт өргөж явах, хадгалах, төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг хамгаалахад Төрийн албаны зөвлөлийн гүйцэтгэх үүрэг маш өндөр байх ёстой гэж би бодож байна.

Ер нь яг өнөөдрийн байдлаар төрийн албаны шалгалт өгөх сонирхолтой иргэд ер нь хэчнээн байгаа юм бэ? Өмнөх жилүүдтэй харьцуулахад. Тийм ээ. Өнөөдөр эдийн засгийн өсөлт ямар хэмжээнд байгаа билээ.

Бараа, бүтээгдэхүүний нь үнэ ямар өсчихсөн байгаа билээ. Зүгээр төрийн үйлчилгээнд ажиллаж байгаа 58 мянга 908 үйлчилгээний ажилтан цалингийн доод хэмжээ буюу 550 боловчиг 460-аас 80 мянган төгрөгийн цалин авч байгаа юм.

Яаж ийм мөнгөөр амьдрах вэ? Төрийн үйлчилгээний ажилчдынхаа цалин хөлсийг нэмүүлэх тал дээр Та бүхэн Засгийн газарт, Улсын Их Хуралд ямар нэгэн хүсэлт гаргасан юм байдаг уу?

Хэдийгээр бид төсөв хэлэлцэгдэж байгаа боловч, эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа боловчиг та нараас ирж байгаа хүсэлт. Тийм ээ. Бас бид нарын гаргаж байгаа шийдвэрт тодорхой нөлөөлөл үзүүлнэ.

Би түрүүн асуусан өнөөдөр яг төрийн албаны нэр хүнд.../минут дуусав/

Г.Занданшатар: 82.
Д.Баатарсайхан.

Д.Баатарсайхан: Төрийн албаны сонгон шалгаруулалттай холбоотой Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөл нэлээн цахимжиж байгаа гэж бид түрүүн хэлсэн.

Тэгэхээр ерөнхий болон тусгай шалгалтыг цахимжуулснаар 182 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байгаа юм. Тэгээд өнөөдөр ч гэсэн Та бүхэнд цаасаар

биш цахимаар QR кодоор уншуулах юугаа өгсөн байгаа. Тайлангийнхаа.

Яг өнөөдөр цахим хуудсан дээр 246 зар байж байгаа. Ажлын байрны. Зарлагдсан ажлын байр нь 3540 байгаа. Хэдэн орон тоон дээр хүн өрсөлдөх гээд саналаа илэрхийлээд, энэ нь зарлагдаад байгаа юм бэ гэхээр 3820 орон тоо байгаа.

Тэгэхдээ үүнээс байгууллагууд захиалгаа өгчхөөд бас дундаас нь зараа би цуцлуулъя хүнээ олчихлоо гэдэг тал бий.

Тэгэхээр эндээс маш жижигхэн гэдэг юм уу цөөн, 67 зарыг буцаан татсан. Энэ гарчхаад байгаа заруудад бүртгүүлж төрийн албанд өрсөлдөхөөр хүсэлтээ гаргасан 3672 иргэн байна. Бүртгэлийг нь ингээд хянаж.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Д.Баатарсайхан.

Д.Баатарсайхан: Бүртгэл нь баталгаажсан 2304 хүн байж байгаа. Бүртгэл нь цуцлагдсан 1258 хүн байж байгаа.

Тэгэхээр цуцлагдсан хүмүүс нь шаардлагаа хангахгүй байна гэсэн үзүүлэлтэд орж байгаа гэсэн үг. Баярлалаа.

Ерөнхий шалгалтыг жилд 4 удаа авахаар байгаа. Улирлаар. Сая 03 сарын 15-наас 17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Одоо дараагийн бүртгэл маань 04 сарын 19-ний өдрөөс бүртгэл хийгээд 05 сарын 24-ний өдөр шалгалт авагдана гэсэн ийм юутай явж байгаа.

Г.Занданшатар: 84.
Б.Баатарзориг дарга гүйцээгээд хариулчихъя.

Б.Баатарзориг: Б.Жаргалмаа гишүүн ээ, Та сонгон шалгаруулалтыг яаж хүмүүс сонирхож байна вэ гээд.

Манайх харахад төрийн албаны ерөнхий шалгалтын сонгон шалгаруулалт боловч явж явж хувийн хэвшлийнхэн манай сонгон шалгаруулалтын дүнг нөөцөд орсон байдлыг их судалдаг болоод байгаа. Төрийн өмчит үйлдвэрийн газрууд бас өндөр оноо авсан ийм хүмүүсийг судлах байдал илүү бас ажиглагдаж байгаа.

Дараачийн зүйл бол яг сонгон шалгаруулалтын нөөцөөр 14 мянган хүн нөөцөд ажиллах ийм нөөц бүрдүүлчхээд байгаа. 14 мянга 165 хүн. Жишээ нь, яамд болон Төрийн албаны зөвлөл шинээр ажил албан тушаалд хүмүүсийг томилохдоо туслах түшмэлийн 1700-аад албан тушаалууд дээр улсын хэмжээнд ямар нэгэн ажилласан жил, мэргэжлийн шаардлага хангадаггүй учраас 14 мянган.../минут дуусав/

Г.Занданшатар: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн асуулт асууя.

Б.Дэлгэрсайхан: Олон гишүүдтэй давхардуулахгүй ганц хоёрхон юм асуучихъя.

Төрийн албаны зөвлөлийн тайлан, үйл ажиллагааг бүгдээрээ сонслоо. Тэгээд би нэг ийм л юм асуух гэсэн юм.

Төрийн албанд орох хүний нөөц 14 мянга байна гээд түрүүн таны илтгэлд гарсан. Гэтэл хөдөө орон нутагт ажиллах хүн олдохгүй байна шүү дээ.

Тэгээд жишээлбэл сумын захиргаа, Тамгын газар, сургууль, эмнэлэг гээд ингээд. Тэгээд энэ дээрээ та нар онлайнгаар шалгалт авч байна.

Одоо бид ингээд цахимд орчихсон гээд л ингээд байдаг. Яг цагаа тулахад үүнийг чинь бас тэр хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байгаа улсууд өгөхөд бас жоохон бэрх байна шүү. Яг үнэндээ бол.

Тэгээд шалгалт очихоороо энэ хүн ч тэнцэхгүй, тэр хүн ч тэнцэхгүй гээд. Тэгээд хөдөө өөр хэн ажиллах юм. Нэг жоохон туршлагатай багш энэ сумдаа арай гайгүй нэр нөлөөтэй юм гээд нэг сургуулийн захирал тавиад тэгээд захиргааны албанд зарим нэг хүүхдийг гуйж аваачаад. Чи нэг 3 жил ажиллачих. Тэгж байгаад аймаг, орон нутаг руу оруулья барья гээд ингээд бас тэр хөдөө орон нутгийг чинь нэг эзэнтэй болгочих гээд ингээд ярьж хөөрөөд байдаг.

Гэтэл одоо энэ шалгалт нь цахим гээд тэгээд. Яах вэ, Улаанбаатар ч яах вэ тэгээд төв суурин газар өрсөлддөг л юм байгаа биз.

Энэ хөдөө орон нутгийг та нар туршлага, ажилласан жил, энэ бүгдийг нь харгалздаг тийм юм байна уу, үгүй юу? Зүгээр л онолын баахан энэ тэндээс шинэ гарсан хууль тогтоомж байдаг юм уу, эсвэл янз бүрийн юмаар аваад ингээд нэг хүн унагаад.

Тэгээд л ийм байдалтайгаар байхаар хүн урамгүй болоод. Одоо дээр нь бүр сая шалгалт шүүлэг очоод л. Тэгээд энэ далимаар ер нь ажиллахаа больё. Цалин хөлс нь ч бага юм. Дарамт нь ч их юм гээд.

Тэгээд Солонгос явдаг хүний чинь тоо улам л их болж байна. Өнөөдөр хэн Солонгос явж байна гэхээр төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс л явж байна шүү дээ.

Тэгээд энд гоё юм яриад байдаг. Тийм ч сургалт.

Яг үнэндээ хөдөө орон нутагт очоод та нар хэдэн удаа сургалт хийчихсэн юм? Хэдэн удаа хууль сурталчилчихсан юм? Үүнийгээ ярь л даа. Түүнээс биш энд тэнд бид олон улсын тийм ч туршлага гээд. Энэ чинь монгол монголоороо л байна биз дээ.

Тэгээд үнэндээ одоо ингээд сая сум, орон нутгийн Тамгын газрын дарга нар ирээд л яг бодит амьдрал дээр харахаар зэрэг тэр сумын Тамгын газар нь үнэндээ ажиллах хүн алга. Ихэнх сум ийм байдалтай байгаа. Одоо хоёр, гурван ажлыг нэг хүн хийж байна.

Тэгээд хөдөө арай чамай нэг хүн тогтоох гээд ингээд арга эвийг нь олоод. Дээр нь бас Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлээд, энэ төвөөс хөдөө рүү гээд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх гээд явахаар зэрэг ингээд шалгалт шүүлгээрээ дарамталдаг юм уу.

Үүнийг чинь дарамт гэж үзэх юм уу, эсвэл зөв юм гэж үзэх юм уу? Би ойлгохгүй байгаа юм. Тэгээд тэнцэхгүй ээ гээд л ингээд явуулчихдаг.

Тэгэхээр шалгалтдаа жоохон уян хатан. Тэр орон нутагт нь таарсан боломж, бололцоог та нар ер нь судалж байсан юм байна уу? Хүн болгон ижил мэдлэгтэй байх албагүй шүү дээ. Энэ чинь.

Хүүхдийг тэгдэг биз дээ. Хүн болгон математикч байх албагүй гэдэгтэй адилхан. Тэгээд хүн болгон тэр суманд амьдарч байгаа хүн Улаанбаатарт энэ олон төрлийн мэдээлэлтэй байгаа газрын бүх юмыг мэдэх бас албатай ч юм уу, үгүй ч юм уу.

Ер нь хуучин социализмын үе уламжлал бий шүү дээ. Тэр сумдаа нэр нөлөөтэй, бас нэг гайгүй. Багш нар дотроо ч.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Цэдэндамба гишүүн. Самдангийн Цэдэндамба гишүүн.

Хөдөө аймаг, сумын төрийн албаны нөөцийн асуудал маш хүнд байгаа шүү. Цалин, хөлсний ч асуудал. Одоо тэр ТҮ-г ялгаад хаячихсан.

С.Цэдэндамба: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулья.

Орон нутгийн захиргааны хүний нөөцийн асуудал хүндрэлтэй байгаа нь нийтлэг ийм асуудал. Үүнийг бүр бодлогын түвшинд, Засгийн газрын түвшинд, ер нь төрийн институтүүдийн түвшинд хамтран шийдэх яах аргагүй чухал асуудал.

Орон нутагт тэр шалгалт бол явагддаг. Ер нь Тамгын газрын 14 орон тоонд л шалгалт өгч орно. Бусад сургууль, цэцэрлэгийн эрхлэгчээс бусад байгууллагад ер нь шалгалтгүй орж байгаа.

Тэгэхээр 14 хүнийг сонгон шалгаруулах, томилох нь яах аргагүй төрд тавьж байгаа шаардлагын хуулиар тогтоосон шаардлагын дагуу хийхээс аргагүй.

Зүгээр шалгалтыг орон нутгийн онцлогтой зохион байгуулахыг судалж үзэж байна уу гэж байна. Судалж үзэж байгаа. 04 сарын 01-нээс мөрдөж байгаа тусгай шалгалтад мөн энэ захиалгат бус гэдэг юм уу, тодорхой салбарын асуудлыг шийдэх үүднээс тэр нийтээр авдаг шалгалтаас арай өөр зохицуулалтаар шалгалтыг зохион

байгуулья гэдэг ийм зохицуулалт хийгээд эхэлж байна.

Ер нь орон нутагт ганцхан төрийн байгууллага ч биш тэр хүний нөөцийн хомсдол байгаа нь ер нь нийгмийн асуудалтай холбоотой. Гишүүн зөв хэллээ. Тэр цалин хөлс, орон сууц. Энэ бүх нөхцөлийг шийдэхгүйгээр хэчнээн ч хүмүүсийг тэнд аваачаад тогтохгүй байгаа.

Тийм учраас Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлого”-ын үр дүнгээс хүний нөөцийн нөхөн хангалт ихээхэн хамрагдана гэж харж байгаа.

Цалин хөлсний талаар түрүүн нэлээн ярилаа. Энэ талаар тодорхой санал, судалгаа хийгээд Засгийн газарт өргөн барьсан гэдгийг хэлсэн. Өөрөөр хэлбэл 2022 онд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, цалин хөлсний тухай суурь судалгаа хийгээд, энэ судалгаанаас гарсан үр дүнг тайланд ч оруулсан байгаа. Үр дүнгээс нь гарсан саналуудыг холбогдох байгууллага, Засгийн газарт хүргүүлээд ажиллаж байна.

Тэгэхээр энэ асуудал олон байгууллага, институтийн хамтын бодлого, үйл ажиллагаагаар шийдэгдэх ийм асуудал гэж бодож байна.

Г.Занданшатар: 84.
Б.Баатарзориг дарга. Товч тодорхой хариулна шүү.

Б.Баатарзориг: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулья.

Таны дүгнэлттэй санал нэг байгаа. 330 сумаас 312 сумд тодорхой хэмжээгээр төрийн албан хаагчдын хүрэлцээ, хангамж дутагдалтай байгаа. Ийм учраас өмнө нь энэ хуралдаан дээр

өөр асуудал хэлэлцэж байхад Ц.Сандаг-Очир гишүүн, Ц.Идэрбат гишүүн, Ж.Батжаргал гишүүн нар тодорхой саналуудыг тавиад ерөнхий шалгалтуудаа орон нутгийн онцлогтой болгооч ээ гээд.

Ийм учраас 04 сарын 01-нээс эхлээд ерөнхий шалгалт дээр онцлогтой болгож байгаа. Ингээд агуулгын хувьд онцлогтой. Тэнд шалгалт өгсөн хүн энд яаманд мэргэжилтнээр ирэхгүй. Тэндээ л үйлчилнэ.

Тийм учраас манай зөвлөлийн гишүүд хэлсэн. Хөдөө аж ахуй, мал аж ахуй тулгамдаж байгаа асуудлуудын тусгай захиалгуудыг авч байгаа.

Яагаад очихгүй байгаагийн учир шалтгааныг бид бүгдээрээ эндээс нь мэдэж байгаа. Энэ асуудлыг ч бид тодорхой түвшинд шинэтгэлийн реформын хувилбар гээд өргөн барьсан зүйлүүд бий. Би нийтийн өмнө амлалт өгөхгүйн тулд зарим зүйлүүдийг тодорхой энд илэрхийлэхэд хязгаарлагдмал байгаа учраас зөв ойлгоорой гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн тодруулья. 1 минут.

Б.Дэлгэрсайхан: Яах вэ, ер нь огт шалгалт авахгүй бай гэж мэдээж хэлж болохгүй л дээ. Бас төрийн алба юм чинь.

Тэгээд бусад гишүүдийн ярьж байгаатай адилхан тэр онцлогтой шалгалт, ерөнхий шалгалтыг нэг онцлогтой болгоё гээд байгаа дээр чинь бас санал нэг байна.

Тэгээд бас энэ тусгай шалгалт гээд 14 мянган албан тушаалтан байх ёстой гээд. Энэ бас зовлонтой. Үүнийг та нар маань бас тэр аймаг, орон нутгийнх нь

Засаг даргатай нь нэг зөвшилцөөд нэг ийм механизм байна уу, үгүй юу.

Тэгээд энэ болох юм даа гэж яахгүй бол. Тэгээд буруу ишилсэн сүх шиг юм шалгалтад тэнцсэн гээд ороод ирдэг. Нэг баг болж ажиллаж чаддаггүй. Зовлон их бий. Тэгээд жалга довын асуудал байна. Бас тэнд чинь. Тийм ээ. Тэгээд үүнийг бүгдээрээ л мэдэж байгаа.

Тэгэхээр үүнийг та нар бас нэг харж үзээч ээ. Түүнээс биш одоо нэг аймгийн Засаг даргад нэг эрх мэдэл.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Үүнийг анхаарч ажиллая. Төрийн албаны зөвлөл.

Г.Занданшатар: Засаг даргын Тамгын газар ярилцлагаараа өөрсдөө шийдэх нь байна шүү дээ.

84. Төрийн албаны зөвлөлийн дарга тодорхой хариулъя. Тантай санал нэг байна л гэж хариулах байх л даа.

Б.Баатарзориг: Ойлголоо. Дарга.

Б.Дэлгэрсайхан гишүүн ээ,

04 сарын 01-нээс хэрэгжиж байгаа тэр сонгон шалгаруулалтын багц журмаар өмнө нь бол. Одоо бол 60 хувь нь ярилцлагаар авдаг болсон. Энэ нь өөрөө төрд ажиллах удирдах ажилтны түвшин, стандартыг бууруулж байгаа гэсэн ойлголт биш шүү.

Ер нь 60 хувь нь ярилцлагаар. Одоо хариулт ер нь ойлгогдчихлоо. Тийм байгаа. Шинэ журам үйлчилж байгаа.

Ингээд 13.00 цаг болсон учраас үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан завсарлалаа.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлж Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч байгаа. Үг хэлж байгаа. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Тэгэхээр ажлын хэсгийг оруулъя.

Г.Мөнхцэцэг: Асуултаа асууж байгаа юм уу?

Г.Занданшатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Мөнхцэцэг: Төрийн албаны зөвлөлийн тайланг сонсож, танилцлаа.

Тэгэхээр ер нь төрийн ачааг нуруундаа үүрч яваа хамгийн хүндхэн салбаруудын нэг бол яалт ч үгүй боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарынхан байна.

Тэгэхээр өнөөдөр ажлын байр, цалин, тэтгэмж, дээр нь амьдрах орчин нөхцөл гээд л олон асуудлууд энэ салбаруудад дүүрэн бий. Манай төрийн албаныханд энэ зовлонгууд дүүрэн бий. Тэгээд ер нь гишүүдийн яриад байгаатай би санал нэг байна.

Гишүүд маань хөдөө орон нутагт ажилладаг төрийн албан хаагчид гэж бараг байхгүй болсон.

Ер нь хөдөө эзгүйрч байна. Суманд Тамгын газруудад ажилладаг боловсон хүчингүй боллоо гэдэгтэй би санал нэг байгаа.

Тэгэхээр бид төрийн албаа чадавхжуулах, төрийн албаныхаа чадамжийг дагаад ер нь цөөлөх гэдэг тал дээр бодлого барьж байгааг ойлгож байгаа. Гэхдээ хамгийн гол нь чадамжтай гээд энэ салбаруудад ажилладаг боловсон хүчинг ер нь тогтвор суурьшилтай ажиллуулахад төр бодлогоор дэмжиж ажиллах нь зүйтэй болов уу гэж ойлгоод байгаа юм.

Тэгэхээр зарим нэг асуултууд гишүүдтэй давхцаад байгаа учраас нэг зүйлийн асуултыг тавья гэж бодсон юм. Төрийн албаны шалгалттай холбоотой асуудлууд байна.

Үндсэндээ жилд 4 удаа шалгалт авч байгаа. Тийм үү. Одоо 14 мянган хүн шалгалтад төрийн албанд ажиллахаар бүртгэлтэй байгаа гэж бодож байна.

Тэгэхээр шалгалтынхаа журамд өөрчлөлт оруулах цаг нь болсон болов уу гэж харж байгаа юм. Та бүхэн түрүүн хэлж байх шиг байна лээ. Журамд нь өөрчлөлт орж байгаа.

Ер нь тодорхой хэмжээгээр орон нутгийн онцлогийг харгалзсан шалгалтуудыг авахаар болсон гээд ярьж байх шиг байсан. 04 сарын 01-нээс эхлээд хэрэгжинэ гээд хэлчихсэн байх аа. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр анхаарах хэрэгтэй. Одоо тэр байгаль хамгаалагчаас. Дээр нь тэр мал эмнэлгийн мэргэжилтнээс шалгалт авдаг бол одоо бас арай дэндчихсэн гэж. Үүнтэй би санал нэг байна.

Үнэхээр тэр ганц морьтой, газар нутгийн хэмжээ нь том. Тэгээд өвөл зунгүй, өглөө оройгүй нохой нүцгэн явж байдаг энэ байгаль хамгаалагч нараас төрийн албаны шалгалт аваад ажиллуулна гэвэл одоо бүр ч боломжгүй юм гэж харж байгаа.

Тэгэхээр шалгалтын журамдаа ямар онцлог өөрчлөлтүүд оруулснаа тодорхой хэмжээгээр хэлээд өгвөл зүйтэй болов уу гэж бодож байна.

Тэгээд орон нутгийн онцлогийг харгалзсан шалгалтуудыг авна гэххээд жишээлбэл байгаль хамгаалагчаас авсан тэр шалгалтаараа тэр хүн тэндээ ажиллана. Тийм үү. Тэгэхдээ яам, Тамгын газар ирж ажиллахгүй гэж байна л даа. Тийм ээ. Ийм тодорхой хэмжээний хориг, заалтууд туссан юм шиг байна.

Ер нь тэгэхдээ төрийн албаны нөгөө ахин дэвшдэг зарчим чинь бас алдагдах юм биш үү. Тэгээд насаараа тэр хүнд байгаль орчны тэр байцаагчаараа тэндээ ажиллаад амьдраад байна гэсэн үг юм уу?

Тэгэхээр тодорхой хэмжээгээр авах гэж байгаа шалгалтынхаа зүйлүүд дээр бас анхаарах зүйлүүдийн нэг нь энэ юм уу гэж би бас бодож байгаа учраас энэ асуултыг тавья гэж бодсон юм.

Ямар онцлог өөрчлөлтүүд орсон юм? Төрийн албаны шалгалтад. Тийм. Энэ дээр хариулт өгөөч ээ.

Г.Занданшатар: 82. Должингийн Баатарсайхан.

Д.Баатарсайхан: Г.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны сонгон шалгаруулалтын чиг үүргийг хариуцсан

Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан хариулж байна.

Төрийн албаны ерөнхий шалгалт, тусгай шалгалт, шатлан дэвших шалгалт, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн шалгалт, төрийн захиргааны төсвийн шууд захирагчийн шалгалт гээд ийм таван журмаар зохицуулагдаж байсан журмыг нэг журам болгоод 04 сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэн эхэлж байгаа.

Журамд орсон гол өөрчлөлт нь нэгдүгээрт 14 мянган хүний нөөц бүрдүүлсэн гээд байгаа ерөнхий шалгалт байгаа. Ерөнхий шалгалт нэлээн өргөн хүрээг хамардаг. Ямар нэгэн мэргэжил, ажилласан жил шаардахгүйгээр бүртгэл хийгээд явдаг шалгалт байгаа. Тэгээд улирал болгон авна.

Тэгэхдээ бас онцлог байгаа. Энэ шалгалтыг харьяалж байгаа орон нутагтаа өгнө. Дараа нь хаашаа нь ч тэр нөөцөөсөө тусгай шалгалтаа өгөөд явах энэ бололцоог нь нээсэн. Нэгдүгээр онцлог нь тэр.

Хоёрт нь, тусгай шалгалтыг хуулиар 30, асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, монгол хэл тус бүр 20, 20 гээд 60 хувийг нь цахимаар авдаг байсан бол одоо 60 хувийг нь харилцаа, хандлага, зан үйлээр нь томилох эрх бүхий байгууллагын төлөөлөлтэйгөөр тухайн орон нутагт байгаа гэдэг юм уу, яаманд байгаа, агентлагт байгаа салбар зөвлөл зохион байгуулж авна.

Төсвийн шууд захирагч дээр нэг шалгалтын агуулга нэмэгдсэн байгаа. Тэр нь ямар зүйл нэмэгдсэн бэ гэхээр хүний нөөцийн удирдлага, гүйцэтгэлийн удирдлага, санхүүгийн удирдлага гээд ийм гурван агуулга бас нэмэгдэж орсон. Шинээр. Хуучин хүнийг томилдог,

чөлөөлдөг, цалин хөлс тогтоодог энэ албан тушаалтанд иймэрхүү чиглэлийн агуулгын шалгалт ордоггүй байснаар авдаг болсон гэсэн үг.

Орон нутагт байгаль хамгаалагчаар гэдэг юм уу, шалгалт өгчихсөн хүн яам, Тамгын газар луу шилжихэд бас хуулийн зохицуулалттай. Хууль дээрээ яам, тамгад ирэхээр ахлах түшмэл, түүнээс дээш голдуу байгаа. Дэс түшмэлүүд ч байгаа. Тэгээд жилийн шаардлагатай байдаг. Энэ нь төрийн албаны хуулийн 23 дугаар зүйл дээр заачихсан.

Энэ шаардлагаас гадна боловсролын шаардлага, мэргэжлийн шаардлага байгаа.

Тэгэхээр мэргэжлийн шаардлага дээр нь бид Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтыг голлож байгаа. Энэ сургалт дээрээ уян хатан зохицуулалт хийх талаар Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтраад зохицуулалт хийгээд явж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол ахлах түшмэлд томилогдох гэж байгаа хүн дэс түшмэлийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтыг хангачихсан байвал бүртгэлд хамрагдаж орж болох нь гээд. Төрийн нарийн бичгийн дарга болох гэж байгаа хүн эрхэлсэн түшмэлийн шаардлагыг хангачихсан. Туршлагынхаа шаардлагыг хангачихсан байвал орох бололцоотой гээд.

Орон нутагт хүн хүчний хүрэлцээ муу байна. Шалгалтад орж болохгүй байна гэдэгтэй холбоотой асуудал нь мэргэжил зөрүүтэй асуудлууд нэлээн гардаг юм. Дээрээс нь туршлагын асуудал гардаг юм.

Тэгэхээр туслах түшмэл буюу яг суманд ажилладаг мэргэжилтнүүдийн хувьд тест, сорилын шалгалт авахгүйгээр зохицуулсан байгаа. Зөвхөн ярилцлагаар. Тэгэхдээ ярилцлага нь дүн шинжилгээ хийх, удирдан зохион байгуулах, манлайлах гэсэн гурван ур чадварын хүрээнд явдаг шалгалт байгаа.

Дэс түшмэл нь туслах түшмэлд тэдэн жил ажилласан байна гэдэг шаардлагатай байсныг уян хатан болгоод туслах түшмэлд ажилласан байвал давуу байдал болно гэдгээр шаардсан.

Тэгэхээр туслах түшмэл дээр ажилласан жил шаардахгүйгээр явж байгаа энэ онцлогоороо төрийн жинхэнэ албаны туслах дэс түшмэлийн албан тушаалууд богино хугацаанд нөхөгдөөд байх ийм боломж нь байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Гомбилдагвын Мөнхцэцэг гишүүн тодруулж асууя.

Г.Мөнхцэцэг: Баярлалаа. Шалгалтын журамд өөрчлөлт оруулж байгаа нь зөв зүйтэй, цаг үеэ олсон зүйл гэж бодож байна. Ер нь тэгээд л 60 хувийг нь цахимаар авдаг байсан гэдэг. Өнөөдөр харилцаа, хандлага хамгийн чухал байна. Тийм.

Тийм учраас энэ шалгалтын зарчимд өөрчлөлт орж байгаа нь зөв гэж ойлгож байна. Тэгээд нэмээд дээр нь бас нэг зүйлийг асуучихъя гэж бодож байсан. Энэ чөлөөлөгдчихөөд байж байгаа 30 гаруй мянган төрийн албан хаагчдыг нөхөж томилох асуудлыг ямар шалгуураар томилох гэж байгаа вэ? Энэ дээр ер нь Төрийн албаны зөвлөл ямар бодлого барьж байгаа вэ? Тийм. Энэ дээр нэмээд нэг хариулт авчихъя.

Г.Занданшатар: 82.

Д.Баатарсайхан: 30 гаруй мянган гээд. Засгийн газрын “шүүр” ажиллагааны хүрээнд явагдсан судалгаан дээр та тулгуурлаж хэлж байгаа байх. Түүнээс түүрүүн би хэлсэн. Төрийн албанд манай веб сайт дээр бүх зарлагдсан тоо, орон тоо, бүртгэлд хамрагдах гээд хүсэлтээ өгсөн иргэд байгаа.

Тэгэхээр нэгдүгээрт хуулийн шаардлага.

Хоёрдугаарт, албан тушаалын шаардлагаа хангасан хүнийг нээлттэй, ил тод, богино хугацаанд сонгон шалгаруулах байгаа.

Ташрамд бас танилцуулахад сонгон шалгаруулалтын захиалга байгууллагаас ямар нэгэн асуудалгүй л ирэх юм бол Төрийн албаны зөвлөл 3 хоногийн дотор нийтэд зарлан мэдээлдэг байгаа.

10 хоног нийтэд зарлана. 10 хоног бүртгэл явна гэсэн ийм зохицуулалттай байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Төрийн албаны зөвлөл Улсын Их Хурлын байгууллага л даа. Өнөөдөр гишүүд маань Төрийн албаны зөвлөлөөс нэлээн л олон асуулт асууж, тайлантай холбоотой мэдээллийг аваад бас жоохон ширүүн ч хандаж байгаа асуудлууд харагдаад байх.

Ер нь бид Улсын Их Хурал маань яг энэ Улсын Их Хурлынхаа байгууллагыг ажиллуулах тал дээр хангалттай ажиллаж чадахгүй байгаа. Ер нь Төрийн албаны зөвлөлийн тэр хэрэгжүүлж байгаа төрийн албаны хуулийн хэрэгжилтийг бид КОВИД-ын хууль гэдэг хоёр, гурван удаа

сунгаснаараа Төрийн албаны зөвлөлийг ажлыг нь хийлгээгүй.

Өнгөрсөн жил 07 сарын 05-нд байх. Наадмын өмнө манай Монгол Ардын намын бүлгийнхэн маань Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бас хулгай хийсэн.

Ер нь Төрийн албаны зөвлөлийн хэрэгжүүлдэг гол барьдаг Төрийн албаны тухай хууль уг нь маш чамбай хууль болоод хэрэгжиж явсан. Төрийн албаны зөвлөлийн үүрэг роль, чадамж нэлээн нэмэгдсэн байсан.

Харамсалтай нь тэр хуулийн хулгайгаар төрийн албаны чадамжийг бууруулсан зүйл, заалтууд орж ирсэн.

Ер нь өнөөдөр бид төрийн албанд хэнийг яаж авах вэ гэдэг асуудлаасаа илүү төрийн албанд хүн ажиллуулах тал дээрээ анхаарах цаг нь болсон. Одоо ингээд тоон үзүүлэлтүүдийг харахад 2020 онд 20 мянган хүн төрийн албанаас гарсан. 2021 онд 23 мянган хүн төрийн албанаас гарсан байгаа. Энэ юутай холбоотой юм. Шалтгааныг бид олох ёстой. Тэгээд эмчлэх ёстой.

Хамгийн нэгдүгээр асуудал мэдээж цалингийн асуудал. Төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийн амьжиргааны гол тэр цалин хангалттай биш байна. Өнөөдөр төрийн үйлчилгээний албанд ажиллаж байгаа манай сувилагч нар гэхэд сарын дундаж цалин дөнгөж 700 мянган төгрөгийн цалин аваад ажиллаж байна.

Сүүлийн үед сувилагч нарын орон тоо маш ихээр төрд хэрэгтэй болсон. Үйлчилгээний ажил дээр буюу манай үйлчлэгч, асрагч гээд. Энэ хүмүүс бараг 500 мянган төгрөгийн цалинтай ажиллаж

байна шүү дээ. Ийм төрд хэн ажиллах юм бэ. Энэ хамгийн гол асуудлын нэг байгаа.

Та бүхэн санаж байгаа бол Монгол Ардын нам сонгуулийн мөрийн хөтөлбөртөө инфляц, үнийн өсөлттэй уялдуулж цалинг үе шаттайгаар нэмэгдүүлнэ гэсэн. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл тэр цалин нэмэгдэх асуудлууд явахгүй байгаа.

Хоёр дахь асуудал, төрийн албанд орсон албан тушаалтнууд нэн ялангуяа туршлагатай хүмүүс өнөөдрийн Засгийн газрын оруулж ирж байгаа тэр шалгууруудын асуудлууд нь багасаж, өөрсдийн намын томилгоо хийдгээс болоод төрд итгэх итгэлгүй болоод ажлаасаа гардаг болсон. Хоёр дахь том шалтгаан.

Гуравт нь, төрд ажиллаж байгаад үндэслэлгүйгээр халагддаг.

Тэгээд халагдсаныхаа нөхөн олговрыг олж авч чаддаггүй. Энэ буруу шийдвэр гаргасан албан тушаалтнууд нийтдээ 7 тэрбум төгрөгийн хохирлыг төрд учруулсан.

Энэ хохирлыг тэр шийдвэр гаргасан албан тушаалтан эргэж төлөх ёстой. Харамсалтай нь өнөөдөр 600-хан сая төгрөг төлөгдсөн гэдэг ийм тоон мэдээлэл байгаад байгаа.

Ер нь тэгээд энэ цалин багатай хүмүүст төр өндөр шаардлага тавиад ажиллуулна гэдэг бол үнэхээр бэрхшээлтэй. Төрд шинээр орж ирж байгаа ажилчдын дийлэнх олон хувь буюу 40 гаруй хувь нь өнөөдөр 20-иос 30 насны залуучууд байгаа. Нөгөө чадамжтай хүмүүс нь ажлаасаа гардаг. Ийм л дүр зураг өнөөдөр Монголын төрд нүүрлээд байна.

Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээнүүдийг үе шаттай авах вэ? Түрүүний ярьдаг цалин төрд тэр өндөр албан тушаалыг хийх боломжийг нь хангадаггүй.

Гуравт нь, мэдээж хариуцлагагүй байдлаар халагддаг гэсэн асуудлууд дээр ер нь ямар байр сууриуд Та бүхэнд байна вэ?

Г.Занданшатар: 88. Ганбаатарын Билгүүн хариулъя. Ажлын албаны дарга.

Г.Билгүүн: Ажлын албаны дарга Г.Билгүүн Н.Ганибал гишүүний эхний асуултад хариулъя.

Би танд товчхон танилцуулчихъя.

КОВИД-ын хууль бидэнд Төрийн албаны тухай хуулийг үр дүнтэй зөв хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулсан нь үнэн. Тэрийг би хохирол гэж хэлж чадахгүй. Бэрхшээл учруулсан, сорилт учруулсан.

Товчхондоо КОВИД-ын хууль хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд нэг ёсондоо 2020 оны 04 сарын 29-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх энэ хугацаанд төрийн албанд КОВИД-ын хуулийн 3.2 дахь хэсгийг үндэслээд 2808 иргэн томилогдсон.

Төрийн албаны зөвлөл энэ дээр зүгээр байгаагүй. Энэ хууль хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд ч гэсэн энэ хуулийг яаж ойлгох вэ, яаж зөв хэрэглэх вэ, яаж хүмүүсээ шилжүүлэх вэ, яаж томилох вэ гэдэг дээр удаа дараалан тогтоол гаргаж байсан, зөвлөгөө өгч байсан, зөвлөмж гаргаж байсан.

Тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд миний түрүүний

хэлдэг 2808 иргэнээс 794 иргэн нь төрийн албанаас чөлөөлөгдсөн.

Яагаад гэхээр хууль бусаар томилогдсон. Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагаа хангаагүй, ажилласан жил нь хүрэхгүй гэсэн үндэслэлээр.

823 иргэн ажлаасаа чөлөөлөгдөөд. Тэгэхдээ ном журмынхаа дагуу сонгон шалгаруулалтдаа ороод, сонгон шалгаруулалтдаа тэнцээд буюу хамгийн өндөр оноо аваад төрийн албанд буцаад жинхлэн томилогдсон байна.

Энэ тайланд онд буюу 2022 оны 12 сарын 31-ний байдлаар КОВИД-ын хуулийн хүрээнд томилогдсон 1191 хүн улсын хэмжээнд төрийн албанд ажиллаж байсан, ажиллаж байгаа ийм тооцоо байгаа.

01 сарын 05-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс бүх төрийн байгууллагуудад мэдэгдэл хүргүүлсэн. Хууль бус томилгоотой байгаа КОВИД-ын хуулийн 3.2-оор томилогдсон хүмүүсийнхээ асуудлыг цэгцэл гэсэн.

Энэ дээр мэдээ нэгтгэгдээд явж байна. Эхний 2 сарын байдлаар нэгтгэгдээд үзэхээр үүнээс 55 орчим хувь нь цэгцэрчихсэн. Би тэгэхдээ сарын өмнөх тоо хэлж байгаа шүү. 495 хүн л яг энэ хуулийн 3.2-ын дагуу томилогдон ажиллаж байгаа. Одоо энэ тоо буурсан байх. Ямар ч гэсэн эхний нэг, хоёрдугаар улиралдаа багтаагаад асуудлыг бүрэн цэгцлэх зорилготой ажиллаж байгаа гэдгийг танилцуулж байна.

Тэр 2022 онд нийтдээ төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдын тоо 32 мянга 68 байгаа. Үүнийг бид ангилсан. Хүйсээр нь ангилсан. Ямар

шалтгаанаар ажлаас гарч байна вэ гэдгээс нь бас ангилсан.

Хамгийн өндөр буюу 16 мянга 698 төрийн албан хаагч өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. 10 мянга 623 нь бусад хууль тогтоомжоор төрийн албанаас чөлөөлөгдсөн гээд хэд хэдэн ангиллаар нь нарийвчлаад гаргачихсан байгаа.

Тэгэхдээ бид үүнийг яаж гаргадаг вэ гэхээр нөгөө тушаалын үндэслэх хэсэгт нь юу гэж заасан байгаа юм тэр ангиллаар нь гаргаж байгаа. Яг бодит шалтгаан нөхцөлийг нь тогтооё гээд Засгийн газартай хамтраад буюу “**Шинэ сэргэлтийн бодлого**”-ын “Хурдасгуур төв”-тэй хамтраад бид судалгаа хийж байгаа.

Нэгтгэсэн урьдчилсан байдлаар Засгийн газарт танилцуулсан.

Өөрийн хүсэлтээр гэдгийн цаана яг үндсэн шалтгаан нь юу вэ. Цалин хөлс үү, ар гэрийн гачигдал уу. Тийм ээ. Яах вэ, тушаалын үндэслэх хэсэгтээ өөрийн хүсэлтээр. Тэгэхдээ яг нарийн ямар учир шалтгаан байна вэ. Үүнийгээ олж тогтоож, үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зүйтэй гэдэг үүднээс “**Хурдасгуур төв**”-тэй хамтраад төрийн албан хаагчдын дунд судалгаа явуулсан. Судалгааныхаа урьдчилсан дүнг урьдчилсан байдлаар Засгийн газарт танилцуулсан.

Тэгээд энэ судалгаа албан ёсны дүн гарахаар яг нарийн учир шалтгааныг нь тогтоогоод үүнээсээ урьдчилан сэргийлэх, үүнтэйгээ тэмцэх, дахиж ийм асуудал гаргахгүй байх чиглэлээр арга хэмжээ авч ажиллана гээд.../минут дуусав/

Г.Занданшатар: 81.
Б.Идэрчулуун дарга. Бадамцоогийн Идэрчулуун дарга.

Б.Идэрчулуун: Н.Ганибал гишүүний асуултад Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун хариулж байна.

Гишүүнтэй санал нэг байна. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд хохирол учруулж байгаа асуудал санаа зовох асуудал мөн.

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд учирч байгаа хохирол гэдэг нь өөрөө их өргөн ойлголт.

Тэгэхдээ Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д зааснаар Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэгт төрийн жинхэнэ албан тушаалд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан энэ 4 тохиолдолд төрд учирч байгаа хохирлыг нэхэж байгаа юм.

Тэгээд энэ бол ганцхан Төрийн албаны зөвлөлийн хийх ажил биш. Энэ бас аудитын байгууллагатай хамтрах, прокурорын байгууллагатай хамтрах хамтарсан ажлуудыг бид хийж байгаа.

Үүнийг зогсонги биш нэлээн хөдөлгөөнд оруулаад. Одоогоор үнийн дүн бага байж магадгүй. Тэгэхдээ яг он гарснаас хойш гэхэд өнөөдрийн байдлаар төрийн хохирол учруулсныг буцааж төлсөн дансанд 72 сая төгрөг байх жишээтэй.

Тэгээд бага гэхгүй энэ процесс их удаан ажиллагаагаар явагддаг. Шүүхэд нэхэмжлэл гаргана. Үүндээ шийдвэр гаргуулна. Тэгээд тэр шийдвэр нь шийдвэр гүйцэтгэлд очно.

Эргэж төлөгдөх нөхцөл нь хангагдаад бид үүний араас хөөцөлдөөд явж байгаа. Энэ бодитой цаашаа хэрэгжих зүйл.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн тодруулъя.

Н.Ганибал: Өөрийн хүсэлтээрээ төрийн албанаас гарч байгаа тэр шалтгаан ер нь бид бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ.

Ихэнх нь Солонгос руу ажил хийхээр явдаг. Гадаадад явахын тулд ажлаа өгдөг ийм л асуудал байгаа. Тэд юуны төлөө явж байна вэ гэхээр мэдээж цалин цавагтай, амьдралд хүрэлцэхүйц тэр боломжийн төлөө л явж байгаа.

Тэгэхээр энэ дээр бид эргээд хэлчхэд, эргээд сануулчихъя. Одоо тэр сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрийг манай Монгол Ардын намынхан, манай Ардын намын бүлгийнхэн маань биелүүл ээ. Тэр цалин цавгийг нэмэх асуудлаа нэн яаралтай оруулж ирж хэлэлцүүлж, асуудал болгон дээрээ үүнийгээ ярьж баймаар байна.

Үр дүн нь төрийн албанд ажиллах хүнгүй болж байна шүү. Үүнийгээ л хэдүүлээ олж харах ёстой. Тэгэхгүй тэр нүүрсний хулгайнаас 40 их наядын боломж алдагдсан. Тэр цалин цаваг нэмэх асуудал бүрэн боломж байгаа байхгүй юу. Үүнийгээ ашиглахгүй байна шүү дээ. Хулгай л хийгээд байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд.

Тэгэхээр 1992 онд ардчилсан Үндсэн хууль байгуулагдсанаас хойш

босоо тогтолцоотой нэг намын үзэл санаагаар явж байсан засаглалын тогтолцоо өөрчлөгдөж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага байгуулагдаж, хэвтээ тогтолцоо бий болсон цагаас, 1994 он шиг санаж байна. Төрийн албаны зөвлөл гэдэг байгууллага байгуулагдаж, төрийн байгууллагыг төвхнүүлэх гэж, бас чанартай байлгах гэж бараг 30-аад жил зүтгэсэн байх.

Тэгээд хараад байхад энэ албанд олон жил зүтгэсэн, бараг зарим нь анхнаас нь зүтгэж байсан хүмүүс ч энэ тайлангаа тавьж байх шиг байна.

Тэгээд олон гишүүд олон зүйлийг асууж, хариулт авч байна. Миний хувьд асуугаад байх зүйл гэхээсээ илүү хэд хэдэн санааг л хэлье гэж бодсон юм.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл төрийн албыг сайн сайхан байлгахын төлөө зүтгээд байгааг нь хардаг, мэддэг. Гэхдээ үүнийг ажлыг нь хийлгэхгүй байгаа зүйл бол би эрх баригч нам гэж ойлгодог. Улс төр гэж ойлгодог.

Ерөөсөө очоод Төрийн албаны зөвлөл дээр хумсаа аваачаад зоочихдог. Тэгээд тулгалт хийдэг. Тэгээд КОВИД-ын гэдэг юм уу, янз бүрийн хуулийг ил болон хулгайгаар батлуулж, ингээд үүгээрээ төрийн албыг бужигнуулдаг.

Саяын хүмүүсийн хариултаас харж байна шүү дээ. 2020 оны 04 сарын 12-ноос хойш баталсан хуулиас 2800 хүмүүсийг бужигнуулсан байна. 2800 гэр бүл бужигнаж байгаа. 2800 байгууллага бужигнаж байгаа.

Ахиад сая 2022 оны 07 сард мөн хулгайгаар хууль оруулж ирж батлуулсан. Тэгээд үүгээрээ бас өчнөөн төчнөөн байгууллагыг бужигнуулдаг. Өчнөөн төчнөөн намын харьяаллын ах

дүү, хамаатан саднаа албад, агентлагийн газруудад аваачиж шигтгэдэг, суулгадаг. Тэгээд эргээд Төрийн албаны зөвлөлөөсөө хариуцлага нэхээд байдаг.

Нэг гараараа аваачиж болох бүтэхгүй юм хий гэж шахдаг. Нөгөө гараараа хариуцлагын тогтолцоог шаарддаг.

Тэгэхээр үүнийг төр өөрөө анхаарах цаг нь болсон.

Төрийн албаны зөвлөлийг бие даасан бүрэн эрхт байгууллагаар ажиллах боломжийг нь ахиж хуулиар харж үзэх ёстой. Хэрвээ та нарт санаа оноо байвал энэ хуулийг өргөн барилцахад ч гэсэн бас бэлэн байна гэж.

Дээр нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага бий болсноос хойш миний байнга ярьдаг зүйл бол би энэ Улаанбаатарын түгжрэл, утаа, стресс, энэ зүйлийг би Улаанбаатартай дангаар нь ноцолдоод шийднэ гэж боддоггүй.

Орон нутгийн суманд байгаа хүмүүсийн амьдралын чанар, аймагт байгаа хүмүүсийн амьдралын чанар, хот, аймаг хоёрын ялгаа арилж байж энэ байдал гайгүй болно.

Тийм учраас аймаг, сумдад ажиллаж амьдрах хүмүүс дээр манай Төрийн албаны зөвлөл бас уян хатан байж, анхаарч өгч байгаарай гэж хүсэх байна. Жишээлбэл, багийн дарга. Багийн даргад дээд мэргэжил гэсэн шалгуур тавьсан. Багийн дарга энд байгаа хорин хэдэн яамны бүх ажлыг хийдэг. Дугуйтай, морьтой. Гадаа гарч юу болно, дотроо орж юу болно гэдэг билээ. Ийм ажлыг хийдэг. Цалин гээд сүртэй юм байхгүй.

Тэгээд тэндээс бүх багийн дарга, хороон даргаас ирсэн мэдээлэл нэгтгэгдэж улс орны хэмжээний юм болдог. Тэрийг сэтгэлтэй, зүтгэлтэй хүмүүс л хийдэг.

Тийм учраас энэ тал дээр бас анхаарах ёстой гэдгийг хэлэх гэсэн юм.

Дээр нь Төрийн албаны зөвлөл зарим эрхээ зарим газраа алдаад байх шиг санагдаад байна. Жишээлбэл, Авлигатай тэмцэх газар тэнд зөрчил байна уу гэдгийг хэлэх ёстой болохоос биш төрийн албаны тийм тийм шалгуурыг хангаагүй байна гэж танай зарим эрх үүргийг Авлигатай тэмцэх газар бичиж өгөөд явуулаад байдаг байхгүй юу.

Энэ байдлууд дээр та хэд маань анхаараарай.

Тэгээд энэ хүнд хүчир ажлыг 30-аад жил нуруундаа үүрч, цаашид ч бас итгэл үнэмшилтэйгээр тайлангаа тавьж байгаа Та бүхэнд амжилт хүсье. Шаардлагатай гэвэл хууль, эрх зүйн талд чинь туслахад.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Тийм ээ. Үг хэлсэн. Хавдисламын Баделхан гишүүн.

Х.Баделхан: Баярлалаа. Төрийн албаны зөвлөлийн тайланг сонслоо.

Бас шинэлэг ажлууд их байна. Ялангуяа төрийн албаны ерөнхий шалгалт, тусгай шалгалтыг тэр цахимаар авч байгаа нь маш том дэвшил болсон.

Цаашдаа үүнийг үргэлжлүүлээд ер нь төрийн албаны бүх ажлыг бид цахим руугаа шилжүүл. Энэ шударга болно гэж. Өмнө нь орон нутагтаа, ер нь бүх салбарт маргаан их гардаг байсан. Төрийн албаны

шалгалттай холбоотой. Одоо маргаан тасарсан. Ямар ч гомдол байхгүй.

Тийм учраас цаашдаа цахимжуулах ажлыг улам нэмэгдүүлээсэй л гэж хэлмээр байна.

Хоёр дахь нь, төрийн албыг улс төрийн алба, төрийн захиргааны алба, төрийн тусгай алба, төрийн үйлчилгээний алба гэж ангилж байгаа л даа. Энэ дотроо хамгийн чухал нь тэр төрийн захиргаа бөгөөд төрийн тусгай алба.

Ер нь мэргэшсэн, цомхон төрийн албатай болно гэж их ярьж байгаа. Ялангуяа төрийн захиргааны алба мэргэшсэн цомхон байх ёстой.

Тэгэхээр төрийн захиргааны алба нийт 225 мянган төрийн албан хаагч нарын 9 хувь нь төрийн захиргааны албан хаагч нар. Тэгээд төрийн тусгай алба 2 хувь гэж сонсох шиг боллоо.

Ер нь энэ талаар л голдуу ярина шүү дээ. Тэр төрийн үйлчилгээ яах вэ иргэд үйлчилж байгаа юм чинь.

Тэгэхээр манай төрийн албан хаагч нарын тоо их байна гэж их ярьдаг. Тэгээд энэ төрийн захиргаа, төрийн тусгай алба бусад улс орнуудтай харьцуулахад хүн амын тоотой харьцуулахад манайх ямар түвшинд байдаг юм?

Ер нь их байна уу, бага байна уу? Цаашдаа ямар бодлогоор ажиллах вэ гэж.

Хоёр дахь нь, төрийн үйлчилгээний албан хаагч. Нийт төрийн албан хаагч нарын гуравны хоёр нь бараг төрийн үйлчилгээний албан хаагч нар юм байна.

Тэгэхээр төрийн үйлчилгээний албан хаагч нар гэдэг сургууль, эмнэлэг, цэцэрлэгийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс шүү дээ.

Тэгэхээр эднийг зөвхөн төрийн сургууль, цэцэрлэгийн байгууллагад ажиллаж төрөөс цалин авч байгаа хүмүүсийн тоо л гэж ойлгох уу?

Ер нь манай улс 1990 оноос хойш зах зээлийн харилцаанд шилжсэн. Одоо төр, хувийн хэвшил гэж ялгахгүй. Тухайлбал, эрүүл мэндийн салбарыг 2022 оноос эхлээд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсон. Төр, хувь гэж ялгахгүй. Хэн сайн ажиллана тэр байгууллага л цалин авдаг. Өндөр цалин авдаг.

Боловсролын салбар ч гэсэн хувьсах зардлаар цалинжиж байгаа. Хүүхэд хаана сурна тэндээ нөгөө төрийн хувьсах зардал очдог. Гэтэл ажилчдыг нь хувийн, төрийн гэж ялгаж болох уу?

Одоо хувийн эмнэлгийн байгууллага, хувийн сургуулийн байгууллагад ажиллаж байгаа ажилчид адилхан эмч нар, багш нар. Төрд ажиллавал тэрийг чинь төрийн үйлчилгээний албан хаагч гэж үзээд. Тэр хувийн байгууллагад ажиллаж байгааг нь адилхан мэргэжлийн хүмүүс. Эд нарыг төрийн үйлчилгээний бус гэж ялгаварлаж болох уу? Ер нь.

Ер нь улсын хэмжээнд нийтдээ хэчнээн хэмжээний албан хаагч нар байдаг юм? Тэнд хэчнээн нь төрд, хэчнээн нь хувьд ажилладаг юм?

Ер нь цаашдаа энэ тал дээр ямар бодлого барих вэ? Ер нь ялгаварлаж болохгүй шүү дээ гэсэн асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Асуултад 85. Цэнддаваагийн Амартөгс хариулья.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулья. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс.

Эхний асуултад хариулахад, төрийн албаны 4 ангилал байгаа. Тэгээд үүнийг илүү тодорхой болгох. Үйл ажиллагааных нь хүрээнээс хамаараад хэрэгжүүлж байгаа үүрэг, чиг үүрэг, хариуцлагаас нь хамааруулаад оновчтой тогтоох асуудлыг бид судалж, шийдлийн гарц хайж байна.

Тэгэхдээ Үндсэн хуулийн зарчимд нийцүүлээд ажиллаж байгаа, таны хэлсэн төрийн захиргаа болон төрийн тусгай албан хаагч бол жинхэнэ албанд тооцогдож байгаа бөгөөд ойролцоогоор 67 мянган албан хаагчид энд хамаарагдаж байна.

Энэ нь нийт албан хаагчдынхаа хувьд эзлэх хувийн жин бага байгаа гэдгийг хэлье.

Улсын хэмжээнд ажиллаж байгаа ажиллах хүчинд 17.3 хувь нь төрийн албан хаагчид байна гэдгийг өмнө нь дурдсан. Энэ тоон мэдээлэл байна. Үүнээс төрийн үйлчилгээний албыг ялангуяа нийтийн үйлчилгээ, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээг бид төрийн болон хувийн гэж ялгалгүйгээр хүртээмжтэй байдлыг хангах, үйл ажиллагааны бие даасан байдал, мэргэшсэн байдлыг нь ахиулах зүйл дээр бодлогын шинэчлэлүүд явж байгаа.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсний бодлогын шинэчлэлийг хийгээд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн системийг бүрэн нэвтрүүлэхэд бид ажиллана.

Ингэснээр төрийн албан хаагчдын цалин нэмэгдэх ёстой. Суурь цалин нэмэгдэх ёстой. Мөн гүйцэтгэлээс хамаарсан нэмэгдэл, нэмэгдэл хөлс нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

Нийт улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын тоо нэгдсэн дүнгээрээ ажиллах хүчний судалгаагаар гардаг. Төрийн салбарт ажиллаж байгаа нь шууд төрөөс орон тоо, цалингийн санхүүжилтээ авч байгаа учраас бид ялгаатай статистик мэдээлэл гаргаж байгаа.

Одоо яг үзүүлж байгаа үйлчилгээнийх нь хувьд ялгамжтай байдлыг бид гаргахгүй. Нийт улсынхаа хэмжээнд авч үзэх ёстой гэдэг зарчим байна.

Цаашид ер нь төрийн албыг бид иргэдэд ая тухтай амьдрах, амьдралын чанарыг сайжруулах агуулгаар нь авч үзээд тогтолцооны шинэчлэл хийх ёстой гэдэг байр суурьтай байгаа. Энэ маань өөрөө яг нийтэд үйлчлэх ёстой гэдэг үүрэг дээрээ суурилоод. Харин яаж үр дүнтэй үйлчилгээг зохион байгуулах вэ гэдэг ажил дээр төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнд суурилсан механизм.

Төрийн захиргааны алба буюу бодлого тодорхойлдог. Эргээд хууль тогтоомжийг гаргаж хэрэгжүүлдэг үйл ажиллагаанд оролцож байгаа байдлаараа Төрийн албаны хууль, Төрийн жинхэнэ албаны хуульд хамаарч тодорхой шаардлага, шалгуур тавигдаж үйл ажиллагаагаа иргэдэд нээлттэй мэдээлэх зарчмаар ажил, хөдөлмөр нь үнэлэгдэх боломжтой байх ёстой.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар Багануур дүүргийн 5 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Голдуу ахмадууд байна. Тэгээд эрхэм хүндэт ахмадууд, Багануурчууд Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Урт насалж, удаан жаргаарай. /алг ташив/

Х.Булгантуяа гишүүнийг хаслаа. Ц.Цэрэнпунцаг гишүүнийг хаслаа. Сандагийн Бямбацогт гишүүнийг хаслаа. Алга байна.

Ингээд Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Туваан: Төрийн албаны зөвлөлөөс тайлан оруулж ирж байна. Тэгээд тайлантай танилцаж байна.

Тэгээд төрийн албан хаагч гээд энэ хүмүүстэй холбоотой асуудлууд нэлээн байгаа. Одоо ингээд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлье гээд гадаа бас энэ эрүүл мэндийн салбарынхан, боловсролын салбарынхан жагсаж байна. Тэгээд яагаад жагсаж байгаа гэхээр энэ хүмүүсийн цалин болохгүй байна.

Тэгэхээр энэ асуудал дээр Төрийн албаны зөвлөл ямар судалгаа хийж ордог юм бэ? Үүнийг бид зөндөө ярьдаг. Яг ний нуугүй хэлэхэд төрийн албан хаагчид чинь ажил хийж байгаад ажиллангаа ядуурдаг ийм л систем рүү орчихсон шүү

дээ. Хүрдэггүй. Ялангуяа залуучууд. Шинээр орон нутагт ажил хийж байгаа залуучууд цалин нь хүрэхээ байсан.

Хоёул хоёулаа ажилтай байна гэдэг ховор. Тэгээд нэг нь ажиллаад 2 хүүхэдтэй бол ядуучуудын эгнээ рүү зүгээр алхаад орчхож байна. 700 хэдэн мянган төгрөгийн цалин гэж байна. Эндээс чинь цалингаасаа нийгмийн даатгалын шимтгэл төлнө, орлогын албан татвар төлнө. Гар дээр авч байгаа юм хэд байгаа билээ. Тэгтэл юмны үнээ хар даа. Доор хаяж нэг дахин нэмэгдчихсэн явж байгаа.

Тэгэхээр бид Төрийн албаны зөвлөлийнхөн, Их Хурлынхан бид энэ байдлыг мэдсээр байж чихээ таглаад хажуугаар нь дуугүй өнгөрч болохгүй. Одоо энэ дээр шийд гаргахгүй бол төрийн албан хаагчид чинь бүгдээрээ Солонгос руу, Америк, Европ руу ажиллахаар гараад дууслаа.

Сумын мал эмнэлэгт ажиллаж байгаа 2 хүн, хөдөө аж ахуйн тасагт ажиллаж байгаа 3 хүн гээд энэ салбарыг төлөөлж ажиллаж байгаа 5 хүн ажиллахаас ер нь 3 ажиллаж байгаа газар цөөхөн байна шүү. 4 байхгүй байгаа. Нэг ч хүн ажиллахгүй сумдууд Төв аймагт байна. Та нар худлаа гэж бодож байвал үүнийг нягтлаад үзээрэй.

Тэгэхээр энэ дээр одоо хэдүүлээ нэг ийм бодлого явуулахгүй бол болохоо байсан цаг болжээ.

Сая Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын ярилцлага байна. Хууль зөрчиж томилогдсон 6 мянган албан хаагч гээд. Би 1200 албан хаагч гэж бодоод байсан. Бараг 5 дахин бага бодож байсан байна. Энэ ямар учиртай тоо юм бэ? Энэ дээр томилсон томилгоо дээр нь

хууль зөрчсөн юм бол энэ томилгоо дээр ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ?

Дараагийн асуудал. Энэ улсын төсөвтэй дагаж батлагдаж орж ирсэн 25 жилээс дээш ажилласан хүмүүс дээр цалингийн нэмэгдэл яг 25 дээрээ гацдаг байдал ерөөсөө маш олон хүмүүсийн дургүй хүргэж байна. Нэг ажлын байран дээр удаан хугацаанд тогтвортой ажиллах гэдэг энэ бодлогыг бараг дэмжихгүй эсэргүүцэж байгаа юм шиг ийм юм болжээ гэдэг юм ярьж байна.

35 жил, 30 жил ажилласан хүмүүс 25 хувиа л авч байна.

Дээрээс нь нэг жилийн нэг хувь гэдэг чинь шударга юм аа, нэмэгдэж байгаа юм гэж бид хэдэд ойлгуулаад байсан. Яг хөрсөн дээр төрийн албан хаагчид биш байна. Бодитойгоор багассан байна шүү. Энэ асуудлыг та тавиарай гэдэг зүйлийг маш олон хүн хэлж байна.

Тэр цалин нь алагчлалтай. Одоо бид босоо, хэвтээ гэж яриад сурчихсан. Орон нутгаас энэ жил улсын төсөв дагаж 80 хувь хүртэл нэмж болно гэсэн. Энэ нэмэгдээгүй. Тэгээд энэ дээр хэвтээ буюу энэ орон нутгаас авч байгаа хүмүүсийн цалин нь нэмэгдчихсэн. Босоо буюу босоо тогтолцоотой томилгоотой явж байгаа улсуудын цалин нэмэгдээгүй. Энэ асуудлыг ер нь мэдэж байгаа юу. Мэдэж байгаа юу? Тэрийг асууя.

Тэр төрийн албаны шалгалтыг одоо энэ байгаль хамгаалагч, энэ хүмүүсээс авдгаа боль оо. Байгальдаа элэгтэй, тэр орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийг зүгээр л ажиллуул л даа. Одоо энэ хүмүүс чинь шалгалтад тэнцэх ч юм.../минут дуусав/

Г.Занданшатар: 83. Самдангийн Цэдэндамба гишүүн хариулна. Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор С.Цэдэндамба хариулна.

С.Цэдэндамба: Ц.Туваан гишүүний асуусан дөрвөн асуултаас хоёр, гуравт нь хариулахыг бодъё. Манай бусад гишүүд хариулах байх.

Сүүлийн асуулт. Төрийн албаны шалгалтыг байгаль хамгаалагч, энэ юунаас болиоч ээ гэдэг ийм санал тавьж байна. Зүгээр энэ бас түрүүн хэлсэн. Энэ салбарын хуулиудад тухайн салбарын албан хаагчдыг, байгаль хамгаалагчдыг малын эмнэлгийн мал эмчийг төрийн албан хаагч байна гэдэг зохицуулалт хийчихсэн учраас л Төрийн албаны зөвлөл хуулийн дагуу авахаас аргагүй байгаа.

Хэрвээ энэ асуудлыг шийдье гэвэл бас шийдэл бий. Манай хууль санаачлагч нар тэр салбарын хуулийн энэ ангилал, төрлийг нь өөрчлөөд өгье гэдэг хууль санаачлаад шийдэх юм бол бас гарц байгаа гэдгийг анхааралдаа авна уу гэж хүсэж байна.

Үнэхээр тэрнээс үүссэн асуудлууд байгаа юу гэвэл байгаа.

Хоёр дахь, цалингийн нэмэгдэл. Энэ дотроо хэд хэдэн асуулт байна. Ажилласан жилийн нэмэгдэл 25 жил дээр гацчихлаа гэж хэлж байна. Энэ үнэн. Төрийн албаны зөвлөл ямар саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд явуулсан бэ гэвэл ажилласан жил болгонд нь нэг хувийн нэмэгдлээр тооц гэдэг ийм саналыг явуулсан. 30 жил ажилласан 30 хувь, 28 жил 28 хувь гээд. Тэр хүний ажлын хөдөлмөр, жилийн хөдөлмөр үнэлэгдэх ёстой гэдэг зарчим барьсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газарт оруулсан саналыг үүнийг өсгөх боломжгүй байна. Цаанаа санхүүгийн асуудал, нөөц байхгүй гэсэн ийм тайлбар хийсэн байгаа. Тэгэхдээ яваандаа энэ шийдэгдэх байх.

Энэ нэмэгдлийн явцад зарим албан хаагчдын нэмэгдэл багассан гэж хэлж байна. Ийм тохиолдол бий. Өмнө нь 5-аас 10 жил ажилласан хүн тийм тодорхой 5 хувийг нь авдаг байсан бол одоо 4 жил ажиллаж байгаа бол 4 хувиа авдаг гэсэн ийм жоохон зөрүүнүүд байгаа. Тэгэхдээ энэ нь яг ажилласан цаг хугацаандаа нийцэж байгаа учраас шударга зарчим юм болов уу. Цаашид энэ зарчмаа барьж явъя гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгэхээр босоо буюу төвөөс томилогддог байгууллагуудын албан хаагчид орон нутгийн зарим, тэр дундаа нийслэлийн захиргааны албан хаагчдын цалин зөрүүтэй байгаа. Мэдэж байгаа юу гэж байна. Мэдэж байгаа. Тоо хэмжээг нь гаргаад, тооцооллыг нь хийгээд.

Энэ жилийн төсвийн ерөнхий төсөөллийн өмнө энэ асуудлыг төсвийн тооцоонд оруулж өг гэдэг саналаа Хөдөлмөрийн яам, Засгийн газарт өгсөн байгаа гэсэн ийм тайлбарыг өгье. Манай бусад гишүүд нэмэх байх.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 12-ын В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт сурагчид Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтоно гэж байгаа. Хүүхдүүдээ амжилт хүсье.

88. Ганбаатарын Билгүүн. Ажлын албаны дарга хариулъя.

Г.Билгүүн: Г.Билгүүн. Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга. Ц.Туваан гишүүний хоёр дахь асуултад хариулъя.

Өнөөдөр үдээс өмнө Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 6 мянга гаруй төрийн албан хаагчтай холбоотой мэдээлэл хийсэн юм шиг байна. Бид энд байсан учраас яг тодорхой мэдээлэл одоогоор авч амжаагүй байна.

Зүгээр бид юу гэж ойлгож байна вэ гэхээр сар гаруйн өмнө Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Засгийн газрын харьяа бүх байгууллагуудад 595 дугаартай албан бичиг явуулсан юм билээ.

Бид ажлаа уялдуулах үүднээс тэр албан бичгийг авч үзсэн. Тэр албан бичиг дээр үндсэндээ 11 зүйл дурдсан байгаа юм. Энэ 11-ийг зөрчсөн бол төрийн албанаас чөлөөл. Эсвэл хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ ав гэсэн.

Тэгэхээр Ц.Туваан гишүүн ээ, 6 мянга гэдэг бол зөвхөн нөгөө КОВИД-ын хуулийн 3.2-оор томилогдсон тоо биш. Тэр Хэрэг эрхлэх газраас явсан бичиг дээр 11 зүйл тусгагдсаны зөвхөн нэг нь л.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Туваан: Түрүүн тэр мал эмнэлэг, хөдөө аж ахуйтай холбоотой юман дээр боловсон хүчний хомсдол гэдэг юманд орчихсон шүү. Энэ дээр та хэд маань анзаарч боловсролын тухай хуулиуд хэрэг хэлэлцэгдээд орж ирэх гэж байна. Энэ дээр саналаа тодорхой тавиарай.

Хоёрдугаарт, тэр хэвтээгийнхэн аваад, босоо томилгоотой улсууд нэмэгдлээ авахгүй байна гэж. Энэ зөв юм уу? Яагаад байдал, орон нутаг, газар дээр ийм байгаад байна?

Одоо нөгөө нэг төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжинэ. Дахиад алагчилсан шийдвэр болсон. Тэнд ажиллаж байгаа ТЗ биш ажилчид, дээрээс нь ТҮ-гийнхэн дахиад орж ирнэ. Соёлын салбарынхан орж ирэх. Ингээд алагчлалтай, ялгамжтай байдлаар цалин яваад байна гэдэг асуудал дээр нэг хариулт авья.

Г.Занданшатар: 82. Должингийн Баатарсайхан. Төрийн албаны зөвлөлийн гишүүн.

Д.Баатарсайхан: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Д.Баатарсайхан. Төрийн албаны зөвлөлийн гишүүн.

Нэгдүгээрт, мал эмнэлгийн малын эмч, энэ чиглэлийн мэргэжилтнүүдийн хомсдолтой байна гэдэг асуудал яг одоо яригдаж байгаа асуудал биш ээ. 2008 онд сум болгонд дээд боловсролтой 2 малын эмч ажиллуулна гээд “Монгол мал” хөтөлбөр гэж хэрэгжүүлээд гаргачихсан юм.

Гэтэл тухайн үедээ суманд тийм дээд боловсролтой 2 малын эмч байгаагүй. Дундговь аймгийн хөдөө аж ахуйн техникум, Сэлэнгийн Алтанбулагийн техникум төгссөн тусгай дунд мэргэжлийн л эмч нар их байсан юм. Тэндээс авхуулаад үүдэлтэйгээр явчихсан юм.

Хоёрт нь, бас нэг зүйл байдаг юм. Суманд Тамгын газар дотор хөдөө аж ахуйн тасаг, мал аж ахуйн тасаг гээд хоёр хоёр хүнтэй тасаг бий болгочихсон. Тасаг болохоор ангилал, зэрэглэл нь жоохон өсчхөөд нөгөө цалингийн ялгаа гарах гээд байна.

Тэгэхээр тийм хүн хомс байдаг юм. Хөдөө аж ахуйн их сургууль дээр аймгуудтай, танай аймгаас, танай сумаас сурч байгаа малын эмч, мал зүйчээр гээд ийм судалгаа хийгээд явж байгаа байдалтай саяхан би.../минут дуусав/

Г.Занданшатар: Д.Баатарсайхан гишүүн гүйцээгээд хэлчихье. 82.

Д.Баатарсайхан: Тэгээд явж байгаа юм.

Дараа нь, цалингийн алагчлал гэдэг дээр бас бодох юм байгаа юм. Босоо удирдлагатай нөхдүүд сая цалин нэмэгдэхээс өмнө суманд ажилладаг албан хаагчдаасаа өндөр цалинтай байсан юм. Сумынхан ТЗ-3-аар явж байхаар улсын бүртгэлийнхэн, нийгмийн даатгалынхан, халамжийнхан гээд ТЗ-5-аар яваад байсан юм. Төрийн сангийн мэргэжилтэн.

Тэгээд сая орон нутгийнхныг жоохон нэмэхээр ахиад өндрөөр явж байснууд нь ахиад нэмье гээд. Ингээд төсөв зардал хэцүү байна. Цаашдаа анхаарья. Энэ дээр хамтарч ажиллая

гэдэг асуудлыг Сангийн яам бас ийм санал гаргасан. Энэ дээр хамтарч ажиллахад бэлэн байгаа.

Г.Занданшатар: Болсон уу? Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Санал, үг нэг явчихсан.

Ингээд Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцлээ.

Өмнө нь Төрийн албаны зөвлөлийн тайланг бараг чуулганаар хэлэлцэж байгаагүй.

Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэж санал, дүгнэлт гарахгүйгээр хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр хэлэлцдэг байсан.

Төрийн байгуулалтын Байнгын хороон дээр ярилцаад төрийн албаны шинэчлэл, шинэтгэл, төрийн албанд тулгарч байгаа сорилт, бэрхшээл, төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах гээд энэ цогц олон асуудлууд байгаа учраас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцлээ.

Нийт 23 гишүүн асуулт асууж, үг хэллээ.

Улсын Их Хурлын Хяналт шалгалт, үнэлгээний газраас Төрийн албаны зөвлөлийн ажлын тайланд, үйл ажиллагааны тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Тэгээд гишүүдийн санал, дүгнэлт Улсын Их Хурлын Хяналт шалгалт, үнэлгээний газрын тайлан зөвлөмжид үндэслээд Төрийн байгуулалтын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлд дараах үүрэг чиглэлийг өгч байна.

Нэгдүгээрт, төрийн албанд “дабл стандарт” мөрдөгдөж таарахгүй. Нэг л стандарттай байх хэрэгтэй.

Өнөөдөр ярьж байгаа олон гишүүд өөрсдөө баталсан хуулийнхаа шаардлагыг Төрийн албаны зөвлөлөөс нэхэж байна. Форм хувцас, тэр хуулийн шаардлага, яагаад шалгалт аваад байгаа юм. Энэ дандаа нөгөө салбарын хуулиудаар болон Төрийн албаны тухай хуулиар маш өндөр шаардлагууд тавьчихсан. Түүнд нь хөдөө, сум, орон нутагт шаардлага хангасан, нийцсэн хүн олддоггүй.

Өнөөдөр суманд багшийн дутагдалтай, эмчийн дутагдалтай, төрийн албан хаагчдын дутагдалтай. Аймаг, суманд ажиллах хүчний хомсдолд бараг үндсэндээ орж байна. Төрийн албан хаагчдын.

Нөгөө талаасаа сонгон шалгаруулалтаар мянга гаруй хүн хууль бусаар томилогдсон байна гэсэн. Өнөөдөр 6 мянга болж зөрүүтэй тоо яригдаж байна.

Төрийн албаны ёс зүйн зөвлөл төрийн байгууллагууд дээр 2961 зөвлөл ажиллаж байна гэсэн. Дараагийнхаа өгүүлбэрт 567 байгууллага л өөрсдөө саналаараа Ёс зүйн зөвлөл байгуулсан. Бусад нь байгуулаагүй, жигдрээгүй. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа зөрчил төдий байна гэж байгаа юм.

Ёс зүйн зөрчил 0.1 хувиар буурсныгаа их буурсан, их сайн амжилт илрүүлж байгаа гэж байгаа боловч үүний 75 хувь нь ажлын байр дээр архи дан согтуурахтай холбоотой зөрчил байна.

Энэ архидалтаас чинь л төрийн албаны хамаг муу муухай юм эхэлж байгаа шүү дээ. Юу юу боллоо. Одоо

Төрийн ордон, байгууллагууд дээр хар хууль. Бараг Г.Занданшатарын хар хууль гэж нэрлэж байгаад архи дарс оруулахаа болиод мөрдөгдөөд эхэлсэн.

Эргээд хавтгайрах хандлага бий болсон байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль баталж шаардлагыг чангатгасан. Ажлын байран дээр архидан согтуурах юм бол эрүү, зөрчилд тооцогдож байгаа.

Тэгээд Төрийн албаны ёс зүйн хуулийг яаралтай батлах шаардлагатай. Ёс зүйг хуульчилдаггүй гээд мэргэн цэцэн хүн олон. 1992 онд ардчилсан шилжилтийн үед хуучин ёс суртахууны хэм хэмжээг хуучин нийгмийн юм гээд хэм хэмжээг байхгүй болгочихсон.

Тэгээд ардчилал гэдгийг дураараа авирлах, анархизм, бүх юм эрх чөлөөтэй, юу дуртайгаа хийж болно гэсэн ийм ойлголт гүнзгийрсэн.

Гэр бүлийн харилцаанд, төр нийгмийн харилцаанд, нийгмийн бүх харилцаанд ёс зүйн хэм хэмжээ улаан шугам, хил хязгааргүй боллоо. Энэ бүхэн чинь өнөөдрийн төрийн албаны авлига, хээл хахууль, олон юмны учир шалтгаан болж байна.

Ийм учраас нэгэнт хэм хэмжээ байхгүй болчихсон. Хуучин аман хуулиар, зан заншлын хуулиар зохицуулагддаг байсан бичигдээгүй хуулийг хуучин нийгмийн үлдэгдэл гээд тэр чигээр нь социализмын үед үгүйсгээд, социализмынхаа юмыг шилжилтийн үед үгүйсгээд ингээд хэм хэмжээ байхгүй болчихсон учраас Төрийн албаны ёс зүйн хуулийг яаралтай батлах шаардлагатай.

Ингэж байж ёс зүйг төлөвшүүлж, хэм хэмжээ болж байж дараа нь хууль шаардлагагүй болж болно.

Энэ бол төрийн албаныхаа нэр хүндийг өргөх гэсэн л хандлага. Дэлхийд хуульчилдаггүй гэж яриад байгаа. Японы төрийн албаны ёс зүйн хууль байна. Германы сахилга хариуцлагын хууль байна. Солонгосын хууль байна. Азийн оронд энэ даяарчлал, нийгмийн сошиал, нийгмийн сүлжээний эрин үед чинь ёс зүйн асуудал зөөлөн ур чадварыг нэгдүгээр шаардлага болгож тавьж байна.

Ийм учраас хууль, эрх зүйн өөрчлөлтүүдээ бид яаравчилмаар байна.

Төрийн албаны зөвлөлөөс сонгон шалгаруулалтын ажилд тодорхой ахиц гаргасан. Цахимжуулсан. Үүнийг нэг мөр мөрдүүлэх хэрэгтэй байна. Төрийн бүх өмчийн компаниуд ажиллуулах хэрэгтэй.

Зөвхөн “Эрдэнэс Монгол” дээр биш. Төрийн өмчийн бүх тэр хэдэн зуун компани байдаг юм. Дархан, Эрдэнэтээс нь авхуулаад бүх газар.

Ингээд төрийн албанд чинь төрийн албаны нэр хүндийг унагааж байгаа зүйл чинь нам, бүлэглэл, хэсэг, бүлгийн эрх ашгийг төлөөлсөн хүмүүс энд тэнд цүнх баригчид нэрээр дүүргээд. Тэр хүмүүс төрийн албаны нэр хүндийг унагаж янз янзын асуудалд холбогдож байгаа.

Монгол төрийн алба аль ч намын үед дампууруулж ирснийг таслан зогсоох хэрэгтэй. Цэвэр сонгон шалгаруулалтын засаглал гэдэг юмаа тогтоох ёстой.

Ийм учраас цаашдаа хөдөө орон нутагт боловсон хүчин олдохгүй байгааг, төрийн албаны нэр хүндийг өргөх, улмаар төрийн албан хаагчдын нэр хүндийг өсгөх шаардлагатай байна.

Сумдад төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин маш ялгавартай тогтоогдож, маш их хэл ам гарч байна. Иргэдийн төлөөлөгчдийг төрийн албанд гуравны нэг нь ажиллана, ажиллахгүй гэсэн ялгаатай олон шийдвэр гарснаараа иргэдийн Хурал, Засаг даргын Тамгын газруудын харилцан хяналт, тэмцэл алдагдаж байна. Үүнийг нэг мөр мөрдүүлэх хэрэгтэй байна.

Цалингийн систем зах замбараагүй боллоо.

Ийм учраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудлыг, нийгмийн баталгааг хангах асуудлыг шийдвэрлэж байж төрийн албанаас бид ёс зүйн хариуцлагаа давхар шаардана.

Олон Улсын Валютын Сангийн шаардлагаар энэ хэмжээндээ царцаах ёстой байсан. Тэр үед 180 гаруй мянган л албан хаагч байсан. Одоо 225 мянга 205-д хүрчхээд байна.

Ямар хүчин чадлаар хэдэн хүн ажиллаж болох ажлыг хэдэн хүн хийж байна гэдэг ажлын байрны дүгнэлт, зураглал гаргаж энэ дээр эрс шинэчлэл хийе. Ингэж байж цалинг нэмэгдүүлсе.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо нэмэгдээд, багш, эмч нарын цалин нэмэгдээд, орон тоо нэмэгдээд байна гэж байгаа боловч яг нарийвчлаад үзэх юм бол тийм биш байна шүү.

152 мянган төрийн үйлчилгээний албан хаагчид байгаа гэж байгаа чинь дотроо нарийвчилж үзвэл бодит байдалтай зөрж байна. Тоо баримтууд чинь.

Ийм учраас төрийн албыг цомхон, чадварлаг болгох замаар төрийн албан

хаагчдын цалин, нийгмийн баталгааг хангах хэрэгтэй байна.

Төрийн өмчийн бүх компаниудыг сонгон шалгаруулалтаар, төрийн албыг бүгдийг нь сонгон шалгаруулалтаар томилж “шүүр” ажиллагаагаа жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Тэгээд доор байгаа энгийн ажилчдыг дарга нар нь шүүрддэг тийм ажил байж таарахгүй. Яг тэр сонгон шалгаруулалтаар бус, хууль бусаар томилогдсон хүмүүсээ дээр дооргүй нэг стандартаар, нэг зарчмаар л хандаж цэгцэлж жигдлэх хэрэгтэй.

Тэр суманд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн асуудал, тэр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын нөхцөл байдлын талаар хөдөө орон нутгаас маш их асуудлууд ирж байна.

Ингэж ер нь төрийн албаны нийгмийн баталгааг нь хангасан, цалинг нь өсгөсөн.

Тэгээд дээр нь ёс зүй, сахилга шаардлагыг нь хангасан ийм нэг эрс шинэчлэл реформыг хийх хэрэгтэй. Энэ дээр хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлэх талаар Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарч шаардлагатай өөрчлөлт дээр Төрийн албаны зөвлөл тоо, судалгаагаар хангаж хамтарч хийх хэрэгтэй.

Төрийн албаны зөвлөлийг сая олон гишүүд шүдгүй арслан, хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага гэх мэтээр томьёолж тодорхойлж байна.

Тэгэхээр хуулиар бүх эрх мэдэл нь байгаа. Шаардлага тавьж, одоо жинхэнэ утгаараа ажиллаж эхлэх шаардлага, тэр боломж Төрийн албаны хуульд байгаа.

Тэгээд болохгүй байвал тэр хуулиа оруулаад ир. Боловсруулаад ир.

Ингээд энэ онд ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулъя, авлига хээл хахуультай тэмцье гэж байгаа уг үндэс маань төрийн албаны өөрчлөлт шинэчлэлтээс эхэлнэ.

Төрийн албанд байгаа хүмүүсийг тэр Шүгэл үлээгчийн хуультай уялдуулах хэрэгтэй. Төрийн алба нь дотроосоо л шүгэл үлээнэ шүү дээ.

Тэр хүмүүсийн хөдөлмөрийн баталгаа, Хөдөлмөрийн хууль, Төрийн

албаны хуулиар баталгааг нь хангах асуудлыг Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгах хэрэгтэй.

Ингээд нэг цогц өөрчлөлтийг хийхийг Төрийн байгуулалтын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлд 23 гишүүний хэлсэн санал, дүгнэлт, Улсын Их Хурлын Тамгын газрын хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээнд үндэслээд ийм чиглэлийг өгч байна.

2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцлээ. /алх цохив/

Дараагийн асуудалд орно.

Хоёр.Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл

/Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, А.Адъяасүрэн, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Н.Ганибал, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар нараас 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл

суутган төлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нар ажиллалаа.

Байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Ажлын хэсгээс манай улсад өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалд хамрагдвал зохих малчдын тоо 238 мянга 329 байдгаас 48 мянга 800 буюу 20.5 хувь нь сайн дурын даатгалд даатгуулсан.

Эрүүл мэндийн даатгалд 141 мянга 400 малчин хамруулахаас 49 мянга 200 буюу 34.8 хувь нь хамрагдсан байгааг танилцуулж, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа нь ирээдүйд эдгээр иргэдийн нийгмийн баталгаа алдагдаж, улмаар халамжийн зардал өсөх, улсын төсөвт ачаалал нэмэгдүүлэх тул хамрах хүрээг өргөтгөх арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр зарчмын зөрүүтэй 8 санал, найруулгын шинжтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны

санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Басангийн Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Мэндбаярын Дондогдорж тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал тус яамны Хуулийн хэлтсийн дарга, Ламжавын Бямбасүрэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Өлзийбаярын Бодьгэрэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Санжмятавын Лхагвадорж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Жигжидийн Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Хөдөө хөрч гадаа хандаж байгаа хэдэн малчдын талаар анхаарал халамж тавьж байгаа нь маш зөв зүйтэй.

Ялангуяа энэ хуулийг өргөн барьсан нь манай Ардчилсан намын

нэлээн хэдэн гишүүд байгаа юм шиг байна.

Гэхдээ үр дүнгүй хэд хэдэн арга хэмжээ хэрэгжүүлж байгаа л даа. Энэ Засгийн газар, энэ Монгол Ардын намынхан. Тэр “Хөдөөгийн сэргэлт” ч гэнэ үү. Тийм ээ.

Тэгээд ер нь дэлхий нийтийн судалгаагаар ойрын тав, арван жилд хотжих хөдөлгөөн бол тэртээ тэргүй явагдана шүү дээ. 70 хувь нь хотжино гэж байгаа. Энэ бол баталгаатай. 80 хувь нь. Тэгвэл. Хотжино гэж байгаа.

Тэгээд урсгал сөрж урсаж байгаа зөрүүд хүн шиг л байх юм. Аан.

Одоо тэр хэдэн малчдынхаа. Ер нь бараг эрэгтэйчүүд болчихсон доо. Хэдэн залуучууд л үлдээд байгаа шүү дээ. Тэр хэдэн хөгшчүүд нь тэтгэвэрт гараад л тэгээд л дуусна. Гарчихсан ч байгаа. Зарим нь.

Тэгээд дундаж наслалт 65. Тэр эрэгтэйчүүд нь 60 хүрч байна уу, үгүй юу. Ийм л байдалтай байгаа. Энэ мөнгийг улс шууд даачих хэрэгтэй. Ерөөсөө. Тэгээд л хөдөө гарсанд 3 хувийн зээл өгнө ч гэх шиг. Үгүй энэ уул уурхай энэ тэр яваад цөлжөөд гандаад энэ бэлчээргүй болоод дуусаж байгаа шүү дээ. Тэр гүний уурхай энэ тэр явчихаар чинь гүний ус нь байхгүй болчихдог юм байна. Цөлжилт явагддаг юм байна. Энэ хэдэн малчид маань тал талаасаа хавчигдаж байгаа шүү. Ер нь.

Яагаад вэ гэхээр тэр өргөн уудам нутагт ер нь бараг л эр цэргүүд гэсэн ч болно доо. Эзэнтэй байлгаж байгаа шүү дээ энэ улс орныг.

Одоо энэ урамшууллаар нь яг хэдэн төгрөгөөр хэдэн малчин урамшдаг

юм? Жилд. Хэдэн хүн нийгмийн нийгмийн даатгалаа төлөх боломжтой юм? Ийм гаргасан юм байна уу?

Би бол энд маш цөөхөн хүн хамрагдах юм шиг байна лээ. Намайг орон нутагт ажиллаж байхад ярьж байна лээ. Энэ хуулийн агуулга, үзэл санаа нь зөв боловч яг хамрах гэхээр цөөхөн хүн байгаа шүү.

Ер нь та очоод хэлчхээрэй. Тэр хотоос баахан хүн авчирна гээд байгаа. Тэр нь ирээд л буцаад л. Нөгөө **“Шинэ гэр бүлийн мөнгө”** гэдэг шиг юм болно шүү. Монгол Ардын намынхан дандаа л нэг тийм амьдралгүй бодлого явуулдаг. Тэгээд тухайн үедээ л оноо авах гэсэн.

Ийм юм хэрэггүй ээ. Хоёр зуун хэдхэн мянган малчид байгаа. Тэтгэвэрт гарчихсан нь хэд байна вэ? Одоо хэдэн залуучууд л байна шүү дээ. Энэ хэдэн охидууд нь тэгээд сургууль, соёл, энэ тэр гээд Улаанбаатарт ороод ирсэн. Буцдаггүй. Тэр хүүхдүүдийг бас буруутгах аргагүй. Залуучуудыг. Мэдээж хэрэг соёлтой газар байна. Аргагүй. Дэлхий нийтээрээ тийм байгаа юм чинь яах юм.

Тэгэхээр байгаа хэдэн малчдаа бас эрүүл мэндийн үзлэгт, нийгмийн даатгал, тэтгэвэртэй байлгахын тулд үүнийг нь улс, засаг даачих хэрэгтэй. Тэртээ тэргүй татвар төлөгчдийн мөнгийг хаа хамаагүй зарцуулаад үрж байгаа шүү дээ. Ямар ч хэрэггүй юманд. Ингэж зарцуулдаг.

Ийм бодлого баривал яасан юм бэ. Ингээд шийдчихвэл зөв байх. Ер нь тэгвэл ч хөдөө гараад мал маллаад явчих айлууд ихсэх байх.

Энэ хэдэн хямдхан мах. Үүний хүчинд л одоо энэ хэдэн Монголчууд чинь амьдарч байгаа шүү дээ.

Тэгээд малчдын талаар анхаардаг бодлого, энэ тэр гэдэг юм маш муу байгаа, сул байгаа. Тэр ярих хэлэх юмнаас хэтрэхгүй байгаа.

Малаа ярихаас гадна бид хүнээ ярих ёстой. Тэр нийгмийн даатгалд нь, эрүүл мэндийн даатгалд нь хамгийн наад талын тэр мөнгө төгрөгийг нь төлөөд өгчих хэрэгтэй байгаа юм. Яг ялгаж салгаад.

Тэрийг ч энэ уул уурхайнаас баахан татвар төлж байгаа. Энэ уул уурхайг нь ашиглаж байгаа. Энэ гадна, дотнын компаниуд. Тэгээд дундаас нь баахан авлига авч байгаа. Тэгээд ард түмэнд наалддаггүй.

Г.Занданшатар: Д.Ганбат гишүүн маш зөв юм ярьж байна шүү. Хэдэн малчдаа хайрлах хэрэгтэй л дээ.

Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуйн яам. Тэр Малчдын талаар төрөөс баримтлах бодлого оруулж ирнэ гэсэн. Яасан? 83.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Яаман дээр сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Мал аж ахуйн салбарын стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад гурав дахь удаагаа хуралдаад ерөнхий төлөвлөгөөнийхөө төслийг боловсруулчихсан байгаа.

Удахгүй үүнийг Засгийн газарт танилцуулаад улмаар шаардлагатай гэвэл Их Хуралд танилцуулахаар энэ төлөвлөгөөгөө оруулахаар бэлтгэл ажлаа хангаад ажиллаж байгаа.

Энэ төлөвлөгөөтэй холбоотой бид салбарын эрдэмтэн, судлаачид, тэгээд ер нь мал аж ахуйн салбар цаашдаа ямархуу чиглэлтэй байх нь вэ гэдэг тал дээр өнгөрсөн жил “Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай төлөвлөгөө”-ний адилаар төлөвлөгөөгөө нарийвчлаад, шаардлагатай төсөв, мөнгөтэй нь боловсруулсан ийм төлөвлөгөө гаргая гэдэг байдлаар олон талын судалгаануудыг гаргаж байна.

Энэ төлөвлөгөөг боловсруулсны дараа хэд хэдэн хэлэлцүүлгийг хийнэ. Үүний дараа оруулж ирж танилцуулъя гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Тэгээд энэ “Мал аж ахуйн талаар баримтлах бодлого” гээд байх юм. Тэгээд малчингүйгээр бэлчээрийн хууль ярина, малчны бодлогыг ярихгүйгээр мал аж ахуйн бодлого ярина. Энэ нүүдлийн мал аж ахуй чинь малчингүй боллоо. Малчдын залуу халаа байхгүй боллоо. Залуу малчид гадаад, дотоод явна гээд, хот суурин бараадна гээд байхгүй. Малчдын залуу халаа байхгүй болчихлоо гэж бүх малчид ярьж байгаа шүү дээ.

Тийм учраас бодлогоо тодорхой болгохгүй бол монгол махгүй болчихвол яах вэ гэдэг асуудлыг Д.Ганбат гишүүн чухал асуудал хөндлөө шүү дээ.

Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна.

Д.Ганбат: Их Хурлын дарга бид хоёр нэлээн чухал асуудлыг хөндөж яриад байхад та хэдийн хариулж байгаа царай энэ тэр. Аан. Бас хэцүү байна шүү.

Тэгээд юу шүү дээ. Миний асууж байгаа асуулт тов тодорхой шүү дээ. Энэ

урамшуулалд хэчнээн хүн хамрагдаж болж байгаа юм бэ? Хэдий хэмжээний юм өгдөг юм бэ? Тэрийг тодруулж байна.

Нөгөө талаар шууд даачих, төлчих боломж байгаа юу? Тэр уул уурхайгаас орж ирж байгаа. Тэд нарыг бэлчээргүй болгосныхоо төлөө энэ уул уурхайн компаниуд. Түүнд нь уялдуулаад шийдэж болох уу?

Тэгээд хүний орлогыг бас дур мэдээд хуульчлаад зарчих чинь ямар билээ? Хууль эрх зүйн талаасаа харсан, мэдсэн юм байна уу?

Манай гишүүдийн тавьж байгаа сэтгэл арга ядаад л явж байна шүү дээ. Хэдэн малчдаа бодоод. Үүнийг та нар аль дээр үед бодоод судлаад хийчихсэн байх ёстой.

Ялангуяа тэр Их Хурлын даргын хэлээд байгаа тэр мал нь байгаад, бэлчээр нь байгаад малчингүй болчихвол яах юм гээд.

Г.Занданшатар: Ц.Болорчулуун дарга хариулья. 83.

Ц.Болорчулуун: Тэгэхээр хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үндсэндээ 5 төрлийн урамшуулал байгаа.

Газар тариалангийн үйлдвэрт улаан буудайн урамшуулал. Өнгөрсөн жилээс хүнсний ногооны урамшууллыг олгож эхэлсэн. Сүүний урамшуулал. Дээрээс нь ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал гээд байгаа.

Өнгөрсөн жил, 2022 оны тухайд гэх юм бол нийтдээ 90.6 мянган малчинд 30.9 тэрбум төгрөг, 47.6 мянган малчинд 12.7 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байгаа.

Г.Занданшатар: Тэгээд энэ үзэл бодол зөрж маргалдаж тэмцэлдэж болох боловч үнэн хэрэгтээ Монголын төлөө, монгол малчны төлөө Улсын Их Хурлын гишүүд санал нэгтэй байх ёстой байгаа юм. Яам ч гэсэн үүнийг анхаарах ёстой байгаа юм.

Тэрийг л онцолж тэмдэглэж хэлж байгаа шүү дээ. Түүнээс энд зүгээр нэг яриа биш.

Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Энэ төрөөс олгогдож байгаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний урамшууллаас тодорхой шимтгэлүүдийг авах тухай хууль гарч ирж байгаа юм.

Тэгээд энэ хуулийн үзэл баримтлал нь өөрөө сайн дурынх юм билээ. Нийгмийн даатгалын шимтгэл заавал хийх, сайн дур гэсэн хоёр л ангиллаар явж байгаа л даа.

Тэгээд сайн дурын даатгал төлөх ёстой тэр бүлэглэлийн хүмүүс дээр дахиад төрөөс олгож байгаа урамшууллаас нь сайн дураар авахаар ингээд хуульчилчихаар одоо ямар үр дүн гардаг юм гэж. Ийм л зүйл гарч ирээд байгаа юм.

Эрүүл мэндийн даатгал бол заавал даатгал биз дээ. Энэ чинь. Үгүй тэгээд заавал даатгалыг бид авдаг арга механизмаа л олж чадаагүй, авч чадахгүй л байгаа л асуудал шүү дээ. Тэгээд үүнийгээ яаж шийдэх ёстой юм?

Ер нь нийгмийн даатгалын шимтгэл гэдэг татвар биш. Тодорхой насны босго алхаад буюу тэр хөдөлмөрийн чадвар юм сулрах үед нийгмийнхээ баталгааг хангах зорилгоор

урьдчилж төлж байгаа өөрийнх нь хуримтлалын мөнгө.

Тийм учраас тэр улсуудыг тодорхой насны босго алхсаны ар дээр нь нийгмийн баталгааг нь хангая гэж үзэж байгаа бол ер нь нийгмийн даатгалыг яаж хүн болгоноос тодорхой хэмжээний мөнгө авч даатгалын нэрийн дансыг нь бүрдүүлдэг байх ёстой юм бэ? Энэ чинь заавал даатгалын систем рүү ер нь шилжих ёстой зүйл биш юм уу?

Тэр тусмаа малчдын тухай асуудал яригдвал нүүдэлчдийн өв соёлыг тээж яваа ганц салбар нь.

Тэгэхээр аялал жуулчлал, элдэв бусын юм ярихаар зэрэг бид үндэснийхээ өв соёл дээр тулгуурласан юмыг хөгжүүлнэ гэж ярьцгаах. Үүнийгээ тогтвортой авч явна гэвэл өв соёлоо тээж яваа хэсгээ төрийн бодлогоор яаж дэмжиж, тэтгэж, тогтвортой байлгах юм гэдэг тухай л асуудал байгаад байгаа шүү дээ.

Тийм учраас үнэхээрийн ийм онцгой салбар мөн гэж бүх нийтээрээ хүлээн зөвшөөрүүлж байгаа бол энэ даатгалынх нь асуудал гэдэг юм уу, энэ аж ахуй зохион байгуулалтынх нь үйл явц тогтвортой явдаг тал дээр төр тодорхой дэмжлэг үзүүлэх ёстой болов уу.

238 мянган малчны тухай ярьж байгаа юм. Гэтэл наад малчдын чинь 20 орчим хувь нь сайн дураараа даатгалд хамрагдаад яваа юм билээ. Тэр нь жоохон амьжиргаагаа аваад явчих чадвартай, малын тоо толгой ахиутай, бас эргэлтэд орчихсон тийм малчид нь төлчхөөд яваад байгаа.

Үндсэндээ малын тоо толгой багатай тэр хэсэг нь үлдчихээд байгаа

юм. Тэгээд тэр улсуудынхаа амьдрал ахуйг дэмжих, нийгмийн даатгалд, эрүүл мэндийн даатгалд хамрагдах, түүгээрээ дамжиж эрүүл мэндийн үйлчилгээгээ хэвийн авах, тодорхой насны босго алхахаараа амьдралынхаа наад захын хэрэгцээг хангах, тэр амьдралын чанараа бий болгох, тэтгэвэр, тэтгэмжээ авах бололцоог нь бүрдүүлэх энэ л үүднээс л асуудалд хандах ёстой юм байна.

Тэгэхээр энэ дээр цааш нь лавшруулж хийсэн судалгаа юмнууд юу байна вэ? Хэдий хэмжээний мөнгө гарах гээд байгаа юм бэ? Наад хоёр зуун хэдэн мянган хүнээс чинь тэр 20 хувийг нь хасаад тооцёё гэж бодоход хэдий хэмжээний мөнгө гарах гээд байгаа юм.

Тэрийг нь төр хариуцаад даатгал хамруулах ийм бололцоо байна уу? Нийгмийн хамгааллын яам гэдэг юм уу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам гэдэг юм уу, энэ төсөл санаачлагч нарт ямарваа нэгэн тийм тов тодорхой тооцооллын санал байна уу? Үүнийг сонсьёё.

Г.Занданшатар: Байнгын хорооноос эхний хэлэлцүүлэг учраас Байнгын хорооноос л асуулт.

Энэ зарчмын зөрүүтэй 10 санал гарсан. Түүнтэй л холбогдуулж үндсэндээ хэлэлцэх эсэх дээр хууль санаачлагч ярьчихсан. Одоо хэн хариулах вэ? Байнгын хороо, ажлын хэсэг л хариулах ёстой.

Ц.Болорчулуун дарга. 87. Хөнгөн үйлдвэрийн газрын дарга хариулдаг нь яаж байгаа юм.

Б.Батжаргал: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Б.Батжаргал. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Дэлхий дээр нийтдээ универсал буюу бүх нийтийн тогтолцоо, зорилтот буюу сайн дурын, албан журам гэж хосолсон гэсэн хоёр ийм үндсэн хэлбэр байгаа.

Манай улсын хувьд хоёр дахь ангиллыг нь ашиглаж явдаг уламжлалтай.

Манай нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл дээр яг малчидтай холбоотой Ж.Батжаргал гишүүний асуусан асуултын хариулт болох зохицуулалт тусгагдсан байгаа.

Энэ ямар зохицуулалт тусгагдсан бэ гэхээр малчдынхаа нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тодорхой хугацаанд төрөөс даах зохицуулалт орсон байгаа.

Энэ дагуу тооцооллоо хийгээд үзэхээр нийтдээ 195, 200-аад мянган малчдыг хамруулна гэж тооцох юм бол нийтдээ 5 жилд 130 орчим тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 10 санал байгаа. Санал хураалт явуулна.

Энэ тоо баримтууд чинь их л зөрөөд байдаг юм шүү. 305 мянган малчин болоод малчдын тоо 7.5 мянгаар өслөө гээд л урьдчилсан тооллогын дүнгээр зарлаад л байсан. Одоо юун дээр 246 мянга гээд л байж байдаг.

Мал бүхий өрхийн тоогоо яаж салгадаг юм тэгээд.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Сая Ж.Батжаргал гишүүний хэлээд байгаа нүүдэлчдийн өв соёлыг тээж яваа нүүдэлчин Монголын удам бол малчид. Тэгээд заавал татвар болон шууд суутган авчхаж болно.

Сайн дурын даатгалыг шууд суутган авах чинь зөв юм уу, буруу юм уу гэсэн. Энэ бол бас хүний нөгөө сонгох эрх чөлөөтэй холбоотой л асуудал болчихож байгаа юм даа.

Ингээд Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “улаан буудайн” гэсний дараа “, хүнсний ногооны” гэж, “шимтгэлийг” гэсний дараа “тухайн” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Дамбын Батлут, Буланы Бейсен, Цагаанхүүгийн Идэрбат, Батсүхийн Саранчимэг, Цаашид “Ажлын хэсэг” гэнэ.

Юуны тооллого вэ? Бүртгэлийн санал хураалт уу? Бүртгэлийн санал хураалт хийгээгүй. Нэг хийгээдэх гэж үү? Бөхчулууны Пүрэвдорж гишүүний саналаар бүртгэлийн санал хураалт явуулья. /алх цохив/

Бүртгэлийн санал хураалтад Ширнэнбаньдийн Адьшаа, Норовын Алтанхуяг, Сайнбуянгийн Амарсайхан,

Телиуханы Аубакир, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Энхтайваны Бат-Амгалан, Сүхбаатарын Батболд, Д.Батлут, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, Оюунчимэг, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан нар бүртгэгдээгүй байна.

Санал хураалт явуулна. Тэгэхдээ энэ байна шүү дээ. Хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн үү? Сайд аа, Х.Болорчулуун сайд аа, С.Чинзориг сайд аа,

Эрүүл мэндийн даатгалын сангийн чинь мөнгөн орлого л нэмэгдэнэ гэсэн. Одоо бол “улаан буудайн” гэсний дараа “хүнсний ногооны” гэж, “шимтгэлийг” гэсний дараа “тухайн” гэж тус тус нэмэх ийм зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулах гэж байна. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Энэ санал хураалт дэмжигдэхгүй бол төслөөрөө үлдэнэ гэсэн үг. Ажлын хэсэг Ц.Сандаг-Очир гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажилласан.

52.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрөөс олгох урамшууллаас” гэсний дараа “эрүүл мэндийн болон” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Бараг найруулгын санал. Байрлалыг нь сольж байгаа юм. Нийгмийн даатгалын болон эрүүл

мэндийн гэж байсныг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэр.

56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ж.Батсуурь гишүүнийг дэмжсэнээр тооцох санал гарсныг тусгана уу.

3.Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “, шаардлага” гэснийг хасаж, мөн зүйлийн 3.1 дэх хэсгийн “улаан буудайн” гэсний дараа “, хүнсний ногооны” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир гишүүний санал. Хүнсний ногоог нь Ж.Батжаргал нарын гишүүд нэмсэн шүү дээ. Ноднин. Урамшуулалд.

4.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмэх:

“3.2.Төрөөс олгох урамшуулал авах эрх үүссэн иргэн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг уг урамшууллаас төлж болно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн Нямаагийн Энхболд, Цэндийн Сандаг-Очир, Баттөмөрийн Энхбаяр нарын гишүүдээр тасаллаа.

Нямаагийн Энхболд гишүүн. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Халдашгүй байдлын дэд хорооны гишүүн.

Н.Энхболд: Баярлалаа. Энэ саналыг дэмжиж байгаа юм.

Ер нь яг энэ санал дэмжигдэж байгаатай холбогдоод Ц.Сандаг-Очир гишүүн ээ, Ц.Туваан гишүүн ээ, сайн сонсож байгаарай.

Тэр ард нь энэ 3.2-ыг угаасаа хасчхаад энэ шинээр оруулж байгаа юм байна. Тийм ээ. Яг ингэж явах ёстой юм. Тэгэхгүй бол хүрээ, шаардлага гэж баахан явж байснаа хамгийн сүүлд 3.3 дээр нь ийм заалт байх чинь нэгдүгээрт, дараалал нь.

Хоёрт, энэ дээр нэг ийм логикийн асуудал байгаа юм. Энэ чинь хариулахгүй байх. Санал хэлэх байх. Тэгэхдээ манайхан бодоорой.

Энэ нэг эрх мэдэл өгч байгаа юм шиг ийм заалт орж угаасаа болохгүй л байсан л даа. Тэр мөнгөнөөсөө өөрөө төлнө үү, төлөхгүй байна уу тэр хүний эрхийн асуудал шүү дээ. Тэгэхэд нь эрх нээж өгөөд л. Хаалга онгорхой байхад л чи үүгээр ор гээд л тэгээд байгаа юм шиг ийм заалт байсан байхгүй юу.

Тэгэхээр 3.3 гэдэг заалт байхгүй байх хэрэгтэй. Энэ дээрээ хасчихсан юм билээ. Нэгдүгээрт ийм зүйл байгаа юм.

Хоёрдугаарт, угаасаа төлж болохгүй гэсэн юм байхгүй шүү дээ. Урамшууллаасаа хүн сайн дурынхаа юмыг төлнө үү, өөр юманд зарна уу. Тэгээд ямар асуудал байна. Болно гэж байгаа болохоос заавал төл гэж хэлээгүйгээс л хойш энэ чинь төлөхгүй идээд л байна шүү дээ. Төлөхгүй нь бол.

Тэгэхээр энэ нэг ийм сонин болчихоод байгаа юм.

Тэгээд байна шүү дээ. Санал юу вэ гэхээр хэрэв 3.2 гээд орчихвол энэ доод талын олон шаардлага гэсэн юм байна шүү дээ. Үүнээс ерөөсөө тэр тэтгэвэр тогтоолгоогүй байх, албан журмаар даатгуулаагүй байх хоёр нь л үлдэх хэрэгтэй. Бусад нь утгагүй заалтууд байна.

Угаасаа тэр мөнгийг авчихсан хүн чинь эрх нь нээгдчихээд авахгүй байна гэж байхгүй шүү дээ. Эрх нь нээгдсэн мөртлөө аваагүй хүнээс тэр татварыг авахгүй.

Тэгэхээр “эрх нээсэн бол” гэдэг үг нь угаасаа утгагүй байна. Тэр хоёр шаардлагыг нь үлдээгээд л бусдыг нь хасчих хэрэгтэй. Нэг их олон. Тэгээд бид гар дээрээ ирсэн юмаар л ярина шүү дээ.

Тэгээд тэр шаардлага бол даатгалд хамрагдаагүй, тэтгэвэр тогтоолгоогүй байх, албан журмаар даатгуулаагүй байх.

Г.Занданшатар: Ойлголоо. Нямаагийн Энхболд гишүүн ээ. Тэр дараагийн заалт юм байна. Энэ заалтыг Та дэмжиж байгаа заалт хэлчихлээ. Дараагийн заалт дээр саналыг авлаа.

Цэндийн Сандаг-Очир гишүүн. Ажлын хэсэг саналаа дэмжиж хэлж болно.

Ц.Сандаг-Очир: Дарга аа, 3.2-ыг бид ярьж байгаад 4 дүгээр заалт руу оруулья гэдэг. Тэгээд танаас гүйцээн боловсруулах чиглэл авахаар санал хураалгамаар байгаа юм.

Тэгээд сая Нямаагийн Энхболд дарга яриад байгаа. Энэ хуулийн чинь амин судас нь, зүрх нь ерөөсөө өөрийнх нь хүсэлт байхгүй юу.

Тэгэхээр тэр тавигдах шаардлага дээр тэр 4.1.3-ыг Та шаардлагагүй гээд байгаа. Энэ нь өөрөө зөвшөөрлөө л гаргасан байх ёстой юм. Түүнээс хүчээр гэдэг юм уу, авах юм ерөөсөө байхгүй. Тэгж байж энэ асуудлын энэ хуулийн харилцаа үүсэж байгаа юм.

Тухайн иргэн өөрөө авахыг зөвшөөрсөн хүсэлтээ гаргаж байж, тэгж байж энэ харилцаа үүсэх юм.

Тийм учраас тэр дараагийн санал хураалт дээр 4.1.3 дахь заалт бол заавал ч үгүй байх ёстой шүү гэдгийг хэлье.

Тэгээд 3.2 дээр байгаа энэ заалтыг гүйцээн боловсруулах чиглэлээр чиглэл өгөөч ээ гэж даргаас хүсэж байгаа юм.

Г.Занданшатар: Энэ дараагийнхаа 5 дугаар санал хураалт буюу 4 дүгээр зүйлтэй нийлүүлж гүйцээж боловсруулах юм уу, дангаар..,

Ц.Сандаг-Очир: Тийм. Тийм тийм. Яг үнэн.

Г.Занданшатар: 4, 5 хоёрыг нийлүүлээд гүйцээн боловсруулахад чиглэл өгчих юм уу? Тийм ээ.

Ц.Сандаг-Очир: Тэгье тэгье. Яг үнэн.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлэх үү? Үүнийгээ гүйцээж хийлгэчих үү? Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Дарга гүйцээн боловсруулах чиглэл өгөх гэж байгаа учраас гүйцээн боловсруулах шатанд тэгвэл анхаараасай гэж үгээ хэлье.

Би бол яг энэ саналын томьёоллыг дэмжихгүй үг хэлж байгаа юм.

Яагаад дэмжихгүй үг хэлж байгаа вэ гэхээр энэ хуулийн маань үндсэн зорилго бол төрөөс урамшуулал авна. Энэ урамшууллаа авчхаад нийгмийн болон эрүүл мэндийн даатгалаа төлөхгүй байгаа хүмүүсийн тухайтад. Өөрөөр хэлбэл идчихээд байгаа, уучхаад байгаа гэдэг асуудал үүсээд байгаа учраас энэ идээд, уугаад байгаа мөнгөө эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалд хамруулаач ээ л гэж орж ирсэн хуулийн төсөл гэж би ойлгосон байхгүй юу.

Тэгтэл бүхэлдээ энэ хуулийн зорилгоо үгүйсгээд дахиад үргэлжлүүлээд идээд, уугаад байж болно гэдэг ийм сонголт үлдээсэн заалт хураах гээд байгаа юм.

Хэрвээ ийм сонголт үлдээх юм бол энэ хуулийн үр нөлөө, утга байхгүй бас болчихно. Сулраад явчихна.

Тийм учраас сонголтгүй байх ёстой. Төрөөс нэгэнт урамшуулал өгөөд байна. Тэгээд байхад эрүүл мэндийн даатгалаа төлөхгүй байна, нийгмийн даатгалаа төлөхгүй байна. Ер нь жоохон эрхлүүлж байна шүү дээ.

Хүний нийгмийн даатгал, эрүүл мэнддээ өөрөө анхаарал тавих юм бол уг нь өөрийнх нь ухамсар, хариуцлагын асуудал шүү дээ. Тэгээд л бид улам эрхлүүлээд л, улам хариуцлагыг нь сулруулаад л. Тэгээд эвий минь гээд л байдаг.

Хотын бид нарт ийм эвээл юу ч байхгүй байгаа шүү дээ. Ер нь. Тэгээд хотын бид нар чинь бас ойлгоод энэ хуулийнхаа төслийг дэмжих эсэхийг нь дэмжихсэн.

Тэгэхээр энэ ярианы хүчийг сулруулмааргүй байна. Хэрвээ сонголт

үлдээх юм бол энэ хуулийн үр нөлөө, утга, тооцоолол хийх бас аргагүй болчхож байгаа байхгүй юу. Тэгвэл урамшуулал хийх ер нь өгөх ёстой юм руугаа орно шүү. Ер нь. Бүр нарийн яривал.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн ахлагч Цэндийн Сандаг-Очир гишүүний саналыг үндэслээд энэ 4, 5 дугаар зүйлийг гүйцээн боловсруулах чиглэл өгчихье.

Эрүүл мэндийн сайд бас энэ дээр саналаа өгнө биз. Сая тэгш, шударга ёсны зарчмын хувьд, хууль дээдлэх ёсны хувьд Баттөмөрийн Энхбаяр гишүүний санал үндэслэлтэй.

Бидний цалингаас, хэн нэгний цалингаас, иргэн Доржийн цалингаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авахдаа асуудаггүй. Хүсэлт гаргуулдаггүй. Орлого гэж тооцоод л олж байгаа орлогын тодорхой хувиар нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутган авдаг.

Тэгэхээр энэ бол суутган авах хууль болохоос биш хүсэлт гаргаад тэгээд процесс хийгээд ингээд явах юм бол хэрэгжихэд их хүндрэлтэй хууль болчихно. Яг энэ хүүхдийн мөнгөн дээр ямар маргаан гарлаа. Өгсөн, авсан энэ тэр гээд бөөн маргаан болно.

Тийм учраас энэ бол заавал шинж чанартай байх ёстой. Ийм заалт болгож гүйцээн боловсруулах шаардлагатай байна. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. 4, 5 хоёрт. /алх цохив/

Г.Занданшатар: Зочин танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 11-ийн Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт сурагчид Та бүхний спорт, сурлагын ажилд өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтоно гэж. Сайн сурцгаахыг хүсье.

4, 5 дугаар заалтуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас 6 дугаар заалтаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын 4 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсгийг тус тус хасах.

4 дэх санал хойшлогдсон учраас энэ саналаар санал хураалт явуулахгүй. Хойшлуулж байна.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “төв байгууллагаас” гэснийг “төв байгууллага энэ хуулийн 4.1-д заасан журмын дагуу суутган эрүүл мэндийн болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Содномын Чинзориг гишүүн, Цэвэгдоржийн Туваан, Нямаагийн Энхболд гурван гишүүнээр тасаллаа.

С.Чинзориг: Байнгын хороон дээр би уг нь санал хэлсэн юм. Уг нь ажлын хэсэг тэр миний хэлсэн саналыг хүлээгээд авчихсан бол саяынх шиг гүйцээн боловсруулах гээд энэ 4, 5 дахь санал санал хураагдахгүй, хойшлохгүй байх байсан юм л даа.

Тэгээд манай ажлын хэсэг ойлгоогүй. Үлдээхээд байгаа юм. Би бол Б.Энхбаяр гишүүнтэй санал нэг байгаа юм.

Энэ 4 дэх саяын тэр ажлын хэсгийн үлдээчихье, гүйцээн найруулах санал авъя гээд байгаа энэ санал чинь заавал энд урамшууллаасаа эрүүл мэндийн болоод нийгмийн даатгалын шимтгэл төлж болно гэж орох энэ заалт ерөөсөө огтоосоо шаардлагагүй заалт.

Энэ хуулийн чинь үйлчлэх хүрээ, үндсэн зорилго нь тэр урамшууллаасаа л эрүүл мэндийн болоод нийгмийн даатгалын шимтгэлийг л суутган тооцох, суутган төлөхийг л зохицуулж байгаа харилцааг зохицуулж байгаа ийм хууль шүү дээ.

Үндсэн хуулийн хүрээ зохицуулалт нь ийм байсаар байтал дотор нь үүнийг заавал нэмж оруулах шаардлагагүй. Үүнийгээ хасчих гээд би Байнгын хороондоо зөндөө ярьсан юм. Тэгээд ажлын хэсэг байлгаж байя гээд ингээд үлдээчихсэнээс болоод гишүүдийн дунд маргаан үүсгээд. Тэгээд энэ санал хураалт хураагдсангүй. Гүйцээн боловсруулах гээд чиглэл авчихлаа л даа.

Тийм учраас ажлын хэсэг дээрээ яриад энэ 4 дэх томъёолол буюу тэр 3.2 дахь заалтыг тэр чигээр нь хасчих хэрэгтэй байгаа юм. Ц.Сандаг-Очир гишүүн ээ.

Би уг нь эртээд Байнгын хороон дээр зөндөө ярьсан юм шүү дээ.

Хуулийн би зарчмыг нь дэмжээд л байгаа юм. Одоогийн байгаа хуулийн зохицуулалт ийм байгаа юм л даа.

Ер нь цаашдаа Нийгмийн бодлогын байнгын хороо Засгийн газраас өргөн барьсан Нийгмийн даатгалын хуулийг боловсронгуй болгох хүрээнд тэтгэвэр бодох аргачлал, эд нараа нэлээн харж үзэж сангийн алдагдлыг нэмэгдүүлэхгүй бууруулах тийм чиглэлийн оновчтой бодлого гаргах болов уу гэж би бодоод л байгаа юм.

Малчдын болоод малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хамруулах нь зөв хэрэг. Зөв хэрэг.

Гэхдээ одоо сайн дурын даатгалд шимтгэл төлж байгаа иргэд чинь нийгмийн даатгалын шимтгэл 10 хувиар, эрүүл мэндийн даатгалын шимтгэл 1 хувиар л төлж байгаа юм л даа.

Одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 5500 гэдэг чинь сарын 55 мянган төгрөг л нийгмийн даатгалын шимтгэлд. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд нь 5500 төгрөг л орох юм.

Яах вэ, энэ нь сайн хэрэг. Малчид хамрагдаж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ нөгөө талдаа бидний тэтгэвэр бодох энэ аргачлалыг маань нэлээн боловсронгуй болгохгүй бол сан дээрээ асар их ачаалал өгч байгаа юм.

Одоо ингээд малчдын ноос, арьс ширний урамшууллыг нь суутган тооцоод шимтгэлийг нь төлж байгаа гэдэг нь нэг талын сайн хэрэг. Нөгөө талдаа нийгмийн даатгалын сан дээр асар их ачаалал ирж байгаа ийм л асуудал.

Үүнээс чинь ингээд бодоход одоо бид ингээд сарын 55 мянган төгрөгийн шимтгэл төлөөд л тэгээд л хоёр, гурван жилийн дараа бүрэн тэтгэврийн доод хэмжээ 550 мянган төгрөг байна.

Бүрэн тэтгэврийн доод хэмжээ нэмэгдэхгүй бол энэ хэмжээгээр 550 мянган төгрөгийн тэтгэвэр авахаараа сарын 55 мянган төгрөгийн тэтгэвэр авчхаад л тэгээд тэтгэвэрт гарахлаараа 550 мянган төгрөгийн тэтгэвэр аваад ингээд төлсөн шимтгэлээсээ 10 дахин өсгөж тэтгэвэр авах, энэ хэмжээгээрээ сангийн алдагдал нэмэгдэх сөрөг юмнууд байгаа юм.

Тийм учраас цаашдаа Засгийн газраас өргөн барьсан нийгмийн даатгалын хууль тогтоомжийг Байнгын хороо хэлэлцүүлж Их Хуралд оруулахдаа ер нь тэтгэвэр бодох аргачлалаа бид яах юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ямар харьцаатай бодож байх вэ гэдгээ нэлээн сайн бодохгүй бол энэ сангийн чинь алдагдал нэлээд их нэмэгдээд байгаа юм.

Бид сангаа муу хэлээд л байдаг. Хамгийн энэрэнгүй хууль л манай нийгмийн даатгалын хууль байгаа юм л даа.

Г.Занданшатар: Нийгмийн даатгалын хууль дээр энэ асуудлыг ярья.

Тэгэхдээ нэгхэн сарынхыг төлөөд шууд тэтгэвэрт гарчихна гэж байхгүй л дээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Хууль санаачлагчид нэлээн олон зүйлийг бодсон. Тэгээд энэ хууль бол “тарган мал тал бүрийн ашигтай” гэдэг шиг төрөөс олгох урамшууллаас нь тооцох энэ хууль маш олон давхар төрлийн ач холбогдолтой хууль байгаа юм.

Энэ хууль эрх зүйн орчинд малчид, ногоочид гээд нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ бэлэн мөнгөний орлогогүйгээсээ, төв, орон нутгаас хол

зайд оршдог зэргээсээ шалтгаалж төлж чадахгүй байгаа улсуудад сонголт өгч байгаа л хууль юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлаад оруулж ирсэн “Хүнсний хангамж, аюулгүй байдал” гээд 36 дугаар тогтоол дээр чинь төв, орон нутгийн хүмүүсийг хүнсээр хангая гэдэг концепц явж байгаа. Яаж хангалтын хувийг нэмэгдүүлэх вэ гэхээр урамшууллын бодлого төр засгаас хэрэгжүүлээд явчихсан юм.

Тэгэхээр тэртээ тэргүй урамшуулал авч байгаа хүмүүсийг тэндээс нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх ийм сонголтыг өгч байгаа хууль.

Нийгмийн даатгалын багц хууль парламент дээр одоо яг хэлэлцэгдэж байгаа. Концепц дотор нь нийгмийн даатгалын шимтгэлийн хамрах хүрээг өргөжүүлэх гэж байгаа юм.

Яагаад гэхээр энд хамрах хүрээ өргөжсөнөөрөө эргээд улсын төсөвт ирэх ачаалал, шимтгэл төлөхгүйгээр халамжийн тэтгэвэр авдаг энэ ачааллыг бууруулья л гэж байгаа асуудал байгаа юм.

Улсын төсөв дээр энэ хуулийг баталснаас ачаалал нэмэгдэхгүй байгаа юм.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны өөрчлөлтийг бид хийсэн. Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо руу оруулчихсан байхгүй юу. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр заавал та эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөхгүй бол эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах асуудал чинь хүндэрнэ гэсэн концепц байхгүй юу.

Тэгэхээр тэр үгийг нь хойно урд нь оруулаад байгаа хүртэл энэ рүү чиглэсэн асуудал байгаа юм. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт маш өндөр хувь руу орж ирэх юм. Энэ хууль батлагдсанаар.

Шимтгэлээрээ эрүүл мэндийн, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд ирэхээр ялангуяа сая эрүүл мэндийнх дээр хэлчихсэн. Нийгмийн даатгал дээр малчдад бид супер сайн нөхцөл өгдөг. Эрэгтэй 55, эмэгтэй 50 гээд. Тэгсэн хэрнээ дээрээс нь нөхөн тооцох хуулийг нэг жилээр батлаад, хоёр жил болгож сунгаад байхад энэ хувь нэмэгдэхгүй байсан байхгүй юу.

Яагаад гэхээр малчид чинь өөрсдөө жилдээ хоёрхон удаа бэлэн мөнгөний орлоготой хүмүүс. Нэг нь ноолуур дээр. Нэг нь махаа хөлдөхөөр. Бусад үед бэлэн мөнгөний орлогогүй байхгүй юу.

Тэгэхээр авдаг урамшууллаас нь өөрсдийнх нь сайн дурын үндсэн дээр төлүүлчих юм бол хамрагдах хувь нэлээн нэмэгдээд ороод ирэх юм.

Түүрүүн Ж.Батжаргал гишүүн хэлж байна. Тэр эрүүл мэндийн даатгал бол албан журмын даатгал гээд. Энэ зөв. Албан журмын даатгалаа та эндээсээ төлөх үү, үгүй юу гэдэг л сонголтыг нь асууж байгаа юм. Түүнээс биш тэр хүний албан журмын даатгалыг шууд эндээс нь автоматаар авна гэсэн үг биш.

Урамшууллын бодлого Англид ч, Америкт ч, Австралид ч, Монголд ч явдаг юм. Ингэж байж хүн амаа, ялангуяа төвлөрсөн хүн амаа хүнсээр хангадаг.

Монгол хөдөө аж ахуйн орон гэж байгаа мөртлөө бид хэд сүүнийхээ 10 гаруйхан хувиар л хангаж байгаа шүү дээ.

Энэ дээр сүүний урамшуулал олгодог нь маш зөв болсон гэж бодож байгаа.

Хүнсний ногоо. Ганцхан төмснөөс бусдыг нь бид хангахгүй байсан шүү дээ. Урамшууллын бодлого орж ирээд хүнсний ногоо, нарийн ногооны хангалт нэмэгдээд ирсэн.

Гэх мэтчилэн ийм урамшууллаудаа авч байгаа улсууд дээр нь та хэд тэгвэл эндээсээ сайн дураараа эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалаа төлчхөөч ээ л гэсэн сонголт өгч байгаа хууль.

Мөн энэ түүхий эдүүдээр нь үйлдвэрлэл явуулж байгаа үндэсний үйлдвэрүүд түүхий эдтэй болж байгаа юм. Ноостой болж байгаа юм. Арьс ширтэй болж байгаа юм. Сүүтэй болж байгаа юм. Гурилын үйлдвэрүүд улаан буудайтай болж байгаа юм.

Тэгэхээр ийм тал бүрийн олон төрлийн ашигтай хууль учраас гишүүд маань.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 8 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт сурагчид Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт хүсье. Сурлага, спортын өндөр амжилт хүсье. /алга ташив/

Манай Жаргалтулгын Эрдэнэбат гишүүний төгссөн сургууль уу? Д.Өнөрболор, Ч.Ундрам гишүүн чинь гурвуулаа Зүүнхараагийнх биз дээ.

Эрхэм хүндэт сурагчдадаа сурлагын өндөр амжилт хүсье. Сайн сурцгаагаарай.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Би энэ хуулийг. Хөөе. Б.Пүрэвдорж гишүүн.

Хуулийг яах вэ зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Гэхдээ ингэж ойлгож бодоод дэмжиж байгаа шүү. Тэртээ тэргүй эрх нь байгаа хүнд эрхийг нь өгч байгаа тухай хууль биш ээ. Өөр юм байна.

Саяын тайлбараас яах аргагүй та нар юуны өмнө эрүүл мэндээ бодооч. Тийм. Тэтгэвэрт гарсан хойноо амьдрал ахуйнхаа юмыг бодооч гэдэг рүү энэ мөнгийг нь чиглүүлж өгч байгаад л юу гэж бодож байна.

Түүнээс нэг эрх олгоод, болохгүй байгаа юмыг нь нээж өгөөд байгаа юм энд алга гэж харж байгаа.

Б.Энхбаяр гишүүний ярьж байгаа шиг сонголтын тухай асуудал гэвэл тийм сонголт гэж байхгүй. Чи үүндээ хий гэж хэлж өгдөг сонголт гэж байхгүй л дээ. Сонголтгүй авна гэвэл татвар л авна. Сайн дураараа хийнэ гэвэл тэр хүн юу руугаа хийнэ. Авдаггүй шүү дээ.

Харин зүгээр үүний дараа жишээ нь энэ юу хөнгөлөөд өгчихлөө. Миний энэ урамшууллаа авдаг юмыг амар. Би гар дээрээ аваад л, буцааж төлөөд л.

Ц.Туваан аа, Ц.Сандаг-Очир оо,

Гар дээрээ аваад л буцааж төлөөд л, ингээд л дахин дахин юм хийж байснаас шууд надад өгөхдөө миний тэр данс руу хийгээд, үлдсэнийг нь л надаа өгчхөөрэй гэж өөрөө шийдэж байгаа л асуудал байна шүү дээ.

Дараа нь дахиад нэг хууль гаргая. Би ерөөсөө одоо юу гэдэг юм өөр нэг юмнаас олж байгаа орлогоо бас ийм хууль гаргая. Надад сайн дураараа хийх эрх олгооч гэдэг асуудал гарч ирвэл яах вэ? Бас ийм хууль гарах уу?

Ноолуур төлчихлөө. Мөнгөө авчихлаа. Би тэр олон юм дамжуулж байснаас надад ноолуур төлж байгаа тэр нөхрийг миний данс руу хэдийг нь хийчих. Нөгөө эрүүл мэндийн даатгалын данс руу нь тэдийг нь хийчих гэдэг асуудал тавья гэж бодъё. Тэгээд надад тийм эрх нээж өгөөч гэсэн хууль гаргахгүй биз дээ. Энэ чинь. Тийм ээ.

Тэгэхээр ийм юмнууд бас гарах нь байна шүү. Дараа нь. Тийм. Гэхдээ зарчмын хувьд дэмжиж байна. Хөнгөлж байгаа юм байна л гэж ойлгож байна.

Зүгээр бас ингэлээ гээд тэр цаана зардал илүү нэмэгдэх гэдэг дээр би санал. Яах вэ, тэртээ тэргүй ингэж төлсөн ч тэнд байгаа мөнгө хэвээрээ л байна. Тийм ээ. Шаардлага гарвал төлж л таарна. Эрүүл мэндийн. Үүнээс төлсөн ч, өөр юмнаас гарсан ч төлж л таарна шүү дээ.

Даатгалыг сүүлд нь буцаагаад авахад.

Дараа нь нэг тийм хууль санаачилна. Тийм. Юунаас олсон орлогыг. Сайн дураараа суутгуулах эрх өгөөч гэж бодож олдог юм билээ. Нэг юм бодно. Тийм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Энэ санал дэмжигдсэнгүй.

Санал хэлчихсэн л дээ. Санал хэлээд дуусаад одоо горимын санал уу? Горимын санал хэлэх хүн хэн байгаа юм? Т.Аубакир, Т.Энхтүвшин гишүүд горимын санал. Телиуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Би сая зөвшөөрч санал өгсөн чинь аппаратур ажилласангүй. Дарга аа. Дахин санал хураалт явуулж өгнө үү?

Г.Занданшатар: Төхөөрөмж ажилласангүй.

Т.Аубакир: Тийм. Төхөөрөмж ажилласангүй.

Г.Занданшатар: Санал хураалтыг хүчингүйд тооцож өгөөч гэсэн ийм горимын санал гаргаж байна гэж ойлголоо. Тийм үү. Ингээд Т.Аубакир гишүүний саналаар санал хураалт нь эсрэг гарсан учраас хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. /алх цохив/

55.8 хувийн саналаар Т.Аубакир гишүүний санал дэмжигдлээ.

Санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас 7 дугаар санал хураалтыг дахиж явуулъя. /алх цохив/

62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Энэ хуулийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

28 гишүүн дэмжиж, 54.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Одоо найруулгын саналаар санал хураалт явуулна. Найруулгын санал.

1.Төслийн гарчгийн, 2 дугаар зүйлийн, 4 дүгээр зүйл, мөн зүйлийн 4.1, 4.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн” гэснийг, “эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Заавал даатгалаа урьд нь оруулж байгаа юм байна. Эрүүл мэндээ урьд нь.

53.1 хувийн саналаар найруулгын санал дэмжигдлээ.

2.Төсөлд шинээр зүйл, хэсэг нэмсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлэх, мөн төслийн нэр томьёо, найруулгыг жигдлэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутган төлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн

бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Гурав.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар явуулж зарчмын зөрүүтэй 31 саналын томьёололд бэлтгэн Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Эдийн

засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хилийн боомт чиглэсэн болон хил дамнасан төмөр замын өмчлөлийн асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар дахин хэлэлцэх шаардлагатай гэж горимын санал гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Эдийн засгийн байнгын хороонд буцаасан.

Байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж, ажлын хэсгийн гишүүдээс хилийн боомтын дэд бүтэц, улсын хил дамнасан байгууламж, хилийн боомт гэсэн ойлголтыг Монгол Улсын Хилийн тухай хуулийн заалтуудтай уялдуулах, хөрш оронтой төмөр замын хил дамнасан байгууламж барих, ашиглах үйл ажиллагаатай холбогдуулан төслийн 24 дүгээр зүйлд Улсын хилийн боомт чиглэсэн хил дамнасан төмөр зам нь нийтийн зориулалттай төмөр замд хамаарах бөгөөд энэ төмөр замын өмчлөгч нь нэг хуулийн этгээд байна гэж нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцогч гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут төслийн 47

дугаар зүйлд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт ажилтны нэг сарын дундаж цалингийн хөлсийг 36 дахин нэмэгдүүлж олгох гэж нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцогч гишүүдийн олонх нь дэмжээгүй.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудын хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ажлын хэсгийн ахлагч, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мандширийн Энхболд, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхээгийн Мяндасмаа, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэрэгжилтийн дарга

Хүчитбаатарын Итгэлт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Лхамрагчаагийн Булганхүү.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Батгөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Цэдэвийн Сэргэлэн гишүүн асуулт асууна.

Ш.Адъяаа гишүүн картаа ахиж уншуул. Картаа сугалчихсан. Сая санал хураалтад та дандаа эсрэг. Ороогүй байна шүү.

Ц.Сэргэлэн: Би ажлын хэсгийн гишүүдэд хандаж энэ хуулийн төсөл дээр ганц хоёр санал байна. Яагаад ингэсэн юм бэ гэдэг асуулт ч байна даа.

Энэ 7 дугаар зүйл дээр Засгийн газрын бүрэн эрх гэж байгаа юм. Хуулийн төслийн 7.1.5 дээр Монгол Улсын хилийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасан хилийн бүсэд төмөр замын суурь бүс барихтай холбоотой асуудлыг шийдвэрлэх гээд орхичихсон байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яах вэ дээ технологийн байдаг юм уу. Нэг алдаа байна. Хилийн “бүс”, “зурвас” гэж хоёр ангилсан газар байгаа шүү.

Тэгэхээр энэ зурвасыг нэмэх хэрэгтэй. “Хилийн бүс” гээд таслал тавиад “зурвас” гээд оруулчихвал зөв болно. Яагаад гэвэл улсын хилийн шугамаас 15 километрээс илүүгүй газрыг улсын “хилийн зурвас” гэдэг юм. “Хилийн бүс” гэвэл 100 километрээс дотогш газрыг “бүс” гэдэг юм. Ийм ялгаатай хоёр газар байгаа шүү.

Тэгэхээр зурвасаа хаячихсан байна. Та бүхэн маань. Энэ бол тусгай дэглэм тогтоосон газар. Энд ямар нэгэн үйл ажиллагаа явуулахад зөвхөн Засгийн газар зөвшөөрдөг ийм зохицуулалттай.

Энэ 7 дугаар зүйл “Засгийн газрын бүрэн эрх” гэдэгт орж ирж байгаа нь зөв. Ганцхан Та бүхэн маань “зурвасаа” хаяжээ гэдгийг би хэлэх гэсэн юм.

Анхааралдаа аваарай. Ажлын хэсгийнхэн.

Дараагийн дугаарт, энэ 16, 17, 18 дугаар зүйл дээр төмөр замын “тусгай бүс”, “зурвас газар”, “хамгаалалтын бүс” гэсэн байна. Энэ газрууд ерөөсөө өмчилж, эзэмшиж болохгүй газар. Энэ заалтын аль нэгэн дээр нь энэ газруудыг эзэмшүүлэх, өмчлүүлэхийг хориглосон заалт байх ёстой гэж би бодож байна.

Энэ газар замбараагүй олгодог явдлаас болоод нэг мэдэхэд танай тусгай бүсэд чинь юм уу аягүй бол газар олгочихсон байж байхад байг л гэхгүй.

Тийм учраас үүнийг хуулиар хориглож өгөх ёстой.

“Төмөр замын тусгай бүс, төмөр замын зурвас газар, төмөр замын хамгаалалтын бүсэд газар эзэмшүүлэх, газар өмчлүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг энэ хуульд заавал суулгаж өгөх ёстой гэсэн би энэ зарчмын байр суурийг илэрхийлж байна.

Ажлын хэсгийнхэн үүнийг анхаарна биз. Ажлын хэсгийн дарга, манай эрхэлсэн сайд маань ч байж байна. Үүнийг анхаарна биз дээ.

Тэгэхгүй бол энэ хэзээ нэгэн цагт эзэмшилд оччихсон, хувийн эзэмшилд оччихсон, аль нэгэн компанийн бас

эзэмшилд оччихсон, эсвэл иргэний өмчлөлд оччихсон байж байхыг үгүйсгэдэггүй юм.

Зүгээр төрийн өмч байна гэж энэ 17 дугаар зүйл дээр нэг өгүүлбэр орсон байна. Үүнийгээ улам баталгаажуулаад, Газрын тухай хуультайгаа уялдуулаад эзэмшүүлэх, өмчлөхийг нь хориглоод заачих юм бол энэ бүрэн найдвартай болно шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Ер нь энэ тал дээр ажлын хэсэг ямар бодол саналтай ингэж хийсэн юм. Тэр миний хэлээд байгаа зурвас газрыг яагаад орхигдуулсан юм. Хилийн зурвасыг. Энэ газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэхийг хориглох асуудал дээр Та бүхэн ямар байр суурьтай байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ.

Ж.Бат-Эрдэнэ: Ц.Сэргэлэн гишүүний хуулийн 7.1.5-д заасан Монгол Улсын хилийн тухай хуулийн 30.1-д заасан хилийн бүсэд төмөр замын суурь бүтэц барихтай холбоотой асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд заасан байгаа юм.

Тэгээд энэ дээр таны саналыг хүлээж авъя. Тэгээд үүнийг Их Хурлын дарга найруулгаар өгөөч гэсэн тийм удирдамж өгчхөөч ээ гэж хүсэж байна.

Энэ дээр бүс. Зурвасыг нь хаячихсан юм байна. Зурвас гэдгийг оруулчихъя. Бид уг нь хуулийнх нь дагуу оруулсан байгаа юм.

Хоёрдугаарт, та төмөр замын тусгай бүс, зурвас газар, хамгаалалтын бүсүүдийг ярьж байна.

Энд ерөнхийдөө санал нэг байгаа юм. Энэ төмөр замын зурвас газар гэж байгаа юм. Энэ бол яг үнэхээр тодорхой хэмжээний хамгаалалтад авч байх ёстой бүс газар байгаа. Өөрөөр хэлбэл бидний нөгөө өргөст тороор хамгаалчихсан байгаа бүс шүү дээ. Үүнийг чинь зурвас газар гэж байгаа юм.

Тэгэхээр 17.2 дээр төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна гээд нэгдүгээрт тодорхойлж байгаа юм.

Үүнийг тухайн газарт нь ч өмчлүүлэхгүй. Тухайн суурь бүтэц эзэмшиж байгаа компанид ч өмчлүүлэхгүй. Төрийн өмчид хэвээрээ байлгана. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ар талд нь 17.4 дээр. Гишүүн та хараарай. Төмөр замын зурвас газарт төмөр замын тээврийн үйл ажиллагаанаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно гээд. Уг нь яг таны саналыг энд тусгачихсан байгаа юм.

Ер нь бид чинь Улаанбаатар төмөр замын зурвас газарт чинь нэг мэдэхэд л нэг барилга, байшин хаанаасаа өгчихсөн нь мэдэгдэхгүй барилга байшин, үйлчилгээний газрууд гараад өчнөөн барилга, байшин баригдсан шүү дээ. Үйлчилгээний газрууд ч гээд.

Тийм болохоор энд хамгаалалт хийж өгөөд, төмөр замын зурвас газарт төмөр замын тээврийн үйл ажиллагаанаас бусад гэж байгаа юм. Ийм үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно гээд заачихсан байж байгаа шүү.

Г.Занданшатар: Цэдэвийн Сэргэлэн гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Сэргэлэн: 17.4-ийг би уншсан. Энэ бол үйл ажиллагаа явуулахыг л хориглоод байгаа юм. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа гэдэг чинь хүний үйл ажиллагаа.

Би газар эзэмших, өмчлөхтэй холбоотой харилцааны тухай яриад байгаа юм. Тэр газар дээр үйл ажиллагаа явуулахыг нь хориглож байна. Энэ зөв. Бусад үйл ажиллагаа явуулахыг нь хориглож байгаа.

Тэгвэл тэр доор байгаа газрыг нь хэн нэгэн иргэний эзэмшилд өгч болохгүй. Хэн нэгэн иргэний өмчлөлд өгч болохгүй. Аль нэгэн аж ахуйн нэгжийн эзэмшилд өгч болохгүй гэдэг энэ агуулгыг оруулбал яасан юм бэ гэдгийг би санал хэлээд байгаа хүн.

Хэзээ нэгэн цагт энэ дээр чинь нэг нөхөр газар эзэмшигчсэн энэ миний газар. Та нар миний газар дээр ийм юм хийхгүй гээд зогсож байхыг байг гэхгүй. Баталгаажуулалт нь энэ.

Эзэмшүүлэх, өмчлүүлэхийг хориглох нь зөв өө гэдэг.

Г.Занданшатар: Энэ эхний хэлэлцүүлэг. Тэгэхээр эцсийн хэлэлцүүлэгт Эдийн засгийн байнгын хороон дарга, ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ нар.

Б.Дэлгэрсайхан гишүүн ээ, ер нь Цэдэвийн Сэргэлэн гишүүний гаргасан саналыг үндэслээд тэгээд тэр 24.2 дээр чинь хилийн боомт чиглэсэн төмөр замын асуудал нийтийн зориулалттай төмөр зам байна гэсэн мөртлөө 24.3-т нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулсан төмөр зам гэрээгээр шилжүүлэх хугацааг заана гээд.

Тэгэхээр доодох газар, дэд бүтцийн асуудал энэ тэр чинь бас хэсэг хугацаанд, тодорхойгүй хугацаанд. Тэр хугацаа энэ тэрийг тодорхой болгож. Тэр хугацаанд яах юм. Тэр газар өмчлөл энэ тэрийг. Газрын харилцаа нарийн учраас тодорхой тусгахгүй бол ийм эрх зүйн зөрчил гарч болзошгүй байна.

Тийм учраас үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр тэр 24.2, 24.3-тай нийлүүлээд Ц.Сэргэлэн гишүүний гарсан юмыг гүйцээн боловсруулах чиглэлийг өгчихье. /алх цохив/

Тэгээд яг энэ заалт дээр 11 дүгээр дээр 24.2-тойгоо бас хамт ярих юм уу. Тухайн үедээ ярь. Ингээд ойлгочихъё. Ц.Сэргэлэн гишүүн. Харин тийм.

Тэгэхээр энэ асуудал чинь түүнтэй холбогдоод байна. Ц.Сэргэлэн гишүүнийх.

Тэгээд тэр юу энэ тэрээ хамт анхаарчих. Хилийн бүс, зурвас хоёрынхоо ялгаа энэ тэртэй уялдах шаардлага гарч болох байх. Гүйцээн боловсруул.

Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Төмөр замын тээвэр маш чухал. Өртөг зардал хямд байх гээд олон чухал асуудлууд бий.

Гол гол ямар чухал өөрчлөлтүүд орж байгаа юм? Энэ өөрчлөлтүүдийг оруулснаараа тээвэр, эдийн засагт нөлөөлөх боломж бололцоо юм хум нь ямар юм?

Бид бүхэн хууль, бодлого тогтоогоод байна уу? Ямар байна? Миний мэдэхийн лав Улсын Их Хурал төмөр замыг нарийн царигтай буюу олон

улсын стандартад нийцсэн байна гээд л баталчихсан байдаг.

Тэрийг нь Үндсэн хуулийн цэц дээр өргөн байна гээд л шийдчихдэг. Ийм байж болох юм уу? Ингэж явах уу? Цаашаа яах вэ?

Тэр байтугай Үндсэн хууль дээр 4 гэсэн тоог аваад л хаячихдаг. Бид бодлого боловсруулж, хууль тогтоодог хүмүүс мөн үү, биш үү.

Тэгээд манай төмөр зам чинь бараг 1920, 1930 оны төмөр зам байгаа биз дээ. XIX зууны үеийн, XX зууны эхэн үеийн.

Тэгэхэд манай дэлхийн хоёр дахь эдийн засаг болчихсон, айл хөрш болчихсон улс орон чинь 300, 400 километрийн хурдтай явж байна шүү дээ.

Одоо тэр “**Боомтын сэргэлт**” гээд л яриад байх юм. Боомтын сайд гээд л томилсон. Энэ хэдэн боомтуудыг чинь сэргээж өгч байгаа газар чинь энэ урд хөршийнхөн л байх шиг байна шүү дээ.

Манайхан яадаг вэ гэхээр социализмын үед тийм тийм үйлдвэр гаднынхан барьж өгсөн. Та нар юу хийж байна гэхээр одоо энэ Засгийн газар аягүй бол социализм байгуулж байна л гэх юм уу.

Одоо тэр Гашуунсухайтын боомтын асуудлыг бас шийдэж өгч байгаа юм билээ. Замын-Үүдийн боомтын асуудлыг шийдэж өгч байгаа юм билээ.

Тэгээд гол тээвэр чинь нүүрс шүү дээ. Гадагшаа гаргах. Үүнийгээ ер нь нарийн болговол яасан юм бэ. Монголын хөгжлийг санаатай болон санамсаргүй

хэчнээн жил гацаах гэсэн юм. 10 жил, 20 жил, 30 жил гацлаа.

Оросын Холбооны Улстай энэ урд талынхаа төмөр замын асуудлыг ярьж шийдэх талаар ямар байх юм. Тэдний дүрэм журамд яаж нийцэж байгаа юм. Наад тээврийн юу чинь. Урд хөршийнхтэйгөө яаж нийцэж байгаа юм. Тэр талаар ажилласан, тохируулсан ийм юм байгаа юу?

Төмөр зам хөгжлийн зам биш гацаадаг зам болсон байна шүү.

Бид дэлхийн хоцрогдсон алс бөглүү ийм л хязгаар болчихлоо. Энэ төмөр замыг хөгжүүлэхгүй ингэж явсаар байгаад. Үүнийг 8 жил энэ чигээр нь л байлгаж байна л даа. Энэ олонх 62, 65 суудал эзэлчхээд.

Тэгээд өнөөдөр 100 сая тонн нүүрс гарч байх ёстой шүү дээ. Тэр төмөр зам бүтээн байгуулалт хийлээ гээд л тууз хайчлаад л баахан баатрууд төрөөд байсан. Зарим нь гараад явчихсан. Хаашаа алга болсон нь мэдэгдэхгүй. Одоо тэрийгээ “шувуу” гээд л онгоцоор авчрах юм уу. Энэ төмөр замаараа авчрах юм уу. Тэр баатруудыгаа. Тийм. Одоо аль тээврээр нь авчрах юм байгаа юм гэх мэтчилэнгийн ийм зүйлүүд байна.

Хэзээ энэ төмөр зам чинь тэр дэлхийн жишигт очиж, тэр тээвэр нь 100 сая тонн, транзит тээвэр, энэ бүх боломж нь хангагдах юм бэ? Сайндаа л 25 билүү, 30 сая тонн төмөр зам дээр транзит тээвэр хийж байгаа байх.

Урагшаа гардаг тийм нүүрс тээврээс саяхан л 3-хан сард багтаад л автомашинаар 13, 12 тонн нүүрс гарсан юм шиг байна.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Төмөр замын тухай хууль 2007 онд анх батлагдсан.

1949 онд Монгол Улс төмөр замтай болсон. 2007 он хүртэл үндсэндээ хуульгүй, зохицуулалтгүй байсан. 2007 оноос Төмөр замын тухай хуулийг батлаад, 2010 онд Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого Улсын Их Хурал батлаад явж байгаа.

Яагаад энэ хуулийг оруулж ирэх болсон шалтгаан гэх юм бол тэр үед юу гэдэг юм, 2007 онд, 2010 онд Монгол Улс ганцхан төмөр замтай. Улаанбаатар төмөр зам. Ганц төмөр замтай. Компанитай. Тэр гол зам гээд Алтанбулагаас Улаанбаатар, Замын-Үүд хүртэл 1100 километр төмөр замтай. Өөр төмөр зам байгаагүй.

Та сая хэлсэн. Ер нь юу гэдэг юм, 2010 оноос хойш бид төмөр зам барих гээд их будилсан. Нарийн царигаар барина, өргөн царигаар барина. Нарийн царигаар барьчих юм бол танк орж ирнэ гээд нэлээн будилсан. Далан овоолоод шороо тавьчихсан. Түүнд хэдэн зуун сая доллар зарцуулчихсан гээд бөөн асуудалтай.

Ингэж гацаж гацаж байгаад үндсэндээ юу гэдэг юм, таны улс төржиж байгаа утгаар хэлэх юм бол Ардын нам эрх барьсан үеэс эхлээд 2019 оноос, 2018 оноос 800 гаруй километр төмөр зам барилаа.

Зүүнбаян-Тавантолгойн төмөр зам 416 километр төмөр зам. Тавантолгой-Гашуунсухайтын төмөр зам 230 гаруй километр төмөр зам. Ханги-Мандал-Зүүнбаянгийн төмөр зам бас 200 гаруй километр төмөр зам.

Ингээд энэ төмөр замуудыг барьсантай холбоотойгоор. Мөн төмөр замын олон компани байгуулагдсантай холбоотойгоор Төмөр замын тухай хуулийг шинэчилж найруулж энэ олон харилцаануудыг зохицуулах ийм шаардлага гарсан юм.

Тэгээд энэ хүрээндээ Төмөр замын тухай хуулийг оруулж ирсэн. Одоо царигийн асуудал та ярьж байна. Яах аргагүй Улсын Их Хурал ордоос боомт руу чиглэсэн төмөр зам нарийн байж болно гэсэн заалттай.

Мөн Н.Алтанхуягийн Засгийн газрын үед нарийн царигийн төмөр зам барина гэсэн шийдвэртэй байсан. Үүнийг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгосон. Үүнтэй холбоотойгоор өргөн царигийн төмөр зам барьж байгаа.

Хятад Улс нарийн царигтай. Ялангуяа бид нүүрсээ аль болох хурдан гаргаад уг нь нарийн царигаараа барьсан бол шууд холбогдоод олон дахин ачиж, буулгах барих гэдэг юм уу асуудал үүсэхгүй байсан байх.

Одоо яаж зохицуулж байгаа гэх юм бол үндсэндээ өргөн, нарийн царигийн хил холболтын төмөр замуудыг бид хил дээр барьж байгуулж байж таны, бидний ярьж байгаа уул уурхайн бүтээгдэхүүн, нүүрсээ тээвэрлэх бололцоо бүрдэнэ. Энэ бол дахин ажил болж байгаа. Дахин ажил болж байгаа.

Бусад тохиолдолд үндсэндээ төмөр замын сүлжээ өргөн царигтай байна. Хоорондоо өргөн царигаар холбогдоно.

Ер нь царигийн асуудлыг Улсын Их Хурал шийднэ. Хуультай. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар

ч ийм. Өргөн барьсан хуульд ч ийм заалттай явж байгаа гэдгийг танд хэлье.

Тэгээд өөр юу яригдлаа. “Шувуу” ажиллагаа. Тэр хариуцлага хүлээх улсуудад хариуцлагаа хүлээлгэнэ. Тийм. Тавантолгой төмөр зам дээр олон улсын аудитын байгууллага орж шалгалт хийх гэж байгаа. Үндэсний аудитын газраас. Мөн Засгийн газраас тодорхой шалгалтууд орсон ажиллаж байгаа.

Түүнээс гадна олон улсын аудитын байгууллагаар шалгалт хийлгэж зөрчилтэй асуудлуудыг тогтоохоор ажиллаж байгаа гэдгийг танд хэлье.

Оросуудтай харьцангуй юу гэдэг юм, Богд хаан төмөр зам дээр Оросуудтай гэрээ хийхээр бид ажиллаж байгаа. Богд хаан төмөр зам урьд нь яах аргагүй Улаанбаатар төмөр замаас салаалаад Улаанбаатар төмөр зам руу буцаад нийлэх зам учраас үүнийг Улаанбаатар төмөр замын 50 хувийг нь Оросууд эзэмшдэг.

Тийм учраас хамтрагчтайгаа ярилцаж, зөвшилцөж хийх шаардлагатай байсан. Мөн нэлээд өндөр үнийн дүнтэй гэрээ хийгдсэн байсан. Энэ бүгдийг эргэж нягталж байгаа.

Тийм болохоор үндсэндээ Оросуудтай харилцан ойлголцож Богд хан төмөр замыг барихаар ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Тодруулахын өмнө зочин танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэнгийн урилгаар, Баттөмөрийн Энхбаяр нарын урилгаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2003 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Монгол Улсын ууган 8 сургуулийн нэг. Ирэх жил 100 жилийн ойгоо тэмдэглэх түүхт сургуулийн төгсөгчид Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Мандширийн Энхболд. Тэгээд 85 хариулах уу? Сая асуусан. Улсын Их Хурал зөвхөн яагаад нийтийн зориулалттай төмөр замын чиглэлийг тогтоож царигийг л батлах. Бусад тусгай зорилтын ч юм уу төмөр замынхыг болохоор хэлэлцэхгүй, батлахгүй гэж та нар бичсэн юм. Сая төмөр замын царигийн асуудал хөндөгдөж байгаа учраас.

Энэ чинь нэгдсэн систем байдаггүй юм уу? Төмөр зам чинь. Төсөл дээр чинь тийм байгаа шүү дээ. Ажлын хэсэгт хамаагүй төсөл.

Яараад яах вэ дарга аа. Нухацтай асуудлыг нухацтай л хэлэлцэх хэрэгтэй.

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна. 1 минут.

Д.Ганбат: Сая Г.Занданшатар даргын хэлээд байгааг тодруулаад өгчхөөрэй. Тийм.

Засгийн газар нь ямар юмаа шийддэг юм. Улсын Их Хурал нь ямар зүйлээ шийддэг юм. Тийм ээ. Төмөр зам дээр.

Энэ маш их мөнгө, хөрөнгө оруулалт орсон. Гашуунсухайтын болон Зүүнбаян, Тавантолгойн төмөр зам дээр.

Энэ чинь одоо тэгээд хэзээ ашиглалтад орж, хэзээ тээвэр нь хийгдэх юм бэ? Тэр хил холболт энэ тэр нь юундаа яагаад саатаад байдаг юм бэ? Тэнд чинь ахиад л хууль дүрэм энэ тэр юм гарах уу, үгүй юу? Яг тэдийд өдийд орно гэсэн юм байна уу?

Монголын ард түмэнд хэрэгтэй юм болохоор л дандаа хойшилж байдаг. Тийм. Энэ уул уурхай сайхан цикл үе чинь, супер циклийн үнэтэй үе чинь удахгүй өнгөрчих нь байна шүү дээ.

Тэгээд үүнээс Монголын ард түмэн хохироод үлдэж байдаг. Баахан хэрэггүй хөрөнгө оруулалтууд тэнд нь ингээд үлдэх нь. 10 жилийн дараа аягүй бол энэ нүүрс чинь хэрэггүй ч болж мэдэхээр байна шүү дээ. Ялангуяа эрчим хүчнийх нь.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Тавантолгой, Гашуунсухайт чиглэлийн төмөр зам баригдсан байгаа. Холболтын төмөр зам баригдах гээд ТЭЗҮ хийхээр сонгон шалгаруулалт зарласан явж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол төмөр зам маань хил дээр очоод мухар болчихсон. Тэр дээр Тавантолгойн төмөр замаар нүүрс тээвэрлэж байгаа. Тэндээс шилжүүлээд нүүрсээ автомашин руу шилжүүлж хилээр гаргаж байгаа. Холболтын төмөр зам баригдчих юм бол холболтын төмөр замаар шууд нүүрс Хятадын төмөр замтай холбогдоод шууд тээвэрлэгдэх ийм бололцоо бүрдэх юм.

Энэ ажлууд ТЭЗҮ хийсний дараа бүтээн байгуулалтын ажлууд хийгдэнэ. Ер нь нэгээс хоёр жилийн дотор хийхээр төлөвлөж байгаа.

Ер нь анхнаасаа хэрвээ ингээд төмөр замын трассаа зөв тавьчихсан, Хятадтай хил холболтын төмөр замын цэгээ тохирчихсон байсан бол энэ төмөр замын трасс хоорондоо Хятадын төмөр замтай зөрөхгүй байсан. Зөрснөөс болж үндсэндээ нэлээд хүндрэлтэй асуудлууд үүсээд үүнийг шийдэхэд нэлээд их хэмжээний хөрөнгө, цаг хугацаа зарцуулахаар ийм байгаа.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ царигтай холбоотой асуудлуудыг хаана, яаж шийдэх юм. Эсвэл тэр нийтийн зориулалттай төмөр замын чиглэлийг Улсын Их Хурал тогтоох уу гээд байна.

Энэ Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг 2010 онд бид Улсын Их Хурлаар баталсан. Энэ бодлого дотор царигийн асуудлууд нэгдүгээрт туссан байгаа.

Хоёрдугаарт, чиглэл. Энэ нийтийн зориулалттай гээд бидний тодорхойлоод байгаа энэ гол төмөр замууд, магистрал төмөр замын чиглэлүүдийг тэнд бид өнөөдрийн яриад байгаа баруун босоо, төв шугам, зүүн босоо, зүүн төмөр зам гээд байгаа. Энэ бүх төмөр замууд чинь тэр бодлого дотор батлагдаад гарчхаж байгаа юм.

Тийм болохоор үндсэндээ энд зааснаар Улсын Их Хурал үндсэн том чиглэлүүдийг заахаар болчхож байгаа юм.

Тэгэхээр энэ хууль бол. Д.Ганбат гишүүн ээ. Энэ хууль Төмөр замын тээврийн тухай хууль шүү.

Тэгэхээр тээврийн зохицуулалттай асуудлууд. Энэ бол ерөөсөө бүхэлдээ цоо

шинэ хууль болж орж ирж байгаа байхгүй юу. Урьд нь Улаанбаатар төмөр зам гээд ганц.../минут дуусав/

Г.Занданшатар: Бүх төмөр замын чиглэл, нэгдсэн систем, бодлогын асуудал. Бодлого бол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдаж байгаа. Энэ бол хууль болно.

Тэгэхээр дараа нь хуульдаа нийцүүлж бодлогоо өөрчилж болно.

Тэгэхээр энэ төмөр замын чиглэл, царигийн асуудал бүхэлдээ Улсын Их Хурлаар шийдэгдэх ёстой шүү. Ингэвэл Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан болохоор. Хуулийн зохицуулалттай.

Тэгэхгүй зөвхөн нийтийн зориулалтын замыг гээд төслөө Засгийн газар боловсруулчихсан юм байна.

Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Төмөр замын тээврийн хуулийн шинэчилсэн төслийг дэмжиж байгаа. Саяхан бид Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталсан.

Ер нь аль том бүтээн байгуулалтаа төр, хувийн хэвшлийн түншлэл дээр тулгуурлаж хийе гэдэг концепцыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар бид гаргасан.

Тэгвэл энэ Төмөр замын тухай хууль дээрээ бид энэ төмөр замын дэд бүтцийн асуудлыг “төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийж болно” гэдэг үгээ оруулахгүй бол болохгүй. Одоо яах юм, бид нар. Шивээхүрэн-Арцсуурыг төрийн өмчөөр хийх гээд байгаа юм уу? Энэ Бичигт. Одоо юу гэдэг юм, энэ Хөөт-

Чойбалсан-Сайншанд-Сүхбаатар гэдэг юмыг бүгд төрийн өмчөөр хийх гээд байгаа юм уу? Төр, хувийн хэвшлийн түншлэлээр л хийх гэж байгаа биз дээ.

Тийм учраас салбар хууль дээрээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр энэ төмөр замыг хийж болно гэдэг үгээ оруулаад явах нь зөв байх шүү.

Хоёр дахь асуудал. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төмөр зам барьсан. Тэгвэл юу гэдэг юм, энэ хууль дээр төмөр замын суурь бүтцийг, төмөр замын тээвэрлэлтийг тэр төрд хүлээлгэж өгөх хүртэл хугацаанд нь тэр хувийн хэвшлийн компани эрхлээд явах ийм бололцоо боломжийг нь нээж өгөх хэрэгтэй.

Тэгээд төр, хувийн хэвшлийн түншлэлээр компаниудаар төмөр зам бариулчихдаг. Тэгээд суурь бүтцийг нь арчлах асуудал, тээвэрлэх асуудлыг нь тусдаа өөр компани хийхээр хүртэл ийм заалт ороод ирчихсэн байж байна шүү дээ. Тэгээд яаж энэ компани чинь орлогоо олж авах юм. Мөнгөө олж авах юм. Яаж энэ төмөр замыг чинь цаашдаа өөр компаниуд барьж байгуулах юм.

Төр, хувийн хэвшлийнхээ түншлэлийн тухай хуулийн эсрэг ийм заалт орсон ийм хууль болсон байна.

Тийм учраас 22, 24, 26 дугаар заалтуудыг өөрчлөөд, ялангуяа төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой заалтыг оруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх, суурь бүтцийг арчлаад явах заалтуудыг тодорхой болгож оруулмаар байна.

Цаашдаа бид нэг юман дээр их сайн онцгой анхаарах хэрэгтэй байж байна. Үнэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр цаашдаа энэ том бүтээн

байгуулалтаа хийлгэх гэж байгаа бол тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийсэн хувийн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжсэн, тэднийг орлогоо олох бололцоо, боломжийг нь олгосон ийм заалтуудыг хийж байж л цаашдаа энэ хууль, энэ хөрөнгө оруулалтууд хэрэгжээд явна шүү.

Тийм учраас би зарим заалтуудыг татаж аваад ажлын хэсэг дээрээ гүйцээн боловсруулаад явах ёстой гэж бодож байна.

Би энэ дунд нэг их их төмөр зам мэддэг, төмөр зам дээр өссөн, төмөр замын нарийн технологийг мэддэг хүн олон байгаа гэдэгт эргэлзэж байна. Төмөр зам барих хэцүү. Төмөр замыг цаашдаа ашиглаад, найруулаад, үүнийг арчлаад явах маш хүнд байдаг шүү.

Тийм учраас энэ заалтуудаа эргэж нэг хараад, дахин гүйцээж боловсруулах ийм чиглэлийг өгөөч ээ.

Дээр нь юу гэдэг юм, болж өгвөл Үйлдвэрчдийн байнгын хороогоор ч гэсэн оруулаад зарим асуудлуудаа эргэж харвал яасан юм. Ийм саналтай байна.

Г.Занданшатар: Ер нь ингээд анхны хэлэлцүүлэг дахиад л буцаавал яасан юм бэ. Үүнийг ахиж боловсруулахгүй бол энэ чинь ерөөсөө. Тийм.

Ерөөсөө бүгдийг нь унагаахгүй бол энэ болохгүй болчихсон байна гэж Т.Энхтүвшин гишүүний хэлж байгаа зөв шүү. Ерөөсөө.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Энэ ер нь ёстой завааруулчихсан юм биш биз.

Ж.Бат-Эрдэнэ: Т.Энхтүвшин гишүүний ярьж байгаатай ер нь хагастай нь зөвшөөрч байгаа шүү.

Ерөнхийдөө энэ хууль чинь. Түрүүн би хэлсэн. Улаанбаатар төмөр зам гэдэг ганцхан компани байсан. Одоо төр, хувийн хэвшлийн маш олон компаниуд болсон.

Ер нь олон концепц байгаагийн нэг концепц хувийн хэвшлийг хамгаалах байгаа шүү. Хувийн хэвшлийг оруулж ирэх асуудал байгаа юм шүү. Улаанбаатар төмөр зам гэж ганцхан хамтарсан компани байсан бол одоо төрийн, хувийн маш олон компаниуд орж ирсэн. Энэ компаниудын хоорондын харилцааг зохицуулах маш том чухал, одоо бүр цоо шинэ хууль орж ирж байгаа шүү дээ.

Тэгэхээр хамаагүй эсрэг хууль гэж бүр далийгаад явж болохгүй.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дээр Ц.Цэрэнпунцаг гишүүн ахлаад бид өөрсдөө ажилласан.

Хамгийн гол нь миний нүдэнд тэрийг боловсруулж байхад юу харагдаж байсан гэхээр төмөр зам л харагдаж байсан. Одоо энэ хуулийг боловсруулахад юу харагдаж байгаа вэ гэхээр хувийн хэвшлийг яаж хамгаалах юм гэдэг асуудал байгаа байхгүй юу даа.

Түрүүний Улсын Их Хурал дээрээс татаж авчирсан бас нэг зүйлийг үлдээчихсэн байсныгаа энэ дотор оруулсан. Өөрөөр хэлбэл хувийн хэвшлийн компани, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийнхаа дагуу Концессын хуулиар хийхэд энэ том хөрөнгө оруулалтаа баталгаажуулахын

тулд төр тодорхой хэмжээний давуу эрх гэх юм уу, боломж бололцоог, ажиллах боломж бололцоог нь хангах. Дээрээс нь тээвэрлэлт хийх гэсэн зүйлүүдийг нь бас оруулаад ингээд явах нь зүйтэй байгаа юм.

Тийм болохоор энэ бүр эсрэгээр явчихлаа гээд ингэж ярих нь бас буруу байгаа шүү.

Т.Энхтүвшин гишүүнийхээр би аваад 24.3. Сая Их Хурлын дарга хэллээ. Гүйцээн боловсруулахад анхаараад буцаж оруулж ирээрэй гэсэн. Яг энэ дотор нь жоохон тодруулах асуудал л байгаа шүү. Гүйцээн боловсруулж тодруулах асуудал.

Түүнээс биш энд үндсэндээ хамгийн гол нь энэ их хөрөнгө оруулж ирж байгаа энэ аж ахуйн нэгжүүдийг цаашаа ажиллах боломж бололцоо, концессын хугацаандаа, 20 жил байна уу, 10 жил үү, 15 жил байна уу энэ хугацаанд боломж бололцоог нь олгоход хамгийн чухал концепцуудынх нь нэг нь энэ дотор байж байгаа юм гэдгийг л хэлье.

Ер нь түрүүн дарга хэлчихсэн шүү дээ. 24.3 дээр гүйцээн боловсруулах гэдэг. Энд үг, үсгийг нь жоохон тодруулаад ойлгомжтой болгоод орж ирэх нь зүйтэй байгаа юм гэж бодож байна. Тийм.

Дахин дахин хэлэхэд энэ чинь төр өөрсдөө өчнөөн хэмжээний хөрөнгө оруулж чадахгүй байгаа.

Тэгэхээр аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулаад орж ирж байгаа. Энэ хугацаандаа өөрсдөө ашгаа олоод ингээд явах. Буцаад төрдөө төмөр замаа шилжүүлээд ингээд төрийн өмч болгоод явах боломж бололцоог нь аль аль талдаа тэгш байх, тэгш нөхцөлийг олгоход энэ

хууль чинь орж ирж байгаа юм шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Сайд хариулахгүй юм байна.

Тэгэхдээ энэ төмөр замын бодлогын тэр төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ, царигийн асуудал гээд тусдаа юмнууд байсан. Үүнийг жоохон бүрхэгдүүлсэн.

Тэгээд тэр төр, хувийн хэвшлийн түншлэл төмөр замын бодлого дээр ч байсан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр ч байсан. Дараа нь баахан зөрчил үүсэхээр болох харилцаануудыг нэг мөр зохицуулахгүй бол.

Энэ бүгдийг нь уншлаа. Төмөр замын бодлоготойгоо харьцуулж уншиж үзлээ.

Тэгвэл яагаад зөвхөн нийтийн зориулалттай төмөр замын царигийн асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Зөвхөн Улсын Их Хурал шийднэ гэж байгаа юм.

Зөвхөн энэ хуулийн 7.1.7-д заасан царигийн асуудлыг л Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Бусдыг нь шийдвэрлэхгүй гэсэн агуулгатай болсон байна шүү дээ.

С.Бямбацогт сайд хариулья.

С.Бямбацогт: Манай зарим гишүүд хуулиа унших хэрэгтэй. Тийм.

Хуулиа уншаагүй байж тэгээд одоо бас юм яриад байх хэрэггүй байх.

Энэ нийтийн зориулалттай төмөр зам гэж тийм үү, төмөр замын суурь бүтэц бүхий нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой нийтэд тээврийн үйлчилгээ

үзүүлэх зориулалттай төмөр замыг гэж байгаа юм.

Ерөөсөө бүх төмөр зам орж байгаа. Энд. Тусгай зориулалтын төмөр зам гэдэг дээр төмөр замын суурь бүтэц бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зориулалттай. Аж ахуйн нэгжүүдэд дотоод үйл ажиллагаанд зориулсан төмөр замыг тусгай зориулалтын л гэж байгаа юм.

Тэгээд үүнээс бусад бүх төмөр замыг бүгдийг Их Хурал мэднэ ээ. Их Хурал мэднэ.

Үндсэндээ өөрөөр хэлэх юм бол Их Хурал бүх төмөр замаа мэднэ. Аж ахуйн нэгжийн хашаан доторх төмөр зам руу Их Хурал оролцох шаардлагагүй гэсэн л ийм агуулгатай. Нийтийн зориулалттай төмөр зам. Тэр утгаараа үндсэндээ Их Хурал бүгдийг нь мэдэж байгаа.

Хоёрдугаарт нь, төр, хувийн хэвшлийн түншлэл.

Т.Энхтүвшин гишүүн ээ, байж байгаа. 24.3 дээр төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгасан байна. Маш тодорхой байж байгаа.

Ерөнхийдөө бид Ханги-Мандалын төмөр зам хувийн хэвшлээр баригдсан. Концесс. Энэ дээрээсээ туршлага аваад ингээд үндсэндээ энэ төмөр замыг цааш цаашдаа зүүн босоо төмөр зам, баруун босоо төмөр зам, бүгдийг нь хувийн хэвшлийнхэн барих гэж байгаа.

Тийм болохоор хувийн хэвшлийнхээ эрх зүйн харилцааг илүү боловсронгуй болгоод, хувийн

хэвшлийнхэн төмөр зам барих бололцоо боломж, дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ хуульд оруулж ирж байгаа юм. Тийм. Ингэж орж ирж байгаа байхгүй юу.

Дэмжээд байхад чинь дэмжихгүй байна гэж яриад байх юм. Хувийн хэвшлийг. Дэмжиж байгаа заалтууд явж байгаа.

Дээрээс нь илүү либерал болгож байгаа. Улаанбаатар төмөр зам монопол байсан. Өөрөө тээвэрлэдэг, өөрөө суурь бүтцээ эзэмшдэг. Бусдыг явуулдаггүй. Бусдыг явуулахдаа хэтэрхий өндөр үнэ тавьдаг. Энэ монополийг бид задалж байгаа. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоёр нь тусдаа байна гэдэг нь.

Тэгээд хоорондоо шударга өрсөлдөх тэгш боломжийг бий болгохоор ярьж байгаа юм. Монополийг задлах.

Ийм заалтууд орчихсон байгаа шүү дээ. Үүнийг уг нь уншаад гишүүд маань харчихмаар байгаа юм л даа. Мушгиж яримааргүй байна шүү.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Хашаа руу орж байгаа төмөр зам биш л дээ. Тусгай зориулалтын төмөр зам гэж төмөр замын суурь бүтэц бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулж. Гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр зам гэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг өөрөөр хэрэглэвэл маш янзын байдлаар хэрэглэж болно.

Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн.

Т.Энхтүвшин: 24.3-ыг чинь би уншаад байж байгаа юм л даа.

Энэ төмөр замын суурь бүтцийг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих тохиолдолд төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг түншлэлийн гэрээнд тусгана л гэсэн ийм заалт байж байгаа юм.

Би энэ дээр юу хэлээд байна гэхээр нэгэнт л юу гэдэг юм төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьсан юм бол суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх бололцоо боломжийг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьсан компанид нь нээж өгөөч ээ. Ийм заалт оруулж өгөөч ээ л гэж хэлж байгаа юм. Яг ийм заалт байхгүй байгаа шүү дээ.

Харин 26 дээр нь юу гэж байна. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь тусдаа хуулийн этгээд байна л гэсэн заалт байж байгаа юм. Тэгээд 26 дээрээ ч гэсэн бид энэ төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгчид нь тусдаа хуулийн этгээд байж болно гэдэг ийм заалтыг л оруулж өгч цаашаа явна уу гэхээс биш шууд хуулийн этгээд байж болно, байна гээд ганцхан үгээр юу гэдэг юм нэг хуулийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын хилийн боомт чиглэлийн болон хил дамнасан төмөр зам нь нийтийн зориулалттай төмөр зам байна гэж байгаа юм.

Үүнийг бид хувийн хэвшлийнхээ боломж бололцоог нь дэмжье. Хувийн хэвшлээ концессоор барих бололцоог нь дэмжээд, дундуур нь хэн нэг нь орохгүйгээр, хэн нэг нь бололцоог нь

хулгайлахгүйгээр, өрөм буюу тэр бусад асуудал руу нь юу гэдэг юм шугам дотор нь дараагийн концесс эзэмшигч орж ирж будилуулах. Тэр юу гэдэг юм, ашиг олох боломж бололцоог нь хаах үүднээс нэг өмчлөгч байна.

Өөрөөр хэлбэл хил дамнасан төмөр зам явсан л бол тэр лүү концессоор нэг л байг. Одоо Ханги-Мандал руу явсан бл Ханги-Мандалын тэр хэн байдаг юм тэр хүн нь тэр чигээр нь эзэмшээд концессынхоо хугацаанд бүрэн эзэмшээд явах.

Түүнээс биш тэр Ханги-Мандалынх нь завсраар нь хэн нэгэн орж ирээд тэр өрмийг нь аваад, тэр юу гэдэг юм салаа зам хийгээд будилуулаад байхгүй ийм бололцоог нь бид хангаад энд өөрчлөлт хийж.../минут дуусав/

Г.Занданшатар: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал тусдаа.

Тэгэхдээ нийтийн хэрэглээний зам гэж хуучин хуульд байсан. Дагнасан хэрэглээний зам гэж хуучин хуульд байсан. Нийтийн хэрэглээний талбай гэж нийтийн хэрэглээний зам эзэмшигч, нийтийн хэрэглээний талбай эзэмшигч гэсэн ойлголтууд байсан.

Үүнийг нийтийн зориулалттай төмөр зам эзэмшигч гэсэн мөртлөө тусгай зориулалтын зам нь гэрээний үндсэн дээр нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замыг хэлнэ гээд ингээд ийм ацан дунд маш олон юм явах гээд байна л даа.

Зочид танилцуулъя.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн 11-ийн А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт оюутнууд Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн суралцаж, сайн эмч болцгоогоорой. /алга ташив/

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Дарга аа, ийм байгаа шүү.

Нийтийн зориулалттай төмөр зам гэж төмөр замын суурь бүтэц бүхий нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай төмөр зам гээд. Одоо бидний хамгийн сайн мэддэг Улаанбаатар төмөр замын Замын-Үүд, урагшаагаа явж байгаа Алтанбулагийн төмөр зам.

Энд ачаа тээвэр ч явна, нийтийн үйлчилгээ, зорчигч тээвэр ч явж байгаа.

Тусгай зориулалтын төмөр зам гэдэг нь төмөр замын суурь бүтэц бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан. Өөрөөр хэлбэл одоо жишээ нь бид нарт том жишээ байна шүү дээ. Болдтөмөр-Ерөөголын уурхай руу явсан төмөр зам. Энэ бол тусгай зориулалтын төмөр зам.

Авто тээвэр дээр хүртэл байдаг шүү дээ. Тусгай зориулалтын авто зам гэж.

Гагцхүү дараа нь жишээ нь тийшээгээ хөгжил сайн болоод нийтийн төмөр зам, өөрөөр хэлбэл зорчигч урсгал тийшээгээ явахаар бол эднийхтэй гэрээ хийж байгаад тодорхой хэмжээний стандартыг нь өөрчлөөд зорчигч явах боломж бололцоог нээх ёстой байгаа юм.

Тэр утгаар нь нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх. Гэрээний үндсэн дээр нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх.

Г.Занданшатар: Тэрийг ч ойлгоод л байна л даа. Энэ чинь нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой гэж маш ерөнхий ойлголт.

Юуг ч нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой болгож болно. Юуг ч гэрээний үндсэн дээр нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх болгож дараа нь хувиргаж болно.

Энэ хоёрын чинь ялгааг ялгахад байна шүү дээ, сүүлд нь энэ дээр ёстой хуулийн зөрчил юуг ч яаж ашиглаж болохоор болчхож байгаа байхгүй юу.

Нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх үү, үзүүлнэ. Гэрээний үндсэн дээр. Суурь бүтэцтэй юу, бүтэцтэй. Хоёулаа. Ганц ялгаа нь нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой.

Нийгэм, эдийн засгийн ач холбогдолгүй зам гэж ер нь юу байх юм. Юу ч нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой гэж тайлбарлаж болно шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг гишүүн, Байнгын хорооны дарга.

Ц.Цэрэнпунцаг: Сая Д.Ганбат гишүүн чухал асуудал хөндөж байгаа юм.

Ер нь царигийн асуудал энэ төмөр замын хууль дээрээ. Одоо энэ цоо шинэ хууль. Энэ царигийн асуудал ер нь энэ дээрээ нэг мөр шийдэгдэж орж ирвэл зүгээр байгаа шүү.

Өнөөдөр яг бодит амьдрал дээр гарч байгаа бид Их Хурал дээр төрөөс төмөр замын талаар явуулах бодлогоо

тодорхойлчихсон. Тэгтэл өнөөдөр Засгийн газар дээр Засгийн газрын шийдвэрээр хилийн төмөр зам билүү. Ийм ойлголт оруулж ирээд өнөөдөр нарийн царигтай төмөр замын асуудлууд баригдах шийдвэр гаргаад энэ засаг нь явж байгаа шүү дээ.

Тэгэхээр ер нь үүнийг дахиад нэгмөсөн энэ царигийнх нь асуудлыг энэ дээр нь оруулж энэ нэг мөр шийдэл, одоо бид энэ бодлогоо тодорхойлж нэг мөр энэ асуудлыг ийм салаа утгагүй болгож нэгмөсөн энэ хууль дээрээ ер нь бид ажиллавал яасан юм.

Г.Занданшатар: Яах вэ, ер нь зүгээр тусгай зориулалтын зам гэхээрээ Улсын Их Хурлаар хэлэлцэгдэхгүй. Чиглэл юу гээд. Тэгсэн мөртлөө яг адилхан замыг ингээд Улсын Их Хурлаар хэлэлцэгдэхгүй ийм л зам. Чиглэл цариг хоёр нь тийм нэг цоорхой л гарч ирж байгаа юм л даа.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Нэг асуулт асууя.

Тэгэхээр Төмөр замын тээврийн тухай хууль ярьж байна. Түрүүн Ц.Сэргэлэн гишүүн асуугаад Их Хурлын дарга чиглэл өгсөн асуудлыг би яг тодотгож асуух гэж байсан юм.

Энэ Төмөр замын тээврийн хууль дээр нөгөө газрын харилцааны асуудал ерөөсөө байхгүй байгаа нь энэ газрын харилцааных нь асуудал нь бие даасан тусдаа хуулиар газрынхаа хуулиар зохицуулагдана гэж би ойлгож хуульчлаагүй юм байна гэж ойлгож байна.

Тэгэхдээ эндээс нэг тодотгож асуух асуулт нь хуулийн төслийн 9.1.5-д төмөр замын бүтээн байгуулалттай

холбоотой газар эзэмшүүлэх төсөл нь газар олгох гэж орж ирсэн юм. Одоо санал хураах гэж байгаа ажлын хэсгийн саналын томъёоллоор газар эзэмшүүлэх эрх олгох гэж хураах гэж байгаа.

Тэгэхээр эндээс би юу гэж тодруулж асуух гэж байна вэ гэхээр газар эзэмшүүлэх гэхээр гадаадын иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах гэж бид газрын хууль үйлчилж байгаа.

Энэ төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд газар эзэмших харилцаа явна гэж ойлгох уу? Эсвэл төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой гадаадын хуулийн этгээд юм уу, эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн газрын харилцаа хэрхэх вэ гэсэн энэ 9.1.5-тай холбоотойгоор ийм асуулт байгаа юм.

Яагаад ингэж асууж байна вэ гэхээр Улаанбаатар төмөр замын хувьд Монгол, Оросын хамтарсан компани байгаа. Бид Үндсэн хууль ёсоороо бол хууль, олон улсын Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хоёр хоорондоо зөрчилдвөл олон улсын гэрээний заалтыг нь дагаж мөрдөх хуультай.

Хэрвээ Монгол Улсын олон улсын гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдвөл бид Үндсэн хуулиа дагаж мөрдөх тийм Үндсэн хуультай.

Тэгэхээр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 1949 оных шиг санаж байна. Монгол, Оросын хамтарсан төмөр замын энэ компанийн хувь нийлүүлсэн гэрээ бол Монгол Улсын олон улсын гэрээнд тооцогдож явдаг буюу Монгол Улсын хуулиас илүү давж хүчин төгөлдөр үйлчилдэг.

Тэр ч утгаараа хугацаа байна уу, байхгүй юу газрыг хугацаагүйгээр ашиглаж байгаа. Одоо Улаанбаатар төмөр зам Монгол Улсын газрыг хугацаагүйгээр, төлбөргүйгээр ашиглаж байгаа.

Тэгэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд гадаадын иргэн, хуулийн этгээдэд зөвхөн хугацаатай, төлбөртэй ашиглуулна гэсэн Үндсэн хуультай.

Тэгэхээр энэ гэрээ Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй 30 жил үйлчилж байна. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээ авахгүй юм уу?

Энэ чинь нэг төгрөг ч болтугай төлбөр төлөхгүй юм уу? Бид ингээд Үндсэн хуультайгаа нийцэхгүй олон улсын гэрээ үйлчилж байгааг ярихгүй яваад байх юм уу?

Энэ чинь Монгол Улсын Үндсэн хууль буюу Монголын нийт ард түмний бүтээл хамгийн дээр нь байхгүй юм уу? Төлбөрийн хэмжээг нь би мэдэхгүй. Тэгэхдээ ямар нэгэн байдлаар Үндсэн хуульдаа нийцүүлж нэг ч гэсэн төгрөг авах ёстой биз дээ гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ салбар дээр чинь нэлээн олон жил ажилласан. Бидний бас нэлээн том проблемуудын нэг Улаанбаатар төмөр замын асуудал шүү дээ.

Бид 1949 оны гэрээ гэж байгаа. Анх энэ төмөр замыг 1946 он байх. Анхны хэлэлцээр хийгдээд 1949 оноос үйл ажиллагаа нь төмөр зам тавигдаад явсан байдаг.

Тэгээд энэ гэрээн дотор анх Монгол Улс энэ зурвас газраа. Тэр битгий хэл төмөр замын байгууламж байгуулагдана гээд энэ бүр Баянгол дүүргийн нэлээдгүй хэсэг газрыг хүртэл зурвасалж аваад. Тэгээд үүнийгээ бид барьцаанд. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтынхаа хэлбэр лүү оруулаад, газраараа хөрөнгө оруулалт оруулаад, тэгээд хамтарсан компани байгуулаад энэ Улаанбаатар төмөр зам чинь өнөөдөр бид нарт үйлчлээд явж байгаа юм шүү дээ.

Тэгээд бид одоо жишээ нь энэ хоёр улсын хоорондын хэлэлцээрүүд дээр үргэлжийн энэ асуудлуудыг ярьж байдаг. Бидний хуультай зөрчилдөөд байгаа гэдэг утгаараа. Яг Б.Энхбаяр гишүүний хэлдэгчлэн энэ газрыг бид Газрын тухай хуульдаа оруулья.

Тэгээд аж ахуйн нэгж яг энэ газраа ямар хэлбэрт нь ашиглах юм, яаж төрөөс тодорхой хэмжээний түрээс аваад явах юм гэдэг асуудлууд тавьж байгаа.

Тэгэхээр Оросын тал юу тавьдаг вэ гэхээр тэгвэл тарифынхаа асуудлууд, бусад асуудлуудаа, энэ 16 мянган ажилчдаа. Дээрээс нь нийгмийн бүтээн байгуулалтууд байж байгаа. Өчнөөн олон цэцэрлэгүүд, өчнөөн олон сургуулиуд. Үүнийгээ тэгвэл та нар буцаагаад яг төрийнхөө хэмжээнд авчих л даа.

Тэгээд зөвхөн яг тээврийнхээ үйл ажиллагааг хэдүүлээ явуулья. Тэгээд газрынхаа асуудлыг шийдье гэсэн ийм зүйлүүдийг тавьдаг. Тэгээд өчнөөн олон жил бид энэ гэрээг хийсэн шүү дээ. Энд тэр гэрээг дээр хийж байсан хүмүүс нэлээн байх л ёстой.

Тэгээд энэ дээрээ бид одоо жишээ нь энэ олон цэцэрлэг, сургуулиудыг төр өөр дээрээ аваад ачаалалдаа үүрч

чадахгүй. Дахиад л Улаанбаатар төмөр замаар үүрүүлээд л яваад байгаа шүү дээ. Үүрүүлээд л яваад байгаа.

Тэгэхээр энд буцаагаад нөгөө газрынхаа асуудлуудыг ярихаар болохгүй болчихоод байна.

Одоо энэ хуулийн дагуу нэг том концепц бол ерөөсөө суурь бүтэц буюу бидний мэддэгчлэн далан бүхий төмөр замын зурвас. Дээгүүр нь явж байгаа тээвэр, зүтгүүр, вагон. Энэ бол хоёр аж ахуйн нэгж болно гээд тэгж байгаа. Ингэж байж энэ олон улсын зарчмаар явж байгаа. Энэ бол маш том гол концепц нь энэ шүү дээ. Ерөөсөө энэ хуулийн.

Тээвэрлэгч, дэд бүтэц эзэмшигч хоёр тус тусдаа байна гээд. Яг үүгээр одоо жишээ нь дахиад бид Улаанбаатар төмөр зам дээрээ нэг асуудал тавина. Одоо тээвэрлэгч болон дэд бүтэц эзэмшигч, суурь бүтэц эзэмшигч хоёр компани болж хуваагдана. Улаанбаатар төмөр зам гэдэг асуудлыг бас дахиад оросууд дээрээ тавьж эхэлнэ.

Яагаад гэхээр бид ийм хуулийн дагуу явж байгаа. Оросууд ч гэсэн өөрсдөдөө бас ийм шугамаар явж байгаа шүү дээ. Өөрсдөдөө бас л суурь бүтэц, тээвэрлэгч гээд салчихсан.

Тэгэхээр тэр хууль нь зөв зүйтэй хувилбар гэдгийг мэдэж байгаа.

Тийм болохоор бид өөрсдийнхөө хуульд цоо шинэ ийм зарчим, логикийн том шинэчлэл хийгээд явж байгаа байхгүй юу. Бид нар. Яг өөртэй чинь адилхан холбоотой асуудлыг би санал нэг байгаа. Одоо хүссэн хүсээгүй Улаанбаатар төмөр зам дээр бид Ерөнхий хороон дээр дахиад л асуудлуудаа тавиад л оросуудтайгаа олон асуудал ярихын нэг

нь дахиад газрын асуудал энэ хуулиа дагаад орж ирэх байх.

Бид энд нөгөө төрийн өмч байна гэдгээр нь тодорхойлчихсон. Тэгээд ямар ч байсан аж ахуйн нэгж нь нэг их эзэмшээд байхгүй гэдэг рүү нь оруулчихсан.

Тэгэхээр дахиад газрын асуудал маань яригдана. Үндсэн хууль буюу энэ чинь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх гээд нэг заачаад байгаа юм л даа. Тэгээд энэ дээр өөр найруулгаар юу гэх юм. Газрын тухай хууль гэж заах ёстой байдаг юм уу. Хуульч хүний хувьд яг юу гэх ёстой байдаг юм.

Бид өөрсдийнхөө хүрээнд, хуулийн хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гээд явчхаж байгаа юм.

Ямар ч байсан Улаанбаатар төмөр замын хувьд бид 1949 оныхоо хэлэлцээр дээр ер нь л бага багаар засаад яваад байгаа юм шүү. Бага багаар бид өөрчлөлт хийгээд л яваад байгаа.

Г.Занданшатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа санаа бол уг нь зөв боловч энэ хуулийн нөгөө оруулж ирсэн юутайгаа их сонин зөрчилдөөд байгаа юм.

Суурь бүтэц эзэмшигч гэж хуучин байсан юм шүү дээ. Ойлголт. Тийм үү. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг гэж байсан. Хөдөлгөөний нэгдсэн зурмагууд байсан.

Тэгээд тэр бүгд байхгүй болоод суурь бүтэц эзэмших ч гэсэн ойлголт байхгүй болоод, тэгээд энэ нийтийн зориулалт, нэр томьёо юун дээр бүгд байхгүй болчихсон.

Ёстой биднийг уншихгүй байна гэж загнаад байна. Та хэд тэгвэл тэрийгээ уншаагүй байна.

Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг, хөдөлгөөний нэгдсэн зурмаг байхгүй. Суурь бүтэц эзэмшигч гэсэн нэгдсэн тодорхойлолт байхгүй. Төмөр замын аюултай бүс, аюулгүй бүсийн хуучин зурмаг, аюултай бүсийн тодорхойлолт байсан. Байхгүй. Нэр томьёон дээр байхгүй. Нэр томьёон дээр байхгүй учраас цаашдын зохицуулалт дээр байхгүй. Хөдөлгөөний нэгдсэн зурмаг чинь гарч байж энэ суурь бүтэц дэх хөдөлгөөний, Монгол Улсын нийт төмөр замын галт тэрэгний хөдөлгөөний зурмаг хөдөлгөөн гарах ёстой.

4.1.18 дээр төмөр замын цариг гэж байна. Зурмаг гэж алга. 19 дээр суурь бүтцийн хөдөлгөөний зурмаг биш. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг оруулсан байна. Суурь бүтэц дэх нэгдсэн зурмаг гэж байгаа.

Мэргэжлийн хүмүүс хариулаадах. 84. Хуучин суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг гэж байсан уу? 84. Тийм, үгүй гээд л хариулчих. 84.

Х.Итгэлт: Тийм.

Г.Занданшатар: Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг гэж суурь бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг хэлдэг байсан биз.

Х.Итгэлт: Тийм.

Г.Занданшатар: Тийм үү, үгүй юу гэдгээ л хариул.

Х.Итгэлт: Тийм.

Г.Занданшатар: Тэр яагаад байхгүй болчихсон юм?

Хөдөлгөөний нэгдсэн зурмаг гэдгийг тэр галт тэрэгний хөдөлгөөний зурмаг болгосон байна. Яагаад тэгсэн юм?

Ингээд энэ асуудлууд чинь. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Хуулийн төсөлтэй холбогдуулаад ганц нэг тодруулах асуудал байна.

Өнөөдөр төмөр замын төрөөс явуулах бодлогын асуудал бол Монгол Улсын эдийн засагт хамгийн их чухал ач холбогдолтой ийм асуудал. Бид энэ ач холбогдлыг КОВИД-ын үед л мэдсэн.

Бүх хил боомт хаагдсан үед энэ 16 мянган төмөр замчид галт тэрэг гэдэг төмөр замын асуудал дээр Монгол Улс эдийн засгийн хувьд амиа зогоож, энэ эрсдэлтэй нөхцөлөөс гарсан.

Энд суурь бүтэц, бусад бодлогын асуудлыг ярьж байна. Гэхдээ энд ажилладаг 16 мянган хүний нийгмийн асуудал дээр. Ялангуяа тэтгэврийн сан бүрдүүлэх тухай Н.Номтойбаяр сайдын үеэс бас хэд хэдэн саналууд тавиад дэмжигдээд явж байсан юм байна.

Энэ асуудлыг энэ хуульд ямар байдлаар тусгах боломж байгаа вэ? Тусгах ийм санал энд харагдахгүй байна. Энэ дээр ямар бодолтой байна гэсэн.

Дээр нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд суурь бүтцийн асуудлуудыг ярьж байна. Одоо энэ дээр Ханги-Мандал-Зүүнбаянгийн чиглэлийн төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүтээн байгуулсан.

Тэгээд энэ хил хоорондын холболтын цэг, терминал барих асуудал өнөөдрийг хүртэл их сонин асуудал би сонссон. Тэр хил холболтын терминалыг Хятадын компани барина гээд шийдвэр гаргасан тухай сонссон. Энэ үнэн юм уу?

Өнөөдөр та нарын энэ яриад байгаа юмтай чинь энэ шийдвэр чинь зөрчилдөж байна шүү дээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэр холболтын цэг, барьсан бүх асуудлыг тэр Төр, хувийн хэвшлийн хүрээнд гүйцэтгэсэн компани нь шийднэ гэж яриад байгаа. Гэтэл тэр тийм мэдээлэл байгаа.

Тэр холболтын цэг дээр барьсан терминалыг Хятадын компаниар бариулахаар шийдвэр гарсан байна гэж. Энэ ямар учиртай мэдээлэл байна аа? Ингээд энэ дээр нэг хариулт авъя.

Г.Занданшатар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ийм байгаа шүү. Хилийн холболт дээр олон улсын төмөр замын тээвэрлэлтийн дүрмээр нийлүүлж. Өөрөөр хэлбэл тээвэрлэлтэд авчирч байгаа. Өөрөөр хэлбэл жишээ нь урдаас орж ирж байгаа нь манайд ачиж буулгах терминалаа барьдаг. Манайх цаад талдаа. Нэг талдаа бол Орос, нэг талдаа Хятадад терминалаа барьдаг ийм дүрэмтэй юм шүү.

Тийм болохоор манай тал руу орж ирж одоо жишээ нь урд байж байгаа төмөр замын хувьд Хятадын тал орж ирж манай хилийн наад талд нь төмөр замаа барьдаг ийм дүрэмтэй. Энэ бол олон улсын төмөр замын тээвэрлэлтийн тухай дүрэмдээ заасан зүйл байгаа юм шүү.

Тийм болохоор наад талдаа тэр Хятадын тал терминалаа барих гэж байгаа гэсэн ийм зүйл яригдаж байгаа байх гэж ойлгож байгаа.

Энэ бол олон улсын дүрэм юм.

Яг холболтын цэг ямар хэмжээнд явж байгаа энэ тэрийг сайд тодорхой хэмжээнд хэлэх болов уу гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, төмөр замын концессын гэрээгээр бид одоо жишээ нь Хангийн чиглэлээр барилаа. Энэ дээр мэдээж холболтын цэгтэй холбоотой асуудал. Магадгүй зүгээр түрүүн би хэлж тайлбарласан шүү дээ. Хятадууд орж ирээд ч байдаг юм уу тэр ачиж буулгах асуудлыг нь ингээд тусад нь. Тэр таны ярьж байгаа нэг талдаа наад талаасаа цаанаасаа орж ирээд тэр ачиж, буулгах терминалаа барих ёстой.

Гэхдээ наанаас явж байгаа өөрөөр хэлбэл Хангийн чиглэлээс наанаасаа явж байгаа энэ төмөр зам дээр дунд нь таслаад жишээ нь ямар нэгэн үйл ажиллагаа явуулах, ямар нэгэн концессын гэрээгээр үйл ажиллагаа явуулахгүй гэдгийг нь хамгаалаад энэ хуульд нэг тээвэрлэгч, нэг эзэмшигч байна гэдгээр нь заагаад хамгаалалт хийчихсэн байгаа шүү.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу энд хөрөнгө оруулж байгаа компанийг нь хамгаалаад явчихсан ийм заалт орж ирсэн байгаа гэж.

Яг холболтын цэгтэй холбоотой асуудал ярьсан уу. Сайд. Яг холболтын цэг ямар байгаа вэ л гэж байх шиг байна. Хэзээ хийгдэх юм бэ гэж байгаа юм шиг байна.

Г.Занданшатар: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах юм? 84. Мандширийн Энхболд.

М.Энхболд: Ш.Адъяаа гишүүний асуултад хариулъя.

Хангимандалын холболтын цэгийг Хятадын талтайгаа бид нэгдсэн байдлаар хоёр талын өртөө боловсруулах одоо ачаа шилжүүлэн ачих байгууламж нэгдсэн зохион байгуулалттай байх үүднээс зүгээр төлөвлөлтөө нэгтгэж хийж байгаа юм.

Зураг төсөл маань адилхан байхын тулд ингээд Хятадтайгаа хамтраад хийж байгаа болохоос Монгол талынхаа бүх асуудлыг концесс эзэмшигч өөрсдөө гүйцэтгээд ингээд өөрийнхөө Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх барилгын ажлаа концесс эзэмшигч өөрсдөө хийгээд явна.

Зүгээр төлөвлөлтөө бид Хятадын талтайгаа хамтраад нэг төлөвлөлттэй болчихвол энэ дээр галт тэрэг цаашдаа солилцоо нэмэгдэх, ачаа боловсруулах хүчин чадал нэмэгдэх юм гэж ингэж л үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Тэтгэврийн сангийн тухай асуудал. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ер нь төмөр зам бол хувийн тэтгэврийн сантай байж болох цорын ганц.

Ж.Бат-Эрдэнэ: Нийгмийн даатгалын багц хуультайгаа л холбоотой асуудлууд.

Ер нь яах вэ, зүгээр энэ салбар салбарынхаа нийгмийн даатгалтай холбоотой нийгмийн чиглэлийнхээ хуульд ингээд тусгаад явсан нь дээр байх

л гэж байгаа юм л даа. Бид энд бас Улаанбаатар төмөр зам дээр хэрэглэж байсан нэг заалтыг сүүлд оруулсан.

Түүнээс биш тэтгэвэртэй холбоотой асуудал хуулийнхаа дагуу Улаанбаатар төмөр зам ч бай, сүүлд орж ирж байгаа Монголын төмөр зам, бүхий л төмөр замын байгууллагууд Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийнхаа дагуу энэ тэтгэвэр нь тусгагдаад явчихна л гэж ойлгож байгаа.

Тэгэхгүй болохоор тэр салбар салбар дээр авто тээвэр дээр авчирч наагаад л, зам дээр авчирч наагаад л, төмөр замынхан дээр авчирч наагаад л. Өөр юу байдаг юм. Ингээд байвал энэ чинь нийгмийн даатгалын багц хууль гээд энэ том хууль байх шаардлагагүй л болчих гээд байгаа юм л даа.

Тэгэхээр энэ утгаараа тэтгэвэртэй холбоотой асуудал нь тэр тусгайлсан хуулиараа шийдэгдэнэ л гэж байгаа юм. Хаягдахгүй.

Г.Занданшатар: Тодруулъя. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Төмөр замын асуудал арай өөр онцлог салбар. Энэ бол хоёр улсын хэлэлцээрээр 50, 50 хувь эзэмшдэг.

Гэтэл энд миний авсан судалгаагаар Оросын тал бас ингээд хувийн тэтгэврийн сан байгуулаад явж байдаг.

Тэгээд Ж.Бат-Эрдэнэ гишүүн сая ярилаа шүү дээ. Сургууль, цэцэрлэг, бүх юм төмөр замын мэдэлд байдаг гээд. Энд төр оролцохгүй гээд.

Гэтэл тэр 16 мянган ажилчдын асуудлыг энэ хүрээнд тусгайлан

нийгмийн асуудлыг шийдэхэд яагаад болохгүй байгаа юм. Энэ талаар нэмэлт тайлбар авъя.

Г.Занданшатар: Ажлын хэсэг. 84. Нэр усаа хэлээд. Протоколд тэмдэглэгдэж байгаа учраас.

Х.Итгэл: Х.Итгэлт. Гишүүний асуултад хариулъя.

Энэ хууль маань бүх Монгол Улс төмөр замын үйл ажиллагаа явуулж байгаа суурь бүтэц эзэмшигч төмөр замын компаниуд. Эд нарт бүгдэд нь үйлчлэх юм. Нэг.

Хоёрдугаарт, энэ хуулиараа бид төмөр замын салбараа либералчлаад, энэ салбар луугаа олон аж ахуйн нэгжийг татъя, оролцуулъя гээд явахаар энэ дээр хувийн тэтгэврийн сан ч юм уу, үүнийг зохицуулчихаар бусад хувийн хэвшлүүдтэйгээ дарамт болчих болов уу гэж харж байгаа.

Нөгөө хувийн хэвшил маань юу гэж орж ирсэн бэ гэхээр төмөр зам бариад түүгээр уул уурхайн бүтээгдэхүүн ч юм уу, төмөр зам хийе гэсэн чинь нийгмийн асуудалдаа орооцолдох ч юм уу. Тэр нь компанидаа дарамт болох вий л гэж байгаа юм.

Улаанбаатар төмөр замын хувьд үйлдвэрчний эвлэлийн байгууллага, хамтын гэрээ. Энэ нь бэхжээд явчихсан. Энэ нь нийгмийн даатгалын багц хуулиараа тэр хувийн тэтгэврийн сан.../минут дуусав/

Г.Занданшатар: Юмыг дандаа буруу мушгиж ойлгох юм.

Ш.Адьшаа гишүүн хувийн тэтгэврийн сантай байж болно, тийм

төмөр замын байгууллага байж болно гэсэн. Байхгүй ч байж болно.

Одоо зөндөө байгууллагууд хувийн дэвтрийн сантай болоод ажилчид нь түүндээ шимтгэлээ төлөөд. Тэгээд нээлттэй байж болно гэдэг хувилбараар оруулчихъя гэхээр бусдад дарамт үзүүлнэ энэ тэр гээд болохгүй талаас нь юмыг дандаа ингэж мушгих юм. Сонин улсууд юм аа.

Б.Дэлгэрсайхан гишүүн. Ингэх тусам л дэмжлэггүй болно.

Б.Дэлгэрсайхан: Би гишүүдийн ярьж байгаагаас бас хэдэн асуудлыг нь тодруулья гэж бодож байгаа юм.

Ер нь Их Хурлын даргын ярьж байгаа үнэн л дээ. Өмнөх хуульд нийтийн хэрэглээний зам, дагнасан хэрэглээний зам гээд ялгаатай. Дагнасан хэрэглээний зам гэдэг нь юу юм гэхээр уул уурхай түшиглэсэн ч байдаг юм уу, одоо энэ Багануур чиглэлийн. Тэгээд хойшоо Төмөртэй, Баянголын чиглэлийн замыг хэлээд байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ шинэ хуульдаа тусгай хэрэглээний гэж оруулж ирж байгаа юм байна гэж ойлголоо.

Дээрээс нь Ц.Сэргэлэн гишүүний асуугаад байгаа газар “өмчлөх”, “эзэмшүүлэх” гэдэг дээр. Тийм юм бараг байхгүй байх. Ялангуяа энэ түншлэлийн гэрээгээр баригдаж байгаа төмөр замын хувьд “ашиглах” гэж орж ирэх ёстой. Тэгэхээр түүгээрээ явах байх гэж бодож байна.

Дээрээс нь Б.Энхбаяр гишүүний ярьж байгаатай би яг санал нэг байна. Бид энэ хуулийг өнөөдөр баталж болно. 1949 оны гэрээгээр Улаанбаатар төмөр

замд үйлчлэхгүй шүү. Үүнийг манай яам мэдэж байгаа юм байгаа биз дээ.

Ер нь цаашдаа манай Монгол талын ерөнхийлөн. Одоо юу гэдэг юм. Улаанбаатар төмөр замыг төлөөлж байгаа, энэ өмчлөлийг төлөөлж байгаа сайд байна.

Ер нь цаашдаа Улаанбаатар төмөр замын нийгмийн байгууламжуудыг улс, аймаг, сум нь, одоо тэр дайран өнгөрч байгаа юуг нь улс өөртөө авахгүй бол энэ ингээд хоёрын хооронд хаягдчихсан. Тэгээд Улаанбаатар төмөр зам нь үүнийгээ дааж давахаа байчихсан. Энэ чинь социализм биш шүү дээ.

Тэрийг нь зах зээлийн журмаар нь ажиллуулдаг болгохгүй бол ингээд цаашдаа Улаанбаатар төмөр зам чинь дампуурах юм уу. Яг хөдөлгөөнийх нь улсууд нь 9 мянга байдаг. Үлдсэн нь нийгмийн байгууламжид л ажилладаг улсууд шүү дээ.

Тийм учраас жишээлбэл, өмнө нь Дорноговьд байгаа төмөр замын эмнэлэг, сургууль энэ тэрийг чинь бүгдийг нь аймаг авчихсан байгаа. Тэгээд цэцэрлэг нь төмөр замдаа байдаг юм шиг байгаа юм.

Цаашдаа Улаанбаатар төмөр зам эмнэлэг, цэцэрлэг, сургууль, тэр барилга, контор, одоо нөгөө барилга барьдаг юм энэ тэрээсээ цаашдаа салахгүй бол энэ байдлаараа яваад урагшлахгүй шүү. Үүнийг яам санаачилж үүнийгээ Оросын талтай яриад энэ нийгмийн байгууламжуудаас нь салгаж, жинхэнэ төмөр замын үүрэг гүйцэтгэх ийм утга учраар нь ажиллуулах ёстой гэдгийг бодолцох хэрэгтэй байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, энэ ажлын хэсгийнхэн ч бас зөв ярьж байна. Энэ

хууль дээрээ суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хоёр хоёр тусдаа байна гээд заачхаж байгаа юм.

Тэгэхээр наадах чинь байна шүү дээ. Юу гэж харагдаад байна вэ гэхээр хэдий доор нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэрээгээр түншлэлийн гэрээнд тусгасан байна гээд. Гэрээ бол гэрээ. Хуульдаа үүнийг зааж өгөхгүй бол гэрээ хамаагүй, хуулиар явна гэвэл үндсэндээ Монгол Улсад төмөр замын дэд бүтэц дээр хөрөнгө оруулах хүн дахиж орж ирэхгүй шүү.

Тийм учраас бүр тусад нь төр, төрийн өмч давамгайлсан төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид нь тусдаа, тээвэрлэгч нь тусдаа гэж нэг заагаад. Энэ орж ирсэн концепц чинь зөв.

Гэхдээ тусдаа 24.3 дээрээ нийтийн зориулалттай төмөр замын суурь бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьсан тохиолдолд төрийн өмчлөлд шилжүүлэх хүртэлх хугацаанд нь хувийн хэвшлийн түншлэгч нь суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно гэж ийм альтернатив хэлбэрээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулаг. Тэгээд дараа нь тодруулж асууж болно. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Энд нийтийн хэрэглээний зам, дагнасан хэрэглээний зам гээд урд нь байсан гэж байна.

Яах вэ, үг, үсгийн хувьд жишээ нь авто тээвэр дээр тусгай зориулалтын зам гэж байдаг юм. Үүнийг нэг шаблон, нэг стандарт руу нь оруулж байгаа юм.

Анх орж ирсэн хууль ерөөсөө үндсэндээ энэ хэдэн төмөр замын хүмүүс ойлгодог. Улаанбаатар төмөр замынхан

ойлгодог. Тэгээд Оросын хуулийг дуурайсан, Оросын хуулийг хуулсан ийм хууль байсан юм шүү.

Ажлын хэсэг дээр бид ярьж байгаад, төмөр замынхантайгаа ярьж байгаад хэдүүлээ яг стандартаар нь ойлгож сурья. Зүгээр гаднаа ямар ч хамаагүй Монгол Улсын иргэн төмөр замын хуулийг уншихад ойлгогдох хэлбэр лүү нь оруулья. Тэр элдэв янзын технологийн үг, үсгээсээ хэдүүлээ салъя. Ерөнхийдөө стандарт руу нь оруулья. Бусад тээврийн стандарт, хуулиуд ямар байна. Тэр үг, хэллэг рүү нь хэдүүлээ оруулья гэж ярьж байгаад манай төмөр замынхан бас тодорхой хэмжээнд зөвшилцөл хийгээд энэ хууль бараг л 50 хувь үг, үсэг нь өөрчлөгдөж орж ирж байгаа юм шүү. Өөрчлөгдөж орж ирж байгаа юм шүү. Бүр энгийн болж байгаа шүү.

Зүгээр энгийн та бүхний харж байгаагаар төмөр зам гэхээр гайхалтай айхтар болгоод л, тэнгэрийн, сансрын хэмжээнд аваачиж тавиад, тэгээд жишээ нь төмөр зам барих зөвшөөрлийг хүртэл Засгийн газар нь олгоод байдаг ийм хууль орж ирсэн шүү дээ. Энэ чинь төмөр зам тавих, одоо өнөөдөр бид чинь 400 гаруй километр төмөр зам өөрсдөө тавьчихсан шүү дээ.

Яах гэж тэрийг жишээ нь Засгийн газар төмөр зам барих тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгож байх ёстой юм. Мэргэжлийн байгууллага нь олго л доо. Мэргэжлийн яам нь олго л доо. Ингээд бид аливаа юмыг хүндрэлээс нь гаргаж, либералчилсан энгийн зүйл рүү нь оруулах хэрэгтэй шүү дээ.

Энэ хууль чинь тэгж энгийн болж орж ирж байгаа хууль шүү.

Ерөөсөө Тээврийн хууль ямар байх ёстой юм тэр лүү орж ирж байгаа, энгийн болж ирж байгаа цоо шинэ хууль байгаа шүү.

Хоёрдугаарт, Б.Дэлгэрсайхан гишүүнийхтэй би нэг зүйл дээр нь санал нэг байна.

Ер нь яах вэ хувийн хэвшлээ бид хамгаалах ёстой. Миний гол барьж байгаа зарчим ч энэ. Хувийн хэвшлийг хамгаалахгүй бол дараа нь мэдээж төр дандаа юмаа хийнэ гэж байгаа бод бид хэдэн зуун, хэдэн арван жил хойшлогдоод хүлээгээд явж байгаа.

Тийм болохоор хувийн хэвшлээ бид хамгаалах нь зүйтэй. Гэхдээ энэ чинь бас нэг бодолцохгүй бол, зарчим гэж нэг зүйл байгаа шүү дээ. Тэрийгээ л хэдүүлээ бодох ёстой юм.

Түүнээс биш. Бүр болохгүй бол давуу эрх олгоно гээд биччихье л дээ. Тэгвэл. Би түүнээс чинь л, зарчмаас л хазайгаад байгаа юм. Түүнээс миний зарчим хувийн хэвшил, тэр тусмаа концессоор хийх төр, хувийн эвслийн түншлэлийн гэрээнийхээ дагуу тодорхой хэмжээний зохицуулалтыг хийнэ гэдэг дээр миний хувьд зуун хувь зогсож байгаа. Зуун хувь зогсож байгаа. Энэ хууль ч тэр либералчлал руу орсон.

Манай хамгийн том либералчилж байгаа иргэний нисэхийн асуудлууд байж байна. Авто тээвэр бол тэр чигээрээ либерал болчихсон. Дандаа хувийн тээврийн хэрэгслүүд л ажиллаж байгаа. Бид ч гэсэн өөрсдөө тэр шүү дээ. Гэтэл энэ хууль дээр чинь жишээ нь машинист гэхэд зөвхөн л Улаанбаатар төмөр зам машинист сургадаг юм шиг л ийм хууль л байгаа шүү дээ.

Үгүй шүү дээ. Машинистыг хаана л хаана хийж болно шүү дээ. Хаана л хаана сургаж болно шүү дээ. Улаанбаатар төмөр зам урд тал дээр ч тэр машинист давхиж л байдаг, хойно ч давхиж л байдаг. Ингээд бүх зүйлийг чинь энэ чинь либералчлаад орж ирж байгаа юм байхгүй юу даа. Уг нь бол. Хуулиа сайн уншвал энэ чинь урьдын хуулиас юу явал үг, үсэг нь магадгүй зөрсөн байх аа. Би зүгээр энгийн тээврийн үг, үсэг рүү оруулсан шүү. Ер нь тээврийн энгийн стандарт руу л оруулсан байгаа юм.

Тэгээд доторхыг нь Та бүхэн маань сайн үзээрэй гэж. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн тодруулж асууна.

Б.Дэлгэрсайхан: Яах вэ, би ийм л юм хэлээд байгаа юм л даа.

Тэр 24.3 дээр төмөр замын төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэрээнд тусгасан байна гээд л товчхон хийчихсэн юмыг задлаад ингээд ер нь төмөр замын суурь бүтцийн үйлчилгээг түншлэгч нь эзэмших хугацаандаа суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхэлж болно гэдэг юмаар л нэмээд оруулчихъя л гэж байгаа юм.

Тэгж байж одоо нөгөө дэд бүтэц хийх компани, гадна дотнын хөрөнгө оруулагч орж ирнэ үү гэхээс биш суурь бүтцийг би эзэмших юм байна. Тэгээд ахиад дээгүүр нь тээвэрлэгчийг тусдаа өөр компани хийх юм байна гээд явах юм бол хэн ч үүнд хөрөнгө оруулахгүй.

Тийм учраас үүнийг ингэж болно гэдгийг нь хуульд хийж өгч байж гаднын хөрөнгө оруулагчийг татна шүү. Зүүн, баруун.../минут дуусав/

Г.Занданшатар: Жадамбын Баатар-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхдээ сандраад байх юм байхгүй шүү дээ. Бүү сандар л даа. Түрүүн дарга хэлчихсэн шүү дээ.

Энэ дээр чинь гүйцээн боловсруулах удирдамж өгчихсөн. Хэдүүлээ гүйцээн боловсруулаад л ороод ирье л дээ. Тийм. Баталгаажуулах гээд л араас нь бүр мэрийгээд чармайгаад л хичээгээд л явчих юм. Тэгээд гүйцээн боловсруулахаар авчихъя. Болж байна.

Ер нь зарчмыг би ойлгож байгаа шүү дээ. Зарчмыг ойлгож байгаа.

Г.Занданшатар: Яг тухайн хөндөгдөөгүй заалт болохоор. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Монгол Улсын төрөөс төмөр замын бодлого, бичиг баримт гарсан байгаа.

Тэгээд энэ бодлого, бичиг баримтад Замы-Үүд, Сүхбаатарын хоорондох өргөн зам. Түүнтэй салаалсан буюу огтлолцсон тохиолдолд өргөн төмөр замтай байна.

Хэрвээ уул уурхайн ордоос хилийн боомт хүртэл төмөр зам тавигдах тохиолдолд ямар царигтай байхыг Засгийн газрын өргөн барьснаар Улсын Их Хурал шийднэ гэдэг заалттай. Энэ заалтынхаа хүрээнд Тавантолгойн-Гашуунсухайтын төмөр замын анхны тогтоол нь яаж гарсан бэ гэхээр Н.Алтанхуягийн Засгийн газрын үед нарийн царигтай төмөр замаар гарсан. Үүнийг 2020 онд Үндсэн хуулийн цэц хүчингүй болгосон. Тэгээд энэ нарийн царигаар нь тавихыг хүчингүй болгосон.

Тэгээд буцаагаад Засгийн газар чинь оруулж ирээд өргөн төмөр замаар тавих юм гэдгээ оруулж ирэлгүй энэ Тавантолгой-Гашуунсухайтын төмөр зам тавиад, үүнээсээ болоод асуудал үүсчихсэн. Энэ нь одоо Хятадтай холбогдох асуудал нь удаашрах ийм нөхцөл байдалд орчхоод байгаа.

Тэгэхээр нэгэнт л уул уурхайн ордоос хилийн боомт хүртэл ямар царигаар тавих асуудлыг Их Хурал шийдэх заалттай байгаа тохиолдолд бид хоёр хөрштэйгөө эвтэй найртай сайхан амьдрах, хамтран ажиллах энэ зорилгын хүрээнд би ямар тогтоолын төслөө өргөн барьсан бэ гэхээр уул уурхайн ордоос аль улсын хил рүү гарч байна түүн рүү. Одоо Орос руу гарч байвал өргөн төмөр замаар, Хятад руу гарч байвал нарийн төмөр замаар холбох ийм тогтоолын төслийг өргөн барьсан.

Харамсалтай нь үүнийг хэлэлцэхгүй Их Хурал байлгаад байгаа.

Тэгэхээр энэ асуудал Төмөр замын тухай хууль дээр ямар байдлаар орж ирсэн юм? Яаж цаашаа шийдэгдэх юм?

Өөрөөр хэлбэл энэ чинь одоо жишээ нь Тавантолгойгоос нүүрсээ борлуулах гэж Гашуунсухайт руу төмөр зам тавьж байгаа. Ерөнхийдөө танай бодлогыг чинь би эсэргүүцэж байна, манай улс эсэргүүцэж байна гэж өргөн төмөр зам тавьчихаад, тэгэхдээ манай нүүрсийг аваач ээ гэж хэлэхээр энэ чинь асуудалд ороод байгаа байхгүй юу даа.

Тийм учраас одоо энэ төмөр замаар нэг танк орж ирээд л энэ улс орныг эзэлчихдэг гэж тийм Пи Ар энэ тэрээсээ татгалзаад бид хоёр хөрштэйгөө эвтэй найртай байх энэ хүрээн доор бид тухайн орных нь царигаар уул уурхайн

ордоос төмөр зам тавих асуудлыг нэг мөр шийдэх ёстой байхгүй юу даа.

Тэгээд энэ дээр хууль санаачлагч, ажлын хэсэг ямар шийдвэр энэ дээр гаргасан бэ? Энэ дээр тодорхой хариулт авъя.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

Ж.Бат-Эрдэнэ: Таны санаачилж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэрвээ Улсын Их Хурлаар орж ирэх юм бол хувь гишүүнийхээ хувьд энэ салбар дээр ажиллаж байсны хувьд би жишээ нь дэмжинэ.

Одоо энд ажиллаж байх үеийнхээ тогтоолоор ч гэсэн, уул уурхайн объектоос хил чиглэсэн төмөр зам нь хилийн боомт хүртэлх төмөр зам бол тухайн улсын төмөр замын сүлжээтэй нэг байх зарчим ерөнхийдөө баримтлах ёстой.

Зүгээр Улсын Их Хурлаар тогтооно гэж байгаа шүү дээ.

Тэгээд тухайн үед жишээ нь урагшаа Улсын Их Хурлаар тогтоогоод нарийн байна гээд заачихсан байсан. Зүгээр хаана, хэзээ, яг ямар нууцын зэрэглэлтэй байдаг юм, ямар зэрэглэлтэй байдаг юм. Мэдэхгүй. Өөрчлөгдөөд өнөөдөр энэ бодлого явчихсан болохоор тухайн үеийн шийдвэр гаргасан хүмүүс нь гаргах юм болов уу, яах юм. Хариулах юм болов уу.

Ер нь зүгээр таны гаргасан тогтоолын төсөл бол зөв төсөл. Бид чинь юу шүү дээ. 2010 онд орсон Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод царигийн асуудал маань тусгаад тодорхой заачихсан юм.

Энд царигийн асуудал заагдаагүй. Энэ нь өөрөө тээврийн асуудал байгаа юм шүү. Төмөр замын тээврийн тухай хууль юм байгаа юм шүү. Тээвэрлэлтийг яаж явуулах юм, ямар ямар дэд бүтцүүдийн хоорондын зохицуулалтыг нь яах юм.

Түрүүн даргын хэлээд байсан тэр зурмаг энээ тэрээ хоорондын зохицуулалт, тээвэрлэлтийн график юмнуудыг нь яаж зорчих юм, хоорондоо ямар харьцаатай байх юм, ямар гэрээгээр эрх тэгш тээвэрлэх боломж бололцоо нээгдэх юм.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын хойд өнцгөөс давхисаар байгаад л хамгийн сүүлийн төмөр зам Ханги-Мандал болон Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замаар гараад явахад ямар нэгэн боогдох хаагдах юм байхгүй. Энэ олон төр, хувийн хэвшлийн, концессын болон янз янзын төмөр замаар ямар нэгэн хүндрэлгүйгээр урагшаагаа, хойшоогоо гараад нэвт явах ийм боломжийг гаргаж байгаа тээвэрлэлтийн тухай хууль юм шүү.

Тийм болохоор цариг энэ дээр тодорхой заасан юм байхгүй байгаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр бид өнөөдрийн байдлаар Замын-Үүдээр өдөрт 14 цуваа вагоныг л гаргах ийм хүчин чадалтай байгаа. Үүнийг жоохон нэмэгдүүлэх талаар ажиллаж байгаа байх.

Харамсалтай нь Монгол Улсын уул уурхайн экспортод тулгуурладаг эдийн засагт дэндүү бага байгаа. Гэтэл үүний хажуугаар бид Бичигт рүү төмөр зам тавих ёстой. Аль эсвэл тэр Бургастай болон Ярантын боомтоор төмөр замууд тавьж байж бид экспортынхоо тэр

бүтээгдэхүүнийг илүү асуудалгүй тээвэрлэх ийм боломжийг л бүрдүүлэх юм л даа.

Гэтэл өнөөдөр өргөн төмөр зам тавиад аваачдаг. Хятадууд нь хүлээж авдаггүй. Тэгээд л Замын-Үүдээр ганцхан 14 цуваа вагон гарахаар нэг цуваа вагон дээр 500 сая төгрөгийн авлигал чинь гарч ирээд байгаа байхгүй юу даа.

Тийм учраас үүнийг эсэргүүцдэг хүмүүс энэ Их Хурал дотор байгаа. Тэгэхээр би энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Горимын санал гаргаж болно. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн горимын санал гаргана. 1 минут.

Б.Пүрэвдорж: Тийм юм байдаггүй шүү. Энд 4 минутаар хэлдэг шүү.

Энэ дээр тээвэрлэлтийн асуудлыг Төмөр замын тээврийн тухай хуулиар шийднэ гэсэн боловч хамгийн гол нь яаж их тээвэр хийх вэ гэдэг асуудал бүр бодлогын хэмжээнд. Өөрөөр хэлбэл хоёр хөршийнхөө тэр төмөр замын царигт нийцсэн тэр шийдлийг энэ Төмөр замын тухай хуульдаа оруулж ирээгүй байна.

Дээрээс нь Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого, бичиг баримтын хүрээнд асуудлаа шийдээгүй байна.

Тийм учраас энэ хуульд тодорхой хэмжээгээр царигийн асуудлыг бодлогын хэмжээнд оруулах зорилгоор хуулийн хэлэлцүүлгийг анхан шатын хэлэлцүүлэгт буцаая гэсэн горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Бодлогын баримт бичиг тусдаа л даа.

Тэгэхээр ийм байна. Энэ нэр томьёоны тодорхойлолтуудыг нарийвчлах шаардлагатай. Энэ нийтийн зориулалттай төмөр зам, тусгай зориулалттай төмөр зам гэж яг үндсэндээ аваачаад үзэхээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замыг хоёулаа хэлнэ л гэж байгаа юм.

Нэг нь гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замыг. Нөгөөдөх нь нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай төмөр замыг гэсэн. Яг эцсийн дүндээ энэ бол маш том зөрчил ирээдүйд бий болгоно.

Хоёрдугаарт нь, суурь бүтцийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч. Энэ тодорхойлолтыг тодорхой болгоогүйгээс болоод энэ дотор төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьчаад өмчлөх хугацаандаа яах юм, эзэмших асуудал яах юм. Ашиглах энэ гурван суурь бүтцийн асуудал тодорхойгүй.

Гуравдугаарт, галт тэрэгний хөдөлгөөний зурмаг гээд галт тэрэгний явах, өнгөрөх хугацааг заасан технологийн баримт бичгийг хийнэ гээд л хаячихсан. Тэгтэл суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг нэг ондоо. Одоо яг энэ галт тэрэгний ирэх, буцах зам.

Монгол Улсын нийт суурь бүтцүүдийн хөдөлгөөнийг уялдуулах, зохицуулах юм байхгүй бол энэ галт тэрэгний чинь нэгдсэн уялдуулсан зохицуулсан бодлого. Тэгээд энэ хоёр хөрш маань пропускная способность буюу нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах гээд байдаг. Тэгтэл манай нэвтрүүлэх хүчин чадал энэ тэртэйгээ

уялдсан бодлогын шинэчлэл байх ёстой юмнууд байхгүй.

Тэгээд хөдөлгөөний нэгдсэн зурмаггүйгээр галт тэрэгний хөдөлгөөний тээвэрлэлтийн аюулгүй байдал, аюулгүй байдлын бүс энэ тэрийн тодорхойлолтуудыг хаячихсан.

Тийм учраас анхны хэлэлцүүлэгтээ ахиж хийх нь зүйтэй. Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу санал хураалт явуулах цагийг жич зарлаж болно. Улсын Их Хурлын дарга.

Тэгээд санал хураалт явуулах ирц хангалтгүй байгаа учраас энэ асуудлыг хойшлууллаа. /алх цохив/

Яах вэ, анхны хэлэлцүүлэгт буцаах нь. Ямар ч байсан хойшлууллаа. Тийм.

Анхны хэлэлцүүлэгт явуулах юм бол байна шүү дээ. Б.Пүрэвдорж гишүүн

Дөрөв.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн миний бие Ж.Сүхбаатар, Х.Нямбаатар нарын хамт 2022 оны 09 сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

ээ, санал хураалт явуулна. Санал хураалт ийм олон кноп байхад ямар ч санал дэмжигдэхгүй.

Г.Агар-Эрдэнэ дарга тайлбарлаад өгчих. Тэр Ё.Энхсайхан ажлаа сайн хий.

Суурь бүтэц өмчлөгч, эзэмшигч энэ тэрээ тодорхой болгох хэрэгтэй. Хөдөлгөөний зурмаг гэдэг чинь цусаар бичигдсэн дүрэм гэж үздэг. Тэр нарийн технологийн асуудал гэж байгаа шүү дээ. Нэгдсэн зурмаг.

Энэ суурь бүтэц дэх зурмагаа тодорхойлчихоод тэгээд олон төмөр замын сүлжээ, өргөн нарийн цариг энэ тэр юмнуудаа нэг тодорхойлохгүй бол.

Ингээд үүнийгээ ахиад ярьцгаа.

Ингээд дараагийн асуудалд орно.

Төсвийн тухай хуулийг хойшлуулсан. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хойшилсон.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг Та бүхэнд танилцуулъя.

Энэ хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл буюу Монгол Улсад урьд өмнө нь үүнтэй холбоотой харилцааг огт зохицуулж байгаагүй гэдгээрээ нэгдүгээрт онцлог байгаа.

Хоёрдугаарт, Монголын ард түмэн өөрийн засаглах эрхээ өөрийн төлөөлөгчөөрөө уламжлан хэрэгжүүлнэ гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим байдаг.

Тэр утгаараа энэ хуулийн төслийг боловсруулагчид нь манай улсад сүүлийн 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллага болох “Азтай савар” төрийн бус байгууллагын энд сууж байгаа залуучууд байгаа гэдгийг тодотгож хэлье.

Улсын Их Хурлын гишүүн бид ард түмнээсээ санаачилсан төрийн үйл хэрэгт шууд болон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох энэхүү эрхийг хангаж, иргэний нийгмийн байгууллагын сайн дураараа боловсруулсан энэхүү хуулийг Улсын Их Хурлын парламентын танхимд оруулж ирэх гүүр болж байгаа гэдгийг энд онцлон тэмдэглэе.

Энэхүү хуулийн төсөл нь юун түрүүн амьтны тухай хууль гэхээсээ илүүтэй хүний эрхийн хууль байгаа.

Хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Энэхүү эрхийг нь төрөөс хангаж өгөх, баталгаажуулах үүрэгтэй.

Сүүлийн жилүүдэд эзэнгүй, тэжээмэл, гэрийн тэжээвэр амьтдын тоо толгой ихсэж гудамж, талбайд их түгээмэл болж байгааг Та бүхэн анзаарч байгаа.

Энэ асуудлаар яг албан ёсны тоо байхгүй ч гэсэн төрийн бус байгууллагын залуучууд маань судалж үзэхэд зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд гэхэд нийт гэр хороололд амьдарч байгаа иргэдийн 54 хувь, орон сууцад амьдарч байгаа иргэдийн 12 хувь нь гэрийн тэжээвэр амьтан тэжээж байна гэсэн дүн гарсан.

Мөн 300-аас 320 мянган эзэнгүй золбин нохой, муур өнөөдөр Улаанбаатар хотод бий болсон байна гэдэг харамсалтай тоо мэдээ гарч ирж байгаа.

Нийслэл Улаанбаатар хотын хувьд гэхэд эзэнгүй нохой, муурыг устгахад зориулж жилдээ 1.6-аас 1.8 тэрбум төгрөгийг татвар төлөгчдийн мөнгөнөөс зарцуулдаг.

Энэ устгах ажлаа яаж хэрэгжүүлж байна вэ гэхээр буудаж устгах аргаар хэрэгжүүлж байгаа. Энэ бол сүүлийн зуун жилийн хугацаанд манай улс энэ асуудалтай буудах аргаар тэмцсэн. Харамсалтай нь үр дүнд хүрэхгүй байгаа. Яагаад.

Зөвхөн хос хоёр нохой гэхэд 6 жилийн хугацаанд 16 мянга болж үржих боломжтой. Хос хоёр муур гэхэд 1 сая гаруй болж үржих өндөр үржлийн хурдацтай амьтад байгаа.

Энэ үржлийн хурдыг бид буудаад буудаад дийлэхгүй гэдэг нь өнгөрсөн зуун жилийн бидний үр дүнгээр харагдаж байгаа юм.

Дэлхий нийт ч гэсэн энэ чиг хандлагаас татгалзаж байна. Өнөөдөр дэлхийн 120 гаруй улс гэрийн тэжээвэр амьтны тухай хуультай болсон байна.

Бид одоо энэ дэлхийн өндөр хөгжилтэй орны гэрийн тэжээвэр амьтанд зориулсан тусгайлан салхилуулах тэр цэцэрлэгт хүрээлэн, стандарт, түүнийг эмчлэх эрүүл мэнд, түүнийг хооллох хоолны стандарттай холбоотой тэр өндөр жишигт хүрдэггүй юм гэхэд одоо нэгэнт үүссэн нийгмийн харилцааныхаа асуудлыг зайлшгүй зохицуулах шаардлага бий болчхоод байна.

Сая хэлсэнчлэн амьтан тэжээдэг, тэжээдэггүй гэсэн энэ хоёр хэсгийн харилцаанд зөрчил нэгэнт бий болсон байна. Тухайлбал, нийтийн орон сууцад сая хэлсэнчлэн 12 орчим хувь нь гэрийн тэжээвэр амьтан тэжээж байна.

Ингээд шөнө орой унтаж байхад хуцаад байна, амруулахгүй байна. Ялгадсаа тэр орон сууцын орчны бут сөөг болгонд үндсэндээ эдгээр амьтдын ялгадсаар дүүрлээ. Энэ нь өөрөө хүний болон бусад эрүүл мэндэд саад учруулж байна, хохирол учруулж байна гэдэг асуудал сүүлийн үед хурцаар тавигдах боллоо.

Тийм учраас үүнтэй холбоотой харилцааг зохицуулах шаардлага байна. Нохойгоо салхилуулахдаа хошуувчтай, хошуувчгүй салхилуулж байна. Жилдээ 3850 хүн, хүүхэд нохойд хазуулж байна. Түүний эмчилгээ нь нэг хүнд дунджаар 120 мянган төгрөг зарцуулагдаж байна гэсэн ийм дүн гарч ирж байна.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь өнгөрсөн хойно нь зохицуулаад. Саяын хэлсэнчлэн нэгэнт гудамжинд эзэнгүй гарчихсан хойно нь буудаж устгах хүнд аюултай, аллага сурталчилсан, хүүхдэд сэтгэл зүйн гэмтэл учруулах хэлбэрээр яваад үр дүнд нэгэнт хүрэхгүй юм байна.

Харин энэ тоо толгойг хязгааргүй өсөн нэмэгдэх боломжоос урьдчилан сэргийлэх замаар эзэнгүй нохой, муурын асуудлыг ер нь цэгцэлье гэдэг хүрээнд энэхүү хуулийн төсөл боловсруулагдсан учраас энэ бол юун түрүүн амьтны тухай хууль гэхээсээ хүнд чиглэсэн хүний эрхийн хууль гэж ойлгох учиртай.

Хоёрдугаарт, энэ бол нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хууль. Яагаад. Өнөөдөр халдварт өвчний үндсэн шалтгаан нь хөрсний бохирдол.

Хоёрдугаарт, сая хэлсэн энэ нохой, муурыг алж устгаж байгаа, хөрсөнд булж байгаа. Үүнээс үүдэлтэй халдварт өвчин гэдэг нь тогтоогдож байна.

Зоонозын халдвар судлалын өвчний төв ч гэсэн үүнийг анхааруулж байна. Далан давхарт хүнээ оршуулж байгаагаас илүү их нохой, муурыг бид устгаж хөрсөнд булж байна. Тэр хөрсөнд булсан, тэнд борооны усаар урсаж байгаа, бид агаараар амьсгалж, бид тэр орчинд ирээдүйгээ, хүүхэд залуучуудаа өсгөж байна.

Тийм учраас энэ бол нийгмийн эрүүл мэндээс урьдчилан сэргийлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, мөн хүнд чиглэсэн ийм хууль гэдгийг Та бүхэн маань бас анхаарч үзээсэй гэж бодож байна.

Гуравдугаарт, энэ бол хайрыг түгээхэд чиглэсэн хууль.

Яагаад гэхээр амьд амьтныг хайрлах, хүнийг хайрлах, нэгнийгээ ойлгох энэ үзэл санааг бид сурталчлах ёстой.

Амьтныг алж устгаж байгаа, яргалж байгаа, тамлаж байгаа ийм бичлэгүүдийг үзсэн хүүхэд сэтгэл зүйн хувьд асар их гэмтэж байна. Амьд амьтныг яргалж болно, тамлаж болно гэдэг үзэл санааг бид хэрхэвч сурталчилж болохгүй. Ийм үзэл санааг. Үүнийг үзсэн хүүхэд сэтгэл зүйн хувьд гэмтэлтэй болж нэгнийгээ хайрлах энэ үзэл санаа тэр хүүхдийг гэмтээдэг учиртай.

Тийм учраас Монгол Улсын Үндсэн хуульдаа тунхагласан хүмүүнлэг, иргэний, энэрэнгүй энэ иргэний нийгмийг хөгжүүлэх суурь болсон нэг хууль байгаа юм.

Амьтныг хайрлаж өссөн хүүхэд том болоод хүнийг хайрладаг болно. Тэр утгаараа энэ хууль хайрыг түгээх хайрын

тухай хууль юм гэж тодотгож хэлэх байна.

Тэгээд энэхүү хуулийн төслийг боловсруулж хоёр жилийн өмнө хууль санаачлагч бидэнд танилцуулж, сүүлийн нэг жил гаруй хугацаанд өөрсдөө амралтын өдөргүй энэ хуулийн төсөл дээр санаа чилээж, судалгаа хийж, бүхий л чиглэлд оролцож, төрийг удирдах өөрийнхөө Үндсэн хуульд заасан эрхээ эдэлж, эвлэлдэн нэгдэх эрхээ жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж, хууль боловсруулж санаачилсан “Азтай савар” төрийн бус байгууллагын нийт залуучдаа талархлаа илэрхийлье.

Эрхэм гишүүд Та бүхнийг хэлэлцэх асуудлыг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Батсүхийн Саранчимэг танилцуулна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын гишүүдээс 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч гэрийн тэжээвэр амьтан буюу нохой, муур, тэдгээртэй адилтгах бусад амьтантай холбогдох харилцаа, тэдний асран хамгаалагчийн үүрэг хариуцлага, зоонозын халдварт

өвчин, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Дэлхийн 120 гаруй орон нохой, муур, тэдгээртэй адилтгах гэрийн тэжээвэр амьтныг хүчирхийллээс хамгаалах, хяналттайгаар үржүүлэх, бүртгэх, худалдах, худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулсан хуультай бөгөөд хууль санаачлагчид Монгол Улсад эдгээр асуудлыг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулан **D-Parliament.mn** цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен гэрийн тэжээвэр амьтан гэдэгт муур, нохойноос гадна гэршүүлсэн хүнтэй амьдрах боломжтой бусад амьтдыг хамааруулснаар энэ асуудлыг хариуцсан тусдаа алба бий болох эсэх, гэрийн тэжээвэр амьтны хоол тэжээлийн асуудлын талаар Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир энэ хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн хуульд тусгасан эсэх, асран хамгаалагч, харгалзах эзэнгүй амьтдын устгалын зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хуулийн төсөл батлагдсаны дараах нийгэм, эдийн засгийн үр дагавар болон олон нийтийн орчинд үзүүлэх нөлөөллийн талаар судалгаа хийсэн эсэх, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд гэрийн тэжээвэр амьтантай иргэдийн амьдрах нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын стандарт, норм, нормативыг хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин эзэнгүй амьтны устгалтай холбоотой асуудал болон гэрийн тэжээвэр амьтан, тэр дундаа нохой, муурын үржлийн

асуудлыг төсөлд тодорхой тусгасан эсэх, олон нийтийн газарт гэрийн тэжээвэр амьтантай зорчих эсэх, зохицуулалт нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг нийт өрхийн 25 орчим хувь нь гэрийн тэжээвэр амьтантай манай улсын хувьд хуулийн төсөлд амьтныг бүртгэх, эзэнтэй болгох, хариуцлага тооцох зэрэг асуудлыг нэг мөр зохицуулах шаардлагатайг дурдаад, гэрийн тэжээвэр амьтны талаарх орон нутаг, нийслэлийн ялгаатай байдлыг төсөлд хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан эзэнгүй амьтныг устгалд оруулах тохиромжтой аргыг хэрэглэх, гэр гэрийн тэжээвэр амьтны татварын асуудлын зохицуулалт, амьтанд урьдчилан сэргийлэх тарилга, туулга, үржил хязгаарлах мэс ажилбар хийхэд гарах зардлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг бусад гэдэгт ямар амьтныг хамааруулах, хүн, амьтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс гэр хорооллын эзэнгүй нохой, муур болон бусад амьтны асуудлыг хэрхэн зохицуулах, зөвшөөрөлгүйгээр амьтан тэжээх, үржүүлэхэд хүлээлгэх хариуцлагын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурал ард түмний төлөөллийн байгууллагын хувьд олон нийтийн санал санаачилгын дагуу өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийг хэлэлцэн батлахыг дэмжиж байгаагаа илэрхийлж, гэрийн тэжээвэр амьтны хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөний тооцоог нарийвчлан гаргах, холбогдох хууль тогтоомжид стандартын асуудлыг тусгах зэрэг санал хэлсэн болно.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Г.Амартүвшин, Цэвэгдоржийн Ц.Туваан. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цогийн Зориглон “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн, уран бүтээлч, Эрдэнэбатын Бүжинлхам “Азтай савар” төрийн бус байгууллагын зохицуулагч, Эм-Си-Эс Интернэйшнл ХХК-ийн ахлах мэргэжилтэн, Мөндөрийн Золзаяа “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, “Диди Лекс” ХХК-ийн хуульч, Цэвэлмаагийн Болормаа “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Дэлгэрцогтын Оюун-Эрдэнэ “Азтай савар” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Хаан Банкны төслийн менежер, Батбаярын Алтаншагай “Азтай савар” төрийн бус байгууллагын хуульч, Мөнгөний Ариунзул “Эм-Ди-Эс Хаан Лекс” хуулийн фермийн хуульч, Энхбаярын Анударь Өмгөөллийн “Легал Гайд” ХХК-ийн хуульч, Удвалын Азжаргал Өмгөөллийн “Легал Гайд” ХХК-ийн хуульч.

Асуултыг асууя. Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Юуны түрүүнд Монгол Улсад анх удаа гэрийн гэжээмэл амьтны тухай хууль боловсруулж орж ирсэн Улсын Их Хурлын гишүүд, залуучуудын төлөөлөл, тэр дундаа энэ “Азтай савар” төрийн бус байгууллагын залуучуудад талархаж байгаагаа илэрхийлье.

Энэ маш чухал ийм асуудал байгаа.

Өнөөдөр эзэнгүй муур, нохойг устгахад жил бүр улсын төсвөөс тодорхой хэмжээний мөнгө төсөвлөдөг боловч энэ мөнгө үр дүнгүй газарт цацагдаж байдаг гэж хардаг. Устгаад байгаа боловч жил болгон нэмэгдэж байгаа. Буурдаггүй.

Тийм учраас бид нарт хуультай болоод илүү оновчтой арга хэрэгсэл хэрэглэх шаардлагатай зайлшгүй цаг үе ирсэн гэж харж байна.

Нохой, муурын яа ялгадсаар өчнөөн мянган төрлийн өвчин эмгэг үүсгэгдэж байна. Өнөөдөр Монгол Улс элэгний хорт хавдраар дэлхийд тэргүүлж байна л гэж байна. Бид олон зүйлтэй холбож ойлгож байгаа.

Тэгвэл энэ элэгний бэтэг өвчин үүсэх шалтгаан нь нохойны ялгадаснаас гарах хавтгай хорхой байдаг. Зоонозын төрлийн өвчин Монгол Улсад хэр их байгаа билээ. Нохой, муурын ялгадас үерийн усаар зөөгдөөд хөрсийг бохирдуулаад өвчний үүр уурхай болгож байгаа.

Дээрээс нь гэр хороололд байдаг хүүхдүүд, оршин суугчдыг өдөр болгон айлгадаг. Сэтгэл санааны цочролд оруулдаг. Тайван амьдрах зүйлд нь нөлөөлдөг гээд олон зүйл байдаг. Нохойг өнөөдрийн байдлаар шууд буудаж устгах нь маш хэрцгий тийм хүмүүнлэг бус харагддаг.

Тийм учраас хөгжингүй оронд хэрэглэж байгаа унтуулгатай сум бугаар буудаж устгаж болдоггүй юм байх даа гэж дотроо бодож явдаг байсан.

Тэгэхээр хууль батлагдсанаар маш олон санхүү, хөрөнгийн асуудал гарч ирнэ. Хүний нөөц хэрэгтэй болно. Энэ хууль батлагдана. Хуулийн дараа байх тэр хүний нөөц, одоо хэрэглэж байгаа арга хэрэгслээс илүү хүнлэг болгох, унтуулгатай сумаар устгах гэдэг юм уу, энэ олон олон ажлууд хүлээгдэж байгаа. Энэ дээр яах вэ.

Энэ хууль батлагдсанаар төсөвт хэр хэмжээний мөнгө суух юм бэ? Энэ

ажлыг цаашид хэн хариуцаж явах юм бэ гэсэн ийм асуудал байна. Асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 94. Ажлын хэсгийн гишүүн.

М.Ариунзул: Хуульч, өмгөөлөгч М.Ариунзул байна.

Төсвийн зардалтай холбоотой бид хэд Хууль тогтоомжийн хуулийн аргачлал болон хуулийн төсөл, хуулийн хууль тогтоомжид заасны дагуу зардлын тооцоо болон үр нөлөөний судалгаа хийж үзсэн.

Тэгээд төрийн байгууллагад гарах ачаалал шинээр хүний нөөц бүрдүүлэх хэмжээнд буюу нэг бүхэл тоо гараагүй. Тус бүрд нь болохоор 0.4 0.6 хэмжээний ачаалал нэмэгдэхээр чиг үүргийн хувьд тооцоологдсон.

Тэр нэмэгдэж байгаа чиг үүргийнхээ хувиар цалин болон техникийн зардлууд гарахаар байна гэж тооцоолоод төрийн байгууллагын хувьд нийт 26 сая 132 мянга 703 төгрөг 16 мөнгийн зардал гаргахаар байна гэдэг тооцоолол гаргасан байх.

Тэгэхээр төсөвт дарамт учруулахгүй гэж бид харж байгаа. Тийм байна.

Албан хаагчид болон төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой тухайн албан хаагчид өгөх ажлын ачаалал гэх юм уу, тэр дээр холбогдож гарч байна гэж үзэж байгаа.

Мал эмнэлгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, цагдаагийн байгууллага, Засаг дарга. Тэгээд бүх шатны Засаг дарга.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууна.

Б.Баярсайхан: Өнөөдөр хүүхэд хамгааллын хамтарсан баг гээд яг таны хэлж байгаа энэ орон тоон дээр ажиллаж байгаа хүмүүс хүүхдээ хамгаалах гээд, хүчирхийллийг бууруулах гээд ажилладаг.

Тэгээд энэ хүмүүс дээр бид гудамжинд байгаа муур, нохойны асуудлыг дээрээс нь үүрүүлэхээр энэ ачаалал нь яадаг юм бол оо? Би үүнийг тийм үр дүнтэй гэж харахгүй байна.

Устгахаас гадна үржлийг нь хязгаарлах орчин үеийн дэвшилтэт өртөг багатай тоног төхөөрөмжүүд, арга хэрэгслүүд гадаад улс оронд байгаад байдаг юм шиг байгаа юм. Энэ болгоныг оруулж ирэхэд ямар үнэ өртөгтэй. Ер 26 саяар жилд би хязгаарлагдана гэж бодохгүй л байгаад байна.

Дээрээс нь хүний нөөц тэр давхар ажил хийж байгаа, хүүхдээ хамгаалж дийлэхгүй байгаа улс орны нөгөө хамтарсан багт ордог цагдаа, нөгөө л хүмүүс сонсогдоод байна л даа.

Тэгээд энэ дээр илүү жоохон тодруулж хариулах хүн байна уу?

Г.Занданшатар: Хууль санаачлагч Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулна.

Б.Энхбаяр: Энэ хуулийн дагуу ажиллаж байгаа төр, түүний байгууллагуудын ачааллыг нэмэхгүй.

Ер нь цаашдаа энэ хууль хүчин төгөлдөр үйлчлээд байвал төр энэ харилцаа руу ордог шаардлагагүй тийм нийгэмтэй болно.

Яагаад гэхээр алж устгах ажлаа төр хийгээд байгаа байхгүй юу. Цаашдаа бид 10 жилийн дараа нохой, муурыг буудаж устгадаг нийгэмгүй болно гэж харж байгаа. Устгах шаардлагагүй болно. Урьдчилан сэргийлэх л ажлыг хийнэ.

Энэ урьдчилан сэргийлэх ажлыг төр хийхгүй. Энэ төрийн бус байгууллагууд, хувийн хэвشلүүд тэр урьдчилан сэргийлэх чипийг суулгах, тэр амьтны эмнэлгүүдийг ажиллуулах, тарилгуудыг хийх тэр хүрээнд нь энэ хүмүүс зохион байгуулах учраас саяын хэлж байгаа тэр нөгөө зардал цаашаа нэмэгдэхгүй гэдэг тооцоолол ингэж гарч ирсэн байгаа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Олон сайхан залуучууд санаачилсан. Тэгээд залуучуудын чөлөөтэй сайхан.

Ц.Идэрбат: Өнөөдөр энэ хууль энэ сонсож байгаа хүмүүст ч гэсэн анх удаа яригдаж байгаа.

Амьтныг хайрлах, тэр яргалал. Тэрийг үзэж байгаа хүүхдийн сэтгэл зүй гээд яривал маш их юм байна. Миний хувьд. Үүнийг яг туулаад гарсан хүний хувьд зөндөө л зовлон байдаг.

Үнэхээр тэр нохой буудаад явж байгаа хүн ч өөрөө тэгээд л их л хүнд юмыг туулдаг л даа.

Тэгэхдээ одоо би бас энэ хууль санаачлагч нар ер нь энэ хуулийн мөрдөх хугацаа, хэрэгжилтийг юу гэж тооцож байгаа вэ? Өнөөдөр байгаа Монгол Улсын 330 сум, 21 аймгийн төвийн нөхцөл байдлыг та нар юу гэж үзэж байгаа вэ?

Аймгийн төв дээр жилдээ 1500 нохой устгадаг. Дунджаар. Устгахдаа нөгөө нэг айхтар аргыг чинь хэрэглэдэг. Үүнийг хэрэглэхгүйгээр ямар арга байна вэ гээд судлаад үзэхээр ердөө л нөгөө спрэй билүү, боох, үржил селекцийг нь зогсоох.

Энэ нь ямар үнэтэй байдаг вэ гээд судлаад үзэхээр нөгөө 50 сумтай калибрийн сумнаас хамаагүй илүү байдаг байхгүй юу. Үүнийг тэр болгон энэ 330 сум дээр спрэй хийх мал эмнэлэг байхгүй.

Тэгэхээр энэ хууль хэрвээ гарвал ганц Улаанбаатарт биш 330 суманд хэрэгжинэ. Ингээд спрэй буюу хүмүүнлэг ийм аргыг хэрэглээч ээ гэхээр нохойгоо устгаж чадахаа болихоор энэ намар яах вэ? Намар, хавар нохой устгалууд явагддаг.

Хэрвээ устгал хийхгүй л бол хүн барьж идчих гээд байдаг. Ийм л орчин байгаа.

Тэгэхээр энэ хууль алсдаа би хэрэгтэй хууль. Гэхдээ хэрэгжих хугацаагаа яаж тооцож байгаа вэ гэдгийг нэгдүгээрт асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь би аймгийн төвийн даргаар ажиллаж байхдаа нэг судалгаа хийж үзсэн. Гэр хорооллын 5 мянга гаруй өрхөөс 4 мянга шахам нь нохойтой. Тэр дотор нохойгоо уядаг айл нь дөрөв, таван зуухан байгаа. Бусад нь уядаггүй. Хэлэхдээ манай нохой хүн урдаггүй юм. Араатны өмнөөс хариулаад байдаг байхгүй юу.

Тэгээд л хүүхэд бахируулаад л дайраад л тэгээд л айхтар айхтар юм болдог.

Миний хувьд энэ хуулийн хажуугаар энэ хуульд “нохойгоо уях” гэдэг тэр зүйл, заалтыг оруулаад өгчихвөл үгүй мөн их хэрэгтэй. Нөгөө 1500 нохой буудна гэдэг чинь бараг 70 хувь нь эзэнтэй нохой байдаг юм шүү бас.

Тэгэхээр яг ийм судалгаануудыг та хэд маань бас яаж хийсэн бэ? Ингээд зарим нэг хуулиудтай, Зөрчлийн хууль байдаг юм уу, ийм юмнуудтай уялдуулчих юм бол саяын энэ 330 мянган нохой буудна гэдэг энэ асуудал чинь өөрөө буудахгүйгээр харин тэр айл нь нохойгоо уядаг, хайрладаг, хамгаалдаг болмоор байгаа юм.

Энэ бол би хамгийн түрүүний бодитой юу байх болов уу? Энэ дээр хууль санаачлагч энэ залуучуудын зүгээс ямар зүйлийг бодож тунгааж байгаа бол ингэж бодож байгаа юм.

2016 он шиг санаж байна даа. Би. Хотын дарга нохойнд спираль ч билүү, спрэй хийнэ гээд л ингээд л нэг бөөн шүүмжлэл болсон. Тэр нь яг үнэндээ өнөөдөр энэ мал эмнэлгийн шинжлэх ухаанд үүнээс өөр ямар ч арга байдаггүй юм билээ шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ үйлчилгээ нэвтрэхэд тодорхой хугацаа орно. Энэ хооронд яах вэ? Буудаж болохгүй гэдэг ийм заалт орчихвол энэ намраас эхлээд төв суурин газрын нохой хэцүүднэ шүү л гэж. Судалгаа чинь яаж гарч байгаа юм бэ гэдгийг бас асуух гэж байгаа юм.

Тэр хариуцлагын асуудлыг сайжруулаад тавьчихвал яадаг юм бол. Түүнээс энэ нохой, муур, энэ гэрийн гэжээвэр амьтны энэ хуулийн үзэл баримтлал юмыг би дэмжиж л байна л даа.

Гэхдээ энэ хууль маань батлагдаад гарахаар хөрсөн дээрээ буусан хууль гарвал цаашаа хэрэгжээд явна. Үгүй бол зүгээр л нэг яриад өнгөрөх хууль болчих вий гэсэн ийм болгоомжлол.

Дахиад энэ хуулийг сөхөж гаргах гэхээр хүлээж авахгүй байхыг үгүйсгэхгүй. Хөрс бүрдчихнэ.

Л.Мөнхбаатар: Ц.Идэрбат гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Б.Энхбаяр гишүүн хариулья.

Тэгээд дээр нь тодруулж хариулах шаардлагатай бол ажлын хэсэг нэмж хариулья.

Б.Энхбаяр: Би Ц.Идэрбат гишүүний хуулийг дагаж мөрдөх хугацаатай. Хэзээнээс эхэлж мөрдөх юм бэ гэдэг асуудалтай холбоотой хэсгийг нь хариулья. Ажлын хэсгийн залуучууд маань бусад асуултад нь хариулчхаарай.

Мэдээж Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь дэмжвэл Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарч ажиллана.

Дагаж мөрдөх хугацааны хувьд мэдээж шаталсан хэлбэрээр байх болов уу гэж хууль санаачлагчийн хувьд урьдчилсан хүрээнд харж байгаа.

Шууд энэ хууль батлагдаад л тэр баталсан өдрөөс нь ерөөсөө эзэнгүй нохой, муур буудаж болохгүй гээд заачихвал энэ мэдээж хаус үүсгэнэ. Тийм. Мөн эздийг нэлээн их үүрэгжүүлсэн, эздийн үүрэг хариуцлагыг тодорхой болгосон. Энэ үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлээгүй бол Зөрчлийн хуулийн бас хариуцлага орж ирж байгаа учраас хуулийг сурталчлах. Одоо тэр бүртгэлгүй байгаа нохой, мууруудыг бүртгэлжүүлэх, тэр чип суулгахтай холбоотой тодорхой хугацаа шаардсан мэдээж процесс явна.

Шууд маргааш нь хэрэгжүүлэнгүүтээ өө чипээ суулгаагүй байна гээд хүнийг торгоод байж болохгүй.

Тийм учраас энэ тодорхой хугацаанууд гарч таарна. Тийм учраас хэрэгжих боломжтой боломжит хугацааг. Хэрвээ хэлэлцэх эсэхийг нь дэмжвэл Улсын Их Хурлын ажлын хэсгийн түвшинд Байнгын хороон дээр сайн ярьж байгаад үүнийг шийдвэрлэх бололцоотой байх гэж бодож байна.

Тийм учраас яг таг тодорхой хугацааг би танд хэлэх ийм боломжгүй байна. Бусад асуултад манай ажлын хэсгийн залуучууд нэмж хариулна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье. Өөрийнхөө нэрийг хэлээд асуултад хариулаарай. Протоколд үлдэж байгаа учраас.

М.Золзаяа: Сайн байцгаана уу? Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хуульч М.Золзаяа байна. Ц.Идэрбат гишүүний асуусан нохой тэжээхтэй холбоотой нохойгоо уядаггүй. Үүнээс болоод нийгэмд олон асуудал үүсдэг. Үүнтэй холбоотой асуултад хариулья.

Монголд эрт дээр үеэсээ нохойг өргөн хүрээнд мал аж ахуй хүрээнд тэжээж ирсэн. Орчин үед илүү хотжилтын хүрээнд орон сууц, байр, хашаандаа нохой тэжээдэг явдал нь түгээмэл болсон.

Гэтэл зарим хэсэг хүмүүс нь нохой тэжээдэг хайртай дуртай хүмүүс байна. Зарим хэсэг нь айдаг ч хүмүүс байна.

Тэгэхээр бидний зорьж байгаа нэг зүйл бол энэ амьтан тэжээдэг хүмүүс

байна, тэжээдэггүй хүмүүс байна. Энэ хүмүүс нийгэмд нэг нэгнийхээ эрхийг зөрчихгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон.

Үүнээс гадна хуулийн төсөл боловсруулж байхад зорьсон нэг гол зүйл бол энэ амьтан тэжээж байгаа хүмүүсийн эздийн хариуцлагыг нэмэгдүүлэхтэй холбоотой заалтууд голчлон орсон байгаа.

Яг энэ уяхтай холбоотой гэх юм бол жишээлбэл, хуулийн төслийн 9.1.2 дугаар зүйлд гэрийн асран хамгаалагч, түр харагч, гэрийн тэжээвэр амьтан, бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгүүд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй байхаар заасан.

Үүнээс гадна 9.2.8-д гэр хороолол, амины орон сууц, зуслангийн хашаанд нохойг уях тохиолдолд зориулалтын хүзүүвч, 3 метрээс багагүй урттай гүйлгээ уяа ашиглах. Үүнээс гадна гэрийн тэжээвэр амьтан орон сууц, хашаанаас хараа хяналтгүй гарахгүй байх, бусад амьтан орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэхээр заасан байгаа.

Энэ нь нохойд уруулдаг, нохойгоо уядаггүй асуудал мэдээж нийгэмд түгээмэл тохиолддог асуудал. Үүнээс болоод насанд хүрсэн хүмүүс болон хүүхэд эрүүл мэндээрээ хохирдог асуудал түгээмэл гарсан.

Түрүүн гишүүний танилцуулгад бас дурдагдаж байсан. Үүнээс гадна нохойд хазуулж байгаа тохиолдлын 70-аас 80 хувь нь эзэнгүй нохойд хазуулжээ гэж байгаа.

Тэгэхээр эзэнтэй нохойд хазуулдаг гэж байгаа. Тэгэхээр энэ асуудал өөрөө өрөөсөө л эздийн хариуцлага гээд

түрүүний хэлсэн асуудалтай холбогдож байгаа.

Тэгэхээр үүнийг энэ хуулийн төсөлдөө дагалдан гаргахаар, нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан.

Зөрчлийн тухай хуулиар энэ үүрэг, хариуцлагаа зөрчсөн тохиолдолд тодорхой хэмжээний торгууль оногдуулах байдлаар хариуцлагыг зохицуулсан байгаа.

Үүнээс гадна түрүүн хэлж байсан. Түгээмэл хашаанд ихэнх хувь нь нохойгоо уядаггүй гэдэг асуудал байдаг гэж байгаа. Бид “Азтай Савар” төрийн бус байгууллага өөрийн фэйсбүүкийн групптэй. Энэ групп нь 160 мянга орчим гишүүнтэй групптэй байдаг.

Тэгэхээр энэ группээрээ дамжуулаад амьтан тэжээх соёлыг сурталчлах ажлыг үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хийж эхэлсэн байгаа.

Тэгэхээр энэ ажлынхаа хүрээнд иргэдийг илүү хариуцлагатай болгох, энэ нохой, муурыг хашаанаасаа гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хуулийн төсөл батлагдсан тохиолдол, батлагдаагүй ч байсан одоо ингээд хэрэгжүүлсээр явдаг байгаа.

Л.Мөнхбаатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн. Ц.Идэрбат гишүүн тодруулах юм уу? Ц.Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм ээ тийм. Юу л даа. Ер нь яах вэ энэ хууль гаргачихаар Улаанбаатарын нохой, орон нутгийн нохой гэхгүй гэрийн тэжээвэр гэхгүй ингээд л улс даяар хэрэгжээд явна шүү дээ.

Тийм учраас энэ хуулийн гол концепц, агуулга ганц Улаанбаатар хотод, эсвэл Улаанбаатар хотын орон сууцанд нохой тэжээдэг хүнд биш. Энэ чинь бүх Монгол Улсын энэ бүх өрхөд хамааралтай асуудал болох гээд байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ хууль хэрэгжсэн, гарсан цагаасаа маш амьдралтай хууль гараасай, хөрсөн дээрээ буугаасай. Нохой гэдэг зүйл бол зүгээр нохойгоор жишээ татахад л тухайн хүний хайртай амьтан л болохоос биш бусад хүнд араатан л байхгүй юу.

Гэтэл манай нохой урдаггүй, яадаг ч үгүй юмаа гээд байдаг ийм хандлагыг сая үүрэгжүүлсэн байна.

Тэгдэггүй нөхдүүдийг яах вэ гэдэг тал дээр би асуугаад байгаа байхгүй юу. Үүргээ мэддэг. Нохойгоо уячихна барина, уях ёстой эд нар гэдгээ. Тэгээгүйг яах вэ гэдэг байхгүй юу. Нохойд уруулсан хүний тоо бас байна. Гэхдээ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ц.Идэрбат гишүүн хариуцлагын асуудал асуугаад байна. Тийм ээ. Хэн хариулах вэ? 83 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон өгөөрэй.

У.Азжаргал: Эрхэм гишүүддээ бүгдээрэнд нь баярлалаа. Өнөөдрийн мэндийг хүргэе. Хуульч У.Азжаргал байна.

Тэгэхээр яг энэ гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлд заасан асран хамгаалагч, түр харагчийн үүргээ зөрчиж байгаа этгээдэд яг ямар хариуцлага оноох вэ тухай болбол хуулийн төслийг дагаж гаргах журмын

тухай хууль дээр Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан.

Энэ дээр Зөрчлийн тухай хууль дээр 7.19 дүгээр зүйл дээр гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүнийг торгох арга хэмжээ. Хуулийн этгээдийг мөн торгох санкттай байдлаар зохицуулж өгсөн байгаа.

Гэхдээ бас уях, хүзүүвчийг нь зохих ёсоор зүүлгээгүй, үржил хязгаарлаагүй гэдэг дээр тодорхой хэмжээний ялгамжтай байдлаар зохицуулсан торгуулийн хэмжээнүүд тусгасан байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байна. Тийм.

Л.Мөнхбаатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл орж ирж байгаад баяртай байна. Яагаад гэвэл яалт ч үгүй зохицуулалт шаардаж байгаа энэ зүйл.

Бас “Азтай Савар” гээд төрийн бус байгууллагынхан энэ хуулийн төсөл дээр хамтарч орж ирж байгаад баярлалаа.

Манай охин “Азтай Савар”-ын бас нэгэн гишүүн нь.

Өөрийнхөө амьдрал дээр тулж байсан зүйлийг л тодруулаад асуумаар байна. Тийм ээ. Үнэхээр амьтан тэжээж байхад паспортжуулах, вакцинд хамруулах, байнгын хяналтад байлгах тэр зохицуулалт өнөөдөр ер нь ямар хэмжээнд байгаа юм бэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Нөгөө талаар гэр хороолол 77.2 мянга орчим нохой тоологдсон байна гэсэн байна. Гэр хороололд байгаа нохойг паспортжуулсан байдаг уу?

Ер нь яг энэ чиглэлээр Та бүхэн судалгаа хийсэн үү?

Өнөөдөр тийм ээ, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль орж ирэхэд гэр хорооллын нохой, хашааны нохой, муур, эзэд нь ер нь энэ хуулийн төсөл дээр өөрөөр хэлэх юм бол чип суулгана, вакцинд хамруулна. Тийм ээ. Аюулгүй байлгана гэдэг энэ тал дээр ер нь ямар мэдээлэлтэй байгаа юм? Судалгаагаар тэд нар ер нь юу гэж байна?

Нөгөө талаар энэ зөвхөн муур, нохой гэсэн ийм заалт ороод ирсэн байгаа байхгүй юу. Одоо чинь орчин цагт төрөл бүрийн амьтан тэжээдэг болчихсон. Бүр могой, матар, одоо юу байдаг юм. Гэртээ тэжээж байгаа зөндөө их юмнууд байгаа шүү дээ. Энэ дээр ер нь ямар зохицуулалт хийх юм? Эд нарыг чинь Улаанбаатарын хөрсөнд аваачаад л нөгөөдөх нас барсан бол, үхсэн бол аваачаад нутаглуулна, булна.

Тэгвэл Улаанбаатар хотын хөрсний бохирдол 6-аас 8 метрийн гүндээ бохирдчихсон байгаа энэ тохиолдолд үүнийг яаж зохицуулах юм. Тийм ээ. Энэ зохицуулалт ер нь орох ёстой юу, үгүй юу?

Нөгөө талаар үржүүлгийн, хээлтүүлгийн ажил. Гудамжинд хээлтүүлээд л зогсож байдаг шүү дээ. Одоо циркийн ар талд залуучууд маань.

Ингэснээрээ нөгөө цэвэр цусны байх тэр юм нь алдагдчихсан. Магадгүй амьтны дэлгүүртэй хүмүүс нохой үржүүлээд мөнгө олохыг нь тулд маш үржүүлгийг буруу хийснээс шалтгаалан

цус нь солигдсон, туниа муутай, гудамжаар дүүрэн эрлийз нохой байгаа. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгвэл энэ зохицуулалтыг ер нь яаж хийх ёстой юм? Амьтны дэлгүүртэй хүмүүс дээр энэ зохицуулалтууд ер нь хэр байна вэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Нэгэнт бид хуультай болж байгаа юм чинь яг зөвхөн “Азтай Савар”-аараа л үржүүлэг, аюулгүй байх, хариуцлагатай байх тэр сургалтуудаа явуулаад байх юм уу? Өөр ямар хэлбэрээр зохион байгуулах юм?

Эргээд үнэхээр тэр вакцинаа хамруулах гэхэд цөөхөн байгаа нохойны, амьтны эмнэлгүүд чинь даах юм уу? Мал эмнэлгийн газар чинь энэ дээр ер нь ямар хариуцлага хүлээж байгаа юм?

Үнэхээр түр асран хамгаалуулахаар мал эмнэлгийн газарт аваачаад өгөх юм бол хариуцаж дийлэх юм уу? Цөөхөн байгаа шүү дээ. Тийм ээ. Амьтны “Азтай Савар”-тай адилхан эмнэлгүүд чинь.

Тэгэхээр энэ судалгаануудыг ер нь хэр хийсэн бэ гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм аа? Тэгээд дараа нь үргэлжлүүлээд асууя. Тэгэх үү?

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? 80 дугаар микрофон өгье. Ажлын хэсэг хариулья.

Ц.Зориглон: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Азтай Савар” төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон байна. Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

Энэ паспорт бүртгэлжүүлэлт гэдэг юман дээр яг эмнэлэгт байнга ханддаг

хүмүүс нохой, муур үзүүлж, эмчилгээнд нь тогтмол вакцинд хамруулдаг хүмүүсийн хувьд хангалттай бүртгэл байдаг.

Гэр хорооллын иргэдийн хувьд маш хангалтгүй байдаг л даа. Тэгэхдээ яах вэ сая 2017-2020 оны хооронд зөвхөн Улаанбаатарын хувьд нийслэлээс явуулсан хөтөлбөрийн хүрээнд нэлээн сайн бүртгэл явагдсан гэж үзэж байгаа.

Тэгэхдээ ерөнхийдөө түүнд нь 80 орчим хувь нь хамрагдсан байдаг юм билээ.

Тэгээд ер нь манай хуулийн төслөөр ерөөсөө бүртгэлжүүлэлтийг хамгийн чухалчилж үзэж байгаа л даа.

Яагаад гэхээр энэ бүртгэлжүүлэлт гэдэг юм нь өөрөө гудамжинд амьтан гарч байгаа тоог хянах. Эргээд нөгөө хүн, амьтан гэмтээх асуудал дээр эргээд хариуцлага тооцох нөхцөлийг нь бүрдүүлж өгөх.

Бид цаашдаа хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавихад мэдээлэл байх зорилготойгоор. Энэ бол бүртгэлжүүлэлтийн хамгийн чухал эхлэлийн алхам гэж үзэж байгаа.

Тэгээд хоёр дахь асуулт болох хөрсний бохирдлын тал дээр зөвхөн Улаанбаатар хотод жилдээ 80-аас 100 мянган нохой буудаж байгаа. Тэр маань шууд Цагаан давааны хогийн цэг дээр булагдаад.

Тэгээд хамгийн харамсалтай нь өмнөх жилийн 80-аас 100 мянган нохойны сэг зэм маань хөрсөндөө шингэж амжаагүй байтал дараа жилийн нохой устгалын сэг зэм нэмэгдээд очиж байдаг. Энэ мэдээллийг бид байнга авч байдаг.

Тэгэхээр хөрсний бохирдлын асуудал дахиад л иргэдийн хариуцлага, нөгөө бүртгэлжүүлэлттэй холбогдолтой болоод ирж байгаа юм л даа.

Үржүүлгийн тал дээр яг ингээд бүртгэлтэй цэвэр цусны нохой үржүүлдэг хүмүүс нь маш цөөхөн. Тэд нар нь яг гаднынхаа стандартыг бариад үржүүлдэг хүмүүс нь маш цөөхөн. Нийт социал орчинд юм уу, янз бүрийн зарын сайтуудаар маш их замбараагүй үржүүлгийн зарууд явж байдаг. Замбараагүй үржүүлэг явагдаж байдаг. Ямар ч стандарт байхгүй. Муур дээр ч мөн ялгаагүй.

Тэгээд мөн үржүүлгийнхээ дараа худалдаа борлуулалтад гаргахдаа ямар ч вакцин, туулганд хамруулаагүй тийм цэвэр цусны үзүүлэлтээ хангадаггүй нохой, муурыг худалдаанд гаргаж байгаа.

Бид түүн дээр дахиад л бүртгэлжүүлэлт рүүгээ орно. Юу вэ гэхээр яг үнэхээр энэ үржүүлэг хийх гэж байгаа хүмүүсийг яг бизнес хийж байна гэж үзнэ. Бизнес хийж байгаа бол бизнесийнхээ зарчмаараа.

Манай хуулийн заалт дээр аж ахуйн нэгж заавал байх ёстой гэж оруулсан байгаа. Нэг нохой үржүүлж байсан ч хамаагүй зөвшөөрөл авч байх ёстой гэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя. Аан. Та тодруулах юм уу? Б.Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Дараа нь Ц.Сандаг-Очир гишүүн асууя.

Б.Жаргалмаа: Тийм. Асуусан шүү дээ тэ. Гэр хорооллынхон чинь паспортжуулах энэ юманд хэр мэдээлэлтэй байгаа юм? Судалгаанд хамрагдсан уу?

Зүгээр гэртээ байдаг, хашаандаа байдаг муур нь эзэнгүй л байгаа шүү дээ. Тийм ээ. Тэд нарыг ер нь яаж зохицуулах юм бэ?

Нөгөө талаар зөвхөн гэрийн тэжээвэр нохой, муур гэхчхэн. Гэтэл могой, матар, одоо юу байдаг юм, усан гахай, усан хулганууд бүгдээрээ л тэжээж байгаа шүү дээ.

Эд нар чинь энэ хуулиар зохицуулагдах уу л гэдэг. Өөрөөр хэлэх юм бол тэд нар чинь газрын хөрсөнд л аваачаад байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ дээр яах ёстой юм бол оо?

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. 83 дугаар микрофон өгье.

У.Азжаргал: Гэрийн тэжээвэр амьтан дээр тодорхойлолт хэсэг дээр ашиг шимийг нь ашиглахаас бусад хүнтэй хамт гэршүүлсэн амьдрах боломжтой Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан мал, зэрлэг амьтан, тэжээвэр амьтнаас бусад амьтныг гэрийн тэжээвэр амьтан гэж үзнэ гэж заасан.

Тэгээд энэ дээр юу гэсэн үг вэ гэхээр бусад нөгөө тоть, могой, аалз. Тийм ээ. Нөгөө жижиг нутагт. Эд нар бүгд орж байгаа.

Асран хамгаалагчийн үүрэг дээр нийтлэг асран хамгаалагчийн үүрэг буюу саяын дурдсан гэрийн тэжээвэр амьтныг тэжээж байгаа бүх хүмүүс маань нөгөө амьтныхаа эрүүл мэндэд анхаарах буюу бүртгэл чипний асуудлын тухайд зөвхөн яг нохой, муур буюу дараа нь эзэнгүй

болсон ч гэсэндээ гудамжинд гараад амьдарч чаддаг амьтан дээр бичил чип мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид суулгуулж харьяа сум, баг, хорооны Засаг даргад бүртгүүлэх байдлаар тухайн хүний оршин суугаа эзнийхээ оршин сууж байгаа хаяг дээр бүртгэлтэй байдлаар явах байдлаар зохицуулж өгсөн байгаа.

Тэгээд энэ дээр бусад амьтдыг орж байгаа гэж бас харах нь зүйтэй. Тэгээд бүртгэлийн хувьд бол бас яг тодорхой хэмжээнд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмэх юм уу? Хуулийн төсөл санаачлагч Б.Энхбаяр гишүүн нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Ер нь урьд нь хуулиар хуульчлагдаж байгаагүй шинэ тутам бүхэн бол их соргог байдаг.

Тэгээд мэдэхгүй шинэ юманд мэдээж ямар ч хүн эргэлзэнгүй ханддаг.

Миний хувьд ч гэсэн анх энэ залуучууд хоёр жилийн өмнө Монголд ийм хууль хэрэгтэй гээд анх уулзаж байхад би бас одоо ийм хууль байж болно гэж үү. Энэ хуулиар зохицуулах асуудал юм уу. Амьтныг зохицуулдаг л юм байх даа гэх мэт надад ийм эргэлзээнүүд байсан.

Тэгээд асуудлыг судлаад үзэхээр нээрээ ч зайлшгүй юм байна гэж.

Тэгэхээр ямар ч хүн мэдэхгүй зүйлээсээ айдаг. Яг үүнтэй адилхан яг энэ асуудал дээр манай олон иргэд энэ амьтны талаар хууль байж болдог юм байх даа гэж бодоод байгаа байхгүй юу.

Хууль нь амьтны тухай боловчиг яг доторх агуулга нь хүний тухай хууль байгаа юм.

Ерөөсөө л хүний эрхийн, хүний үүрэг, хариуцлагын тухай ийм хууль.

Л.Мөнхбаатар: Манай ажлын хэсгийн гишүүд гишүүдийн асуултад хариулахдаа нэр, албан тушаалаа хэлээд хариулж байгаарай. Яагаад гэвэл энэ чуулганы нэгдсэн хуралдааны протоколд үлддэг. Хэн хэрхэн хариулсан нь үлддэг байгаа юм шүү.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ харилцааг төрийн байгууллагуудын шугамаар яг Хөдөө аж ахуйн яаманд харьяалах юм уу, Эрүүл мэндийн яаманд харьяалалтай юм уу, аль эсвэл Байгаль орчны яамны харьяаллын асуудал уу?

Энэ бидний зохицуулах гээд байгаа энэ харилцаа чинь. Үүнийг нэг тодруулж өгөөч ээ гэж.

Хоёрт, нохой хүнийг хазвал яах вэ гээд яриад байгаа юм.

Нөгөө талаараа эсрэг талаар нь хүн өөрөө нохойг зодвол яах вэ гэдэг асуудал байгаа байхгүй юу. Зөвхөн нохойгоо биш. Муураа ч гэдэг юм уу. Амьтны эрхийг.

Ер нь амьтны эрхийн асуудал манай улсад ер нь хэр байна вэ? Та бүхэн юу гэж үзэж байна вэ? Цаашдаа энэ харилцаа ер нь байх ёстой юу, ёсгүй юу?

Магадгүй зурагт телевиз үзэж байгаа улсууд хүний эрхээ хангаж чадахгүй байж юун амьтны эрх вэ гэж ингэж бас ярихыг үгүйсгэхгүй. Энэ өндөр хөгжилтэй орнууд чинь ер нь хүний эрхийн асуудлаасаа халиад бүр амьтны эрхийн асуудлыг ярьдаг болчихсон,

хуучилчихсан улс орнууд зөндөө байна шүү дээ.

Тэгээд тэр амьтны эрхийг яаж хангах юм, үржлийг нь яаж хангах юм, ямар орчинд өсгөж үржүүлэх юм, ямар вакцин, тарилгад хамруулах юм. Энэ чинь өндөр хөгжилтэй улс орнуудад энэ асуудлыг ярьдаг болчихсон байна шүү дээ. Тэгэхэд манайх дөнгөж энэ харилцааны эхлэлийн шатанд.

Тэрийг тэжээж байгаа иргэн тэр үүрэг, хариуцлагын асуудлуудыг ярьж байна.

Энэ гэрийн тэжээвэр амьтдын тооллого явдаг л даа. Малын тоотой хамт жил болгон.

Өнөөдрийн байдлаар улсад хэдий хэмжээний гэрийн тэжээвэр амьтад тоологдсон байдаг юм? Нохой, муур.

Тэгээд энэ харилцаан дээр бусад амьтантай адилтгах бусад амьтан гэж байна. Энд юу орох юм? Гахай, тахиа нь орох юм уу? Тэр загас жараахай нь орох юм уу? Шувуу юмнууд нь орох юм уу? Энэ харилцаанд хамаарах уу? Үүнийг нэг тодруулж асууя.

Нөгөө талаар амьдрал дээр бас орон нутгийн шат шатын засаг захиргаанд татвар төлөх үүрэгтэй л дээ.

Тэгээд эндээс ер нь татварын хэм хэмжээ ордоггүй л дээ. Яг үнэнийг хэлэхэд. Нохойны татвар, муурын татварыг төлж байсныг би сайн мэдэхгүй байна. Энэ төрлийн татварын ангилалд хэдэн төгрөгийн улсын төсөвт орлого орж байсан байна. Ер нь ийм үүх түүх байна уу, үгүй юу?

Ер нь байсан ч их бага хэмжээтэй байгаа байх. Тэгвэл цаашдаа энэ хууль

батлагдсанаар ер нь энэ татварын хувь хэмжээ яаж нэмэгдэх бололцоо боломж гарах юм?

Нөгөө талаар амьдрал дээр нэг айлын тэжээвэр нохой галзуурлаа ч гэдэг юм уу, орилж чарлаад байдаг. Тэгээд эзэд нь дуудлага өгдөг. Ингэхээр нөгөө эрх зүйн зохицуулалтгүй учраас онцгой очих ёстой юм уу, Зооноз очих ёстой юм уу, эмнэлэг очих ёстой юм уу гээд ингээд. Энэ байгууллагууд хоорондоо манайд энэ асуудал байхгүй, манайх очих боломжгүй гээд ингээд бие бие рүүгээ хийгээд байдаг байхгүй юу.

Тэгэхээр цаашдаа энэ асуудлыг яг хэн харьяалах юм бэ гэдэг асуудал байна. Энэ байгууллагуудын үндсэн чиг үүрэгт энэ асуудлууд хамаарах юм уу, хамаарахгүй юм уу гэдэг асуудлууд яригдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хуулиар энэ асуудлыг хэр зохицуулж байгаа юм бэ гэсэн ийм хоёр, гурван асуулт байна. Тэгээд та бүхэн минь хариулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Б.Энхбаяр гишүүн эхлээд хариулъя. Дараа нь ажлын хэсгээс тодруулж хариулж болно.

Б.Энхбаяр: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Энэ гэрийн тэжээвэр амьтантай хүн харьцаж байгаа. Харилцаа урьд нь хуульчлагдаж байгаагүй учраас бүх юм шинэ байгаа юм. Бүх юм шинэ байгаа учраас яг таны хөндөж тавьсан энэ асуудлыг ер нь аль яам, сайдын эрхлэх асуудалд хариуцах вэ гэхээр бид бас яг энэ хуулийн төслөө боловсруулж байхдаа бас л яг таны энэ асуулттай бид өөрсдөө тулчихсан.

Одоо энэ хууль маань Улсын Их Хурлын гал тогоонд орж ирэхэд энэ ер нь аль Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах вэ, аль Байнгын хороо хэлэлцэх вэ гэдэг дээр чинь бид чинь бас даргатайгаа жоохон гайхширсан ийм асуудал руу орсон л доо.

Хэрвээ үүнийг хүний эрхийн нүдээр хараад үзвэл энэ Хууль зүйн байнгын хороогоор орох ёстой байсан. Энэ бол одоо байгаль орчин, хөрсний бохирдлын асуудал талаас нь харвал Байгаль орчны байнгын хорооны асуудал байгаа юм.

Ер нь таван хошуу малтайгаа адилгаж үзээд. Амьтан юм чинь таван хошуу малтайгаа нийлүүлье гэвэл энэ нөгөө Хөдөө аж ахуйн байнгын хороо руугаа ороод явчихна.

Үүнийг эрүүл мэнд талаас нь авч үзэж харвал энэ мэдээж Нийгмийн бодлогын байнгын хороогоор орох ёстой асуудал болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ бол ер нь салбар дундын шинжтэй ийм асуудал байна уу даа гэж харж байгаа.

Тийм учраас үүний зохицуулах харилцаа нэлээн салбар дундын шинжтэй. Гол ачаа үүрэг илүүтэй орон нутагт. Таны хэлсэнчлэн нөгөө татвартай холбоотой, бүртгэлтэй холбоотой харилцаан дээр гарч ирэх болов уу гэсэн ийм бодолтой.

Бид ер нь юунд их итгэж найдаж байгаа вэ гэхээр үүнийг төрийн нударгаар, айдсаар, цагдаагийн хүчээр одоо ийм албадах аргаар хэрэгжүүлнэ гэхээсээ юун түрүүн итгүүлэх, ойлгуулах, мэдээлэлжүүлэх, ухамсарлуулах, өөрөөр хэлбэл өөрсдөөр нь, сайн дураар нь, олон

нийтийн хүчээр, оролцоотойгоор энэ хуулийн хэрэгжилтийг хангах юун түрүүн ийм зорилт тавьж байгаа юм.

Тухайлбал, тэр хүүхдийн тоглоомын талбайд өөрийнхөө нохойг салхилуулаад, тэр ялгадсыг нь тэнд бохирдуулаад байгаа иргэнийг тэр цагдаа гэхээсээ илүү тэнд амьдарч байгаа иргэд өөрсдөө хяналт тавих ёстой. Иргэд өөрсдөө үүнийг шахаж шаардах хэрэгтэй. Тэгж байгаад тэр сахилгагүй иргэдэд шаардлага тавьдаг байх хэрэгтэй. Ичээдэг байх хэрэгтэй. Ичээдэг.

Мөн нохой, мууртай иргэд өнөөдрийн чуулганы хуралдааныг үзээд ер нь би чинь цаашдаа ийм болох гэж байгаа юм байна шүү. Юм нарийн болж байгаа юм байна шүү. Чангарч байгаа юм байна шүү. Би чинь зүгээр нэг шохоорхлын журмаар хүүхэддээ тоглуулах гээд, тоглоом авч өгдөгтэйгээ адилхан нэг гөлөг, муужгай авч өгөөд тэгээд хүүхэд нь таалахгүй болонгуут нь гаргаад хаячихдаг. Энэ тоглоом биш юм байна шүү. Энэ чинь амьд амьтан юм байна шүү. Амьд амьтай учраас би өөрөө энэ дээр бас хариуцлага үүрэх, хариуцлагатай байх ёстой юм байна шүү гэдэг ойлголтыг хүртэл өгөх талаас нь бас бодож ингэж хуулиа хийхийг эрмэлзсэн байгаа.

Тэгээд манай ажлын хэсгийн гишүүд нэмж хариулна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсгийн асуултад хариулья.

У.Азжаргал: Ц.Сандаг-Очир гишүүндээ баярлалаа. Хуульч У.Азжаргал асуултад нь хариулья.

Хоёр болон гурав, дөрөвдүгээр асуултанд. Амьтан хохирол учруулбал

яаж зохицуулах вэ тухай тусгасан. Гэрийн тэжээвэр амьтны хуулийн төсөл дээр гэрийн тэжээвэр амьтны хүчирхийллийн эсрэг зохицуулалт тусаж өгсөн байгаа. Тодруулбал, 47.2.4 дэх хэсэг дээр гэрийн тэжээвэр амьтныг зодох, тамлах, хэт ачаалал авхуулахыг хориглож өгсөн.

Улмаар яг дагаж мөрдөх журмын тухай хуулийн Зөрчлийн тухай хууль дээр 7.19.10-д нь гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэл үйлдсэн хүнийг 500 нэгжээр ч юм уу одоо ер нь торгох зохицуулалтуудыг тусгаж өгөх боломжтой гэж харсан байгаа.

Тэгээд гуравдугаар асуулт гэх юм бол тэжээвэр амьтан болон гэрийн тэжээвэр амьтан хоёрын ер нь ялгаа. Гахай, тахиа эд нар бас орох юм уу гэдэг. Ер нь бас мэдээж хүмүүсийн эргэлзээ дагуулж байгаа асуудлуудын нэг байгаа.

Гэхдээ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль дээр 4.1.2 дээр тэжээвэр амьтны тухай тодорхойлолт байдаг. Түүн дээр ашиг шимийг нь хүртэх боломжтой гэдэг байдлаар тодорхойлсон.

Харин гэрийн тэжээвэр амьтан маань ялгаа нь юу вэ гэхээр ашиг шимийг нь хүртэхгүй. Хүн өөртэйгөө хамт гэршүүлэн тэжээх, хамтран амьдрах боломжтой ийм амьтныг гэрийн тэжээвэр амьтан гэдгээрээ ялгаатай байгаа.

Тийм учраас бидний ашиг шимийг нь хүртээд байдаг тахианаас нь өндгийг нь авдаг, гахайны махыг нь авдаг. Тийм ээ. Зөгийн аж ахуй гэдэг. Тэд нар бол тэжээвэр амьтан буюу тусдаа Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулагдах харилцаа байгаа юм.

Дөрөвдүгээр асуулт нь, татварыг хэрхэн зохицуулсан бэ гэж асуусан. Монгол Улсын татварын ерөнхий хууль дээр 7 дугаар зүйлийн 2.21 дээр угаасаа нохойны татварыг авна гэж анхнаасаа зохицуулсан байдаг байгаа.

Тэгээд энэ дээр манай ажлын хэсгийн зүгээс нохойноос гадна муурны татварыг авах нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр гудамжинд гараад өөрөө амьдрах боломжтой, үржчихдэг, цааш цаашдаа нийгмийн асуудлуудыг үүсгэдэг учраас татвар дээр угаасаа байсан нохойны татвар дээр нэмээд муурыг нэмж оруулж өгснөөрөө онцлог байгаа.

Өөр энэ дээр иргэдэд нэг их дарамт учруулж байгаа ч юм уу, нэг бол шинээр бий болгоод байгаа зүйл энд байхгүй байгаа.

Л.Мөнхбаатар: 18.00 цаг болсон байна. Ажлын цаг дууссан байна.

Гэхдээ хэлэлцэж байгаа асуудал дуусаагүй байгаа учраас чуулганы хуралдааны цагийг сунгаж хуралдахаар шийдэж байна. /алх цохив/

Ганибалын Амартүвшин гишүүн. Ц.Сандаг-Очир гишүүн тодруулъя. Тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Түрүүн миний асуултад тэр нэг жишээн дээр орон нутагт онцгой очих уу, зооноз очих уу, эмнэлэг очих уу гэдэг асуудал одоогоор тодорхойгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас түүн дээр цаашдаа ер нь яг хэнд нь харьяалах ёстой юм, хэнийх нь чиг үүрэгт харьяалуулах юм гэдэг

асуудал энэ хуулиар орж ирж байна уу, үгүй юу гэдгийг нь тодруулж өгөөч ээ.

Өнгөрсөн хугацаанд Та бүхний асуултад хариулж байгаа байдлаас сонсоход ер нь энэ харилцааг зохицуулах зайлшгүй шаардлага байгаа юм байна гэдгийг ойлголоо.

Дараагийн ээлжид хот сууринд өсөж бойжиж байгаа хүүхдүүд маань ер нь хөдөө аж ахуй, мал аж ахуйгаасаа маш их хөндийрч байна. Хонь хургаа, ишиг хургаа ялгаж чадахгүй болж байгаа.

Тийм учраас цаашдаа хот суурингийн хүүхдүүд мал аж ахуй, мал амьтныг хайрлах тэр үзэл төлөвшлөөс энэ гэрийн тэжээвэр амьтнаас л амьтныг хайрлах ёстой юм байдаг тэр хүмүүжил юмыг олж авах ёстой юм байна даа гэж ингэж харж байна.

Мэдээж хүнээс гадна амьтныг хайрлах энэ үзэл төлөвшил өөрөө.../минутт дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. 85 дугаар микрофон өгье. Ажлын хэсэг хариулъя.

Э.Анударь: Сайн байцгаана уу? Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь байна.

Тэгэхээр орон нутаг руу зооноз очих уу, мал эмнэлэг очих уу гэдэг асуултад хариулъя.

Тэгэхээр бид энэ хуулийн төслийг нэлээн олон жил судалгаа, шинжилгээг нь хийж байж боловсруулсан.

Дээрээс нь иргэдээс “BePawsitive” өдөрлөг зохион байгуулаад нэг бүрчлэн **D-Parliament.mn** аппликэйшнээр санал авсан.

Мөн дээрээс нь “Хүний эрхийн форум” зэрэг дээр очиж бас хэлэлцүүлэг өрнүүлсэн. Яг нөгөө Хууль тогтоомжийн тухай хуульд заасныхаа дагуу Засгийн газраас санал авсан. Мал эмнэлгийн ерөнхий газрын төлөөллүүдтэй очиж уулзсан. **E-Mongolia**-гийн төлөөллүүдтэй очиж уулзсан.

Тэгэхээр ингээд боловсруулж байх явцад мэдээж төрийн байгууллагын чиг үүрэг талаасаа бас илүү дахиад нэмж яг тусгайлсан тэр нэгжүүдийн саналыг, оролцоог дахиж авах шаардлага байгаа.

Тэгэхээр бид хэрвээ энэ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Ганибалын Амартүвшин гишүүн асуултаа асууя.

Г.Амартүвшин: Баярлалаа. Хууль санаачлагчдад талархаж байна. Энэ бол бас цаг үеэ олсон зөв санаачилга гэж бодож байна.

Яагаад гэвэл аливаа нийгмийн хөгжил, соёлыг бас амьтантай харьцах харьцаагаар нь дүгнэдэг.

Тийм болохоор бидний энэ харьцааг хуульчилж оруулж байгаа нь зөв өө. Яагаад гэвэл одоо ингээд сүүлийн үед юу ажиглаад байна гэхээр ер нь гэрийн тэжээвэр амьтантай болно гэдэг чинь маш том хариуцлага. Энэ амьд амьтан.

Тэгэхгүй гэвэл ингээд харж байхад хүүхдүүддээ тоглоом авч өгч байгаа юм шиг нохой, муужгай, гөлөг аваад өгчихдөг. Нөгөө хэд нь өөрсдийгөө яая

гэж байж бас нэг амьд амьтантай харьцаж чадахгүй. Ээж, аав нь ч тэрэнд анхаарал тавьдаггүй. Тэгээд нэг жоохон тоглож байгаад хаячихдаг, уйдчихдаг. Тэгээд нэг мэдэхэд нөгөө нохой, муур нь гудамжинд гараад явж байдаг. Гэх мэтчилэн.

Энэ хуульчлах гэдэг чинь бас тодорхой хэмжээгээр мэдээллээр хангах, зөв соёл суулгах.

Тэгэхээр энэ тал дээр хуулийн төсөл дээр ямар нэгэн тийм зүйл, заалт, шаардлагатай санхүүжилт байна уу, тийм юмнууд туссан уу, үгүй юу?

Хоёрдугаарт, одоо жишээлбэл, нохой, муурын хоолны бизнес бол маш том бизнес. Дэлхий даяар 100 тэрбум долларын хэмжээтэй борлуулалттай ийм бизнес болчихсон байгаа. Жилдээ доор хаяж 20 хувийн өсөлттэй.

Тийм маш их ашиг олох боломжтой бизнес учраас нохой, муурын хоолны стандарт нь аягүй чухал байдаг. Жишээлбэл, Америкт үүнийг маш тийм нарийн зохицуулалттай байдаг. Чанартай муурын хоолны амьтны гаралтай уураг нь 10-аас дээш хувьтай байх шаардлагатай байдаг. Жишээлбэл. Зарим орцод нь гурил, гурилан бүтээгдэхүүн орж болохгүй гэсэн заалттай байдаг.

Тэгэхээр манайд ийм стандарт байна уу, байхгүй юу? Энэ маш чухал. Яагаад гэвэл нөгөө нохой, муур тэжээж байгаа хүмүүс маань өөрсдөө үүнийгээ мэдэхгүй буруу тэжээдэг. Жишээлбэл, бид хүүхэд байхаасаа хойш муур үнээний сүүнд дуртай гэж боддог. Яг үнэн хэрэг дээрээ мууранд ерөөсөө сүү өгч болдоггүй шүү дээ.

Би олон жил амьтан тэжээж байсан. Манайх мууртай. Сүү ерөөсөө өгч болдоггүй. Муур чинь шингэнээ

нойтон хоолноосоо юм уу, уснаас л авах хэрэгтэй. Тэгээд л аяганд нь сүү хийж өгөөд л. Тэр нь муурны эрүүл мэндэд хортой.

Жишээлбэл, нохойнд шоколад маш хортой гэж байгаа юм. Шоколад идэх юм бол бараг шууд бөөрний дутагдалтай болоод амь нь эрсдэх жишээтэй.

Тэгэхээр энэ мэдээллийг хангаж өгөх ёстой. Үүний ач холбогдол нь бас их чухал юм. Яагаад гэвэл нөгөө мал эмнэлгийн стандарт гэж байна уу, үгүй юу манайд.

Одоо ингээд айлууд чинь маш их хэмжээгээр нохой, мууртай болж байна. Тэрийг дагаад мал эмнэлгийн бизнес чинь бас сайн хөгжиж байна л даа. Энэ бол сайн зүйл. Гэхдээ нөгөө талаас тэдэнд тавьдаг шаардлага нь байх хэрэгтэй. Стандарт нь байх хэрэгтэй.

Сайн чанарын дархлаажуулалт хийж чадаж байна уу? Тийм ээ. Жишээлбэл, ашиг олох олохоос өөр аргаар амьтан тэжээж ээ гэвэл тэрийг заавал засаж байх хэрэгтэй. Тийм ээ. Гэх мэтчилэн мэдээллээр хангаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг хянах шаардлагатай гэж би бодож байна л даа.

Би муураа дагуулаад л Мал эмнэлэг дээр очиж байсан. Зарим нь маш сайн. Аягүй сайн тоног төхөөрөмж. Зарим нь үнэхээр орохоос аймаар л байдаг юм билээ л дээ. Гэх мэтчилэн ийм мэдээллээр хангах, стандартыг мөрдүүлэх, хянах ажлууд нэлээн байгаа. Тэгээд би хариултаа сонсчхоод нэмж асуулт асууя.

Л.Мөнхбаатар: Г.Амартүвшин гишүүний асуултад хариулья. 87 дугаар микрофон өгье. Ажлын хэсэг хариулья.

Д.Оюун-Эрдэнэ: Сайн байцгаана уу? Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. “Азтай Савар” төрийн бус байгууллагын гишүүн Д.Оюун-Эрдэнэ байна. Г.Амартүвшин гишүүний асуултад хариулъя.

Эхний ээлжинд хариуцлага, мэдээлэлжүүлэх ажлыг ер нь яаж хийх вэ? Энэ тал дээр мэдээлэл өгөөч ээ гэдэг асуулт байна. Юуны өмнө энэ хууль маань өөрөө нийгэмд, ялангуяа сүүлийн жилүүдэд их бий болж байгаа амьтан тэжээх өргөжиж байгаа соёлтой шууд холбоотой.

Тэгэхээр яг дурдсанчлан эздийг хариуцлагажуулах, мэдээлэлжүүлэх, соёлжуулах гэдэг бол өөрөө яг хуулийн хэрэгжилттэй нягт холбоотой. Үүн дээр хуулийн төсөлд тусгагдсан байдал нь асран хамгаалагчийн эрх, үүрэг дээр нарийн зааж өгч байгаа.

Юуны өмнө гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч болоход эрх зүйн бүрэн чадамжтай, тухайн гэрийн тэжээвэр амьтныг хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах үүрэгтэй.

Мөн нохой, муурын асран хамгаалагч нь яг нохой, муур тэжээхтэй холбоотой сургалтад хамрагдах гэх мэтчилэн үүргийг тусгаж өгсөн байгаа.

Мөн “Азтай Савар” төрийн бус байгууллагын зүгээс яг энэ гэрийн тэжээвэр амьтан тэжээх мэдээллийг, энэ соёлыг түгээх ажлыг хийсээр ирсэн байгаа.

Хоолны стандартын хувьд хуулийн төсөлд тусгаснаар яг тухайн амьтны төрөл зүйл, онцлогт тохирсон шим тэжээлтэй хоолыг өгөх үүрэг хүлээж

байгаа. Үүн дээр тусгайлсан дэлгэрэнгүй журмын зохицуулалт орох боломжтой гэж бидний зүгээс харж байгаа.

Дараагийн асуултын хувьд мал, амьтны эмнэлэгт тавигдах стандарт байдаг эсэхтэй холбоотой асуулт байна.

Үүн дээр мэдээж үүргээрээ асран хамгаалагчид гэрийн тэжээвэр амьтныхаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авахаар эмнэлгийн байгууллагад хандана. Тухайн эмнэлгийн байгууллага зохих зөвлөгөө, мэдээллийг эргээд өгч ажилладаг.

Яг өнөөдрийн түвшинд Улаанбаатар хотын хэмжээнд гэхэд 20 гаруй жижиг мал, амьтны эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнтэй холбоотой хуулийн төслийн хүрээнд бид санал авах хүрээндээ мал, амьтны.

Тийм Нийслэлийн мал, эмнэлгийн ерөнхий газарт санал өгч хариу санал авсан. Үүн дээр Мал эмнэлгийн ерөнхий газраас газрын амьтны эрүүл мэндийн кодексд Монгол Улс нэгдэн орсон байдаг учраас үүнтэй уялдуулсан зохицуулалт оруулж өгөх саналыг. Мөн цаашид ажлын хэсэг гараад явсан тохиолдолд Мал, эмнэлгийн ерөнхий газрын төлөөлөл орж ажиллах саналыг бид нарт өгсөн байгаа.

Тэгэхээр цааш цаашдын ажлын хэсгийн хүрээнд яг мэргэжлийн чиг үүргийнх нь байгууллагатай хамтарч ажиллаж, төлөөллийг оролцуулж, энэ тухайлсан стандартуудыг дэлгэрэнгүй тусгаж өгөх боломжтой гэж харж байгаа.

Мөн үржил хянахтай холбоотой. Ер нь энэ амьтныг үржүүлэхтэй холбоотой мэдлэг, мэдээллийн талаар бас дурдаж асуулаа.

Яг гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн гол зорилго нэгдүгээрт нийгэмд үүсээд байгаа эзэнгүй амьтдын асуудлыг шийдвэрлэхэд нэлээн чиглэсэн зохицуулалтууд байгаа.

Эзэнгүй амьтад үүсээд, тэдгээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөж байгаа, хөрсний бохирдол үүсгэж байгаа, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа, халдварт өвчин тархаагдаж байгаа гэх мэтчилэн олон асуудлуудыг бий болгож байгаа.

Гэтэл энэ эзэнгүй амьтан бий болох цаад шалтгаан, эх үүсвэр нь өөрөө замбараагүй, хяналтгүй үржүүлэгтэй шууд холбоотой.

Үржүүлгийн хувьд нэг талаасаа амьтан тэжээж байгаа гэрийн тэжээвэр амьтны эзэд өөрсдөө үржлийг нь хаах, хариуцлагатай байх, үржлийг нь хаалгах үүргийг тусгасан.

Нөгөө талаасаа амьтныг үржүүлж ашиг олж байгаа бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудыг үржүүлгийн зөвшөөрөл авах, авсан зөвшөөрлийнхөө дагуу зохих хяналтын доор үйл ажиллагааг эрхлэх.

Яг бизнесийнхээ хувиар татвараа төлөх хуулийн этгээд байх гэх мэтчилэн шаардлагуудыг оруулж өгч байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганибалын Амартүвшин гишүүн тодруулж асууя.

Г.Амартүвшин: Баярлалаа. Тэгээд энэ хууль хэрэгжих хугацаа нь юу билээ?

Энэ хуулиа аягүй сайн сурталчлах шаардлагатай байна л даа. Мэдээ,

мэдээллээр хангах. Тийм ээ. Ялангуяа одоо ингээд нэг юм анзаараад байхад сошиалаар нэг амьтан, муур, ялангуяа муур, нохойн баахан стори хийж, тэр нь тэгээд гоё харагддаг ч боловч яг үнэн хэрэг дээрээ энэ амьтныг бас зовоож байгаа асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг хариуцлага тооцох тийм зохицуулалт байна уу, үгүй юу?

Хоёрдугаарт, ашиг олохын төлөө амьтан үржүүлж байгаа, нохой, муур үржүүлж байгаа хүмүүст ер нь ямар шаардлага тавих вэ? Тэд нарыг чинь бас баахан муужгайнуудыг умайсан жижигхэн байранд үржүүлж байна уу, ямар стандартаар үржүүлж байна гэсэн тийм шаардлага тавих уу? Хариуцлага тооцох уу, үгүй юу?

Л.Мөнхбаатар: Г.Амартүвшин гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 87 дугаар микрофон өгье.

Д.Оюун-Эрдэнэ: Д.Оюун-Эрдэнэ байна.

Хуулийн хэрэгжих хугацааны хувьд мэдээж түрүүн Б.Энхбаяр гишүүний мөн хариулсанчлан энэ өөрөө анхдагч хууль байгаа. Тийм ээ. Яг одоогоор ямар нэгэн зохицуулалтгүй байгаа зүйлийг зохицуулж байгаа. Уг үндсээр нь зохицуулалт оруулж ирж байгаа учраас тодорхой шилжилтийн хугацаа хэрэгтэй гэдгийг бид ойлгож байгаа.

Тэгэхээр дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд шаталсан байдлаар бүртгэлийг хэзээнээс эхэлж хийх юм, үржил хязгаарласан байхыг хэзээнээс эхэлж шаардах юм, устгал хэдий хэмжээнд ямар байдлаар хийгдэх юм гэх мэтчилэн тусгайлсан зохицуулалтууд оруулж ирж байгаа.

Үүн дээр яг ажлын хэсэг дэлгэрүүлээд илүү нарийвчлан оруулж ирэх шаардлагатай гэж бодож байна.

Үржүүлгийн үйл ажиллагааны хувьд яг ямар шаардлага тавигдах юм бэ гэхээр нэгдүгээрт хуулийн этгээд байх шаардлагатай.

Өнөөдөр яг хувь хүн, хууль хуулийн этгээд яг албан ёсны зөвшөөрөлтэй эсэхээс үл хамаараад зарын сайтууд дээр зүгээр гар дээрээс худалдаалах байдал их байгаа.

Тэгэхээр яг зөвхөн зөвшөөрөл авсан хуулийн этгээд зохих шаардлагын дагуу орон байрны стандарт заартын дагуу үйл ажиллагаа явуулна.

Л.Мөнхбаатар: Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Тэгэхээр хуулийг дэмжиж байгаа.

Яагаад гэвэл аливаа амьд бүхнийг хайрлах, хамгаалах асуудал хүний нандин сэтгэл, ёс зүй, харилцаа хандлагын асуудал. Тиймээс бүр эхнээс нь дэмжиж байгаа.

Магадгүй тэгээд сая Б.Энхбаяр гишүүн нөгөө хайрын хууль гэж ярьж байсан байх. Энэ талаасаа дэмжиж байна.

Харин энэ хууль өөрөө хэрэгжих нь их чухал байгаа. Миний хувьд жишээлбэл хамгийн их анхаарал хандуулж байгаа асуудал энэ хөрсний бохирдлын асуудал байгаа. Жишээ нь, нийслэл Улаанбаатар хотын тухайд ярихад хүн амын 50-иас илүү хувь нь амьдарч байгаа. Хөрсний бохирдлоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд хүрчихсэн байгаа. Үндэсний

аюулгүй байдлын түвшинд хүрчихсэн ийм асуудал байгаа.

Тэгээд энэ дээр хөрсний бохирдол дээр бас нэг шалтгаан, үндэслэл болж байгаа нь энэ эзэнгүй амьтад, гэрийн муур, нохойн устгал. Сая энэ дээр маш тодорхой бичсэн байна л даа.

Одоо тэр устгагдсан 216 нохойны 67 хувьд нь шимэгч хорхойтой байдаг гээд л жишээлбэл. Энэ устгагдсан муур, нохой, тэжээвэр амьтад ч юм уу бүгд тэгээд л хөрсөн доор орно. Зарим нь хаа хамаагүй. Магадгүй иргэд, оршин суудаг газар, хүүхэд тоглодог газар ч байж мэдэхээр л байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө л шимэгч хорхой буюу бусад халдварт өвчин ихтэй.

Тэгэхээр энэ өөрөө нийгмийн эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд талаасаа хүртэл маш чухал асуудал.

Тиймээс энэ асуудлыг түрүүн Б.Энхбаяр гишүүн хэлээд байна. Санаачлагчийн хувьд.

Салбар дундын байх хувилбарын тухай ярьж байна. Би үүнийг буруу болов уу гэж бодож байна. Аль нэг хариуцах эзэнтэй байхгүй бол. Одоо өмнө нь бид бас, би Өргөдлийн байнгын хорооны дарга байхад нийтийн эрх ашгийг зөрчсөн нийгмийн эрүүл мэндийн маш чухал асуудлуудыг салбар дундын болгоод орхичихсон чинь яг дараа нь асуудал үүсэхэд хариуцах эзэнгүй болчихдог юм билээ. Эрүүл мэндийн яам нэг юм яриад л, Хүнс, хөдөө аж ахуйн нь нэг юм яриад л, уул уурхай, тэр байгаль орчныг сүйтгэсэн газар нь нэг өөр юм яриад л. Тэгээд эзэнгүй.

Тэгэхээр энэ одоо жишээ нь өнөөдрийн оруулж ирж байгаа энэ гэрийн тэжээвэр амьтдын тухай анхдагч хуулийн

төсөл дээр үүрэг, хариуцлага их байна л даа. Одоо ингэх ёстой, тэгэх ёстой, ингэж хайрлах ёстой, ийм чип зүүх ёстой ч гэдэг юм уу. Тийм ээ.

Тэгэхээр энэ үүрэг хариуцлагад хяналт тавих тэр субъект нь хэн байх вэ гэдгийг хуулийн хэлэлцүүлгийн явцад маш анхаарч тусгах ёстой шүү. Тэгэхгүй бол бид нар жишээлбэл хууль гаргадаг. Одоо жишээ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг гаргануут нэгд санхүүжилт нь байхгүй.

Хоёрт, хариуцах эзний дундын болгоод ингэчихээр эхлээд энэ хууль хэрэгжихэд маш амаргүй байсан. Тэгээд дахиж нэмэлт, өөрчлөлт оруулж байж тодотгосон. Энэ тэгээд цаашаа хэрэгжиж явж байгаа байхгүй юу.

Тийм учраас бид нар одоо мэдээж хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ингээд явахад, хэлэлцэхийг нь дэмжсэн тохиолдолд ажлын хэсэг дээр дэд ажлын хэсэг болон яг ажлын хэсэг дээр яг энэ асуудлуудыг маш тодорхой болгох хэрэгтэй байгаа шүү.

Тэгэхгүй бол яг энэ заалтуудыг харахад чухал заалтууд байгаа ч гэсэн амьдралд хэн энд хяналт тавиад хэрэгжүүлэх вэ гэдэг байна. Тийм ээ. Одоо жишээ нь, 9.2.6. Түрүүн Ц.Сандаг-Очир гишүүн бас асуугаад байсан.

Нохой, муурыг хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгийн талбайд салхилуулахгүй байх гээд л. Тийм ээ. 9.2.7-д нохой, муурыг эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хугацаагаар хараа хяналтгүй орхихгүй байх гээд.

Тэр айл тэнд хараа хараа хяналтгүй орхиж байгаа, үгүйг хэн хянаад байх юм. Хэрвээ тийм зөрчлүүд гаргаад байхад хэн хариуцлага тооцох

юм. Тийм ээ. Зөрчлийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай түрүүн тайлбарлаж байна. Зөрчлийн хууль дээр өнөөдөр жишээ нь энэ талаар яг байхгүй шүү дээ.

Тэгээд мэдээж хажуу талын айлын иргэн хэрвээ нөгөө шүгэл үлээнэ гэдэг шиг мэдээлэл өгсөн тохиолдолд манайх ингэж хараа хяналтгүй удаан хугацаагаар орхиогүй, нэг цаг л байсан гэхэд хэн тэрийг нотлох вэ гээд л. Тийм ээ.

Тэгэхээр энд харахад энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд хариуцах эзэн, субъектүүдийг тодорхой болгох нь чухал болов уу. Түүнээс төрийн бус байгууллага хариуцлаа гэхэд та нар айл болгоноор яваад байхгүй шүү дээ. Та нараас хариуцлага тооцох субъект биш. Төрийн бус байгууллага гэхээр. Тийм ээ.

Тийм учраас ийм зүйлүүдийг хэлэлцүүлгийн явцад маш тодорхой болгох нь чухал байна.

Өмнө нь ярьсан шүү дээ. Эзэнгүй золбин муур, нохойг. Одоо жишээ нь нохойн дээр спираль тавих тухай асуудал. Тэр нь өөрөө бараг гурав, дөрвөн тэрбумын асуудал яриад олон нийтийн сүлжээгээр маш их шүүмжлэл.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ер нь санал хэлжээ. Хариулт авах юм уу? Хэн хариулах юм. Яах вэ, М.Оюунчимэг гишүүн бас нэлээн хэдэн саналууд хэлж байна.

Энэ өөрөө анхдагч хууль байгаа. Дээр нь гэрийн тэжээвэр амьтантай холбоотой хууль тогтоомж дэлхийн 124 улсад байгаа гэж байгаа шүү дээ. Тийм ээ. Манай улс л ийм зохицуулалтгүй явж байгаа. Анх удаагаа ийм зохицуулалттай болохоор хуульчлагдах гэж байна.

Тэгээд энэ хугацаанд хэлэлцүүлгийн явцад таны саналуудыг оруулах бүрэн боломжтой анхдагч хуулийн төсөл учраас хөндөгдөх. Хөндөгдөөгүй асуудал гэдэг зүйл байхгүй учраас оруулаад явах боломжтой.

Гэхдээ нэмж хариулах юм уу? Санал хэллээ гэж ойлголоо. Тэгээд М.Оюунчимэг гишүүний саналыг хэлэлцүүлгийн явцад анхаарч тусгах нь зүйтэй.

Л.Мөнхбаатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: “Азтай Савар” төрийн бус байгууллагын дүү нартаа баяр хүргэе.

Тэгээд залуучууд энэ ажлын хэсэгт идэвхтэй хууль санаачлаад нийгэмд шийдэгдээгүй байсан шинэ хуулийг санаачлаад ингээд ажлын хэсэгт ороод материалууд бэлдээд оролцож байгаад нь баярлаж байна.

Тэгээд юу гэхээр бас улс төрчдийн, төрийнхөн гээд яриад байдаг энэ хүмүүсийн тэр болгон тоодоггүй, орхичихдог зохицуулаагүй зүйлийг оруулж ирж байгаа.

Тэгээд өөрөө эргээд энэ амьтанд хайртай байгаа манай залуучууд амьтны асуудалд их анхаарал хандуулж байгааг илэрхийлж байна гэж ойлгож байна.

Тэгээд нохой монголчуудын хувьд эртнээсээ маш чухал байсан. Одоо хүний нөхөр гэж үздэг. Тийм ээ.

Ертөнцийн гурван хөөрхнийхөө нэгэнд оруулдаг. Тэгээд өөрийнхөө өмч хөрөнгөө хамгаалдаг ийм хань нөхөр гэж ингэж ойлгодог.

Муур ч гэсэндээ бас ингээд манайхан хөдөө орон нутагт гэхэд л гурил, будаагаа, малын тэжээлээ хулганаас хамгаалах зорилготой ашигладаг, тэжээдэг. Зарим настай хүмүүс зүрхэнд сайн гэнэ лээ гээд бас тэжээгээд илээд сууж байдаг.

Тэгэхээр хүн, амьтдын энэ харилцаанууд ингээд яг зохицуулалтгүй байгаад байсан.

Тэгэхээр энэ хууль энэ харилцаануудыг зохицуулахаар орж ирж байгаа. Тийм учраас дэмжиж байгаа.

Асуудлууд давхардсан байж магадгүй. Татварын асуудлыг яаж оруулж ирэх гэж байгаа билээ? Энэ дээр. Одоо нэг орон сууцад амьдардаг хүмүүс, манайх нохой тэжээдэг байхад орон сууцын мөнгөн дээр 2 мянган төгрөг аваад явдаг. Одоо яг ямар зохицуулалттай байгаа вэ?

Тэр спэй хийх зардлыг өчигдөр Байнгын хороон дээр асуусан. Нэлээн өндөр өртөгтэй, зардал нэлээн өндөр өртөгтэй сонсогдож байна лээ.

Тэгэхээр энэ цаашдаа буурах боломж байгаа юу? Хууль батлагдаад ирвэл энэ зардлыг бууруулах боломж байгаа юу?

Хөдөө орон нутагт байдал маш төвөгтэй байгаа шүү дээ. Хөөрхий нөгөө хэдэн сумын Засаг дарга нар баахан нохой урлаа барилаа гэсэн өргөдөл. Тэгээд хэдэн багийн Засаг дарга нараа дуудаж ирээд энэ нохойгоо устга гээд явуулдаг. Нөгөө багийн Засаг дарга нар нь цаашаа хүн гуйна. Нохой устгаад өгөөч гээд. Тэрийг нь монголчууд нохойндоо хайртай. Бас нохой алахыг нүгэл гэж боддог учраас үүнийг хийж

гүйцэтгэдэг хүн байдаггүй. Ингээд л бөөн асуудал. Тэгээд одоо бараг л нэлээн хүнд нөхцөлд л энэ яаж байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудыг зохицуулах нь зөв.

Дээрээс нь энэ асуудлыг. Одоо ялангуяа хот суурин, төвлөрсөн газар дээр. Хөдөө ч гэлтгүй дээ. Энэ асуудлаа цэгцлэхгүй бол гэрийн тэжээмэл нохой, муурыг вакцинжуулах, эрүүлжүүлэх асуудлыг цэгцлэхгүй бол энэ галзуу, бэтэг гээд асуудал. Дээрээс нь нохойд хазуулах гээд хүнд асуудал байгаа.

Тэгэхээр энэ хүний эрүүл мэндтэй холбоотой асуудал байгаа. Тэгэхээр энэ асуудлыг хуулиар цэгцлэх юм байна.

Бүр малчдад маань тулгарч байгаа бас том асуудал байгаа. Энэ гэрийн нохойг гөлөглүүлээд, гөлгийг нь алж устгаж чадахгүй учраас суурин газар бараадуулаад орхидог. Сүүлдээ тэнд хоол тэжээл олдохоо байхаараа хээр гарч чоно нохойтой нийлээд малд маш том хохирол үзүүлдэг ийм зүйлүүд болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ хуулиар зохицуулах юм байна.

Хамгийн сүүлд нь, энэ бүртгэлжүүлэлтийн асуудал аягүй чухал шүү. Энэ дээр яаж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ц.Туваан гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Б.Энхбаяр гишүүн эхлээд хариулъя.

Тэгээд ажлын хэсгээс нэмж хариулаарай.

Б.Энхбаяр: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр гэрийн тэжээвэр амьтныг хүн өөрөө хяналтаасаа алдаад зэрлэгшүүлэх бол хээрийн боохойноосоо илүү аюултай үр дагавартай юм байна лээ.

Саяхан сарын өмнө Австралийн Засгийн газар зэрлэгшсэн муур нь Австрали дахь нэн ховор 20 гаруй зүйлийн амьд амьтныг устгалаа гэдэг харамсмаар мэдээ хийж байсан.

Австрали мөн зэрлэг нохой нөгөө чононоосоо илүү зэрлэгшсэн, бүр шинэ үүлдэр гарсан. Та бүхэн мэдэж байгаа.

Мөн тэнд байгаа байгалийн ховор зүйлийн ан амьтныг устгасан. Энэ их аюултай тийм үр дагавартай юм байна лээ.

Манайх ч гэсэн ердөө л энэ хажууд байгаа. Өнгөрсөн онд. Богд ууланд буга барьсан байна Нүхтийн аманд байгаа хэдэн аргалын маань нөгөө зэрлэгсэн нохойнууд барьсан байна. Ердөө хажууд шүү дээ. Оны өмнө.

Тэгээд ийм үйл явдлуудын дунд байна. Хүн барьж байна, хүүхэд барьж байна. Бичлэгүүд хүртэл гарсан. Олныг сэртхийлгэсэн.

Тэгээд бид яах вэ татвар дээр нэг ийм зарчим баримталсан юм. Хууль дээр татвар яг тэдэн төгрөг байна гэж хатуу тоо тавихаас жоохон хойш суусан. Үүнийг аймаг, нийслэлийн хурлууд өөр өөрийн онцлогтойгоор татвараа тогтоох тэр эрхийг харин олгоё. Шууд хууль дээр махан тоо тавихаас жоохон түдгэлзсэн.

Яагаад гэхээр ний нуугүй хэлэхэд жоохон хэл ам гарах вий. Одоо энэ Б.Энхбаяр гэдэг нөхөр баахан нохой, мууруудыг бүртгэж авч байгаад мөнгө

хийх гэж байна. Ашиг олох гэж байна. Өөрөө идэх гэж байна болох вий дээ. Одоо юу ч болж мэднэ шүү дээ. Ер нь.

Эсвэл манай энэ залуучуудын сайн дураараа сайхан сэтгэлийн үүднээс ажиллаж байгаа энэ ажлыг бас мэдэхгүй. Магадгүй мушгиад, гуйвуулаад.

Энэ хэдийн маань бас тэр мөнгийг нь аваад идэх гэж байгаа юм шиг болчих вий. Одоо ч ер нь хартай авгай шиг л болсон байна шүү дээ. Одоо ерөөсөө хаа сайгүй л.

Тийм учраас жоохон шууд ийм махан тоо тавьж хүн амьтан цочоогоод яах вэ. Ер нь бидний 2021 оны 01 сард баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын хуулийн шинэчлэл дотор энэ асуудлыг бид орон нутгийн чиг үүрэгт нь тавьсан юм. Төв Засгийн газрын биш, орон нутагт нь.

Тэгээд татварын хуулиараа болохоор орон нутгийн татвар хэсэг дээр нь биччихсэн юм. Орлогыг нь.

Тийм учраас үүнийг нийслэлийн болон дүүргийн өөрөө удирдах ёсны байгууллагууд онцлогтойгоороо тогтоож, тэгээд ард иргэддээ тайлагнаж. Энэ мөнгө юунд зарцуулагдаж байгаа гэдгийг тайлагнаж явбал арай шууд амьд холбоос үүсэх байх. Иргэдийн хяналт ч гэсэн ойр байна байх гэсэн ийм бодол санаагаар хуульдаа бичсэн байгаа.

Тэгээд манай ажлын хэсгийн гишүүд нэмж хариулах байх. Ц.Туваан гишүүний асуултад.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. 82 уу? 82 дугаар микрофоныг өгье. Асуултад хариулъя.

М.Золзаяа: Хуульч М.Золзаяа байна. Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Түрүүн СӨХ-оос нохой, муур гэжээлээ гээд мянга, хоёр мянган төгрөг аваад байдаг гэсэн. Үүнийг СӨХ-ны тухай хуулийн дагуу СӨХ өөрсдөө тохиролцсон тохиролцооныхоо дагуу энэ мянга, хоёр мянган төгрөгийг аваад явдаг.

Тэгэхээр энэ нөгөө улсын хэмжээнд авч байгаа татвар биш гэсэн үг.

Энэ спэй буюу үржил хязгаарлах мэс ажилбарын зардалтай холбоотой асуултад хариулхад одоогоор нохой, муур эр эм гэдэг хүйсээсээ хамаараад үржил хязгаарлах мэс ажилбарын зардал нь ойролцоогоор 100 мянгаас 200, 300 мянган төгрөгийн хооронд байдаг.

Энэ зардал нь КОВИД-ын өмнө харьцангуй бага байсан бол КОВИД-ын дараа одоо энэ мэс ажилбарт хэрэглэгддэг хэрэглэгдэхүүнүүд нь үнэд орсноос болоод зардал нь харьцангуй өндөр болсон.

Хэдийгээр энэ асран хамгаалагчдад үржил хязгаарлах мэс ажилбарыг хийх гэдэг нь өндөр, санхүүгийн хувьд зардал болгохоор харагдаж байгаа ч гэсэн үүнийг сум, орон нутаг, нийслэлийн хэмжээнд өөрсдийн төсөвтөө эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах ажлынхаа хүрээнд тодорхой төсвийг тусгах боломжтой гэж харж байгаа.

Жишээлэх юм бол Сонгинохайрхан дүүрэг өнгөрсөн хугацаанд эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах буюу устгалын зардлынхаа тодорхой хэсгийг нь эзэнтэй амьтдад

үржил хязгаарлах мэс ажилбар хийхэд зарцуулсан ийм сайн практик байдаг.

Цаашдаа хуулийн төсөл хэрэгжилттэй холбоотойгоор бусад орон нутгууд энэ жишгээр энэ үржил хязгаарлах мэс ажилбарыг хийх боломжтой гэж харж байгаа.

Энэ нохой, муурын бүртгэлийн хувьд энэ бүртгэлийн ажлыг засаг захиргааны хамгийн бага нэгж буюу харьяа баг, хорооны Засаг даргад бүртгүүлэхээр заасан байгаа.

Энэ бүртгэлийн ажлыг цаашдаа **e-mongolia**-гаар дамжуулаад цахимжуулах боломжтой гэж ажлын хэсгийн зүгээс үзэж байгаа.

Статистикийн тухай хуулийн дагуу баг, хорооны засаг дарга өрхийн бүртгэлийнхээ хүрээнд тухайн өрхийн тэжээвэр амьтны тоо толгойг давхар тоолоод явдаг юм билээ.

Ерөнхийдөө практикт баг, хороон дээр өрхийн нохой, муурын бүртгэл албан бус байдлаар явж байдаг.

Тэгэхээр үүнийг сум, баг, хороон дээр албан байдлаар хийх боломжтой гэж харсан байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? Тийм ээ. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон вэ? 80 уу? 80 дугаар микрофоныг өгье.

Ц.Зориглон: “Азтай Савар” төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон байна.

Ц.Туваан гишүүний асуулт дээр түрүүн буудлагатайгаа харьцуулахад спиний зардал аягүй өндөр харагдаж

байна гэж. Яг тэгж харагддаг л даа, ер нь бол.

Тэгэхдээ бид саяын Сонгинохайрхан дүүргийн жишээн дээр ярихад 57 сая төгрөгөөр 1500 нохойд спин хийсэн байгаа байхгүй юу. Нийслэлийн төсвөөс. Тэгэхдээ тэр маань юу гэсэн үг вэ гэхээр одоо жишээ нэг нохой буудахад 12 мянган төгрөг байгаа. Тийм ээ.

Тэгэхээр 12 мянган төгрөгөөр хэрвээ 1500 нохойг буудсан бол жишээ нь тэрбум 800 сая төгрөг зарцуулах байсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр тийм их амьтан төрөхөөс 57 сая төгрөгөөр сэргийлэх боломжтой болчхож байна гэсэн үг.

Тэгэхээр энэ чинь эргээд цааш цаашдын устгал зарцуулах асар их мөнгийг хэмнэх боломжтой гэж харагдаж байгаа юм л даа.

Тэгээд дээр нь энэ нохой, муур чинь нэг удаа төрөхдөө 6-аас 8, заримдаа 10 гөлөг гаргана. Дахиад тэд нар гудамжинд гарах юм бол бүр их өндөр төсвөөр устгах боломжтой байсныг ингэж хязгаарлаж чадсан байна гэсэн үг болж байгаа юм.

Устгалтын төсөв энэ жилээс бүр нэмэгдэж байгаа сурагтай байгаа. Тэгэхээр бүр их өндөр төлбөр гарах байсан гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай байх.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлж болно. Байхгүй байна.

Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Батгөмөрийн Энхбаяр гишүүн үг хэллэе.

Б.Энхбаяр: Хүн бол нөгөө мэдэхгүй зүйлийнхээ дайсан байдаг юм билээ. Тэрний нэг нь би.

Яг энэ амьтны хуулийг санаачлаач ээ гэж байхад би бас их гайхаж хүлээж авч байсан. Үгүй. Энэ чинь амьтанд хууль байдаг юм уу гээд.

Тэгээд амьтны эрх гэхээр би яг нөгөө хуульч хүнийхээ хувьд үгүй энэ чинь манай Үндсэн хуульд хүн бүр эрх зүй этгээд байна. Амьтан эрх зүй этгээд биш шүү дээ. Амьтны эрх, үүрэг гэж юу байдаг юм гэж. Яг л нэг тийм хайрцаглагдсан, норматив, уламжлалт тийм сэтгэхүйгээрээ хандаж байсан.

Одоо бол нөгөө өнөөдрийн өндөрлөгөөс харахад гэдэг шиг бас энэ залуучуудынхаа ач буянаар энэ талын судалгаа, шинжилгээ, мэдээлэл юмнуудад татагдан орж танилцсаны үр дүнд бид өнөөдөр энэ хуулийг ярьж байна.

Магадгүй хэдэн жилийн дараа, 10 жилийн дараа ч юм уу бид амьтдын эрхийн тухай асуудлыг бас ярих цаг ирэх байх гэж бодож байгаа.

Өөрөөр хэлбэл хүний нэгэн адил сая Үндсэн хуульд заасанчлан хүн бүр эрх зүй этгээд байна гэхээс гадна энэ амьтдыг гэр бүлийн нэг гишүүний адил авч үздэг тэр дараагийн үе шатад би шилжих цаг үе би ойрхон байна байх гэж ингэж бодож байгаа.

Тийм учраас хамгийн хэцүү асуудал бол эхлэх байдаг. Эхлэх бол сайшаалгахаасаа илүүтэй шүүмжлэлд, хардлагад, сэрдлэгт өртдөг.

Тийм учраас манай залуучууд энэ асуудлыг 10 жилийн өмнө анхаарч олон нийтийн, сайн дурын, өөрсдийнхөө цаг заваа зарцуулж энд өнөөдөр олон зуун мянган залуучууд энэ төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэж, амьтанд хайртай болон хайргүй хүмүүс бүгдээрээ л энд оролцож санаа тавьж, бас өнөөдөр Монгол Улсын төрийн эрх барих дээд хууль тогтоох байгууллагад анх удаа иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд өөрсдийн санаачилсан хуулиа хэлэлцүүлж байгаа юм.

Энэ бас их түүхэн үйл явдал шүү. Улсын Их Хурал бол өөрөө ард түмний төлөөллийн дээд байгууллага гэдэг тэр хэв шинжээ хадгалж байгаа, илэрхийлж байгаа, сайн санаачлахыг хүсэж дэмжиж өнөөдөр манай олон гишүүд сайн асуулт асууж, энэ хэрээрээ иргэдэд мэдээлэл өгч, мөн боловсронгуй болох шаардлагатай, нэмж тусгах шаардлагатай асуудлын талаар санал ирүүлж ингэж байгаад бүх гишүүддээ, “Азтай Савар” төрийн бус байгууллагын нийт гишүүдэд, дэмжигчдэд, үүнийг ойлгосон ч бай, ойлгоогүй ч бай, бас цаашдаа ойлгох тэр хүмүүст бүгдэд нь талархлаа илэрхийлье.

Тэгээд энэ бол анхны алхам. Анхны алхам зөв байвал дараа дараагийн алхмууд, шангууд зөв тавигддаг.

Дараа, дараагийн үр хүүхдүүд маань биднээс илүү амьтанд хайртай, биднээс илүү хүний эрхийн мэдрэмжтэй ийм үеийнхэн өсөж бойжиж боловсронгуй болгож авч явна байх гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүдийн санал хураалтыг маргаашийн нэгдсэн чуулганаар явуулна.

Өглөөний 10.00 цагт.

Ажлын хэсэгт баярлалаа.

Чуулганы өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөж байна. /алх цохив/

Хуралдаан 7 цаг 39 минут үргэлжилж, 18 цаг 45 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД